



АНУ-ын Элчин сайдын яам



"Глоб Интернэшнл" ТББ



...Хүн бүр өөрийн үзэл бодолтой
байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх
эрхтэй...

Улаанбаатар хот, 2008 он

Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэлийн болон мэдээллийн эрх чөлөөний талаарх олон улсын хэм хэмжээг эмхэтгэн хэвлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн АНУ-ын элчин сайдын яаманд талархал илэрхийлье.

ХЭВЛЭЛД БЭЛТГЭСЭН:

Х.Наранжаргал

Д.Мөнхбүрэн

Б.Онон

Ч.Энхбаяр

“ЧОЛООТ ХЭВЛЭЛ САН”-д эхийг бэлтгэж хэвлэв.

Хэвлэлийн хуудас: 16/1, 7

Хэвлэсэн тоо: 1000

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Дипломат-95 цогцолбор, 1-р орц, 6 тоот, Улаанбаатар хот, 210620-А, ш/х-28

Утас: 976-11-324627, у/ф-976-11-324764

Э-шуудан: globe@globeinter.org.mn,
hnanan@globeinter.org.mn,
burnee@globeinter.org.mn

Вэб: www.globeinter.org.mn, www.monitoring.mn

ГАРЧИГ

ОМНОТГОЛ	4
I. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧОЛООГ ДЭМЖИХ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ	5
§ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал.....	5
§ Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт	6
§ Хүний Эрхийн тухай Европын Конвенц	7
§ Америк Дундын Хүний Эрхийн Конвенц	11
II. МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧОЛОО	12
§ Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих олон улсын механизмууд.....	12
§ Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний гол асуудал, тулгамдсан асуудлын тухай мэдэгдэл	14
§ Йоханнесбургийн зарчмууд: Үндэсний аюулгүй байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хүртээмж	22
§ Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба гүтгэлгийн эсрэг хуулийн зарчим	30
§ Олон нийтийн мэдэх эрх: Мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн зарчмууд	40
§ Мэдээллийн эрх чөлөө ба Европын холбоо	49
§ Мэдээлэл олж авах тухай хуулийн төсөл боловсруулах нь -Төв болон Зүүн Европ, ТУХН-ын орнуудын чиг хандлага.....	54
III. ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧОЛОО	64
§ Чөлөөт хэвлэлийн харти	64
§ Сэтгүүлчдийн эрх чөлөө, хүний эрх.....	66
§ Ардчилсан хэвлэл мэдээллийн соёлын төлөө тунхаг	69
§ Чөлөөт хэвлэлийн арван номлол.....	71
§ Сэтгүүлчдийн баримтлах зарчим.....	72
§ Мэргэжлийн Сэтгүүлчдийн Нийгэмлэг: Ёс зүйн код	73
§ Америкийн сонины редакторуудын нийгэмлэгийн үйл ажиллагааны зарчим	76
§ Сэтгүүлчдийн эрх, үүргийн тунхаглал	78
§ Францын өдөр тутмын хэвлэлүүдэд хүчин төгөлдөр мөрдөгддөг дүрэм болон мөрдлөгүүдээс.....	80
§ Хэвлэлийн ажилтны ёс зүй	81
IV. СОНГУУЛЬ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ.....	82
§ Ардчилал ба сэтгүүлчдийн гүйцэтгэх үүрэг.....	82
§ Сонгууль сурвалжлах зарчмууд	89
§ Их Британий "БИ-Би-Си" Радио, Телевизийн корпорацийн мэдээллийн программын зарчмуудаас.....	96
§ Хэвлэл мэдээллийн байгууллагуудын баримтлах зарчим.....	97
V. ОРГОН НЭВТРҮҮЛЭГ.....	99
§ Агаарын долгионыг хүртээмжтэй болгох: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон өргөн нэвтрүүлгийг зохицуулах зарчмууд.....	99

ӨМНӨТГӨЛ

Энэ жил дэлхий нийтээрээ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 60 жилийн ойг тэмдэглэж байна.

1948 оны 12-р сарын 10-нд НҮБ-ын Ерөнхий Ассемлейн Анхдугаар Чуулганы 217 А (Ш) тоот тогтоолоор батлан тунхагласан энэ түүхэн бичиг баримтыг бүрэн эхээр нь, улс орны улс төрийн тогтолцоо, газар нутгаас үл хамааран, хүн бүрт түгээн дэлгэрүүлэх, дунд сургууль, боловсролын бусад байгууллагад суралцагсдад таниулан мэдүүлэхийг гишүүн орнууддаа уриалсан юм.

Монгол Улс 1961 онд НҮБ-ын гишүүн болж, хүний үндсэн эрхүүдийг тунхагласан энэ чухал баримт бичгийг хүлээн зөвшөөрсөн билээ.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын XIX зүйлээр хүн бүр үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхийг тунхагласан байдаг. Мөн “үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан боломжтой аргаар эрж сурвалжлах, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх эрх багтана” хэмээн тунхаглажээ.

Энэхүү заалтыг бодитой хэрэгжүүлэхийн тулд улс үндэстэн бүр дотоодынхоо Үндсэн Хууль, бусад хуулиар иргэдийнхээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэлтэй байх, хэвлэн нийтлэх, чөлөөт хэвлэл мэдээлэлтэй байх эрхийг баталгаажуулсан байдаг.

Манай улс ч мөн адил Үндсэн Хуулиараа Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын XIX зүйлийг баталгаажуулж, 1998 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, 2005 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хууль баталж, зарим хуулийн зүйл заалтаар сэтгүүлчийн мэргэжлийн эрхийг бататгасан байдаг.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага үүсэн байгуулагдсан цагаасаа Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын XIX зүйл, түүнд нийцүүлэн баталсан олон улсын эрх зүй, хэм хэмжээг олон нийт, сэтгүүлчдэд таниулахыг хичээн, янз бүрийн төслийн хүрээнд олон бичиг баримт орчуулан иргэд, сэтгүүлчдэд зориулсан гарын авлага, ном товхимолд хэвлэсэн юм. Тэдгээр материалыг эмхэтгэн тусгай товхимол болгон нийтлэхийг сэтгүүлчид удаа дараа хүссэн ёсоор бид үүнийг уншигч танаа өргөн барив.

Энэ ялдамд бидэнд ийм боломж олгосон Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яаманд гүн талархал илэрхийлье.

Иргэн бидний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, хүний хөгжилд хөтөлсөн Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал мандтугай!

Х.Наранжаргал
(“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын тэргүүн)

1. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨГ ДЭМЖИХ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ

§ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг баталсан бөгөөд энэ нь оршил хэсэг, 30 зүйлтэй. Хүний эрх, үндсэн эрх чөлөөг нэгтгэн тодорхойлсон уг Тунхаглал нь хүний эрхийн салбарт улс түмний баримтлах үндсэн удирдамж болсоор байна. Энэхүү баримт бичгийн оршин үйлчилж ирсэн олон жилийн туршлагаас үзэхэд заалт бүр хэрэгжиж байх ёс зүйн болон улс төрийн хүчин чадалтай болохоо батлан харуулж, бүх нийтэд хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааны стандарт болсон учир улс орнууд дотоодын хууль тогтоомждоо Тунхаглалын үзэл санаа, зарчмуудыг хүлээн зөвшөөрч хүндэтгэлтэй хандах болсон ажээ.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын Удиртгал хэсэгт:

"Хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөнхийг иш үндэс болгон, хүний эрхийг үл тоомсорлох, басамжлах нь зон олны ариун сэтгэлийг сэвтээн жигшээсэн балмад үйлдэлд хүргэж байсан бөгөөд хүмүүс үгээ хэлэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөтэй түүнчлэн айх аюулгүй, гачигдах зовлонгүй дэлхий ертөнцийг бий болгох нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл мөн хэмээн үзэж" Нэгдсэн Үндэсний Байгууллагад нэгдсэн улс түмэн хүний үндсэн эрх, бие хүний нэр төр, үнэ хүндийг сахин хамгаалах, ... -аар шийдвэрлэснийг харгалзан, гишүүн улсууд НҮБ-тай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөг нийтээр хүндлэн сахиулахад тус дөхөм үзүүлэх үүрэг авсныг үндэслэн ... хүний эрх, эрх чөлөөг НҮБ-ын гишүүн улс орны ард түмэн, тэдгээр улсын эрх мэдэлд байгаа нутаг дэвсгэр дээр оршин суудаг ард олны аль алинаар нь зохих ёсоор зөвшөөрүүлэн хэрэгжүүлэхийг зарлан Тунхаглаж байна" гэжээ.

1 дүгээр зүйл: Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харьцах ёстой.

2 дугаар зүйл: Хүн бүр энэ тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Мөн түүнчлэн тухайн хүнийг харьяалдаг улс орон буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүйн болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжинд байгаа, өөртөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй.

7 дугаар зүйл: Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчлалаас болон тийнхүү алагчлахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй.

8 дугаар зүйл: Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.

12 дугаар зүйл: хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.

19 дүгээр зүйл: Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.

22 дугаар зүйл: Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй.

28 дугаар зүйл: Хүн бүр энэхүү тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг бүрэн эдэлж болохуйц нийгмийн болон олон улсын дэг журамд аж төрөх эрхтэй.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний үндсэн эрх бүр хүн бүрт тодорхой үүрэг буй болгодог. Жишээ нь: Хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд эргээд Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хүндэтгэх үүрэгтэй. Энэ бүгдийг хураангуйлан хүний үндсэн үүргийг Тунхаглалын 29 дүгээр зүйлд:

- “1. Хүн бүр нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээх бөгөөд гагцхүү нийгэм л бие хүний чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангана.
2. Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй.
3. Эдгээр эрх, эрх чөлөөг НҮБ-ын зорилго, зарчимтай хэрхэвч зөрчилдүүлж болохгүй” гэж тус тус заасан байдаг.

§ Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан улс төр, иргэний эрхийг эдлэх нь бие хүний эрхэм зорилго бөгөөд эдгээр эрх нь хүний мөн чанараас үүдэн гарсан байдаг билээ. Нэгдсэн Үндэсний Байгууллагын дүрэмд заасан зарчмуудын дагуу хүн төрөлхтний гэр бүлийн бүх гишүүнд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс болохыг харгалзан улс гүрэн бүр хүний эрх, эрх чөлөөг бүх нийтээр хүндэтгэн сахих явдлыг хөхиүлэн дэмжих, хувь хүн бүр бусдын өмнө үүрэг хүлээхийн зэрэгцээ эрхийнхээ төлөө тэмцэх учиртайг харгалзан уг Пактыг 1966 онд батлан гаргажээ. Манай улс 1974 онд түүнд нэгдэн орсон юм.

Энэхүү Пактын 19 дүгээр зүйлд:

1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй.
2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.

3. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага ногдуулна. Тийм ч учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараахь шаардлагаас үүдэн гарсан байх ёстой:

а/ Бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх

б/ Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.

Хүний эрх, эрх чөлөө хөндөгдсөн үед түүнийг хамгаалах, сэргээн тогтоох Олон Улсын Эрх зүйн гол механизмын талаар Пактын 28 дугаар зүйлд Хүний Эрхийн Хороо байгуулахаар заасан ба Пактад дурьдсан эрх зөрчигдсөн тухай хувь хүний мэдээллийг хүлээн авч, хэлэлцэж байх эрхийг Хүний Эрхийн Хороонд олгох зорилгоор Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт Протоколыг 1966 онд баталсан. Уг Протоколд манай улс 1991 онд нэгдэн орсон бөгөөд нэгдэн орсон улс нь Пактад тусгагдсан эрхийг зөрчсөний улмаас хохирсон этгээд тухайн эрхийг хамгаалах дотоодын хууль эрхийн бүхий л хэрэгслийг барагдуулсны эцэст Хороонд бичгээр гомдол гаргадаг. Хороо нь Пактад дурдсан хүний эрх зөрчигдсөн улсад ирүүлсэн гомдол, мэдээллийн талаар мэдэгдэх, харин тухайн улс нь энэ талаар ямар арга хэмжээ авсан болон бусад тайлбарыг 6 сарын дотор хариу ирүүлдэг байна. Хороо дараахь тохиолдолд хувь хүний мэдээллийг хэлэлцдэггүй. Үүнд:

а/ Тухайн асуудал нь олон улсын шүүх буюу зохицуулах өөр журмын дагуу хэлэлцэгдээгүй бол,

б/ Тухайн этгээдийн дотоодын хууль эрхийн хамгааллын бүхий л бололцоотой хэрэгслийг барагдуулаагүй бол. Тийм хэрэгсэл ашиглахыг шалтгаангүйгээр удаашруулсан байвал энэ журмыг мөрдөхгүй. Хороо тухайн асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэх бөгөөд саналаа оролцогч улс болон тухайн хувь хүнд мэдэгддэг. Уг Пактад оролцогч улс дараах үүрэг хүлээдэг.

Үүнд:

а/ Энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн аливаа хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн нөхцөлд, уг зөрчлийг албан үүргээ гүйцэтгэж байсан этгээд гаргасан тохиолдолд ч, хохирогчийг хууль зүйн талаар хамгаалах үр нөлөөтэй арга хэмжээ авах,

б/ Ийнхүү хамгаалалт хүссэн аливаа этгээдийн хуулиар хамгаалуулах эрхийг эрх бүхий шүүх, засаг захиргаа, хууль тогтоох байгууллага, эсхүл төрийн хууль зүйн системд орж байгаа эрх бүхий аливаа бусад байгууллагаас тогтоох явдлыг хангаж, шүүхээр хамгаалуулах боломжийг өргөжүүлэх,

в/ Хууль зүйн хамгаалалтын хэрэгслийг олгосон үед түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэглэх явдлыг хангах.

§ Хүний Эрхийн тухай Европын Конвенц

1.1. Мэдээлэл, олон нийтийн хэвлэл, мэдээллийн талаарх Европын бодлого нь Европ дахь интеграчлалыг хурдасгах, ардчиллыг цэвэр ариунаар хэрэгжүүлэх, үндэсний дүр төрхийг хамгаалах, соёлын олон төрөл зүйл, олон ургальч үзлийг хөгжүүлэх үйлсийн түлхүүр мөн болно. Энэ бодлоготой уялдуулан аливаа хүний санаа бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх эрх чөлөөг төрийн байгууллагын оролцоогүйгээр улсын хил хязгаараас үл хамааран баталгаажсан. Хүний эрхийн тухай Европын конвенцийн 10 дугаар зүйлд онцгой

анхаарал хандуулах ёстой юм. Хүний эрхийн тухай Европын конвенцийн 10 дугаар зүйлд тусгагдсан мэдээлэл хайх, бодол санаагаа илэрхийлэх эрх чөлөө нь эрэгтэй, эмэгтэй хүн бүрийн хөгжлийн үндсэн нөхцлийг бүрэлдүүлнэ. Европын конвенцийн 10 дугаар зүйл нь Европын хамтын нийгэмлэг, түүний гишүүн орнуудын олон нийтийн хэвлэл мэдээлэл, мэдээллийн хуулийн үндэс болдог.

Хүний Эрхийн тухай Европын конвенц (ХЭТЕК)-ийн 10 дугаар зүйл нь Европын хамтын нийгэмлэгийн хүрээнд олон нийтийн хэвлэл мэдээлэл, мэдээллийн хуулийн ирээдүйн үндэс төдийгүй түүний гишүүн орнуудын хуулийн хариуцлагын хэрэглүүр болно. Хүний эрхийн тухай Европын Конвенцийн хэрэгжилтэд Европын Конвенцийн дараах байгууллагууд буюу Хүний эрхийн асуудлаарх Европын комисс, Сайд нарын хороо, хүний эрхийг хамгаалах Европын шүүх хяналт тавьдаг юм. Конвенцийн нэгдүгээр зүйлийн дагуу гишүүн орон бүр Конвенциор олгогдсон эрх болон эрх чөлөөг өөрсдөдөө хамаарагдах хүн бүрийн хувьд баталгаажуулах ёстой. Конвенцийг зөрчсөний улмаас хохирсон гэх эрэгтэй эмэгтэй хүн, бүлэг хүмүүс хэн боловч өргөдлөө Комисст гаргаж болно. Комисс нь тухайн хэргийг шүүхэд шилжүүлэх, эсвэл энэ тухай өөрийн тайланг Сайд нарын хороонд илтгэх эрхтэй. Хүний эрхийг хамгаалах Европын шүүхийн шийдвэр, мөн сайд нарын хооронд шийдвэр нь гишүүн улсын хуульд өөрчлөлт оруулахыг шаардсан байж болно (25-54 дүгээр зүйл).

Конвенцид тусгагдсан эрх ба эрх чөлөө нь ихэнх гишүүн орнуудын үндэсний шүүхүүдэд шууд хэрэгжих үйлчлэлтэй байдаг. (Энэ нь Конвенцийн “өөрөө хэрэгжих” чанар буюу гишүүн орнуудад шууд хүчин төгөлдөр үйлчлэх шинж чанартай холбоотой юм). Улс орон дотооддоо асуудлыг шийдвэрлэх бүх арга хэрэгслийг гүйцээсний дараа өргөдлийг Комисст гаргаж болно. Олон оронд хэвлэл мэдээллийн хууль, нэвтрүүлгийн мэдээллийн журам, мэдээллийн хуулийг Европын Конвенцийн 10 дугаар зүйлээр хамгаалагдсан бодол санаагаа илэрхийлэх болсон мэдээллийн эрх чөлөөний үндсэн дээр болон түүний хүрээнд боловсруулж иржээ.

1.2. Хүний эрхийн тухай Европын Конвенцийн 10 дугаар зүйл нь гишүүн орнуудын дотоодын хууль тогтоомжид шууд хүчин төгөлдөр үйлчлэх шинж чанартайн гадна тухайн зүйлийн ач холбогдол, хэрэглээ нь Европын хамтын нийгэмлэгийн Зөвлөлийн эрх зүйн бүтэц, мэдээлэл, олон нийтийн хэвлэл мэдээллийн бодлогоор тодорхой илэрч байна. Санаа бодлоо илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөний тухай 1982 онд Сайд нарын хорооноос гаргасан тунхаглалд олон нийтийн мэдээллийн салбарт “Улсын хил хязгаараас үл хамааран хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ямар ч эх сурвалжаас үл хамааран мэдээлэл хийх, олж авах, олж авсан мэдээллээ ХЭТЕК-ийн 10 дугаар зүйлд заасан нөхцөлийн хүрээнд түгээх аливаа хүний эрхийг хамгаалах зорилттойг” дурджээ. Цаашдын чухал алхмууд нь Венад (1986), Хельсинкт (1988), Никозиад (1991) хуралдсан “Европын хэвлэл мэдээллийн сайд нарын” бага хурлуудын үеэр хийгдсэн байна. Энэ хурлуудаас гаргасан тунхаглал, шийдвэрүүд ХЭТЕК-ийн 10 дугаар зүйл нь санаа бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх суурь эрх чөлөөний баталгаа болоод зогсохгүй Европын Зөвлөл болон ХЭТЕК-иос батламжилсан бусад үндсэн эрхийг хэрэгжүүлэх хүчин зүйл болдгийг тэмдэглэжээ.

1989 оны гуравдугаар сарын 15-нд батлагдсан “Улс хоорондын телевизийн тухай Европын Конвенцод” ч мөн ХЭТЕК-ийн 10 дугаар зүйлийн заалт тусгалаа олжээ. Конвенцийн удиртгалд заахдаа:

Олон ургальч үзэл, ардчилсан бүх хүчнүүд, улс төрийн намуудын адил тэгш нөхцөлд соёлыг хөгжүүлэх, санаа бодлоо чөлөөтэй бүрдүүлэх үйл хэрэгт телевизийн нэвтрүүлгийн чухлыг тэмдэглэж:

Холбооны болон мэдээллийн технологийн хөгжил нь санаа бодлыг илэрхийлэх, хил хязгаар харгалзахгүй олон төрлийн эх сурвалжаас мэдээлэл эрж хайж, хүлээн авах, дамжуулах эрхийг цаашид ч хөгжүүлэх үйлст үйлчлэх болно” гэсэн байна. Цааш нь үргэлжлүүлэн:

“ХЭТЕК-ийн 10 дугаар зүйлд тусгагдсан бодол санаагаа илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөө нь ардчилсан нийгмийн чухал зарчмуудын нэг бөгөөд ардчилсан нийгмийн дэвшил болон хүн нэг бүрийн хөгжлийн үндсэн нөхцөл мөн” гэжээ.

Телевизийн Конвенцийн 4 дүгээр зүйлийн дагуу намууд нь:

“ХЭТЕК-ийн 10 дугаар зүйлд заасан санаа бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөөг хангах ёстой” гэж заасан байна.

1.3. Үүнээс гадна ХЭТЕК-ийн 10 дугаар зүйл нь Европын хамтын нийгэмлэгийн орнуудын хуулийн адил үйлчлэлтэй болно. Энэ нь шүүхийн байцаан шийтгэх хуулинд тодорхой тусгагджээ. Шударга ёсны шүүх нь саяхныхаа зарим шийдвэрт Европын хамтын нийгэмлэгийн орнуудын хууль ёсны хүрээн дэх ХЭТЕК-ийн үйлчлэлийг хүлээн зөвшөөрсөн өмнөх шийдвэрүүдээ дахин баталгаажуулсан байна.

Нидерланд улсын кабелийн телевизийн талаарх хоёр хэргийг шийдвэрлэхдээ Шүүх нь дараах санааг илэрхийлжээ.

“Хамтын нийгэмлэгийн хууль тогтоомжоор баталгаажсан үндсэн эрхийн нэг болох Хүний эрх болон үндсэн эрх чөлөөний тухай Конвенцийн 10 дугаар зүйлээр хамгаалагдсан санаа бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь олон ургальч үзлийн агуулгатай нягт холбоотой юм”

Европын хамтын нийгэмлэгийн хуулинд: ХЭТЕК-ийн 10 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд илүү анхаарах тухай Шударга ёсны шүүхийн шийдвэрт:

“Хүний эрхийн тухай Европын Конвенцийн 10 дугаар зүйлд зааснаар Хүний үндсэн эрх нь шүүх хэрэгжилтийг нь хангах ёстой хууль зүйн ерөнхий зарчмын салшгүй хэсгийг бүрдүүлж байна гэдгийг онцлон тэмдэглүүштэй. Ер нь ийм байр суурийг Шүүх үйл ажиллагаандаа баримталж ирсэн байна. Энэ зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулахдаа Шүүх нь гишүүн орнуудын нийтлэг мөрддөг үндсэн хуулийн уламжлал хийгээд гишүүн орнууд хамтран байгуулж гарын үсэг зурсан хүний эрхийг хамгаалах талаарх олон улсын гэрээнүүдийн үзэл санааг удирдлага болгож байна (...) Энэ асуудалд хүний эрхийн тухай Европын Конвенц ч онцгой ач холбогдлоо өгчээ. (...) Европын хамтын нийгэмлэг нь хүний эрхийг хамгаалах талаар Конвенциор баталгаажуулсан заалтад тохирохгүй гэрээ хэлэлцээр байгуулж болохгүй” гэж тус тус заажээ.

Энэ талаар шүүхийн хийсэн дүгнэлтэд:

Гэрээний 66 ба 56 дугаар зүйлд заасны дагуу төрийн бодлого, улсын аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийн талаарх гишүүн орнуудын бүрэн эрхийн хязгаарлалт нь Хүний эрхийн тухай Европын Конвенцийн 10 дугаар зүйлд заасан санаа бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн зарчмаар тодорхойлогдоно гэсэн байна.

Европын шинэ гэрээний нэгдүгээр бүлгийн зүйлийн нийтлэг үндэслэлд:

“Холбоо нь хүний эрх ба үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын Конвенциор баталгаажуулсан үндсэн гол эрхүүдийг хүндэтгэнэ” гэжээ.

Европын шинэ Конвенцийн 128 дугаар зүйлд заасны дагуу соёлын болон дүрс-дууны мэдээллийн салбарт хамтран ажиллах талаар:

“Хамтын Нийгэмлэг ба гишүүн орнууд соёлын салбарт олон улсын эрх бүхий байгууллагууд, гуравдагч орнуудтай хамтран ажиллахыг Европын зөвлөл хөхиүлэн дэмжинэ” гэжээ. (Европын холбооны гэрээ 1992) Үүнээс гадна “Улс хоорондын телевиз”-ийн тухай Европын Конвенцийн 1989 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн тогтоолын оршилд Хүний эрхийн тухай Европын Конвенцийн 10 дугаар зүйлд заасан санаа бодол, мэдээллийн эрх чөлөө нь Нийгэмлэгийн хууль зүйн хэм хэмжээг тодорхойлох илүү оновчтой хэмжигдэхүүн болох” талаар шууд зааж өгсөн байна.

Телевизийн талаар гаргасан удирдамжийн оршилд телевизийн нэвтрүүлгийг чөлөөтэйгөөр худалдан борлуулах явдлыг нийгэмлэгийн хууль зүйн хэм хэмжээг (ХЭТЕК-ийн 10 дугаар зүйл) илүү оновчтой тодорхойлох хэмжүүр гэж тодорхойлжээ.

1992 оны арванхоёрдугаар сард Комиссын гаргасан “Олон ургальч үзэл ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн төвлөрөл” гэсэн баримт бичигт мөн ХЭТЕК-ийн 10 дугаар зүйлийг үзэл бодол, мэдээлэл зүйн болон олон нийтийн хэвлэл мэдээллийн олон ургальч үзэл бодлын холбогдолтой асуудлыг шийдвэрлэх Шүүхийн байцаан шийтгэх ажиллагаанд мөн зохицож чадахыг цохон тэмдэглэсэн байна.

Европын нийгэмлэг нь ХЭТЕК-ийн бие даасан гишүүн биш ч гэсэн түүний эрх зүйн баримт бичгүүд (Европын нийгэмлэгийн гэрээ, заавар, удирдамж гэх мэт) мөн түүнчлэн Европын Конвенцийн заалттай нийцсэн байх ёстой.

Цаашдаа ХЭТЕК-ийн 10 дугаар зүйлийг Европын хамтын Нийгэмлэгийн хууль эрхийн хүрээнд хэрхэн хэрэглэх талаар тайлбар өгөх хүсэлтийг Люксембургийн Шүүхэд гаргах нь дамжиггүй. (Хинс, 1993 мөн Ленаерты 1991, Лаусон 1992 Винн 1994) Энэ нь Шүүх нийгэмлэгийн эрх зүйн үйлчлэх хүрээнээс хальж зарим улсын дотоодын хууль эрхийн баримт бичигт тулгуурласан ажиллагаа явуулж болохгүйг цохон тэмдэглэж байгаа юм.

Харин улс орны дотоодын хууль зүйн заалт Холбооны хууль зүйн үйлчлэх хүрээнд орсон тохиолдолд Ерөнхий шүүх тэрхүү эрхийн заалтыг ХЭТЕК-ийн адил төстэй эрх зүйн баримтад заасан суурь эрхүүдтэй нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгч, тайлбар өгөх шаардлагатай бүх элементийг нь анхааралдаа авах ёстой. (Гроган, 1991)

Конвенцийн 10 дугаар зүйлийн үйлчлэх хүрээ хэмжээний талаар ерөнхий Шүүхээс хийсэн тайлбар нь Страсбург дахь Хүний Эрхийг хамгаалах Шүүхийн тайлбараас илүү явцуугаар хийгдсэн тохиолдолд асуудал гарч болох юм.

ХЭТЕК-ийн 60 дугаар зүйлийн үзэл санаагаар бол ийм асуудал гарах ёсгүй бөгөөд учир нь Ерөнхий Шүүх нь үзэл бодол, мэдээлэл зүйн эрх чөлөөг хамгаалах ажлыг Хүний эрхийг хамгаалах Европын Шүүхээс илүү өргөн хүрээнд гүйцэтгэдгийн хувьд Европын Холбооны гэрээг зөрчсөн элдэв хязгаарлалтыг илрүүлэх боломж илүү байдагт оршино.

1.4 ХЭТЕК-ийн 10 дугаар зүйлийн ерөнхий танилцуулгад дүгнэлт хийж үзэхэд Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээлэл зүйн талаархи тухайн зүйлийн заалт нь Европын хууль тогтоомжийн гол цөм болж Европын Хамтын Нийгэмлэг болон Европын Холбооны хэмжээнд өнөө ба ирээдүйн үйлчлэх чадвартай нь харагдаж байна. Үүний зэрэгцээ ХЭТЕК-ийн 10 дугаар зүйлийн ерөнхий танилцуулга нь түүний хувиран өөрчлөгдөх байдлыг тайлбарлах, хэрэглэх асуудлыг 4 түвшинд тодорхойлж байна.

-
1. Гишүүн орнуудын түвшинд: (Захиргааны байгууллагын хууль эрхийн үйл ажиллагааны хэмжээнд),
 2. Европын Конвенциор Страсбург дахь Хүний Эрхийг Хамгаалах Шүүх болон Комисст тусгайлан хамааруулсан Европын хууль зүйн тогтолцооны хяналтын үйл ажиллагааны түвшинд,
 3. Улс төрийн бодлогын түвшинд (Европын хамтын нийгэмлэгийн тогтоол, зөвлөмж, хуулиуд, гэрээ, хэлэлцээр гэх мэт)
 4. Европын хамтын нөхөрлөлийн хуулийн хүрээнд ба ХЭТЕК-ийн 10 дугаар зүйлийн тайлбарыг Люксембург дэх Ерөнхий Шүүх хийж, түүнийг Европын Хамтын Нийгэмлэгийн хэмжээнд үйлчлэхээр тогтсон түвшинд зэрэгт тус тус тодорхойлжээ.

Орчуулсан Б.Нарантуяа

§ Америк Дундын Хүний Эрхийн Конвенц

1969 оны 11 дүгээр сарын 22-нд батлагдаж, 1978 оны 7 дугаар сарын 18-нд хүчин төгөлдөр болсон.

13-р зүйл. Бодол, Санаагаа илэрхийлэх Эрх чөлөө

1. Хүн бүр бодол, санаагаа илэрхийлэх эрх чөлөөтэй. Үүнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр эсхүл уран сайхны хэлбэрээр, түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.
2. Омнөх заалтад дурдагдсан эрхийг эдлэхдээ цагдан хяналтын тухай хуулинд захирагдахгүй боловч зайлшгүй дагахаар хуулиар тодорхой тогтоогдсон дараах үүрэг хариуцлагуудад захирагдана. Үүнд:
 - (а) Бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх буюу
 - (б) Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд ба ёс суртахууныг хамгаалах.
3. Бодол санаагаа илэрхийлэх эрх нь сонин хэвлэл, радио өргөн нэвтрүүлгийн давталтууд, мэдээлэл түгээхэд хэрэглэгддэг тоног төхөөрөмжид засгийн газрын болоод хувийн хяналт тавих зөрчил зэрэг шууд бус аргаар эсхүл үзэл бодол, санааг мэдээлэх, түгээхэд саад хийх бусад аливаа аргаар хязгаарлагдах ёсгүй.
4. Дээр дурдсан 2 дахь заалттай зөрчилдөхгүйгээр, олон нийтийн зугаа цэнгээнт хөтөлбөрүүд нь хүүхэд, өсвөр үеийнхний ёс суртахууныг хамгаалах үүднээс тэдэнд хүргэх мэдээллийг зохицуулах цорын ганц зорилгоор л цагдан хяналтын хуулинд захирагдаж болно.
5. Хууль бус хүчирхийлэлд өдөөн хатгасан дайны тухай аливаа ухуулга, яс үндэс, арьс өнгө, шашны үзэн ядалтын аливаа нөлөөлөл ба үүний адил бие хүн ба арьс, өнгө, шашин шүтлэг, хэл, угсаа гарлын хувьд нэг аль ч газрын хүмүүсийн бүлгийн эсрэг аливаа хууль бус үйлдэл нь хуулийн дагуу шийтгэгдэх доромжлол, зөрчил мөн.

Монголын Эмнести Интернэшнл ТББ-аас эрхлэн гаргасан “Хил хязгааргүй сурвалжлагчид” сэтгүүлдэд туслах зөвлөмжөөс хэсэгчлэн авав

II. МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

§ Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих олон улсын механизмууд

Үзэл бодол, түүнийг илэрхийлэх эрх чөлөөний НҮБ-ын Тусгай мэдээлэгч, OSCE-ийн Хэвлэлийн эрх чөлөөний төлөөлөгч, OAS-ын Хэвлэлийн эрх чөлөөний тусгай мэдээлэгч нарын баталсан

ХАМТАРСАН ТУНХАГЛАЛ

Төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид, ЮНЕСКО, сэтгүүлчдийн нийгэмлэг, хүний эрхийн мэргэжилтнүүдтэй Лондонд 2000 оны 11-р сарын 29, 30-нд XIX зүйл, Чөлөөт илэрхийллийн төлөө дэлхийн кампанийн ивээл дор, Канадын сэтгүүлчид Чөлөөт илэрхийллийн төлөө байгууллагын тусламжтайгаар УУЛЗАЖ,

1999 оны 11-р сарын 26-ны тэдний хамтарсан тунхаглалыг САНАН ДАХИН БАТАЛЖ,

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэлгэрүүлэхэд бүсийн механизмуудын ач холбогдол, тийм механизмуудыг дэлхийн бүх бүс нутагт хөгжүүлэх шаардлагатайг ТЭМДЭГЛЭН,

Африкийн Хүний эрх, ард түмнүүдийн эрхийн комиссын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний семинарын болон Африкийн дүрмийн Африкт Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тусгай мэдээлэгч буюу бусад механизм бий болгох тухай зөвлөмжүүдийг САЙШААЖ,

АСЕАН, Ази-Номхон далайн бүс дэх хүний эрхийг хамгаалах, хөгжүүлэх бүсийн механизм бий болгох алхамуудыг САЙШААН ДЭМЖИЖ,

Америк хоорондын хүний эрхийн комиссын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарчмын тухай Америк хоорондын тунхаглалыг ДЭМЖИЖ,

Нэр төр гутаахыг тодорхойлох нь: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ба нэр төрийг хамгаалах зарчим 19 зүйл баримт бичгийг БАТЛАН,

Арьсны үзэл, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, гадаадынхныг үзэн ядах, тэдгээртэй холбоотой бусад үл тэвчих үзлийн талаарх дэлхийн бага хуралд бэлтгэх үйл явцын хэсэг болгож Арьсны үзэл ба хэвлэл мэдээллийн тухай манай хамтарсан тунхаглал батлах зорилгыг МЭДЭГДЭЖ,

Дараах Тунхаглалыг БАТЛАВ:

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн чөлөөтэй урсгалд дэлхийн олон хэсэгт бий болсон хоёр аюул их хэмжээтэй боллоо:

- сэтгүүлчид болон илэрхийллийн эрх чөлөөг хэрэгжүүлж буй бусад этгээдийн эсрэг дайралтууд (алах аргаар цагдан хянах)
- нэр төр гутаахын эсрэг болон гүтгэлгийн эсрэг хориглосон хуулиудыг хэтрүүлж хэрэглэх явдал.

Алах аргаар тавьдаг хяналт

- Алах, хулгайлах, сүрдүүлэх зэргээр сэтгүүлчид, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг

хэрэгжүүлж буй бусад этгээдийн эсрэг дайралтууд, түүнчлэн холбооны хэрэгслийг сүйтгэх нь бие даасан, шалган тогтоох сэтгүүл зүй, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, олон нийтэд мэдээлэл чөлөөтэй очиход үлэмж аюул учруулж байна.

- Улс орнууд ял зэмлэлгүй өнгөрөх уур амьсгалыг эцэс болгох талаар зохих арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд тийм арга хэмжээ нь сэтгүүлчид, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлж буй бусад этгээдийн эсрэг дайралтаас сэргийлэхэд, тийм дайралт гарсан үед шалган тогтоох, буруутай этгээдүүдийг хариуцлагад татах, хохирогчдод хор уршгийг арилгахад хангалттай нөөц зориулж анхаарал хандуулах явдал хамаарна.

Нэр төр гутаах

- Бүх гишүүн орнууд нэр төр гутаахын эсрэг хуулиудаа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахгүй байх, өөрсдийн олон улсын чанартай үүрэгтээ нийцүүлэх үүднээс эргэн харах хэрэгтэй.
- Хамгийн наад зах нь гэхэд нэр төр гутаахын эсрэг хуулиуд дараахь жишигт нийцсэн байх хэрэгтэй
- эрүүгийн хуулиудыг иргэний хуулиудаар олон улсын жишигт нийцүүлэн солих боломжийг авч үзэх;
- Төр, далбаа, төрийн байгууллагууд, төрийн бүх төрлийн албан тушаалтнууд нэр төр гутаасан тухай хэрэг үүсгэх эрхгүй байх;
- нэр төр гутаахын эсрэг хуулиуд олон нийтэд ач холбогдолтой асуудлаар нээлттэй маргахын ач холбогдол, төрийн зүтгэлтнүүд иргэдтэй харьцуулахад илүү их шүүмжлэл хүлээн зөвшөөрөх шаардлагатай байх зарчмыг тусгасан байх; тухайлбал, ийм хуулиудаар төрийн зүтгэлтнүүдийг desacato хуулиуд зэрэг тусгай хамгаалалт тогтоосон хуулиудыг хүчингүй болгох;
- нэхэмжлэгч олон нийтэд хамааралтай асуудлаарх үйл баримтын талаарх аливаа тодорхойлолтын худал болохыг нотлох үүргийг хүлээнэ;
- хэнийг ч үзэл бодлоо илэрхийлсний нь төлөө нэр төр гутаасан хэрэгт хариуцлагад татаж үл болно; олон нийтэд хамааралтай асуудлаар хийсэн мэдэгдэлд нийтлэлийг бүх талаар боломжийн байсан гэдгийг нотлох нь өөрийгөө өмгөөлөх тайлбар байвал зохино;
- нэр төр гутаасанд хүлээлгэх иргэний шийтгэл нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлэхүйц хатуу байж болохгүй бөгөөд нэхэмжлэгчийн хор уршгийг нөхөх буюу хариуцагчийг шийтгэх бус харин гутаагдсан нэр төрийг сэргээхэд зориулсан байх; тухайлбал, төлүүлэхээр шийдвэрлэсэн хохирлын хэмжээ нь жинхэнэ учруулсан хохирлын хэмжээтэй тэнцвэртэй байх бөгөөд хууль мөнгөн төлбөрийн бус арга хэмжээг илүүд үздэг байх.

Үүний зэрэгцээ, гурван тусгай механизм нь мэдээллийн энэ шинэ хэрэгсэл, мэдээллийн чөлөөт урсгалыг дэлгэрүүлэхэд маш өндөр ач холбогдолтойг тэмдэглэн үүнийг дараагийн хамтарсан уулзалтын сэдэв болгох зорилготой болохоо илэрхийлэв.

*Үзэл бодол, түүнийг илэрхийлэх эрх чөлөөний НҮБ-ын Тусгай мэдээлэгч Абид Хуссейн
OSCE-ийн Хэвлэлийн эрх чөлөөний төлөөлөгч Фреймут Дюв
OAS-ын Хэвлэлийн эрх чөлөөний тусгай мэдээлэгч Сантьяго Кантон*

§ Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний гол асуудал, тулгамдсан асуудлын тухай мэдэгдэл

2000 оны 2-р сар

19-р зүйл байгууллагаас гаргав.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих олон улсын механизмын тухай 19-р зүйл байгууллагын семинарын нэр хүндтэй оролцогчид-Үзэл бодол, түүнийг илэрхийлэх эрх чөлөөний НҮБ-ын Тусгай мэдээлэгч, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөөлөгч, Үзэл бодлын эрх чөлөөний талаарх НҮБ-ын Тусгай мэдээлэгч, OAS-ын төлөөлөгч нар Лондонд 11-р сарын 25-26-нд уулзав.

Хүний эрхийн хувьд үзэл бодол, мэдээллийн эрх чөлөөний үндсэн ач холбогдлыг олон улсын байгууллага, шүүх, үүнд дараах мэдэгдлээр онцлон тэмдэглэв:

НҮБ-ын Ерөнхий Асамблейн:

“Мэдээллийн эрх чөлөө нь хүний үндсэн эрх бөгөөд НҮБ-ын бүх эрхэм эрх чөлөөний тулгуур чулуу мөн”.

Европын хүний эрхийн шүүхийн:

“Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ардчилсан нийгмийн зайлшгүй үндсийн нэг, түүний дэвшил, хүн бүрийн хөгжлийн үндсэн нөхцлийн нэг мөн”.

Америк хоорондын хүний эрхийн шүүхийн:

“Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ардчилсан нийгэм оршин тогтнодог тулгын чулуу мөн. Энэ нь олон нийтийн саналыг бий болгоход зайлшгүй шаардлагатай. Мэдээлэл муутай нийгмийг жинхэнэ чөлөөт нийгэм биш гэж хэлж болно”.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хамгийн чухал үнэ цэнэ нь суурь ардчилал, шийдвэр гаргахад олон нийт оролцдог явдал гэж хэлж болно. Мэдээллийг чөлөөтэй олж авахгүй, өөрийнхөө үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх эрхгүйгээр иргэд тэдний амьдралыг хөндсөн шийдвэр гаргахад оролцох нь байтугай зохих ёсоор сонгуульд саналаа өгч чадахгүй. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хүн бүрт байдаг эрх чөлөө мөн. Үүний зэрэгцээ дэлхийн олон бүс нутаг, оронд энэ эрх чөлөөнд нийтийн болон хувийн хүчин зүйлээс олон аюул учирч байна. Шинэ мянган ойртож даяарчлалын үйл явц эрчимжиж байгаа энэ үед интернет, нэвтрүүлэг дамжуулах тоон технологи зэрэг шинэ бололцоо, мөн хэвлэл мэдээллийн дэлхийн монополиуд, нийтийн нэвтрүүлгийн эсрэг дайралт зэрэг шинэ аюул бий болов.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэлгэрүүлэх олон улсын механизмын талаарх семинарт оролцогчид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд бий болсон шинэ бололцоо, шинэ аюулыг харгалзан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хэд хэдэн гол асуудал, түүнчлэн тусгай механизмын чадавхийг дээшлүүлэх хэд хэдэн арга замыг тодорхойлов.

ГОЛ АСУУДАЛ

Энэ баримт бичигт дор дурдсан гол асуудлууд авч үзэв:

- Олон нийтийн хэв журам ба үндэсний аюулгүй байдал
- Эрүүгийн чанартай үйлдлийн талаарх хязгаарлалтууд

-
- Нэр төр гутаахын эсрэг иргэний хуулиуд
 - Хэвлэл мэдэллийн ажилтнуудын эсрэг дайралтууд
 - Албан бус хяналт
 - Мөргөлдөөний талаар мэдээлэх нь
 - Эдийн засгийн арга хэмжээ
 - Үзэн ядах агуулгатай үг
 - Жендерийн тэгш байдал
 - Мэдээллийн эрх чөлөө
 - Нууцлал
 - Эх сурвалжууд
 - Шинэ технологи
 - Хэвлэл мэдээллийн төрийн зохицуулалт
 - Хэвлэл мэдээллийн монополиуд
 - Төрийн санхүүжилттэй нэвтрүүлэг
 - Сонгуулийг мэдээлэх
 - Үндэстний цөөнх ба хэвлэл мэдээлэл
 - Хүүхэд ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
 - Механизмуудын чадавхийг дээшлүүлэх нь

Олон нийтийн хэв журам ба үндэсний аюулгүй байдал

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг олон нийтийн хэв журам, үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар гагцхүү хууль ёсны сонирхолд хохирол учруулах бодит аюул байгаа тохиолдолд хязгаарлаж болно.

Олон нийтийн хэв журам ба үндэсний аюулгүй байдлын тусын тулд үйлчлэх хязгаарлалтууд нь ихэнхдээ хэт өргөн хүрээтэй, тодорхой бус байдаг. Ийм хязгаарлалтыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хэт сөрөг нөлөө үзүүлэхгүй байлгахын тулд Йоханнесбургийн зарчмуудаар тогтоосон болон дараахь нөхцөлийг биелүүлээгүй бол тавьж болохгүй, үүнд:

- зайлуулах боломжгүй хор уршиг учирч болзошгүй
- ноцтой хор уршиг, үүнд хүчирхийлэл буюу бусад хууль бус үйлдэл гарч болзошгүй
- хор уршгийн аюул, үзэл бодлоо илэрхийлэхийн хооронд тохиолдлын нягт шалтгаант холбоотой
- үзэл бодлоо илэрхийлсэн нь хор уршиг учруулах зорилготой байсан.

Эрүүгийн шинжтэй агуулгын талаарх хязгаарлалтууд

Үзэл бодлоо илэрхийлснийг ноцтой хор уршиг учруулах бодит аюулгүй бол эрүүгийн гэмт хэрэгт тооцож үл болно.

Хэвлэмэл материалтай холбоотой гэмт хэрэгт эрүүгийн ял оногдуулах нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд үлэмж сөрөг нөлөө үзүүлдэг. Үүний жишээ бол олонхи тохиолдолд эрүүгийн шийтгэл хүлээлгэдэг худал мэдээ нийтлэхийг хориглосон, мөн засгийн эсрэг

сурталчилгааг хориглосон хуулиуд юм. Ийм хуулиудыг хүчингүй болгох нь зүйтэй. Зарим тохиолдолд хуулиудыг хэт өргөн томъёолж үзэл бодлоо хор учруулахааргүй илэрхийлэхийг хүртэл хориглосон байдаг. Үүний түгээмэл жишээ нь төр, засгийг доромжлох, садар самууны эсрэг хуулиуд юм. Ийм хуулиудыг хууль ёсны сонирхолд илт ноцтой хор уршиг учруулах аюултай тохиолдлуудад түүний хүрээг хязгаарлаж өөрчлөх нь зүйтэй.

Хорих ял

Үзэл бодлоо илэрхийлсэнтэй холбоотой гэмт хэрэгт хорих ялыг хамгийн ноцтой тохиолдолд оногдуулвал зохино.

Үзэл бодлоо илэрхийлсэнтэй холбоотой гэмт хэрэгт хорих ял оногдуулахыг хүндэдсэн ял гэж үздэг.

Нэр төр гутаах

Нэр төр гутаахын эсрэг хуулиудыг хүчингүй болговол зохино. Нэр төр гутаахын эсрэг хуулиуд, үүний дотор төрийн тэргүүн болон бусад төрийн зүтгэлтнийг онцгой хамгаалалтад байлгахаар заасан бусад хуулиуд нь нэр хүндийг хамгаалахад шаардлагагүй юм. Эрүүгийн ял буюу хорих, торгууль, түүнчлэн дахин зөрчил гаргавал хорих ял эдлүүлэх нөхцөлтэй ял хойшлуулах нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд үлэмж сөрөг нөлөө үзүүлдэг. Нэр төр гутаахын эсрэг хуулиудыг олон нийтийн сонирхолтой холбоогүй буюу эцсийн арга хэмжээ болгож хэрэглэхийн оронд анхны арга хэмжээ болгох зэргээр урвуулан хэрэглэх нь олонтаа тохиолддог. Эрүүгийн гүтгэхийн эсрэг хуулиудыг хүчингүй болгож оронд нь иргэний зохих хуулиуд батлавал зохино.

Нэр төр гутаахын эсрэг иргэний хуулиуд

Эрүүгийн хуулиудыг хүчингүй болговол зохино.

Нэр төр гутаахын эсрэг иргэний хуулиудад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг харгалзан үзвэл зохино

Нэр төр гутаахын эсрэг иргэний хатуу хуулиуд хяналтын илүү илэрхий хэлбэрийн оронд хэрэглэж засгийн газар, улс төрчид, эрх мэдэлтнүүдийг нээлттэй шүүмжлүүлэхгүй байж чаддаг. Нэр төр гутаахын эсрэг иргэний хуулиудад дараахь зарчмыг хүндэтгэх хэрэгтэй:

- төрийн байгууллагууд нэр төр гутаасан тухай хэрэг үүсгэх эрхгүй байх
- үнэн зөв нь ямагт өмгөөлөх хэрэгсэл болж байх
- улс төрчид ба төрийн албан тушаалтнууд илүү их шүүмжлэлийг тэвчдэг байх
- олон нийтийн сонирхлыг татсан бөгөөд бүх талаар боломжийн нийтлэлийг нэр төр гутаасан гэж үзэхгүй
- төлүүлэхээр шийдвэрлэсэн хохирлын хэмжээ нь бодит учруулсан хохиролтой дүйцэж байх бөгөөд уучлалт гуйх болон учруулсан хохирлыг нөхөх зэрэг сонгон хэрэглэх арга хэмжээг харгалзсан байвал зохино.

Хэвлэл мэдээллийнхний эсрэг дайралтууд

Хэвлэл мэдээллийнхний эсрэг дайрагчдыг хариуцлагад татах ёстой

Сэтгүлчид болон хэвлэл мэдээллийн бусад ажилтны эсрэг үйлддэг дайралт, сүрдүүлэг нь бие даасан, шалган тогтоох сэтгүүл зүй, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, олон

нийтэд мэдээлэл чөлөөтэй хүрэхэд үлэмж аюул учруулдаг. Засгийн газар, төрийн албан тушаалтнууд ийм дайралтад хамтрах нь эрх мэдлээ ноцтой урвуулсан хэрэг мөн. Засгийн газрууд ял зэмлэлгүй байх уур амьсгалыг эцэс болгох, сэтгүүлчдийг дайрсан гэм буруутай этгээдүүдийг хариуцлагад татахад хангалттай нөөц, анхаарал хандуулвал зохино.

Албан бус хяналт

Төрийн албан тушаалтнууд материал хэвлүүлэгчдэд нөлөөлөх буюу шахалт үзүүлэхгүй байвал зохино

Албан бус хяналт нь утасдахаас авахуулаад биеэр дайрах хүртэл төрийн албан тушаалтны олон янзын үйлдэл байдаг. Ямар хэлбэрээр илрэхээсээ үл хамааран албан бус хяналт нь албан хяналтын адил хүлээн зөвшөөрөх боломжгүй зүйл юм.

Мөргөлдөөний талаар мэдээлэх

Хэвлэл мэдээллийнхнийг мөргөлдөөний талаар мэдээлэхийг хориглохгүй байвал зохих бөгөөд тэдний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах ёстой.

Мөргөлдөөн нь олон нийтийн анхаарлыг заавал татаж хүний эрхийн ба хүмүүнлэгийн үндсэн асуудал тавьдаг. Ийм нөхцөл байдалд олон нийтийн хяналт байх нь эрх хэмжээг хэтрүүлэхээс сэргийлэх, ил тод байдлыг дэмжихэд зайлшгүй юм. Хэвлэл мэдээллийнхнийг мөргөлдөөний талаар мэдээлэхийг хориглох нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон олон нийтийн мэдэж байх эрхийг ноцтой хязгаарласан хэрэг мөн бөгөөд бусдын аюулгүй байдалд илт аюул учруулснаас бусад тохиолдолд хэрэглэхгүй байвал зохино. Хэвлэл мэдээллийнхнийг оролцуулахгүй байхын оронд эрх баригчид боломжтой тохиолдол бүрт мөргөлдөөнт цэгт ажиллаж байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хангах талаар зохих арга хэмжээ авбал зохино.

Эдийн засгийн арга хэмжээ

Эдийн засгийн арга хэмжээг редакторын хараат бус байдалд нөлөөлөх буюу хөндлөнгөөс оролцоход ашиглаж болохгүй

Тодорхой хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу үзэл бодлыг дэмжих эсхүл дарахад чиглэсэн эдийн засгийн арга хэмжээ, “бүтцийн хяналт” гэж нэрлэдэг, үүний дотор засгийн газрын зар сурталчилгааг байрлуулах, засгийн газраас хэвлэх, борлуулах сүлжээ байгуулах буюу шинэ сонин хэвлэхэд хяналт тавих, мөн татварыг ялгамжтай хэрэглэх нь засгийн газраас үзэл бодлыг илэрхийлэх эрх чөлөөнд байж болшгүйгээр хөндлөнгөөс оролцох явдал мөн бөгөөд зогсоовол зохино. Нөгөө талаар, улс орнууд олон нийтэд янз бүрийн мэдээлэл, өөр өөр үзэл санаа хүргэж чадах төрөл бүрийн, олон ургальч хэвлэл мэдээлэл хөгжих орчинг дэмжих арга хэмжээ авбал зохино.

Үзэн ядах агуулгатай үг хэлэх

Төрийн байгууллагууд бүлэг хүмүүсийн хооронд үл тэвчих, үзэн ядах үзлийг дэвэргэхэд хэвлэл мэдээллийг ашиглаж болохгүй

Тодорхой бүлэг хэсгийн эсрэг арьсны үзэл, үзэн ядалт болон эдгээрээс үүсдэг үйлдэл нь тэдгээрийн бай болдог хүмүүсийн эрхээ эдлэхэд хамгийн залт бөгөөд тархсан аргууд мөн. Үүний хамгийн ноцтой жишээ нь үй олноор устгах буюу арьсны өнгөөр ялгаварлах үзэл бүхий дайралтыг сурталчлахад хэвлэл мэдээллийг ашиглах явдал юм. Төрийн

байгууллагууд бүлэг хүмүүсийн дунд үл тэвчих буюу үзэн ядах үзлийг сурталчлахад хэвлэл мэдээллийг ашиглаж болохгүй.

Жендерийн тэгш байдал

Хэвлэл мэдээлэлд эмэгтэйчүүд адил тэгш хүртээмжтэй, төлөөлөлтэй байхыг дэмжих ёстой.

Хэвлэл мэдээлэлд эмэгтэйчүүд адил тэгш хүртээмжтэй, төлөөлөлтэй байх нь эмэгтэйчүүдийн санаа зовоож байгаа асуудлыг зохих ёсоор тусгахад чухал юм. Энэ нь эмэгтэйчүүд шийдвэр гаргахад бүрэн оролцоход болон тэднийг ялгаварлан гадуурхахтай тэмцэхээр зогсохгүй үр дүнтэй, тогтвортой хөгжилд зайлшгүй юм. Төрийн байгууллагууд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахтай тэмцэх, эмэгтэйчүүдийг хэвлэл мэдээлэлд оруулах талаар үр нөлөөтэй арга хэмжээ авах ёстой.

Мэдээллийн эрх чөлөө

Эрх баригчид төрийн байгууллагуудад байгаа мэдээллийг авах талаар хууль тогтоомж батлан гаргах ёстой.

Мэдээллийн эрх чөлөө нь нээлттэй, ардчилсан засгийн газар, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд чухал. Эрх баригчид энэ эрхийг хэрэгжүүлэх хууль тогтоомж батлан гаргавал зохих бөгөөд уг хууль тогтоомж нь Олон нийтийн мэдэх эрх: Мэдээллийн эрх чөлөөний талаарх хууль тогтоомжийн зарчим-д заасан зарчимд нийцэж байх ёстой, үүнд:

- хууль тогтоомж нь аль болох ихийг ил болгох зарчмын баримтлах;
- төрийн байгууллагууд гол мэдээллийг нийтлэх үүрэгтэй байх;
- төрийн байгууллагууд нээлттэй засгийн газрыг сурталчлах ёстой;
- үл хамаарах тохиолдлыг тодорхой бөгөөд нарийн хүрээтэй тодорхойлж “хор уршиг”, “олон нийтийн сонирхол”-ын шалгууртай байх;
- хувь хүн мэдээллийг ил болгохыг татгалзсанд хараат бус захиргааны байгууллагад гомдол гаргах эрхтэй байх бөгөөд уг байгууллага нь шударга, шуурхай бөгөөд зардал багатай ажилладаг байх;
- буруу үйл ажиллагааны тухай мэдээлэгчдийг хууль тогтоомжоор хамгаалдаг байх.

Нууц байдал

Нууцыг хамгаалсан хуулиуд нь олон нийтийн сонирхлын үүднээс шалган сурвалжлахад саад болж болохгүй.

Нууцлалыг, ялангуяа хувь хүмүүсийн хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохоос хамгаалахыг хүний эрхэд тооцдог. Олон улсад хувь хүнийг тэдний нууцыг зөрчдөг хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг засгийн газрын бус этгээдээс хамгаалсан хуулиуд баталсан байдаг. Ийм хууль батлахыг авч үзэхдээ авилгал, хууль бус ажиллагааг ил болгох шалган сурвалжлахыг шаардлагагүй байхад хязгаарлахгүй байхыг анхаарах хэрэгтэй.

Эх сурвалж

Сэтгүүлчдийг нууц эх сурвалжаа мэдэгдэхийг шаардаж болохгүй.

Нууц эх сурвалжийг хамгаалах нь зөвхөн мэдээллийг сэтгүүлчдэд чөлөөтэй очдог байлгахын тулд бус сэтгүүлчдийн аюулгүй байдлын тулд зайлшгүй юм. Сэтгүүлчдийг

эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтад буюу гэмт хэрэгт яллагдаж байгаа хүнийг хамгаалахад шаардлагатайгаас бусад үед, шүүхээс тийнхүү шийдвэрлэсэн бөгөөд тэднийг өөрийнхөө тайлбарыг өгөх бололцоо олгосноос бусад тохиолдолд эх сурвалжаа мэдэгдэхийг шаардаж болохгүй. “Шаардлагатай” гэдэг нь мэдээллийг өөр газраас олж авах боломжгүй, уг мэдээлэл нь онцын чухал бөгөөд түүнийг ил болгох олон нийтийн сонирхол нь тийнхүү ил болгосноос учирч болох хор уршгаас илтэд давж байхыг хэлнэ.

Шинэ технологи

Хууль дүрэм нь шинэ технологийн мэдээлэл олон янзын байх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүчин чадлыг бууруулж болохгүй.

Интернет, хиймэл дагуулын болон нэвтрүүлэг дамжуулах тоон технологи зэрэг шинэ технологи үзэл бодол, мэдээллийн эрх чөлөөг нэмэгдүүлэх, дэлхий дээр мэдээлэл солилцоход урьд өмнө байгаагүй илүү өргөн боломж олгодог. Эдгээр технологийг ашиглаж хортой буюу хууль бус мэдээлэл дамжуулахыг хязгаарлах гэсэн үйл ажиллагааг авсан арга хэмжээ нь уг технологийн асар их эерэг хүчин чадлыг сааруулахгүй байхгүйг харгалзсан байх хэрэгтэй.

Хэвлэл мэдээллийн төрийн зохицуулалт

Хэвлэл мэдээллийг төрийн зохицуулалт, улс төрийн шинжтэй хөндлөнгийн оролцооноос хараат бус байлгах бөгөөд хэвлэлийн эрх чөлөөнд шаардлагагүй хязгаарлалт тогтоохгүй байвал зохино

Засгийн газраас хэвлэмэл хэвлэл мэдээллийн хэрэгсэлд оролцох явдлыг боломжтой болгодог буюу хэвлэмэл материалд эсхүл хэвлэл мэдээллийн ажиллагаанд хууль бус хязгаарлалт тогтоодог хэвлэлийн хуулиудыг хүлээн зөвшөөрч болно. Хэвлэл мэдээлэл, үүнд хэвлэмэл буюу нэвтрүүлэг дамжуулахыг аль алиныг нь зохицуулах эрх бүхий бүх байгууллага засгийн газраас бүрэн хараат бус байвал зохино. Лиценз хүссэн өргөдлийг нээлттэй, ил тод хянан шийдвэрлэж, шийдвэрийг олон нийтийн мэдэж байх эрхийн үүднээс урьдчилан тогтоосон шалгуурын үндсэн дээр гаргаж байвал зохино. Үүнээс гадна нэвтрүүлэг зохицуулдаг эрх бүхий байгууллагын эрх хэмжээ лиценз олгох, гомдол шийдвэрлэхээр хязгаарлагдсан байвал зохино.

Хэвлэл мэдээллийн монополиуд

Засгийн газрууд хэвлэл мэдээлэлд монополиос тавих хэт хяналтаас сэргийлэх арга хэмжээ авбал зохино.

Хэвлэл мэдээллийн монополиуд олон нийтийн олон янзын эх сурвалжаас мэдээлэл авах эрхийг хязгаарладаг. Нийтийн нэвтрүүлэг дамжуулах монополиуд олон нийтийн сонирхолд үйлчилдэггүй учир тэдгээрийг тогтоохгүй байвал зохино. Гэхдээ зарим жижиг зах зээлд монополи сонин нь орон нутгийн мэдээ олж авах цорын ганц арга байх явдал бий. Монополийн тухай журмыг материалын олон ургальч чанарыг хангах, засгийн газруудад хэвлэл мэдээлэлд хөндлөнгөөс оролцох бололцоо олгохгүй байхаар боловсруулсан байвал зохино.

Төрийн санхүүжилттэй дамжуулах станциуд

Төрийн санхүүжилттэй нэвтрүүлэг дамжуулагчид засгийн газраас бүрэн хараат бус байж зохих ёсоор санхүүжүүлсэн, олон төрөлт байдал, олон ургальч үзлийг хөгжүүлж байх ёстой

Нийтийн нэвтрүүлэг дамжуулагчид олон төрөлт байдлыг хөгжүүлэх, нийгмийн бүх бүлэг хэсгийн сонирхолд үйлчилдэг хөтөлбөр байлгах явдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Ийм нэвтрүүлэг дамжуулагчдыг засгийн газар хянах нь эдгээр зорилго, олон нийтийн тэцвэртэй, бодитой, олон төрлийн мэдээлэл авах эрхийг хязгаарладаг. Нийтийн нэвтрүүлэг дамжуулагчдын бие даасан байдлыг хууль тогтоомжоор болон практик дээр хангасан байх ёстой. Үүнээс гадна тэднийг зохих ёсоор санхүүжүүлж мэдээ, бусад нэвтрүүлгийн хувьд редакторууд бие даасан байдалтай байх ёстой.

Сонгуулийн талаар мэдээлэх

Нийтийн хэвлэл мэдээлэл нь сонгуулийн талаар тэнцвэртэй, бодитой мэдээлэх ёстой

Сонгуулийн өмнөх хугацаанд нийтийн хэвлэл мэдээллээр олон нийтэд тэнцвэртэй бөгөөд бодитой мэдээлэл, үүнд намууд, нэр дэвшигчид, сонгогчдын боловсролын талаар өгөх ёстой. Мэдээ, ярилцлага, сонгуулийн хөтөлбөрүүд нэг талыг барьсан байж болохгүй бөгөөд улс төрийн намуудад нэвтрүүлгийн цагийг шударгаар, ялгаварлан гадуурахгүй тэнцвэртэй хуваарилах ёстой. Хөтөлбөрийг зохиохдоо олон нийт, намууд, нэр дэвшигчдийн талаар хангалттай мэдээлэлтэй байж энэ нь сонгуулийн сонголтоо мэдээлэлтэйгээр хийх явдлыг хангасан байх хэрэгтэй.

Үндэстний цөөнх ба хэвлэл мэдээлэл

Үндэстний цөөнхийг ялгаварлан гадуурхахгүйгээр хэвлэл мэдээлэл хүртэх явдлыг хангах ёстой

Улс орнууд үндэстний цөөнхийг ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх үр нөлөөтэй арга хэмжээ авах ёстой. Энэ нь, жишээлбэл, зохицуулах байгууллагын удирдах зөвлөлүүд төлөөлөлтэй байх бөгөөд зохицуулалт нь шууд буюу шууд бусаар үндэстний цөөнхийг хэвлэл мэдээллийн цэг өмчлөх, ажиллуулахгүй байлгаж болохгүй. Нийтийн нэвтрүүлэг дамжуулагчид тэвчих үзлийг дэлгэрүүлэх, тэдний ажиллагсад нийгмийг бүхэлд нь төлөөлж байх явдлыг хангах, үндэстний цөөнхийн хэрэгцээнд үйлчлэх, үндэстний цөөнхөд зохих хүртээмж, ил байдлыг хангахуйц хөтөлбөр гаргаж байх.

Хүүхэд ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө

Хүүхдийн үзэл бодлоо сонгох эрх зэрэг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүрэн хүндэтгэх ёстой

Хүүхдийн эрхийн тухай конвенци хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхээс гадна тэдний хүүхдийн үзэл бодлоо сонгох эрх, тэдэнд хамааралтай асуудалд зохих ач холбогдол өгүүлэх эрхийг тогтоосон байна. Улс орнууд хүүхэдэд хамааралтай асуудлаар нийтийн шийдвэр гаргахад, жишээлбэл, боловсрол, эрүүл мэнд, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбарт хувь нэмрээ оруулах явдлыг хангах арга хэмжээ авах ёстой.

МЕХАНИЗМЫН ЧАДАВХИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Сүлжээ байгуулах

Тусгай механизм ба ТББ-дыг оролцуулсан сүлжээнүүд нь механизмын үр нөлөөг дээшлүүлэх гол хэрэгсэл мөн.

Сүлжээнүүд механизмын зорилгыг сурталчлах чухал хэрэгсэл болох нь хэд хэдэн шалтгаантай. Сүлжээнүүд мэдээллийн хоёр чиглэлд явах урсгалыг нэмэгдүүлж хамтын арга хэмжээ, лобби ажиллагааг дэмждэг. ТББ-ууд цаг тухайд нь мэдээлэл өгөх болон бусад байдлаар механизмыг дэмжиж механизмууд ТББ-уудын үйл ажиллагааны ач холбогдлыг дээшлүүлнэ. Одоо байгаа сүлжээг цаашид хөгжүүлэх, сүлжээ байхгүй газарт шинээр байгуулах шаардлагатай.

Шинэ механизмууд хөгжүүлэх

Одоогийн байдлаар Европ, Америкт байгаа бүс нутгийн механизмуудыг бусад бүс нутагт дэлгэрүүлэх хэрэгтэй байна.

Бүс нутгийн механизмууд нь НҮБ-ын Тусгай мэдээлэгчийн ажилд чухал нэмэлт болдог ба бүх бүс нутагт, үүний дотор Африкийн эв нэгдлийн байгууллага (ОАУ), Зүүг Омнөд Азийн улсуудын нийгэмлэг (ASEAN), Арабын улсуудын нийгэмлэгт дэлгэрүүлвэл зохино.

Нөөц

Тусгай механизмууд үр дүнтэй ажиллахын тулд зохих нөөц шаардлагатай

Тусгай механизмууд хамгийн гол нь улс орнууд, тэдний ивээн тэтгэгч улс хоорондын байгууллагуудын боловсон хүчнээр хангах, захиргааны дэмжлэг үзүүлэх, тодорхой үйл ажиллагааг санхүүжүүлэх талаар хэр зэрэг өгөөмөр байхаас хамаардаг. Онгөрсөн үед механизмуудад зохих нөөц олгоогүйгээс тэдгээрийн ажлын үр дүнг буурч байв. Улс орнууд ба ивээн тэтгэж буй олон улсын засгийн газар хоорондын байгууллагууд тусгай мандатууд зохих нөөцтэй байх явдлыг хангах ёстой.

Механизм хоорондын хамтын ажиллагаа

Оөр өөр механизмууд хоорондоо хамтарч ажиллах нь тэдний ажлын уялдаа холбоог хөгжүүлж үр дүнг дээшлүүлэх боломжтой. Хамтын ажиллагааны дараахь арга хэмжээ байж болно:

- хамтарсан байр суурь, хөтөлбөр боловсруулах байнгын ажлын хэсэг байгуулах;
- төлөөлөгчид мэдээлэл солилцох, явагдаж байгаа ажил, хамтын ажиллагааны цаашдын боломжийн талаар ярилцах;
- бусад төлөөлөгчдийн тайланг өөрсдийн ивээн тэтгэгч байгууллагад танилцуулах;
- бусад төлөөлөгчдийн тайлан, мэдэгдэлд өөрийн лобби ба тайлан бичих үйл ажиллагаандаа үндэслэх;
- хамтарсан мэдэгдэл гаргах;
- бусад шинэлэг хамтарсан үйл ажиллагааг тодорхойлох.

Орчуулсан Ж.Туул

§ Йоханнесбургийн зарчмууд: Үндэсний аюулгүй байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хүртээмж

1996 оны 11-р сар

Дугаар 3

Энэ баримт бичгийг анх 1995 оны 10-р сард 19 зүйл байгууллага, Хэвлэлийн хяналтын эсрэг олон улсын төвөөс зохион байгуулсан зөвлөлгөөний дараа Йоханнесбург дахь Витвотерсрэндийн Их сургуулийн Салбар эрх зүйн төвтэй хамтран хэвлэв.

I. ЕРӨНХИЙ ЗАРЧМУУД

- 1-р Зарчим: Үзэл бодлын эрх чөлөө, түүнийг илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө
- 1.1.Зарчим: Хуульд заасан
- 1.2.Зарчим: Үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалах нь
- 1.3.Зарчим: Ардчилсан нийгэмд шаардлагатай
- 2-р Зарчим: Үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхол
- 3-р Зарчим: Онц байдал
- 4-р Зарчим: Ялгаварлан гадуурхахыг хориглох

II. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ БУЮУ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТУУД

- 5-р Зарчим: Үзэл бодлыг хамгаалах нь
- 6-р Зарчим: Үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болзошгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх
- 7-р Зарчим: Үзэл бодлоо илэрхийлэхийг хамгаалах нь
- 8-р Зарчим: Үйл ажиллагаа нээлттэй байх нь дангаараа үндэсний аюулгүй байдалд аюул учруулах
- 9-р Зарчим: Үндэстний цөөнхийн буюу бусад хэл ашиглах
- 10-р Зарчим: Гуравдагч этгээдээс үзэл бодлоо илэрхийлэхэд хууль бусаар хөндлөнгөөс оролцох

III. МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХЯЗГААРЛАХ

- 11-р Зарчим: Мэдээлэл авах эрхийн ерөнхий зарчим
- 12-р Зарчим: Аюулгүй байдлын шалтгаанаар үл хамаарахыг тохиолдлын нарийн хүрээтэй тодорхойлох
- 13-р Зарчим: Ил болгох олон нийтийн сонирхол
- 14-р Зарчим: Мэдээлэл өгөхөөс татгалзсаныг бие даан авч үзэх эрх
- 15-р Зарчим: Нууц мэдээллийг ил болгох ерөнхий дүрэм
- 16-р Зарчим: Төрийн албанаас олж авсан мэдээлэл
- 17-р Зарчим: Олон нийтийн хүрээний мэдээлэл
- 18-р Зарчим: Сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах

-
- 19-р Зарчим: Хориотой газруудад нэвтрэх
20-р Зарчим: Хуулиар хамгаалах ерөнхий журам
21-р зарчим: Зөрчигдсөн эрхийг сэргээх хэрэгслүүд
22-р зарчим: Хараат бус шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх эрх
23-р зарчим: Урьдчилсан хяналт
24-р зарчим: Тохироогүй шийтгэл
25-р зарчим: Эдгээр зарчим, бусад жишгийн хоорондын холбоо

ОРШИЛ

Эдгээр Зарчмуудыг 1995 оны 10-р сард 19-р зүйл байгууллага, Хэвлэлийн цагдан хяналтын эсрэг олон улсын төв (International Centre against Censorship) олон улсын эрх зүй, үндэсний аюулгүй байдал, хүний эрхийн мэргэжилтнүүдээс Йоханнесбург дахь Витвотерсэндэйн Их сургуулийн Салбар эрх зүйн төвтэй хамтран батлав.

Зарчмуудыг олон улсын ба бүс нутгийн эрх зүй, хүний эрхийг хамгаалах жишиг, үүсч байгаа төрийн практик (дотоодын шүүхийн шийдвэрүүдэд тусгагдсан зэрэг), олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн ерөнхий зарчмуудад үндэслэв.

Эдгээр Зарчмууд нь Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хязгаарлалт, хэсэгчлэн хүчингүй болгосон заалтын Сиракузын Зарчмууд, Онц байдлын үе дэх хүний эрхийн Парисын хэм хэмжээний наад захын жишиг үргэлжлэн үйлчлэхийг тэмдэглэж байна.

УДИРТГАЛ

Энэхүү Зарчмуудыг боловсруулахад оролцогчид:

Нэгдсэн үндэстний байгууллагын Дүрэмд тунхагласан зарчимд зааснаар хүн төрөлхтөний бүх гишүүний угаас заяасан нэр төр, тэгш бөгөөд салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, дэлхийн энх тайвны үндэс болохыг ХАРГАЛЗАН,

Хүмүүс дарангуйлал, дарлалын эсрэг эцсийн арга хэмжээ болгож бослого гаргахгүй бол хүний эрхийг хуулиар хамгаалах ёстой гэдэгт ИТГЭЛТЭЙ БАЙЖ,

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө нь ардчилсан нийгэмд амин чухал, түүний хөгжил дэвшил, сайн сайхан, түүнчлэн хүний бусад эрх, үндсэн эрх чөлөөг эдлэхэд зайлшгүй шаардлагатайг ДАХИН БАТАЛЖ,

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенци, Шүүхийн хараат бус байдлын үндсэн зарчмууд, Хүний ба ард түмнүүдийн эрхийн тухай Африкийн дүрэм, Хүний эрхийн тухай Америкийн конвенци, Хүний эрхийн тухай Европын конвенцийн холбогдох заалтыг ХАРГАЛЗАН,

Хүний эрхийн болон үндсэн эрх чөлөөний ихэнхи хамгийн ноцтой зөрчлийг засгийн газрууд үндэсний аюулгүй байдлыг хамгаалах шаардлагаар зөвтгөдгийг ТОДОРХОЙ МЭДЭЖ,

Ард түмэн өөрийн засгийн газрын үйл ажиллагааг хянаж ардчилсан нийгэмд бүрэн оролцох бололцоотой байгаа бол тэд засгийн газрын мэдэлд байгаа мэдээлэлтэй танилцах заавал бололцоотой байх ёстойг САНАН,

Засгийн газруудыг үндэсний аюулгүй байдлаар шалтаглан эдгээр эрх чөлөөг эдлэх явдлыг үндэслэлгүйгээр хязгаарлуулахгүй байхын тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөөнд үндэсний аюулгүй байдлын сонирхлын үүднээс тавьж болох хязгаарлалтын хүрээ бага байх ёстойг хүлээн зөвшөөрөх явдлыг дэмжихийг ХҮСЧ,

Эдгээр эрх чөлөөг эрх зүйн хэрэгслээр, нарийн боловсруулсан, хууль дээдлэх зарчмын байвал зохих шаардлагыг хангасан хуулиудаар хамгаалах шаардлагатайг ХҮЛЭЭН ЗОВШООРЧ,

Эдгээр эрх чөлөөг хараат бус шүүхээр хамгаалах шаардлагатайг ТЭМДЭГЛЭН,

Дараах Зарчмуудыг БАТАЛЖ, үндэсний, бүс нутгийн ба олон улсын түвшинд зохих байгууллагуудад эдгээрийг өргөн тараах, зөвшөөрөх, хэрэгжүүлэх явдлыг дэмжих арга хэмжээ авахыг зөвлөж байна.

1. ЕРӨНХИЙ ЗАРЧМУУД

1-р Зарчим: үзэл бодлын эрх чөлөө, түүнийг илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө

- (а) Хүн бүр үзэл бодлоо хөндлөнгийн оролцоогүй илэрхийлэх эрхтэй.
- (б) Хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, үүнд төрөл бүрийн мэдээлэл, санааг амаар болон бичгээр, хил хязгаар харгалзахгүйгээр урлагийн буюу өөрийн сонгон авсан бусад хэлбэрээр хүлээж авах, бусадтай хуваалцах эрхтэй.
- (в) Энэ зүйлийн (б)-д заасан эрхийг эдлүүлэхийг олон улсын эрх зүйгээр тогтоосон тодорхой үндэслэлээр, түүний дотор үндэсний аюулгүй байдлыг хамгаалах үндэслэлээр хязгаарлаж болно.
- (г) засгийн газар, хязгаарлалтыг хуулиар тогтоосон бөгөөд тэр нь ардчилсан нийгэмд үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалахад шаардлагатай гэдгийг нотолж чадсанаас бусад тохиолдолд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө буюу мэдээллийн эрх чөлөөнд үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар хязгаарлалт тогтоож болохгүй. Хязгаарлалт үндэслэлтэй болохыг нотлох үүргийг засгийн газар хүлээнэ.

1.1-р Зарчим: Хуульд заасан байх

- (а) үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө буюу мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалт бүрийг хуулиар тогтоосон байвал зохино. Хууль нь олж танилцах боломжтой, бүрхэг бус, нарийн, хувь хүн тодорхой аль нэг үйлдлийг хууль бус болохыг урьдаас мэдэх боломжтойгоор бичигдсэн байвал зохино.
- (б) Хуульд эрх хэмжээг хэтрүүлэхийн эсрэг зохих хамгаалалт, үүний дотор хязгаарлалт үндэслэлтэй эсэхийг хараат бус шүүх буюу трибуналаар хянаж байх тухай заасан байвал зохино.

1.2 Зарчим: Үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалах нь

Үндэсний аюулгүй байдлын үүднээс засгийн газраас зөвтгөх гэж буй үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө буюу мэдээллийн эрх чөлөөний аливаа хязгаарлалт нь үндэсний

аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалах жинхэнэ зорилго, нотлохуйц үр дүнтэй байх ёстой.

1.3 Зарчим: Ардчилсан нийгэмд шаардлагатай

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө буюу мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалахад шаардлагатай болохыг тогтоохын тулд засгийн газар дор дурдсаныг нотлох ёстой:

- а) тухайн асуудлаар мэдээлэл илэрхийлэх нь үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхолд ноцтой аюул учруулж байгаа;
- б) тогтоосон хязгаарлалт нь уг сонирхлыг хамгаалахад байж болох хамгийн наад захын арга хэмжээ мөн;
- в) хязгаарлалт нь ардчилсан зарчимд нийцэж байгаа.

2-р Зарчим: Үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхол

- а) Зөвтгөх гэж буй үндэсний аюулгүй байдлын сонирхол нь түүний жинхэнэ зорилго буюу нотолж болохуйц үр дүн нь үндэсний аюулгүй байдалтай холбоогүй, жишээлбэл, засгийн газрыг эвгүй байдалд орох буюу буруу үйл ажиллагааг нийтэд илэрхий болохоос хамгаалах, түүний төрийн байгууллагуудын ажиллагааны тухай мэдээллийг нуух, эсхүл тодорхой нэгэн үзэл суртлыг нуух, эсхүл хувь хүний дургүйцлыг дарахад чиглэгдсэн байвал хууль ёсны бус байна.

3-р Зарчим: Онц байдал

Албан ёсоор, хууль ёсоор дотоодын ба олон улсын эрх зүйн дагуу тунхагласан улсын оршин тогтноход аюул учруулж буй нийтийн онц байдлын үед төр үзэл бодлоо илэрхийлэх буюу мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж болох боловч зөвхөн тухайн нөхцөл байдалд шаардлагатай хэмжээнд, олон улсын эрх зүйн дагуу засгийн газрын хүлээсэн бусад үүрэгт нийцсэн нөхцөл, хугацаагаар тийнхүү хязгаарлаж болно.

4-р Зарчим: Ялгаварлан гадуурхахыг хориглох

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө буюу мэдээллийн эрх чөлөөг ямар ч тохиолдолд, түүний дотор үндэсний аюулгүй байдлын шалтгаанаар хязгаарласан нь арьсны өнгө, эрэгтэй, эмэгтэй, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал, яс үндэс, бусад байдлаар ялгаварлан гадуурхахтай холбоотой байж болохгүй.

II ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ БУЮУ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТУУД

5-р Зарчим: Үзэл бодлыг хамгаалах нь

Хэнийг ч болов түүний үзэл бодол, итгэл үнэмшлийнх нь төлөө хориглох, эрхийг нь хязгаарлах буюу шийтгэж үл болно.

6-р Зарчим. Үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болзошгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх

15, 16-р Зарчимд нийцүүлэн үзэл бодлоо илэрхийлэхийг зөвхөн засгийн газар дор дурдсан байдлыг нотолж чадсан тохиолдолд үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй гэж шийтгэж болно:

-
- а) зайлуулах боломжгүй хүчирхийлэл өдөөх зорилготой;
 - б) тийм хүчирхийлэл өдөөх магадлалтай;
 - в) үзэл бодлоо илэрхийлсэн, тийм хүчирхийлэл гарч болох магадлалын хооронд шууд холбоо байгаа.

7-р Зарчим: Үзэл бодлоо илэрхийлэхийг хамгаалах нь

15, 16-р Зарчимд нийцүүлэн үзэл бодлоо тайван байдлаар илэрхийлснийг үндэсний аюулгүй байдалд аюул учруулж байна гэж үзэх, аливаа хориглол, шийтгэл хүлээлгэж болохгүй. Үндэсний аюулгүй байдалд аюул учруулахгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх гэж дор дурдсаныг хэлэх бөгөөд үүгээр хязгаарлахгүй:

- (i) засгийн газрын бодлогыг буюу засгийн газрыг өөрийг нь хүчирхийллийн бус аргаар өөрчлөхийг дэмждэг;
 - (ii) тухайн орон, төр, түүний бэлгэдэл, засгийн газар, түүний байгууллага, төрийн албан тушаалтнуудыг шүүмжилсэн, доромжилсон;
 - (iii) цэргийн алба буюу цэргийн үүрэг, тодорхой нэгэн зөрчилдөөнийг үл зөвшөөрсөн буюу зөвшөөрснийг дэмжсэн, эсхүл улс хоорондын зөрчлийг зохицуулахад хүч хэрэглэх, тийнхүү хүч хэрэглэхээр заналхийлэх;
 - (iv) олон улсын хүний эрхийн буюу олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн жишгийг зөрчсөн гэх тухай мэдээлэл дамжуулахад чиглэсэн.
- б) Хэнийг ч болов шүүмжлэл нь зайлуулах боломжгүй хүчирхийлэл өдөөх зорилготой байгаагүй бол тухайн улс, төр, түүний бэлгэдэл, засгийн газар, түүний байгууллага, төрийн албан тушаалтнуудыг шүүмжилсэн, доромжилсны нь төлөө шийтгэж үл болно.

8-р Зарчим. Үйл ажиллагаа нээлттэй байх нь дангаараа үндэсний аюулгүй байдалд аюул учруулах

Үзэл бодлоо илэрхийлснийг засгийн газраас дан ганцхан үндэсний аюулгүй байдал буюу түүнтэй холбоотой сонирхолд аюул учруулж байгаа гэж үзсэн байгууллагаас гаргасан буюу тийм байгууллагын тухай гэдгээр хориглож, шийтгэж үл болно.

9-р Зарчим. Үндэстний цөөнхийн буюу бусад хэл ашиглах

Үзэл бодлоо бичгээр буюу амаар илэрхийлсэн алиныг ч тодорхой хэл дээр, ялангуяа үндэстний цөөнхийн хэл дээр хийгдсэн гэдгээр хориглож үл болно.

10-р Зарчим. Гуравдагч этгээдээс үзэл бодлоо илэрхийлэхэд хууль бусаар хөндлөнгөөс оролцох

Засгийн газрууд, бүлэг буюу хувь хүн бусдыг үзэл бодлоо тайвнаар илэрхийлэхэд хууль бусаар хөндлөнгөөс оролцохоос сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй. Тухайлбал, Засгийн газрууд үзэл бодлоо илэрхийлэхгүй байлгах зорилготой хууль бус ажиллагааг буруушаах, гэм буруутай этгээдийг мөрдөн шалгах, хариуцлагад татах үүрэгтэй.

III МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХЯЗГААРЛАХ

11-р Зарчим. Мэдээлэл авах эрхийн ерөнхий зарчим

Хүн бүр төрийн байгууллагаас мэдээлэл авах, түүний дотор үндэсний аюулгүй байдлын холбогдолтой мэдээлэл авах эрхтэй. Энэ эрхийг засгийн газар хязгаарласан нь хуулиар

тогтоосон бөгөөд ардчилсан нийгэмд үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалахад шаардлагатай гэдгийг нотолж чадахаас бусад тохиолдолд хязгаарлаж үл болно.

12-р Зарчим: Аюулгүй байдлын шалтгаанаар үл хамаарах тохиолдлыг нарийн хүрээтэй тодорхойлох

Төр, үндэсний аюулгүй байдлын холбогдолтой бүх мэдээллийг авахыг хориглох бус харин хуулиар үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалах шаардлагын үүднээс хаалттай байлгах мэдээллийн хязгаарлагдмал ангилал тогтооно.

13-р Зарчим: Ил болгох олон нийтийн сонирхол

Мэдээлэл авах эрхийн талаарх хууль, шийдвэрүүдэд мэдээлэлтэй байх нийтийн сонирхолд эн тэргүүний ач холбогдол өгнө.

14-р Зарчим: Мэдээлэл өгөхөөс татгалзсаныг бие даан авч үзэх эрх

Төр, мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэхэд тохиромжтой арга хэмжээ батлах үүрэгтэй. Эрх баригчид мэдээлэл авахыг хориглосон бол түүний шалтгааныг бичгээр зааж тийнхүү хориглосон нь үндэслэлтэй эсэхийг хараат бус байгууллага авч үзэх эрх, үүний дотор тийнхүү хориглосон нь хууль ёсны эсэхийг шүүхээр хянах эрх олгоно. Хянах эрх бүхий этгээд хориглосон мэдээллийг авч үзэх эрхтэй байна.

15-р Зарчим: Нууц мэдээллийг ил болгох ерөнхий дүрэм

Хэнийг ч үндэсний аюулгүй байдлын үндэслэлээр мэдээлэл задруулсан гэж 1) тийнхүү задруулсан нь үндэсний аюулгүй байдалд бодит хор учруулаагүй буюу учруулах магадлалгүй, эсхүл 2) мэдээллийг мэдэж байх олон нийтийн сонирхол нь задруулсны хор уршгаас давуу байвал шитйгэж үл болно.

16-р Зарчим: Төрийн албанаас олж авсан мэдээлэл

Мэдээллийг мэдэж байх олон нийтийн сонирхол нь түүнийг задруулсны хор уршгаас давуу байвал хэнийг ч төрийн алба хаах явцдаа олж авсан мэдээллийг задруулсан үндэслэлээр ямар нэгэн байдлаар хохироож болохгүй.

17-р Зарчим: Олон нийтийн хүрээний мэдээлэл

Мэдээллийг нэгэнт олон нийтэд аливаа аргаар мэдээлсэн бол хууль ёсны эсэхээс үл хамааран ямар нэгэн үндэслэлээр цаашид нийтлэхийг зогсоох оролдлого нь олон нийтийн мэдэж байх сонирхол түүнээс давуу байна.

18-р Зарчим: Сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах

Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах нь сэтгүүлчийг мэдээллийнхээ эх сурвалжийг хэлж өгөхийг албадах үндэслэл болгож болохгүй.

19-р Зарчим: Хориотой газруудад нэвтрэх

Мэдээллийг чөлөөтэй дамжуулж хүлээж авахад тавьсан аливаа хязгаарлалт нь хүний эрх болон хүмүүнлэгийн эрх зүйн зорилгыг биелүүлэхэд саад болохоор байж болохгүй. Тухайлбал, засгийн газрууд сэтгүүлчид буюу хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйн жишгийг сахиж байгаа эсэхийг хянах мандат бүхий засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагуудад хүний эрх буюу хүмүүнлэгийн эрх зүйн зөрчил гарсан, гарч байна гэж үзэх

үндэслэлтэй газруудад нэвтрэн орохыг хориглож болохгүй. Засгийн газрууд сэтгүүлчид, тийм байгууллагын төлөөлөгчдийг хүчирхийлэл гарч байгаа буюу зэвсэгт мөргөлдөөн болж байгаа газруудад тэнд байх нь бусдад аюултайгаас бусад нөхцөлд нэвтрүүлэхгүй байж болохгүй.

IV ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЗАРЧИМ БА БУСАД АСУУДАЛ

20-р Зарчим: Хуулиар хамгаалах ерөнхий журам

Мэдээллийг илэрхийлэхтэй холбогдсон аюулгүй байдалтай холбоотой хэрэгт яллагдсан хүн бүр олон улсн эрх зүйн бүрэлдхүүн хэсэг болох хуулийн бүх хамгаалалтыг эдлэх эрхтэй. Эдгээрт дараахь хамаарах бөгөөд үүгээр хязгаарлахгүй:

- а) гэм буруугүйд тооцогдох зарчим;
- б) дур зоргоор баривчлагдахгүй байх эрх;
- в) өөрийг нь холбогдуулж байгаа хэрэг, түүний нотолгооны талаар өөрийн нь мэддэг хэл дээр даруй мэдэгдэх эрх;
- г) өөрийн сонгож авсан өмгөөлөгчтэй даруй харьцах эрх;
- д) боломжит хугацаанд хэргээ шүүхээр хянан шийдвэрлүүлэх эрх;
- е) өөрийгөө өмгөөлөхөд бэлтгэх зохих хугацаатай байх;
- ж) хараат бус, нөлөөнд үл автсан шүүхээр хэргээ нээлттэй хянан шийдвэрлүүлэх эрх;
- з) яллах талын гэрчүүдийг байцаах эрх;
- и) өөрт нь өмнө нь гаргаж өгч үгүйсгэх бололцоо олгоогүй нотлох баримтыг шүүх хуралдаанд гаргуулахгүй байх эрх;
- к) шүүхийн шийдвэрийг хянаж хүчингүй болгох эрх бүхий хараат бус шүүхэд давж заалдах эрх;

21-р зарчим: Зөрчигдсөн эрхийг сэргээх хэрэгслүүд

Аюулгүй байдалтай холбоотой хэрэгт яллагдсан хүн бүр Habeas corpus, amparo зэрэг бүх хэрэгсэл ашиглах бололцоотой байна.

22-р зарчим: Хараат бус шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх эрх

- а) Шүүгдэгчийн сонгосноор аюулгүй байдалтай холбоотой хэргийг тангарагтны шүүхээр (тийм шүүхтэй газарт) эсхүл жинхэнэ ёсоор бие даасан шүүгчид хянан шийдвэрлэвэл зохино. Аюулгүй байдалтай холбоотой гэмт хэрэгт холбогдсон хэргийг шүүгчийн албан тушаалд байх хугацаа нь баталгаагүй шүүгчдээр хянан шийдвэрлэснийг хараат бус шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх эрхийн хамгийн ноцтой зөрчилд тооцогдоно.
- б) Ямар ч тохиолдолд энгийн хүний аюулгүй байдалтай холбоотой хэргийг цэргийн шүүхээр хянан шийдвэрлэж болохгүй.
- в) Ямар ч тохиолдолд энгийн хүн, цэргийн албан хаагчийн хэргийг...буюу тусгайлан байгуулсан дотоодын шүүхээр хянан шийдвэрлэж болохгүй.

23-р зарчим: Урьдчилсан хяналт

Үзэл бодлоо илэрхийлэхийг үндэсний аюулгүй байдлыг хамгаалах сонирхлын үүднээс 3-р зарчимд заасан нөхцөлд тус улсын амьдралд аюул учруулсан нийтийн гамшигт байдлаас бусад тохиолдолд урьдчилан хянаж болохгүй.

24-р зарчим: Тохироогүй шийтгэл

Аюулгүй байдалтай холбоотой хэрэгт хувь хүн, хэвлэл мэдээллийн цэг, улс төрийн ба бусад байгууллагад үйлдсэн хэргийн хүндэд тохироогүй шийтгэл, хориглол, ял оногдуулж үл болно.

25-р зарчим: Эдгээр зарчим, бусад жишгийн хоорондын холбоо

Эдгээр зарчмыг олон улсын, бүс нутгийн буюу дотоодын хууль, жишгээр хүлээн зөвшөөрсөн ямар нэгэн хүний эрх, эрх чөлөөг хориглосон буюу хязгаарласан мэтээр тайлбарлаж болохгүй.

Орчуулсан Ж.Туул

§ Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба гүтгэлгийн эсрэг хуулийн зарчим

19 дүгээр зүйл байгууллага, 2000.06 сар

Удиртгал

Энэхүү баримтад багтаж буй зарчмууд нь НҮБ-ийн болон бүс нутгуудын төдийгүй бүх улс орны түвшинд батлагдсан хууль зүйн баримт бичгүүдэд тусгагдсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хувь хүний нэр төрийг хамгаалах хэрэгцээ хоёрын зохистой тэнцвэрт байдлыг хангаж өгч байна. Ардчилсан нийгэмд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө баталгаажсан байх ёстой ч хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хамгаалах үүднээс шаардлагатай хязгаарлалтуудыг нарийвчлан тусгаж өгөх нь дээрх зарчмуудын хэрэгжих үндэс болно. Ялангуяа нэр төрийг хамгаалж гаргасан хуулийн заалтуудад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэсэн хэм хэмжээг бага боловч нийцүүлж оруулах ёстой.

Эдгээр зарчмууд нь олон улсын хууль эрх зүй, хэм хэмжээ, туршлага дээр үндэслэгдсэн бөгөөд хуулийн срөнхий зарчмууд нь улс үндэстнүүдээр хүлээн зөвшөөрөгдсөн байна. Энэ нь 19 дүгээр зүйл байгууллагын олон жилийн судалгаа, зөвлөлгөө, дүн шинжилгээ, олон улсын болон үндэсний хэмжээний семинар зэрэг үйл ажиллагааны үр дүн юм. Дээрх үйл ажиллагааны сүүлийн шат нь 2000.02.29-нөөс 3 сарын 1-ны хооронд Нэгдсэн Вант Улсын нийслэл Лондон хотод зохиогдсон "Гүтгэлгийн эсрэг хууль"-ийн талаарх семинар, улмаар семинараас гаргасан төслийг хэлэлцэх явдал байлаа.

Зарчмуудын шийдвэрлэх асуудлын хүрээ нь нэр төрийн эсрэг гүтгэлэг ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хоорондын тэнцвэрт байдлыг хангахад оршино. Нэр төр гэдэг нь тодорхой нийгэм дэх бие хүний тухай үнэлэмж ба үзэл бодлыг хэлнэ. Энэхүү зарчим нь хувийн нууц, өөрийн үнэлэмж, үзэн ядсан үг яриа зэрэг бусад хувь хүний ашиг сонирхолыг хязгаарлах, хориглох, аль эсвэл сайшаах, дэмжих зорилгыг агуулагүй болно.

ОРШИЛ

Энэ зарчмын төслийг боловсруулагчид:

НҮБ-ийн дүрэм ба Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд нарийвчлан зааж өгсөн зарчмуудад нийцүүлэн хувь хүний эрх тэгш, халдашгүй байх эрхийг хүлээн зөвшөөрөх нь хүн төрлөхтний эрх чөлөөт, шударга ёсч, энх тайван амьдралын гол үндэс гэдгийг харж үзэн,

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн чөлөөт урсгал, олон нийтийн ашиг сонирхолд хамааралтай асуудлаар хувь хүнийг ил тод, нээлттэй шүүмжлэн хэлэлцэх нь хувь хүний хөгжил, түүний нэр хүнд ажил үйлст төдийгүй нийгмийн сайн сайхан, дэвшилийг хурдасгаж бусад хүмүүс үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг бүрдүүлдэгээрээ ардчилсан нийгэмд чухал ач холбогдолтой зүйл гэдгийг баталгаажуулж,

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон улсын пакт, Африкийн хүний эрхийн дүрэм, Америкийн хүний эрхийн конвенц, Хүний эрх, үндсэн эрх чөлөөний тухай Европын конвенц болон улс орнуудын үндсэн хуулийн холбогдох заалтуудыг харгалзан үзэж,

Хуулийг дээдлэн, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг багтаасан хүний эрхийг хамгаалах зорилготой шударга, бие даасан шүүхийн тогтолцоог бүрдүүлэх бодит хэрэгцээ болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хүний эрхийн талаар шүүхийн ажилтнуудыг сургалтад хамруулах асуудлуудыг харгалзан,

Хувь хүний хувьд нэр төр нь үнэт зүйл бөгөөд үүнийг зохих түвшинд хамгаалах хэрэгтэй гэдгийг ойлгож,

Төр засгийн газар нэр төрийг хамгаалах нэрээр гүтгэлгийн эсрэг туйлширсан хуулийг хүлээн зөвшөөрөх нь нийтэд хамаатай асуудлаар нийгмийг хамарсан хэлэлцүүлэг хийхийг хязгаарладаг төдийгүй, өндөр албан тушаал, нэр хүндтэй байр сууринд байгаа хүмүүс ийм хуулийг мушгин гуйвуулах явдал гардаг гэдгийг ухан,

Мэдээллийг чөлөөтэй авах, ялангуяа албан тушаалтанд байгаа мэдээллийг бусад хүмүүс хүртэх эрхийг хангаж өгөх нь үнэн зөв мэдээлэл цацах явдлыг дэмжих эсвэл худал буюу гүтгэлэгийн шинжтэй байж болох мэдээллийг нийтэлж, олны хүртээл болгох үйлдлийг таслан зогсоох ач холбогдолтой гэдгийг санаж,

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийтийн мэдлэг хүртэх эрхийг баталгаажуулах, нийгмийн анхаарал татсан асуудлаар нийтийн маргаан мэтгэлцээн өрнүүлэх, засгийн газар өндөр хариуцлагатай ажиллахад дэмжлэг үзүүлэх энгийнээр хэлвэл, ард түмний "хоточ нохой" байх зэрэг үүрэг гүйцэтгэх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч,

Хэвлэл мэдээллийн байгууллагаас бий болгосон өөрөө удирдах, зохицуулах тогтолцоо нь нэр төрийг сэргээхэд үр дүнтэй, хүртээмжтэй механизм бөгөөд энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчсөн зүйл биш гэдгийг хүлээн зөвшөөрч,

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон нэр төрийг хамгаалах хоёр зүйлийн хоорондын зохистой тэнцвэртэй байдлыг сайн ойлгуулах явдлыг дэмжихийг хүсэн,

дараах зарчмуудыг боловсруулсан бөгөөд бид улс орнууд, бүс нутаг, олон улсын байгууллагуудыг уг зарчмуудыг дэмжих, хүлээн авах болон хэрэгжүүлэх талаар өөрсдийн түвшинд зохих алхам хийхийг зөвлөж байна.

1. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

Бүлэг 1: Үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөө

- (а) Хүн бүр хөндлөнгийн оролцоогүй өөрийн гэсэн үзэл бодолтой байх эрхтэй.
- (б) Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй ба үүнд төрөл бүрийн мэдээлэл ба үзэл санааг ямар нэг хил хязгаарыг үл харгалзан өөрийн сонголтоор амаар, бичгээр буюу хэвлэлээр, уран сайхны хэлбэрээр буюу бусад ямар ч хэвлэл мэдээллээр дамжуулан чөлөөтэй эрж хайх, хүлээн авах эрхтэй.
- (в) (а), (б)-д заасан эрхийг бусдын нэр төрийг хамгаалах шаардлагын үүднээс олон улсын хуульд орсон зарим нэг тусгай үндэслэлээр тодорхой хязгаарлана.
- (г) Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь шууд болон шууд бусаар зөрчигдсэн хэн боловч хараат бус шүүхийн өмнө уг хязгаарлалт нь үндсэн хууль болон хүний эрхийн хуулиудтай нийцэж буй эсэхийг мэдэх эрхтэй.
- (д) Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахдаа хүний эрхийг зүй бусаар зөрчих үйлдлээс урьдчилан сэргийлж, энэ талаар хараат бус шүүхэд хандах хууль ёсны эрхийг нь хангах ёстой.

Зарчим 1.1: Хуульд зааснаар

Үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээлэл хүртэхтэй холбоотой хязгаарлалтыг хуульд зааж өгсөн байна. Уг хуулийн заалт нь ойлгомжтой, хоёрдмол утгагүй, цэгцтэй, яаж дагах ёстой бөгөөд эс бөгөөс хувь хүн ямар нөхцөл байдалд орж болохыг урьдчилан хэлсэн буюу тодорхой зүйлийг өөр аргаар хийх боломж олгосон байна.

Зарчим 1.2: Хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хамгаалах

Бусдын нэр төрийг хамгаалах үүднээс мэдээлэх, илэрхийлэх зэргийг хөндлөгөөс хязгаарлалт тавих үйл нь нэр төр, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах бодит зорилготой, харагдахуйц шалгарсан үр нөлөөтэй байх ёстой (зарчим 2-ыг хар).

Зарчим 1.3. Ардчилсан нийгэм дэх хэрэгцээ

Бусдын нэр төрийг хамгаалах зорилгоор мэдээлэх, үзэл бодлоо илэрхийлэх үйлийг хязгаарлах нь ардчилсан нийгэмд байх зайлшгүй хэрэгцээ юм гэдгийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд энэ хязгаарлалтыг хуульчлах боломжгүй юм. Ялангуяа,

- I. Хууль ёсны нэр төр, ашиг сонирхлыг хамгаалах арга хэрэгсэл нь сул, хүртээмжтэй бус тохиолдолд;
- II. Нөхцөл байдлыг тооцон үзэхэд нэр төрийг хамгаалах хязгаарлалт хэм хэмжээнээс хэтэрсэн болоод үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласнаар нэр төрийг хангалттай хамгаалж чадахгүй нөхцөлд хэрэгжүүлэх боломжгүй юм.

» Зарчим 1-д тайлбар

Зарчим 1 нь олон улсын болон үндсэн хуулиар баталгаажсан үзэл бодлоо илэрхийлэх тухай заалтууд, Иргэний ба Улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын Сиракузагийн зарчмаас урган гарч ирж байна. Зарчим 1.1-ээс 1.3-д буюу тэдгээрээс гарах хувилбарт тусгасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах хууль ёсны гурван хэсэг бүхий шалгуур нь олон улсын болон үндэсний шүүхийн практик, хуулиудад нилээд давтагдсан байдаг.

Зарчим 2. Гүтгэлгийн эсрэг хуулийн зорилго

- (а) Гүтгэлгийн эсрэг хуулийн гол зорилго, үзүүлэх үр нөлөө нь нэхэмжлэл гаргах болон шүүгдэх үүрэгтэй хувь хүн, хуулийн этгээдийг нийтэд доог тохуу болгох, үзэн ядуулах, нийгэм дэх нэр хүндийг нь бууруулах, үнэлэмжид нь халдах зэргээр хохирол учруулсан тохиолдолд тэдний нэхэмжлэл гаргаж, нэхэмжлэгчээр оролцох эрхийг хангахад оршино.
- (б) Нэр төрд нь учирсан хохирол байхгүй, эсвэл учирсан хохирлыг нь барагдуулах үндэслэлгүй (давуу эрхгүй) хуулийн этгээд нэхэмжлэл гаргах, нэхэмжлэгчээр оролцоход "нэр төр" хамгаалах хэргээр гүтгэлгийн эсрэг хуулийг хэрэглэхийг хориглоно. Ялангуяа дараах зорилгоор гүтгэлгийн эсрэг хуулийг хэрэглэхийг (батлахыг) хориглоно.
 - I. Албан хаагчийн буруутай үйл ажиллагааг зүй ёсоор шүүмжлэх, хээл хахуулийг ил гаргах явдалд саад хийх;
 - II. Улсын бэлэг тэмдэг, төрийн далбаа, үндэсний ялгах тэмдэг зэрэг объектийн "нэр хүндийг" хамгаалуулах;
 - III. Төр ба үндэстэн гэх мэт зүйлийн "нэр хүндийг" хамгаалах;
 - IV. Нас барсан хүний өмнөөс нэхэмжлэл гаргах;

V. Нэхэмжлэл гаргах эрхгүй хүмүүсийг төлөөлж хувь хүн нэхэмжлэл гаргах багтана.

(в) Гүтгэлгийн эсрэг хууль нь нэр төрөөс илүү хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдэх ёсгүй. Хууль ёсны ашиг сонирхлыг энэ зорилгоор тусгайлан гаргасан өөр хуулиар зохицуулах ёстой. Гүтгэлгийн эсрэг хууль нь ялангуяа үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам сахиулахад болон гадаад улсын төр, засгийн газартай найрамдалт сайн харьцаатай байхад туслах зорилготой байж хэрхэвч болохгүй.

» *Зарчим 2-т тайлбар.*

Гүтгэлгийн эсрэг хуулийн зорилго нь зөвхөн нэр төрийг хамгаалахад оршино. Гэтэл дэлхийн олон оронд албаны хүмүүсийн буруутай үйл ажиллагааны талаар олон нийтийн зүгээс хууль ёсны шүүмжлэл, хэлэлцүүлэг өрнөхөөс сэргийлэх, таслан зогсоох хэрэгсэл болгож гүтгэлгийн эсрэг хуулийг буруугаар ашиглах тохиолдол гардаг. Мөн олон улс оронд төрийн болон шашны бэлэг тэмдэг зэрэг тодорхой объектыг хамгаалах тусгай хууль гаргадаг. Учир нь иймэрхүү зүйлд нэр хүнд гэх зүйл үгүй ба эс бөгөөс гүтгэлийн эсрэг хуулийг хууль ёсны зорилгоор нь ашиглахгүй байна гэж үзнэ.

Хэн нэгний нэр төрд хууль бусаар халдсанаас үүсэх хор уршиг нь мөн чанарын хувьд тухайн хүн рүүгээ шууд чиглэсэн, хувийн шинжтэй байдаг. Энэ нь өмчтэй адил өв залгамжилж болох тийм ашиг сонирхол биш. Нас барсан хүний нэр төрийг төрөл садан нь өөрийн ашиг сонирхолдоо ашиглах нь өөрийн нэр төрөөрөө амьдарч буй хүнийхээс үндсээрээ ялгаатай. Иймээс хуулийг гуйвуулах болон нас барсан хүний нэр төрийг гутаасан тухай нэхэмжлэх гаргах нь хэргийг нээлттэй, чөлөөтэй хэлэлцэхээс сэргийлдэг байж магадгүй юм.

Хууль бусаар оршиж буй бүлгүүдийн хувьд хувь хүний (бодгаль) нэр төр гэсэн ойлголт бүрэн утгаараа хэрэгжиж чаддаггүй. Тийм ч учраас ийм бүлгүүдийн нэр төрийг гүтгэлгийн эсрэг хууль хамгаалах боломжгүй юм. Бүлгийн бүх гишүүд нэр төрөө гутаалгах, бүлгийн гишүүн учраас хувь хүнийхээ нэр хүндийг шууд бусаар гутаалгасан тохиолдолд асуудлыг зарчим 2-ын б-ийн v-ийн дагуу зохицуулна. Аль нэг бүлгийн гишүүн хувь хүнийхээ хувьд хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд уг этгээд гүтгэлэг түүнд шууд нөлөөлсөн, буюу шууд өртсөн гэдгээ нотолж чадвал хуулийн дагуу шүүхэд хандах боломжтой.

Зарим улс оронд бусдын нэр төрөөс илүү олон нийтийн ашиг сонирхол, нийгмийн хэв журам үндэсний аюулгүй байдал, бусад улстай найрсаг харилцаатай байхыг илүүд үзэж гүтгэлгийн эсрэг хуулийг эрүүгийн хуулиндаа хамтатган баталдаг. Ийм шинжтэй гүтгэлгийн эсрэг эрүүгийн хууль нь дээрх ашиг сонирхлыг нарийн авч үзээгүйгээс Зарчим 1.3-д заасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах шаардлагад нийцдэггүй. Дээрх хууль ёсны гэх ашиг сонирхлууд нь тусгай нэр төр хамгаалах зорилгоор баталсан бие даасан хуулиар хамгаалагдах ёстой.

Зарчим 3. Төрийн байгууллага, албан тушаалтныг гүтгэх

Хууль тогтоох, шүүх болон гүйцэтгэх засаглалын байгууллагууд ба төрийн ажилтнууд үүргээ гүйцэтгэхээс бусад тохиолдолд гүтгэлгийн эсрэг аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

» *Зарчим 3-д санал*

Олон орны дээд шатны шүүх нь албан тушаалтан, сонгуульт албан тушаалтан, төрийн өмчийн үйлдвэр байгууллага болон бүр улс төрийн намыг ч гүтгэлгийн үйл ажиллагаа явуулахыг хязгаарласан байдаг. Энэ нь засгийн газар, албаны хүмүүсийг ил тод шүүмжлэх

нь ардчилалд амин чухал зүйл бөгөөд эдгээр байгууллага, албаны хүмүүсийн нэр төр хязгаарлагдмал, тэд шүүмжлэлээс өөрсдийгөө хамгаалах хангалттай хэрэгсэлтэйг (аргатайг) хүлээн зөвшөөрч буйн илрэл хэрэг юм. Энэхүү зарчмыг хэрэгжүүлэхдээ төрийн захиргааны улам олон байгууллагад энэхүү хоригийг тавьж байгаа олон улсын чиг хандлагыг анхаарч үзэх нь зүйтэй болов уу.

Бүлэг 2. Гүтгэлгийн эсрэг эрүүгийн хууль

Зарчим 4. Гүтгэлгийн эсрэг эрүүгийн хууль

- (а) Зарчмын хувьд эрүүгийн хуулиас гүтгэлгийн эсрэг заалтыг хасч, иргэний хуулиар зохицуулах хэрэгтэй. Одоог хүртэл гүтгэлгийн эсрэг заалтууд эрүүгийн хуулинд нь байгаа улс орнууд энэ зарчмыг хэрэгжүүлэх алхам хийх хэрэгтэй.
- (б) Практикаас харахад гүтгэлгийн эсрэг эрүүгийн хууль эн тэргүүнд нэр төрийг гутаасан буруутай үйлдэлд чиглэдэг бөгөөд одоо хүчин төгөлдөр байгаа эрүүгийн хууль дараахь нөхцлүүдийг харгалзан өөрчлөлт хийх хойшлуулшгүй алхам хийх шаардлагатай байна.
- I. Нэг талын нэр төр гүтгэгдсэн гэх гомдол шаардлага нь эргэлзээтэй, нотлох баримт бүрэн бус бол хэнийг ч гүтгэлгийн эсрэг хуулиар ял тулгаж болохгүй;
 - II. Няцааж байгаа зүйл нь худал ташаа болох нь нотлогдоогүй, санаатай хуурамчаар үйлдсэн буюу худал ташаа болохыг мэдсээр атал бодлогогүй мэдээлсэн эсвэл нөгөө талд зориуд хор уршиг учруулахаар тусгай зорилготой гүтгэсэн зэрэг нь нотлогдоогүй бол гэмт хэрэгт тооцохгүй;
 - III. Гүтгэгдсэн гэх тал өндөр байр суурьтай өөрөөр хэлбэл захиргааны байгууллагын нэр хүнд бүхий албан тушаалтан байсан ч цагдаа, прокурор, захиргааны байгууллагын ахлах ажилтан зэрэг төрийн ажилтан уг этгээлийн өмнөөс гүтгэлгийн эсрэг гэмт хэрэг үүсгүүлэхээр санаачлах, шийдвэрлүүлэх тал болохгүй;
 - IV. Хорих, хорих ял тэнсэх, аль нэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өөрийгөө илэрхийлэх эрхийг нь хасах, сэтгүүл зүйн болон бусад мэргэжлээрээ ажиллахыг түр түтгэлзүүлэх, хэт их торгууль тавих буюу бусад эрүүгийн хатуу ял шийтгэл хариуцлагыг гүтгэлгийн гэмт хэрэгт оногдуулахыг зөвшөөрөхгүй.

» Зарчим 4-д санал

Ямар нэг үйлдлийг “гэмт хэрэгжүүлэх нь” тооцох нь нийгмийн зүй бус үйлдлийг ил гаргаж, түүнд төрөөс хяналт тавих гэсэн тодорхой ашиг сонирхлыг агуулдаг. Хүний үндсэн эрхийг зөрчсөн тухай хэргийг эрүүгийн хуулиар шийдэх үед Засгийн газар хориг, хяналт тавьж байх хэрэгтэйг олон улсын шүүх онцлон тэмдэглэсэн байдаг. Олон улсад бусдын нэр төрийг хамгаалах явдлыг эн тэргүүнд хувийн ашиг сонирхлын асуудал гэж үздэг бөгөөд нэр төрийг зохистой хамгаалахад эрүүгийн хуулийн гүтгэлгийн заалтыг хэрэглэхийг шаардлагагүй үздэг байна.

Олон улс оронд гүтгэлгийн эсрэг эрүүгийн хуулийг олон нийтийн маргааныг нухчин дарах, шүүмжлэлийг хүчлэн хязгаарлах хэрэгсэл болгон гуйвуулдаг. Хуулийн хатуу чанга хариуцлага, тухайлбал хорих ял нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд сөрөг муу нөлөө үзүүлдэг. Ялангуяа хувь хүний нэр төрд учруулсан гэм хорыг арилгахад эрүүгийн бус хариуцлага хангалттай байхад ийм хариуцлагыг хэрэглэх шаардлагагүй нь ойлгомжтой. Гүтгэлгийн эсрэг эрүүгийн хуулийг гуйвуулан ашиглах явдал байнга гарах боломжтой

бөгөөд тэр ч байтугай эрүүгийн хууль нь зөөлөн улсуудад ч ийм явдал гарч байдаг. Гүтгэлгийн эсрэг эрүүгийн хуулийг нийгмийн хэв журам сахиулах, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад хэрэглэх нь хууль бус, нийцэмжгүй зүйл гэдгийг урьд дурьдсан. Эдгээр шалтгаанаар гүтгэлгийн эсрэг эрүүгийн хуулийг зарчмын дагуу өөрчлөх буюу хүчингүй болгох ёстой.

Олон улс оронд нэр төрийг хууль бусаар зөрчих явдлыг эн тэргүүнд гүтгэлгийн эсрэг эрүүгийн хуулиар авч шийддэг хэвээр байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дур зоргоор хязгаарлах, уг гүтгэлгийн эсрэг хуулийг буруугаар ашиглах боломжийг багасгах үүднээс уг хуулиа энэ зарчмын “б”-ийн 4-т тохируулах нь маш чухал. Эхний нөхцөл нь эрүүгийн хуулийн үндсэн зарчим болох нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцохоос үүсдэг. Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцохдоо нэхэмжлэгч тал нь гэмт хэргийн бүх нотлох баримтыг хэрэгт бүрдүүлэх шаардлагатай болно.

Гүтгэлгийн хэргийн тухайд мэдээлэл ор үндэсгүй байх, гэмт хэрэг үйлдсэн үеийн сэтгэл мэдрэлийн өвчний тохирсон зэрэглэл нь нотлох баримт болно. Эрүүгийн хууль дахь гүтгэлгийн гэмт хэрэгтэй холбоотой бас нэг хэцүү бэрхшээл нь төрийн боломжийг ашиглан албан хаагчид өөрийн хувийн нэр хүндээ хамгаалах зэргээр хуулийг буруугаар ашиглах нь 3 дахь нөхцөл юм. 4 дэх нөхцөл нь хариуцлага тэнцвэргүй, үзэл бодлоо илэрхийлэх явдалд цаашид муу нөлөөлөл үзүүлэхгүй байхыг баталгаажуулна.

БҮЛЭГ 3. Иргэний хууль дахь гүтгэлгийн тухай заалтууд

Зарчим 5. Журам

- (а) Нэр төр гутаасны төлөө шүүхэд гаргасан гомдлыг зарим тодорхой шалтгаанаас бусад бүх тохиолдолд 1 жилийн дотор хянан үзэж шийдвэрлэнэ.
- (б) Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор нэр төр гутаасан хэргийг шүүн таслах ажиллагааны үе шат бүрийг зохистой цаг тухайд нь явуулахад шүүхийн байгууллага анхаарах ёстой. Түүний зэрэгцээ хэрэгт холбогдогч этгээд өөрийгөө хамгаалах боломжгүй, ялангуяа үнэнийг нотлох баримттай болж чадахааргүй нөхцөл байдалд хурдавчлуулах ёсгүй.

» Зарчим 5-д санал

Гүтгэлгийн хэрэг гарч, мэдээлэл тарснаас хойш удаан хугацааны дараа эрүү үүсгэх нь хоёр талаас няцаалт өгөх хүчийг сулруулж хэрэгт сэжиглэгдсэн этгээд тухайн үед тохирсон хамгаалалт үзүүлэх боломжийг багасгадаг. Хэрэгт холбогдогчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэтэрхий хаах, сөрөг нөлөө үзүүлэх бүх тохиолдолд нэхэмжлэгч хохирлоо арилгуулах боломжийг бууруулдаг. Зарим гүтгэлгийн хэргийг шийдвэрлэх үед шүүн таслах ажиллагааг маш үндэслэл муутай богино хугацаанд явуулахыг хуулиар оноосон байх нь талуудыг хүнд байдалд оруулдаг. Энэ нь хариуцагч тохирсон хамгаалалт авах боломжгүй болно гэсэн үг юм. Энэ бэрхшээл нь холбогдогч этгээд шүүхэд ил гаргахыг хүсэхгүй байгаа ялангуяа нууц эх сурвалжаас олсон мэдээллийг нотлох баримт болгон ашиглахдаа эх сурвалжаа нууцлахыг хүсэхэд саад болно.

Зарчим 6. Мэдээллийн эх сурвалжийг хамгаалах

- (а) Сэтгүүлч болон ямарваа хуулийн этгээд олон нийтийн эрх ашгийн үүднээс мэдээлэл тараасан бол тухайн мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй. Энэ эрхийг ямар ч нөхцөлд гүтгэлгийн хэрэгт халах, хязгаарлах ёсгүй.

(б) Энэ зарчмын дагуу гүтгэлгийн хэрэгт мэдээллийн эх сурвалжаа задруулахаас татгалзсаны төлөө хэн ч хохирол амсах ёсгүй.

» *Зарчим 6-д санал*

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулж өгснөөр олон нийтийн эрх ашгийн үүднээс мэдээлэл түгээж байгаа сэтгүүлч болон хэн ч мэдээллийн эх сурвалжаа илчлэхээс татгалзах эрхийг олгосон явдал юм. Энэ зарчим нь гүтгэлгийн эсрэг хуулинд заасан эрхийг тодотгож байна. Хувь хүн мэдээллийн эх сурвалжийн нууцлалыг хадгалахын хамт шүүх үйл ажиллагааны явцад уг мэдээллийн эх сурвалж оршин байгаа гэдгийг нотлон үзүүлж болно. Харин уг этгээд ямар хэмжээний мэдээлэл болон эх сурвалжийн хэсгийг нотлох баримт болгон ашиглахаа өөрөө шийднэ.

Зарчим 7. Үнэнийг нотлох

(а) Хариуцагч болсон явдлын маргаантай нөхцөл байдлын үнэн болохыг нь тогтоосон бүх тохиолдолд ямар ч үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөнө (зарчим 8-ыг хар).

(б) Олон нийтэд хамааралтай зүйл агуулсан байвал нэхэмжлэгч уг мэдээллийг худал болохыг өөрөө батлах үүрэгтэй.

(в) Мэдүүлгийнхээ үнэнийг тогтоох гэсэн шүүгдэгчийг үндэслэлгүй зогсоож буй шүүх ажиллагааг дахин хянаж үзэх хэрэгтэй

» *Зарчим 7-д санал*

Энэ зарчмын эхний хэсэг нь олон улс орны гүтгэлгийн эсрэг эрүүгийн хуульд аль хэдий багтсан байна. Энэ нь хэн нэгэн этгээд нэр төрөө хамгаалж чадахгүй байгаагийн төлөө тэр зөв мэдээллийг тараасны төлөө шүүн хэлэлцэх ёсгүй гэсэн үзэл санаанаас гарсан юм. Эдгээр зарчмууд нь хувийн нууцыг хамгаалах зэрэгт бусад хүрээнд гарч болох үйлдлийг журамлах бололцоотой гэсэн үг биш юм. Зарим хэрэг шүүн шийдвэрлэхэд жишээ нь хувийн нууцын тухай хуульд урьд ял эдэлсэнтэй холбоотой мэдээллийг нийтлэхэд зарим хязгаарлалт тавьсан байдаг.

Энэ зарчмын “б” нь олон шүүн шийдвэрлэх ажиллагаанд уламжлал болсон нэг зүйл буюу баримт үйл явдлын гүтгэсэн мэдээлэл ташаа болох нь таамаглагдаж байвал хариуцагчаар мэдэгдэл үнэн болохыг нотлохыг даалгадаг туршлагад эсрэг хариултыг өгч байна. Хэдий тийм боловч нэлээд олон нийтийн эрх ашигт хамаарах мэдээллийнх нь төлөө хариуцагчийг үндэслэлгүй дарамтанд байлгаж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөнд муу нөлөө үзүүлж байжээ.

Зарим шүүн таслах ажиллагаанд хариуцагчийн мэдээллийн үнэнийг нотлох чадвар, боломжийг үндэслэлгүй хязгаарлах практикууд бий. Нотолж чадаагүй хариуцагчийг мэдээллээ үнэн зөв болохыг нотлох оролдлого хийснийх нь төлөө нэмэлт төлбөр төлөхийг шаарддаг ба ийм шийдвэр гаргахдаа уг хариуцагч үнэн зөвийг нь нотолж чадахгүй байгаа учир шалтгааныг авч үздэггүй.

Энэ нь мэдээлэл нь үнэн байсан ч нотолгоо нь хангалтгүй гэсэн шударга бус байдлаар хандаж хариуцагчийг нотолгоо нь хангалттай бус байх вий гэсэн айдаст оруулдаг. Гүтгэлгийн хэргийн шүүн таслах ажиллагаанд нотолгоо танилцуулахыг хориглосон журам нь хариуцагчийн мэдээллийн үнэнийг тогтоох чадварыг хууль бусаар боож буй нь энгийн жишээ юм. Ялангуяа нэхэмжлэгчийнх урьдын ял шийтгэл, гэмт үйлдэл, урьдны амьдралын талаар нотлох баримт, жишээ татах шүүгдэгчийн эрхийг хасах явдал нь маш буруу юм.

Зарчим 8. Албан тушаалтан

Гүтгэлгийн эсрэг хууль нь ямар ч тохиолдолд албан тушаалтанд тэдний хэргэм зэргийг үл харгалзан тусгай хамгаалалт олгох ёсгүй. Энэ зарчим нь аливаа гомдол гаргах, гомдол барагдуулах, хариуцагчийн буруутай эсэхийг тогтоох цаашилбал тохирсон хариуцлагыг үнэн зөв хүлээлгэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

» Зарчим 8-д санал

Олон орны хуулийн тогтолцоонд оршин буй гүтгэлгийн эсрэг хууль нь тодорхой хүмүүст жирийн иргэдийнхээс хавьгүй илүү тусгай хамгаалалт үзүүлдэг. Жишээ нь төрийн зүгээс тэдний нэр хүндийг гутаасны эсрэг хэрэг үүсгэхэд оролцох, албаны хүмүүсийн нэр төрийг хамгаалахын тулд хамгаалалтын өндөр арга хэмжээ авахыг шаардах, албан тушаалтаны нэр хүндийг гутаасан этгээдэд өндөр шийтгэл оногдуулах зэрэг үзэгдлүүд ажиглагддаг. Ойрын үед олон улсын эрх зүйд албан тушаалтнууд шүүмжлэлд илүү хүлээцтэй хандах талаар заалтуудыг оруулж эхэллээ. Энэ нь албан тушаалтнууд дээр өгүүлсэн тусгай хамгаалатад хамаарахгүй гэдгийг баталж өгч байна.

Зарчим 9. Зохих хэвлэл материал

Олон нийтэд холбогдолтой мэдээллийн худал ташаа болох нь нотлогдсон тохиолдолд хариуцагч нь хэвлэн нийтлэх үйл ажиллагаа явуулсаныхаа төлөө зохих өмгөөлөлд байх ёстой. Ташаа мэдээлэл тараасан арга барил болон тараах болсон нөхцөл нь үндэслэлтэй нь тогтоогдсон үед уг хариуцагчийг тэрхүү өмгөөлөлд авна. Шүүх байгууллага тухайн тохиолдол үндэслэлтэй эсэхийг тогтоохдоо олон нийтэд хамаатай зүйлс болон олон нийтийн мэдээлэл хүртэх эрхийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй хослуулах зарчмыг баримтлана.

» Зарчим 9-д санал

Зарим хуулийн тогтолцоо буюу шүүн таслах ажиллагааны баримталж буй уламжлалт хатуу арга барилын улмаас хариуцагч нь худал мэдээллийг санаатайгаар тараасан эсвэл уг мэдээлэл нь үнэн гэдгийг баталж чадахгүй байгаад ялгаагүй хариуцлага хүлээж буй “үндэслэлгүй” шалтгаантай хэргүүдийн тоо өссөөр байна. Дээрх уламжлалт зарчим нь хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд тохиромжгүй нь харагдаж байна. Учир нь хэвлэл мэдээллийн байгууллага нь олон нийтийн мэдээлэл олж авах эрхийг эдлүүлэх үүргийг давхар биелүүлж байдаг ба тийм ч учраас тухайн түүх болон мэдээлэл үнэн эсэх нь батлагдахыг хүлээхгүй нэвтрүүлэх дамжуулах явдал байдаг. Бүр хамгийн сайн сэтгүүлч ч үнэхээр алдаа гаргадаг бөгөөд худал ташаа эсэх нь хараахан батлагдаагүй мэдээлэл дамжуулсан тохиолдолдол бүрт шийтгэл оногдуулах явдлыг нээлттэй орхих нь мэдээллийг цагт нь хүлээн авах ёстой олон нийтийн ашиг сонирхлыг үл тоомсорлосон хэрэг болно. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон нэр төрийн хоорондын илүү тэнцвэртэй байдал нь үндэслэлтэй үйлдэл хийсэн хүнийг хамгаалахын зэрэгцээ, жинхэнэ зүй бус үйлдэл хийсэн хүний эсрэг шүүхэд хандах хохирогчийн эрхийг хүлээн зөвшөөрөхөд оршино. Мэргэжлийнхээ хэм хэмжээний дагуу ажиллаж байгаа л бол хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүд “үндэслэлийн” шалгуурыг хэвийн байдлаар давж гарах нь дамжиггүй.

Зарчим 10. Санаа бодлоо илэрхийлэх

- (а) Хэн ч санаа бодлоо илэрхийлснийхээ төлөө гүтгэлгийн эсрэг хуулийн хариуцлага хүлээхгүй.
- (б) Санаа бодол гэдэг нь дараах шинжүүдтэй байна.

-
1. Бодит бус эргэлзээтэй худал болох нь тогтоогдож болох зүйлээс бүрдээгүй байх, эсвэл,
 2. Хошигносон, тохуурхсан, элэглэсэн хэллэгээр тухайн бодит байдлыг ойлгомжгүй илэрхийлээгүй байх.

» *Зарчим 10-д санал*

Ямарваа гүтгэлгийн хэрэгт санал бодлоо илэрхийлсэн асуудал орсон байвал түүнийг тодорхой нарийн шалгуураар авч үзэх ба үүнийг “үнэлэмжийг” дүгнэх ч гэж нэрлэх явдал байдаг. Гэсэн хэдий ч хувь хүний санал бодлыг өөрөөр авч үзэж хамгаалдаг. Зарим хуулинд “хүн өөрийн санал бодолтой байх эрхтэй” гэсэн зарчмаар хүний санал бодлыг бүрэн хамгаалдаг байна. Харин уг санал бодлыг "зүйтэй" эсэхийг тодорхойлох субъектив хэмжүүрийг хамгаалалтад авах хэргтэй гэж үздэг явдал бий.

Зарим мэдээлэл өнгөн талаасаа баримт мэт харагддаг боловч хэрэглэгдэж буй хэллэг болон нөхцөл байдлын улмаас буруугаар ойлгогдох явдал гардаг.

Хэтрүүлэл, хошигнол, элэглэл зэрэг яруу найргийн хэрэглүүрүүд нь үүний тодорхой жишээ юм. Иймээс гүтгэлгийн эсрэг хуулинд санал бодлыг өнгөц бус бодит утгаар нь хэмжих шаардлагатай байна.

Зарчим 11. Хариуцлагаас чөлөөлөх

(а) Зарим тодорхой мэдээлэлд гүтгэлгийн хариуцлага хүлээлгэхгүй. Тэдгээрт наад зах нь дараах зүйлийг хамруулан ойлгоно.

1. Хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаа түүн дотроо сонгогдсон гишүүдийн нээлттэй хэлэлцүүлэг, хуулийн байгууллагад дуудагдсан гэрчийн өгөх мэдүүлэг;
2. Удирдах түвшин болон тэдгээрийн гишүүдээс гаргасан мэдээлэл;
3. Шүүх хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд (шүүхийн өмнөх шат, хэлэлцэх шатанд) шууд оролцогчдоос (шүүгч, талууд, гэрчүүд, шүүхийн зөвлөл ба тангарагтны гишүүд) гаргасан уг шүүх ажиллагаанд хамаатай мэдэгдэл;
4. Хүний эрхийн зөрчлийг мөрдөх эрх бүхий хүн, итгэмжлэгдсэн этгээдэд хэлсэн мэдээлэл;
5. Хууль тогтоох байгууллагын хэвлэхээр тушаал гаргасан бичиг баримтууд;
6. Дээр /1-5/ дурьдсан материалын үнэн зөв, нягт нямбай тайлан;
7. Олон нийтийн хүсэлтээр хэвлэгдсэн эсвэл гадаад орны шүүх буюу олон улсын байгууллагаас гаргасан албаны мэдээ баримтын үнэн зөв тайлан.

(б) Хэрэв тодорхой төрлийн мэдэгдэл нь хорон санаа, дайсагнасан бодол агуулаагүй нь батлагдсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлнө. Дайсагнасан санаа агуулаагүй гэдэгт хууль, ёс суртахуун болон нийгмийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэх үедээ гаргасан мэдэгдлүүд багтана.

» *Зарчим 11-д санал*

Олон нийтийн ашиг сонирхлыг хүндэтгэн үзвэл хүмүүст байцаагдах бий гэсэн айдас төрдөг нь чөлөөтэй ярих чадварт, магадгүй өөрийн хэлж ярьсан зүйлийнхээ төлөө шүүхэд хариулахад бэрхшээлтэй байдгийг хүлээн зөвшөөрсөн. 11-р зарчмын (а) хэсгийн 1-5-д тодорхойлогдсон зүйлс нь ихэнхдээ гүтгэлгийн эсрэг хуулиар хариуцлага тооцоохгүй зүйлс байна. Энэ нь сонин болон бусад мэдээллийн хэрэгслүүдэд жинхэнэ зохиогч нь шаардлагатай хамгаалалтгүй байсан ч олон нийтийг шударга, нягт нямбай мэдээлэл,

баримт, мөн тэрчлэн бусад тодорхой албан ёсны материалаар хангах боломжийг олгож байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

Тодорхой мэдээлэл хийх тохиолдолд зохиогч нь түүнийг хийх үүрэг хүлээсэн эсвэл хийх тусгай сонирхолтой байсан нь өширхөж хонзогносон шинжтэй биш бол хариуцлагаас чөлөөлнө. Олон улсын хандлага нь эдгээр тохиолдолд энэ өмгөөлөх хүрээг улам өргөнөөр тайлбарлаж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд онцгой ач холбогдол өгч байна.

Зарчим 12. Хариуцлагын хүрээ

(а) Уг гүтгэлгийн мэдээллийн зохиогч, редактор, хэвлэн нийтлэгч нь биш, уг мэдээг тараахад оролцсоноо мэдээгүй, зүй бус үйлдэлд оролцсон үндэслэл байхгүй хэн боловч гүтгэлэг, нэр төр гутаасан хэрэгт татагдах ёсгүй.

(б) Тухайн гүтгэлгийн мэдээлэлд холбоотой байгууллага нь мэдээллийг тараах үйлд Интернетэд холбох техникээр хангасан, уг мэдээллийг интернэтээр дамжуулах ба вэб хуудсыг нь бүхлээр нь болон хэсгээр нь ажиллуулах зэргээр мэдэхгүйгээр оролцсон бол тэрхүү мэдээлэлтэй холбоотой ямар нэг хариуцлага хүлээх ёсгүй. Харин уг байгууллагууд тухайн мэдээллийг дахин цацахаас урьдчилан сэргийлж, 15, 16 дугаар зарчмын дагуу шүүхээс гаргах түр ба байнгын хоригийн арга хэмжээг биелүүлэх хэрэгтэй болж болно.

» Зарчим 12-д санал

Нэг гүтгэлгийн хэрэгт олон хүн холбогдох явдал байдаг. Мэдээллийг гаргах, хэвлэхэд оролцоогүй ба уг зүйл гүтгэлэг гэдгийг мэдээгүй хувь хүн ба, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд тэр ч бүү хэл мэдээллийн агентлаг гүтгэлэгт санаатайгаар оролцсон гэдэг нь нотлогдоогүй хэвлэл түгээгч, сонин зарагчид тэр мэдээллийн төлөө хариуцлага хүлээхгүй.

Энэ зарчмын “б”-д дурьдсан бүлэг хүмүүс, ялангуяа интернетийн үйлчилгээ эрхлэгчид гүтгэлгийн эсрэг хуульд уламжлагдаж ирсэн ойлголт болох хэвлэн нийтлэгчдээс хэд хэдэн талаараа чухал ялгаатай. Тэд мэдээлэл тарааж байгаа хүнийхээ мэдээлэлд шууд холбогдох боломжгүй учраас түүнээс хамгаалах, түүнийг болиулах боломжгүй юм. Тийм учраас интернетийн үйлчилгээ эрхлэгчид тэдний өмнөөс хариуцлага хүлээн эрсдэлд орох нь зохистой бус юм. Хэрвээ тэд гүтгэлгийн шинжтэй материалыг өөрсдөө зохиож Интернетэд цацтал уг мэдээлэлтэй холбоотой зэмлэл, буруушаалт, айлган сүрдүүлэлт гаднаас ирмэгц уг мэдээллээ яаравчлан татаж авах хэрэгтэй. Зарим орнуудад эрх мэдэл бүхий хувь хүн, том корпорациуд интернетийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд саад болох зорилгоор мэдээллийг нь мушгин гуйвуулах явдал байдаг.

Орчуулсан Ж.Туул

§ Олон нийтийн мэдэх эрх: Мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн зарчмууд

“XIX зүйл ” байгууллага, ISBN 1 902598 10 5, 1999 оны 6 сар, Лондон

ТАЛАРХАЛ

Эдгээр зарчмуудыг “19-р зүйл” байгууллагын хуулийн хөтөлбөрийн захирал Тоби Мендель боловсруулав. Эдгээр нь “19-р зүйл” байгууллагаас удаан хугацаанд явуулсан судалгаа, дүн шинжилгээ, санал солилцоо ба дэлхийн олон оронд байдаг түнш байгууллагуудтай хамтран ажилласан өргөн туршлагын үр дүн юм. Уг баримт бичгийг “19-р зүйл” байгууллагын харилцаа холбоо хариуцсан ажилтан Илана Кравиц хянан тохиолдуулж хэвлэлд бэлтгэн, өмнөх үгийг “19-р зүйл” байгууллагын гүйцэтгэх захирал Эндрью Пуддефат бичлээ.

АГУУЛГА

ОМНОХ ҮГ.

- 1-р зарчим. Дээд зэргээр нээлттэй байх
- 2-р зарчим. Хэвлэн нийтлэх үүрэг
- 3-р зарчим. Нээлттэй засаглалыг дэмжих
- 4-р зарчим. Үл хамаарлуудыг хязгаарлах хүрээ
- 5-р зарчим. Мэдээлэл хүртэх үйлдлийг хөнгөвчлөх процесс
- 6-р зарчим. Хураамж
- 7-р зарчим. Нээлттэй хуралдаан
- 8-р зарчим. Нээлттэй байхыг нэн тэргүүнд тавих
- 9-р зарчим. “мэдээлэгчийг” хамгаалах

ӨМНӨХ ҮГ

Мэдээлэл хэмээх зүйл нь ардчилалд хүчилтөрөгч нь болж байдаг. Хэрэв хүмүүс нийгэмдээ болж буй үйл явдлыг мэдэхгүй эсвэл удирдагчдынх нь үйл ажиллагаа нуугдмал байх аваас тэд нийгэмдээ дорвитой хувь нэмэр оруулж чадахгүй. Мэдээлэл бол зөвхөн хүмүүст хэрэгтэй зүйл төдийгүй, мөн шилдэг сайн засаглалын амин чухал бүрэлдэхүүн хэсэг юм. “Муу” засаглал амиа аварч гарахын тулд нууцлагдмал байх хэрэгтэй болдог. Гэвч энэ нь үр ашиггүй, үрэлгэн байдалд хүргэж, авилгалыг газар авахуулдаг билээ. Нобелийн шагналт эдийн засагч Амартия Сений судалснаар ардчилсан засгийн газартай, харьцангуй чөлөөт хэвлэлтэй оронд хэзээ ч нийтийг хамарсан өлсгөлөн гарч байгаагүй байна. Мэдээлэл нь хүмүүст засгийн газрынхаа үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах боломж олгодог бөгөөд дээрх мөн уг ажиллагааг зүй зохистой, мэдээлэл сайтай өөрөөр хэлбэл бодитоор хэлэлцэх үндэс болдог.

Гэхдээ ихэнх засгийн газар үйл ажиллагаагаа нууцаар явуулахыг эрхэмлэдэг байна. Свалид засгийн газар гэдгийг заасан үгсийн нэг нь “догшин нууц” гэсэн утгатай байдаг.

Тэр ч бүү хэл, ардчилсан засгийн газрууд хүртэл зарим ажлаа олон нийтийн нүднээс далдуур хийх эрмэлзэлтэй байдаг. Ингэхдээ засгийн газрууд нууцаа хадгалах шалтгааныг ямагт олж байдаг бөгөөд наад захын жишээ гэвэл үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, нийгмийн дэг журам, олон нийтийн ашиг сонирхол гэх мэтийг дурьдаж болно. Харамсалтай нь ихэнхдээ засгийн газрууд ард түмнийг төлөөлж албан ёсны мэдээллийг хадгалж байгаа гэж үзэхээсээ илүүтэйгээр өөрсдийн эрх мэдэлд байгаа мэдээлэлд өөрсдийн өмч мэг ханддаг.

Тийм ч учраас, “19-р зүйл” байгууллага олон улсын энэхүү багц зарчмыг боловсруулсан бөгөөд ямар ч иргэн өөрийн орны хуульд албан ёсны мэдээллийг олж авах эрхийг хангалттай баталгаажуулж чадсан эсэхийг харьцуулан үзэх олон улсын стандартыг бий болгохыг зорьсон билээ. Эдгээр зарчмууд нь ямар арга замаар засгийн газар дээд зэргийн нээлттэй байдалд хүрэх тухай аргачлалыг олон улсын шилдэг стандарт, практикт нийцүүлэн ойлгомжтой, тодорхой гаргаж өгч байна.

Зарчмууд нь стандартын нэгэн адил чухал зүйл мөн боловч дангаараа бол хангалтгүй юм. Тиймээс тэдгээрийг нийгмийн идэвхтнүүд, хуульчид, сонгогдсон төлөөлөгчид болон төрийн албан хаагчид хэрэглэж байх шаардлагатай. Эдгээр зарчмуудын ач холбогдлыг нь ойлгодог, засаглалыг ил тод болгохыг хүсдэг хүмүүс эдгээр зарчмуудыг нийгэмд тулгардаг онцгой нөхцөл байдалд тохируулан хэрэглэж байх нь зүйтэй. Дэлхий даяар засаглал, түүний хариуцлагыг сайжруулах, ардчиллыг бэхжүүлэх үйлст хувь нэмэр болгох үүднээс бид эдгээр зарчмуудыг нийтэлж байна.

СУРВАЛЖ

Эдгээр зарчмууд нь мэдээллийн эрх чөлөөнд нөлөө үзүүлж байдаг үндэсний болон олон улсын журамд тодорхой стандартыг тогтоож өгч байна. Эдгээр зарчмууд нь мэдээллийн эрх чөлөө болон албан ёсны мэдээлэл олж авах эрхийн талаарх үндэсний хууль тогтоомжид зориулагдсан хэдий ч уг зарчмуудыг НҮБ, Европын Холбоо зэрэг засгийн газар хоорондын байгууллагуудад хадгалагдаж буй мэдээллийг олж авахад ч нэгэн адил хэрэглэж болно.

Эдгээр зарчмууд олон улсын болон бүс нутгийн хууль тогтоомж, стандартууд, улс орнуудын өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг хуулийн практик, /үндэсний хууль тогтоомж, шүүхийн шийдвэрт тусгалаа олсон байдаг/ олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий зарчмууд дээр суурилсан. Уг зарчмууд нь “19-р зүйл” байгууллагын удаан хугацаанд явуулсан судалгаа, дүн шинжилгээ, санал солилцоо ба дэлхийн олон оронд байдаг түнш байгууллагуудтай хамтран ажилласан өргөн туршлагын үр дүн юм.

1-Р ЗАРЧИМ. ДЭЭД ЗЭРГЭЭР НЭЭЛТТЭЙ БАЙХ

Мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн зохицуулалт нь мэдээлэл дээд зэргээр нээлттэй байх зарчимд үндэслэгдэх ёстой.

Дээд зэргээр нээлттэй байх зарчим ёсоор төрийн байгууллагуудад хадгалагдаж байгаа бүх мэдээлэл нь олж авахад хялбар, нээлттэй байх ёстой бөгөөд зөвхөн тодорхой хязгаарлагдмал тооны нөхцөл байдалд л энэ зарчмыг хэрэглэхгүй байж болно /4-р зарчмыг үз/. Энэхүү зарчим нь мэдээллийн эрх чөлөөний үндсэн үзэл баримтлалын гол цөм бөгөөд түүнийг Үндсэн хуульд тусгаж, албан ёсны мэдээлэл олж авах явдал бол иргэний

үндсэн эрх гэдгийг тодорхой болгох нь зүйтэй. Хууль, эрх зүйн хамгийн гол зорилго бол мэдээллийн дээд зэргийн нээлттэй байдлыг практикт хэрэгжүүлэх явдал юм.

Аливаа төрийн байгууллага мэдээллээ нээлттэй байлгах үүрэгтэй ба үүнтэй уялдан нийгмийн гишүүн бүр мэдээлэл хүлээн авах эрхтэй. Тухайн улсын нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа бүх хүн уг эрхийг эдлэх ёстой. Уг эрхийг хангахдаа хувь хүнээс тухайн мэдээллээс ямар зүйлийг тусгайлан сонирхож байгаагаа илэрхийлэхийг шаардах ёсгүй. Төрийн байгууллага мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдол бүртээ татгалзсан шалтгаанаа тайлбарласан зохих үндэслэлээ гарган тавихыг хариуцна. Өөрөөр хэлбэл, тухайн төрийн байгууллагын нээлттэй болгохоос татгалзаж буй мэдээлэл нь хойшид дурьдагдах үл хамаарлуудын хүрээнд багтсан байх ёстой.

Тодорхойлолтууд

“Мэдээлэл”, “төрийн байгууллага” гэсэн ойлголтуудыг өргөн хүрээнд тодорхойлох нь зүйтэй.

“Мэдээлэл” гэж аливаа төрийн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд бүх хэлбэрээр хадгалагдаж байгаа /баримт бичиг, хуурцаг, электроник мэдээлэл г.м/ ямар ч эх сурвалжаас авсан байж болох /тухайн байгууллага буюу өөр байгууллагаас бэлтгэсэн/ болон хэзээ хийгдсэнээс үл хамааруулан бүхий л материалыг хэлнэ. Тэрчлэн энэ хуулийн зохицуулалт нь тусгайлан ангилсан мэдээ мэдээлэлд ч нэгэн адил хамаарна.

Мэдээллийг нээлттэй болгох үүднээс, “төрийн байгууллага” гэсэн ойлголтыг хэрэглэхдээ албан ёсны томилолтоос гадна явуулж буй үйл ажиллагааг нь мөн анхаарсан. Энэ үүднээс уг тодорхойлолтод орон нутгийн эрх барих байгууллагыг оролцуулан засгийн газрын бүхий л шатны байгууллагууд, сонгогдсон байгууллага, тусгай мандаттай ажилладаг байгууллага, улсын үйлдвэрийн газар, төрийн мэдлийн корпораци, “хагас” төрийн бус байгууллага, шүүхийн байгууллага, олон нийтэд үйлчилдэг хувийн байгууллага /зам засвар, төмөр зам г.м/ зэргийг оруулсан болно. Хэрэв хувийн байгууллага олон нийтийн амин чухал ашиг сонирхолд хамаатай байгаль орчин, эрүүл мэнд гэх мэтийн талаар мэдээлэл хадгалж байгаа бол дээрх тодорхойлолтод нэгэн адил хамрагдана. Засгийн газар хоорондын байгууллагуудад ч энэхүү баримт бичигт тодорхойлсон зарчмууд мөн хамаарна.

Мэдээллийн эх сурвалжийг устгах

Мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж, хүртээмжийг баталгаажуулах хэрэгтэй гэсэн зарчим дээр үндэслэн мэдээлэл хүртэхэд саад болох ба хадгалагдаж буй мэдээллийг санаатайгаар устгах нь гэмт хэрэг мөн гэдгийг хуулиар тогтоох ёстой. Түүнчлэн төрийн байгууллагууд мэдээллийг хадгалж, хамгаалах наад захын стандартыг хуулиар тогтоох нь зүйтэй. Төрийн байгууллагууд олон нийтийн мэдээллийг зохих ёсоор хадгалж хамгаалахын тулд хангалттай хэмжээний хөрөнгө зарцуулж, анхаарал тавих учиртай. Мэдээллийг түйлшруулах болон өөрчлөн засварлах аливаа оролдлогоос сэрэмжлэх үүднээс дотор нь байгаа мэдээлэл төдийгүй түүнийг хадгалж буй эх сурвалжуудыг ч нээлттэй байлгах ёстой.

2-Р ЗАРЧИМ. ХЭВЛЭН НИЙТЛЭХ ҮҮРЭГ

Төрийн байгууллагууд нь чухал мэдээллийг хэвлэн нийтэлж байх үүргийг хүлээнэ.

Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулна гэдэгт төрийн байгууллагууд зөвхөн мэдээлэл олж авах хүсэлтэд хариу өгөөд зогсохгүй мөн нөөц бололцоо, хүчин чадлынхаа хэмжээгээр

олон нийтийн сонирхлыг ихээр татсан онцгой мэдээллийг хэвлэн нийтэлж, тарааж байх үүрэг гүйцэтгэх ажиллагааг багтаадаг. Чухам ямар мэдээллийг хэвлэх нь тухайн төрийн байгууллагаас шалтгаална. Хуулиар хэвлэн нийтлэх ерөнхий үүрэг ба хэвлэгдэж олон нийтэд хүрч байх ёстой мэдээллийн төрлийг тогтоож өгнө.

Төрийн байгууллагууд нь наад зах нь доор дурдсан төрлийн мэдээллийг хэвлэн нийтлэх үүрэг хүлээнэ:

- Тухайн төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай мэдээлэл, түүний дотор зардал, зорилго, тайлан тооцоо, стандарт, үр дүн гэх мэт. Ялангуяа тухайн байгууллагын олон нийтэд үзүүлдэг шууд үйлчилгээ
- Олон нийтээс тухайн төрийн байгууллагад шууд хандан мэдээлэл хэрхэн хүсэх буюу гомдол гаргах зэрэг тухай
- Байгууллагын томоохон хэмжээний бодлого, хууль зүйн төсөлд олон нийтийн зүгээс санал бодлоо оруулахад дагах журам, аргачлал
- Тухайн байгууллагад хадгалагдаж буй мэдээллийн төрөл зүйл, хэлбэр
- Олон нийтэд хамаатай аливаа бодлого, шийдвэрийн агуулга, тэдгээрийг гаргах болсон шалтгаан, үндэс болгосон материалын хамт

3-Р ЗАРЧИМ. НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ

Төрийн байгууллагууд нээлттэй засаглалыг идэвхийлэн дэмжих ёстой.

Мэдээллийн эрх чөлөөг хууль зүйн зохицуулалттай болгохын тулд олон нийтийг мэдээлэл хүртэх эрхээ эдлэх тухай мэдээллээр хангах, засаглалын хүрээнд нээлттэй байх дэг жаягийг дээшлүүлэх явдал нэн тэргүүнд тавигдах ёстой. Нэлээд олон орны туршлагаас харахад хариуцлага муутай иргэний алба хамгийн дэвшилттэй хууль тогтоомжийн ч хүчийг бууруулдаг байна. Тэгэхээр дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь мэдээллийн эрх чөлөөний чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Гэхдээ тухайн орны иргэний алба нь хэрхэн зохион байгуулагдсан, мэдээллийг нээлттэй болгоход саад болдог гол хүчин зүйлс, олон нийтийн ухамсрын ерөнхий төвшин зэргээс шалтгаалан хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг харилцан адилгүй зохион байгуулах хэрэгтэй болдог. Тэгэхээр энэхүү хууль нь эрх зүйн тогтолцооны зорилгыг дэмжсэн ажилд тохиромжтой нөөц бололцоо зарцуулж, бүрэн анхаарлаа хандуулахыг шаардсан байх ёстой юм.

Олон нийтийн боловсрол

Аливаа орон өөрийн мэдээллийн эрх чөлөөний хуульд наад зах нь олон нийтийн боловсрол, мэдээлэл олж авах эрхийн тухай мэдээллийг тараах, мэдээллийн хүрээ, түүнийг олж авах арга хэлбэрийн тухай заасан байх ёстой. Сонин тараалт болон бичиг үсэгт тайлагдалтын хэмжээ доогуур улсад мэдээлэл түгээх, боловсрол олгох явдалд радио телевиз маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Хотын уулзалт, зөөврийн кино зэрэг бүтээлч хувилбаруудыг мөн нээн илрүүлэх хэрэгтэй. Иймэрхүү үйл ажиллагааг олон нийтийн байгууллагууд дангаараа хийхээс гадна мэдээлэл өгөх асуудлаар тусгайлан томилогдож, санхүүждэг албан ёсны байгууллага гүйцэтгэвэл илүү үр дүнтэй.

Албаны нууцыг хадгалах заншлыг авч үзэх нь

Засгийн газрын “нууцаа” хаалттай байлгадаг тогтсон хэв маягийг эвдсэн хэд хэдэн механизмыг хуулиар хангаж өгөх ёстой. Үүнд төрийн байгууллагууд өөрийн ажилтнуудад зориулж мэдээллийн эрх чөлөөний тухай сургалт зохион байгуулж байх ч мөн багтана. Уг сургалт нь мэдээллийн эрх чөлөөний хамрах хүрээ, ач холбогдол, мэдээлэл олж авах

журам, дараалал, мэдээллийн эх сурвалжийг хэрхэн үр дүнтэй хадгалах ба олж авах, мэдээлэгчийг хамгаалах хүрээ, ямар төрлийн мэдээллийг тухайн байгууллага хэвлэн нийтлэх үүрэгтэй зэрэг асуудлыг хөндөх ёстой.

Мөн олон нийтийн боловсролын асуудлыг хариуцсан албан ёсны байгууллага засаглалын хүрээнд нээлттэй байдлыг дээшлүүлэхэд өөрийн үүргийг гүйцэтгэх ёстой. Тэр байгууллага нь мэдээллээ тараах ажиллагааг сайн гүйцэтгэж буй төрийн байгууллагыг урамшуулах, нууцлаг асуудалд хандсан кампанит ажил өрнүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулж буй байгууллагыг дэмжих, мэдээллээ нууцалдаг этгээдүүдийг шүүмжлэх зэрэг санаачилга гарган ажиллаж болно. Оөр нэг боломж гэвэл парламент буюу парламентын байгууллагад жил бүр ололт болон шийдвэрлэх асуудлууд, түүний дотор олон нийтэд мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэх, Мэдээллийн эрх чөлөөний зарчмууд: Олон нийтийн мэдээлэл авах эрхийн талаар доголдолтой байгаа асуудлууд, мэдээллийн чөлөөт урсгал, дараагийн жилд авах арга хэмжээ зэргийг багтаасан албан ёсны тайланг боловсруулж өргөн барих байж болно.

4-Р ЗАРЧИМ. ҮЛ ХАМААРЛЫН ХЯЗГААРЛАЛТЫН ХҮРЭЭ

Хуулийн үл хамаарлуудыг маш ойлгомжтой, нарийн тодорхойлох ёстой бөгөөд олон нийтэд “аюултай”, “ашиг сонирхолд нь харш” гэсэн хатуу сорилоор давхар шалгана.

Аливаа төрийн байгууллага тухайн мэдээлэл үл хамаарлын хүрээнд багтаж байна гэж үзсэнээс бусад тохиолдолд мэдээлэл авахыг хүссэн хүсэлт бүрийг биелүүлэх ёстой. Төрийн байгууллагын удирдлага нь мэдээллийг нууцлах 3 хэсэгт сорилын шаардлагыг үндэслэлтэй баталсан тохиолдолд аливаа мэдээллийг өгөхөөс татгалзах эрхтэй.

Гурван хэсэгт сорил

- Уг мэдээлэл хуульд заасан хууль ёсны зорилгод хамаатай байх
- Мэдээллийг задлах нь дээр дурдсан зорилгод заналхийлж, ихээхэн аюул учруулахаар бол
- Дээрх зорилгод учрах аюул занал нь тухайн мэдээллийг нээлттэй болгох олон нийтийн ашиг сонирхлоос илүү их бол зэрэг багтана.

Ямар ч төрийн байгууллагын үйл ажиллагааны ихэнхи хувь нь үл хамаарлын хүрээнд багтдаг байсан ч гэсэн хуулийн үйлчлэх хүрээнээс огтоос ангид байж болохгүй. Энэ нь засаглалын бүхий л салбар /гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх/, түүний бүхий л үйл ажиллагаанд /аюулгүй байдлын ба батлан хамгаалах байгууллагууд/ нэгэн адил хамаарна. Мэдээллийг задлахгүй байх нь тухайн тохиолдлоос шалтгаална.

Засгийн газрууд өөрсдийн гэм буруутай үйлдлийг нуун дарахын тулд мэдээлэл өгөхөд хаалт, саад хийх явдлыг хуульд хэзээ ч зөвшөөрөхгүй.

Үл хамаарлын хууль ёсны зорилго

Мэдээллийг хаалттай байлгаж буй шалтгааны хууль ёсны зорилгын бүрэн жагсаалтыг хуульд тусгах ёстой. Энэхүү жагсаалт нь аливаа баримт бичгийг хаалттай байлгах шаардлагатай хууль зүйн үндэс бүхий ашиг сонирхлыг багтаах учиртай бөгөөд зөвхөн хуулийг бэхжүүлэх, хувийн нууц, үндэсний аюулгүй байдал, худалдааны болон бусад нууц, засгийн газрын шийдвэр гаргах процессын үр ашигтай, нэгдмэл байх зэрэг асуудлаар хязгаарлагдана.

Хууль ёсны ашиг сонирхолд үл харшлах мэдээллийг дээрх жагсаалтад оруулахаас сэргийлж үл хамаарлуудыг маш нарийн тодорхойлох хэрэгтэй. Тэдгээрийн баримт

бичгийн хэлбэр маягаас илүүтэйгээр агуулгыг нь харгалзан гаргана. Энэхүү стандартад нийцүүлэхийн тулд үл хамаарлуудыг боломжтой бол цаг хугацааны хязгаарлалттай байлгах. Жишээ нь, мэдээллийг үндэсний аюулгүй байдалд заналхийлнэ гэсэн үүднээс нууцласан бол үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн тухайн аюул алга болсноор тухайн үл хамаарал хүчингүй болж болно.

Ноцтой хор хохирол учрах нь гарцаагүй үед л татгалзах ёстой

Мэдээлэл нь зөвхөн хуульд тусгалаа олсон хууль ёсны зорилгын хүрээнд хамаарч байх нь хангалттай бус. Төрийн байгууллага уг мэдээллийг задласнаар тэрхүү хууль ёсны зорилгод хор хохирол учрах болно гэдгийг нотлон харуулах ёстой. Зарим үед мэдээллийг нээлттэй болгох нь учрах хохирлоос ч илүү ашигтай байж болох юм. Жишээ нь, армид бий болсон авилгалын тухай мэдээлэл эхэндээ үндэсний батлан хамгаалахыг сулруулах аюултай мэт санагдавч, цаашдаа авилгалыг устгаж, армийг бэхжүүлэхэд тустай. Мэдээллийг нууцалж, хаалттай байлгах нь хууль ёсны үндэслэлтэй гэдгийг батлахын тулд тухайн мэдээллийг задлал хууль ёсны зорилгод ноцтой хор хохирол учруулна гэдгийг харуулах ёстой.

Олон нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих

Мэдээллийг нээлттэй болгох нь хууль ёсны зорилгод хор хохирол учруулахаар байсан хэдий ч түүнийг нээлттэй болгосноор олох ашиг нь хор хохирлын хэмжээнээс давж гарахаар бол уг мэдээллийг задлах ёстой. Жишээ нь, зарим мэдээлэл хувийн нууцтай холбоотой мэт санагдаж байвч түүний зэрэгцээ энэ нь засгийн газар дахь өндөр хэмжээний авилгалыг илэрхийлж байж болно. Энэ тохиолдолд хууль ёсны зорилгод учрах хор хохирлыг уг мэдээллийг олж авахад гарах ашиг сонирхолтой харьцуулж үзэх ёстой. Хэрэв олон нийтийн эрх ашиг илүү чухал байвал тухайн мэдээллийг нээлттэй болгох асуудлыг хуулиар хангаж өгөх ёстой.

5-Р ЗАРЧИМ. МЭДЭЭЛЭЛ ХҮРТЭХ ҮЙЛДИЙГ ХӨНГӨВЧЛӨХ ПРОЦЕСС

Мэдээлэл авах хүсэлтийг хурдан шуурхай, шударгаар шийдвэрлэх ёстой бөгөөд аливаа татгалзсан хариу бүрийг үндэслэлтэй нь хамт нээлттэй байлгах ёстой.

Мэдээлэл авах хүсэлтийг 3 үе шатанд шийдвэрлэх бөгөөд үүнд, тухайн төрийн байгууллагын дотоод хүрээнд, бие даасан засаг захиргааны байгууллагад давж заалдах, шүүхэд давж заалдах гэсэн шатууд багтана. Шаардлагатай нөхцөлд тодорхой бүлгийн хүмүүст, жишээ нь уншиж бичиж чаддаггүй, мэдээлэл бичигдсэн хэлээр ярьдаггүй, эсвэл хараагүй гэх мэт тахир дутуу хүмүүст мэдээллийг бүрэн дүүрэн хүргэх арга хэмжээг авна.

Төрийн байгууллага бүр олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангаж чадахуйц нээлттэй, хүртээмжтэй дотоод тогтолцоог бий болгох шаардлагатай. Ингэхдээ, мэдээлэл авах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, хууль сахиулах үүрэгтэй ажилтныг томилно.

Төрийн байгууллагууд нь урьд нь хэвлэгдсэн мэдээллийн талаар гаргасан, эсвэл тодорхойгүй, дэндүү өргөн хүрээг хамарсан, ахин боловсруулах шаардлагатай хүсэлт тавьсан өргөдөл гаргагчид туслах үүрэг хүлээнэ. Нөгөө талаар, төрийн байгууллага үндэслэлгүй, зүй зохисгүй хүсэлтэд татгалзсан хариу өгч байх хэрэгтэй. Төрийн байгууллага өмнө нь хэвлэгдсэн мэдээллийг гарган өгөх албагүй боловч энэ тохиолдолд тухайн өргөдөл гаргагчид хэвлэгдсэн эх сурвалжийн талаар чиглүүлэх заавар өгөх ёстой.

Хуульд хүсэлтийг шийдвэрлэх цаг хугацааны нарийн хязгаарлалт, аливаа татгалзсан хариунд хангалттай шалтгаан бичиж хавсаргах зэргийг тусган оруулах ёстой.

Давж заалдах

Тохиромжтой нөхцөлд, төрийн байгууллагын ажилтны гаргасан шийдвэрийн талаар тухайн хүсэлт гаргагчаас уг байгууллагын илүү эрх мэдэл, хянах эрх бүхий ажилтанд хандах эрхийн тогтолцоог хуульд тусгаж өгнө.

Ямар ч тохиолдолд хувь хүнд буюу хүсэлт гаргагчид төрийн байгууллагаас мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд уг хүн бие даасан захиргааны байгууллагад давж заалдах эрхийг хуулиар хангах учиртай. Энэ нь Омбудсмен эсвэл Хүний Эрхийн Хороо зэрэг одоо байгаа байгууллагууд буюу эсвэл уг зорилгын үүднээс тусгайлан байгуулсан байгууллага байж болно. Аль ч тохиолдолд уг байгууллага тодорхой стандартыг хангаж, тодорхой эрх мэдэлтэй байна. Түүний бие даасан байдал албан ёсоор болон түүний дарга, удирдах зөвлөлийг сонгох журмаар давхар баталгаажна.

Томилгоог төлөөлөгчдийн байгууллагаас, бүх намын төлөөлөлтэй парламентын хорооноос ч юм уу хийх ба ингэхдээ олон нийтэд нээлттэй, тэдний оролцоог /жишээ нь нэр дэвшүүлэхэд/ авах ёстой. Ийм байгууллагад ажиллахаар томилогдсон хувь хүн мэргэжлийн өндөр стандартыг хангасан, бие даасан байдал, өндөр ур чадвартай, сонирхлын бүлгийн зөрчилдөөнд автагдахгүй байх ёстой.

Эрх бүхий байгууллага нь мэдээлэл өгөхөөс татгалзсан асуудлаар давж заалдсан өргөдлийг шийдвэрлэхдээ аль болох түргэн шуурхай, бага төлбөртэйгээр хийх ёстой. Ингэснээрээ олон нийтэд уг процедур хүртээмжтэй байж, хэт удаан хойшлуулснаар мэдээлэл авах хүсэлтийн гол зорилгыг алдагдуулахаас сэргийлэх ач холбогдолтой.

Эрх бүхий байгууллага давж заалдсан өргөдлийг хянан шийдвэрлэх бүрэн эрхтэй байх бөгөөд түүний дотор гэрчийн этгээдүүдийг асуух, хамгийн гол нь тухайн төрийн байгууллагаас мэдээлэл, мэдээллийн эх сурвалжийг шаардлагатай бөгөөд хууль ёсны гэж үзсэн тохиолдолд авах эрхтэй байна.

Эрх бүхий байгууллага өргөдлийг хянан шийдвэрлэхдээ түүнийг авч хэлэлцэхгүй байх, төрийн байгууллагаас мэдээллээ нээлттэй болгохыг шаардах, төрийн байгууллагаас хурааж авсан аливаа төлбөрийн хэмжээг зохицуулах, хууль бус үйлдэл хийсэн төрийн байгууллагад торгууль ногдуулах буюу давж заалдсан өргөдөлтэй холбогдон гарсан зардлыг төрийн байгууллагаар төлүүлэх шийдвэр гаргаж болно.

Түүнчлэн эрх бүхий байгууллага гэмт хэргийн холбогдолтой гэж үзэх буюу эсвэл мэдээллийг санаатайгаар устгасан гэж үзсэн тохиолдолд асуудлыг шүүхэд шилжүүлж болно.

Өргөдөл гаргагч, төрийн байгууллага хоёрын аль аль нь эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн эсрэг шүүхэд давж заалдах эрхтэй. Шүүх нь давж заалдсан өргөдлийн дагуу өмнөх шатны эрх бүхий байгууллага зөв шийдвэр гаргасан эсэхийг шалгахаас гадна уг хэргийг бүхэлд нь авч үзэх хэрэгтэй юм. Ингэснээр бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлээд зогсохгүй мэдээллийн эрх чөлөөнд тууштай хандах үндсийг бүрдүүлэх юм.

6-Р ЗАРЧИМ. ХУРААМЖ

Хувь хүмүүс мэдээлэл авах хүсэлт гаргахад өндөр үнээр нь саад болох ёсгүй.

Төрийн байгууллагад хадгалагдаж буй мэдээллийг олж авах үнэ төлбөр нь хүсэлт гаргахаар шийдсэн хувь хүн төлөх боломжгүй өндөр үнэтэй байх ёсгүй. Үүнд мэдээллийн эрх чөлөөний хуулийн хамгийн гол цөм бол мэдээлэлд нээлттэй хүрэх явдлыг хөхиүлэн дэмжих явдал билээ. Нээлттэй байхын хожим өгөх үр ашиг нь үнэ төлбөрөөс хамаагүй

илүү байдаг гэдэг нь аль хэдийнээ нотлогдсон зүйл юм. Нэлээд олон орны туршлагаас үзэхэд мэдээлэл олж авахдаа мөнгө төлөх нь мэдээллийн эрх чөлөөт байдлын зардлыг нөхөн төлөх үр ашигтай арга биш гэдэг нь харагдсан байна.

Дэлхийд дээрх төлбөрийг мэдээлэл олж авах хүсэлтэд саад болохгүйгээр тогтоохын тулд олон төрлийн систем хэрэглэдэг. Зарим орны хуульд 2 шатлалтай системийг хэрэглэдэг ба энэ нь гаргасан хүсэлт бүрт тогтсон төлбөрөөс гадна уг мэдээллийг олж өгөхөд гарсан бодит зардлаас хамаарсан хэлбэлзэлтэй хураамж юм. Сүүлчийнх нь хувь хүний болоод олон нийтийн эрх ашигт зориулан мэдээлэл олж авахыг хүссэн тохиолдолд нэлээд хэмжээгээр ашиглагддаг.

7-Р ЗАРЧИМ. НЭЭЛТТЭЙ ХУРАЛДААН

Төрийн байгууллагуудын хуралдаан олон нийтэд нээлттэй байх ёстой.

Мэдээллийн эрх чөлөө нь олон нийт нь засгийн газар олон нийтийн нэрийн өмнөөс юу хийж байгааг мэдэх, шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхтэй байхыг мөн багтаана. Тиймээс мэдээллийн эрх чөлөөг хуулиар зохицуулахдаа эрх барьж буй байгууллагуудын бүх хурал олон нийтэд нээлттэй байх ёстой гэсэн зарчмыг баримтлах ёстой.

Дээр дурьдагдсан “эрх барьж буй” байгууллага гэдэг ойлголтод шийдвэр гаргах эрх бүхий байгууллагыг хамааруулсан ба зөвлөгөө өгөх төдий эрхтэй байгууллагыг оруулаагүй. Улс төрийн зөвлөл буюу нэг улс төрийн намын гишүүдийн хурлыг “эрх барьж буй” байгууллага гэж үзээгүй.

Нөгөө талаас, сонгогдсон байгууллагууд, тэдгээрийн зөвлөлийн хурал, төлөвлөгөөний зөвлөл, олон нийтийн ба боловсролын байгууллагын удирдах зөвлөл, төрийн мэдлийн үйлдвэрлэлийн хөгжлийн агентлаг зэргийг багтааж болох юм.

Энд “хуралдаан” гэж албан ёсны хурал, тодруулбал олон нийтийн асуудлаар төрийн байгууллага албан ёсоор хуралдахыг ойлгоно. Уг хурал албан ёсны эсэхийг түүний кворум, албан ёсны хурлын дэгийн үйлчлэл зэргээр нь тодорхойлно. Олон нийтэд жинхэнэ ёсоор оролцох бололцоо олгохын тулд хурлын тухай зарлах ёстой бөгөөд хуулиар уг зарыг хурал болохоос хангалттай хугацааны өмнө урьдчилан тараана гэж заах шаардлагатай.

Хуралдааныг хаалттай явуулж болох ба ингэхдээ мөрдөгдөж буй дүрэм журамд нийцүүлнэ. Хуралдааныг хаалттай явуулах аливаа шийдвэр олон нийтэд нээлттэй байх ёстой. Хуралдааныг хаалттай явуулах шалтгаан нь өмнө дурьдсан нээлттэй байх зарчмын үл хамаарлын жагсаалтаас илүү өргөн боловч хязгааргүй биш. Хаалттай хуралдах шалтгаанууд нь тухайн тохиолдол бүрт харилцан адилгүй буюу олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хууль сахиулах, мөрдөх ажиллагаа, ажиллах хүчний асуудал, хувийн эрх чөлөө, худалдааны асуудал, үндэсний аюулгүй байдал зэрэг байж болно.

8-Р ЗАРЧИМ. НЭЭЛТТЭЙ БАЙХЫГ НЭН ТЭРГҮҮНД ТАВИХ

Дээд зэргээр нээлттэй байх зарчимтай харшилдсан аливаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох ёстой.

Уг хуулийг баталбал мэдээллийн эрх чөлөөний тухай хуультай бусад хууль тогтоомж түүний заалтуудыг аль болох тохируулах шаардлага гарна. Хэрэв энэ нь боломжгүй бол олон нийтийн мэдээлэлтэй холбоотой бусад хууль тогтоомжууд мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн үндсэн зарчмууд дээр үндэслэсэн байх ёстой. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасан үл хамаарлуудын хязгаарлалт нь төгс ойлгомжтой байх ёстой бөгөөд ингэснээрээ бусад хууль тэдгээрийг өргөжүүлж хэрэглэхээс сэргийлнэ. Ялангуяа, нууцын

тухай хуульд мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасны дагуу задлах шаардлагатай мэдээллийг задласан албан тушаалтныг хууль бус үйлдэл хийсэн хэмээн заах ёсгүй.

Цаашид мэдээлэлтэй холбоотой бүх хуулийг мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн тулгуур зарчмуудад нийцүүлэн багцлахыг эрмэлзэх учиртай.

Түүнчлэн нууцлах ангиллын мэдээллийг сайн санааны үүднээс, мэдээллийн эрх чөлөөний зарчмын үүднээс тодорхой үндэслэлтэй задалсан аливаа ажилтанд ял зэмлэл тооцох ёсгүй. Эс бөгөөс ямар нэг ял зэмлэл хүргэхээс сэрэмжилсэн ажилтан ажлаа хангалттай сайн хийж чадахгүй болж улмаар энэ тухайн байгууллага мэдээлэл нуун дарагдуулах нэг завшаан болно.

9-Р ЗАРЧИМ. “МЭДЭЭЛЭГЧИЙГ” ХАМГААЛАХ

Гэм буруутай үйлдлийн тухай мэдээлэл тарааж буй хувь хүмүүс буюу “мэдээлэгчийг” хамгаалах ёстой.

Гэм буруутай үйлдлийн тухай мэдээлэл тарааж буй хувь хүмүүс буюу “мэдээлэгч”-ийг хуулийн, захиргааны эсвэл ажил олголттой холбоотой аливаа шийтгэлээс хамгаалах ёстой.

“Гэм буруутай үйлдэл” гэдэгт гэмт хэрэг үйлдэх, хууль ёсны үүргээ зөрчих, шударга ёсыг хөсөрдүүлэх, авлига ба шударга бус явдалд автах, төрийн байгууллагыг ноцтойгоор завхруулан удирдах зэргийг багтаан ойлгоно. Үүнд мөн хувь хүний гэм буруутай үйлдэлтэй холбоотой эсэхээс үл хамааран эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд учруулж буй аюул заналыг багтаан үзнэ. “Мэдээлэгч” нь хэрэв сайн санааны үүднээс, тухайн мэдээлэл үнэн бөгөөд гэм буруутай үйлдлийг илчилж чадна гэдэгт итгэлтэй байсны үүднээс хандсан тохиолдолд хамгаалалт эдлэх эрхтэй болно. Уг хамгаалалт нь өөр тохиолдолд бол хуулийн болон ажлын шаардлагыг зөрчихөөр байсан үед ч нэгэн адил үйлчилнэ.

Зарим оронд “мэдээлэгчийг” уг мэдээллээ тодорхой хувь хүн, байгууллагад гаргаж өгсөн нөхцөлд хамгаална гэдэг. Энэ зарчмыг ерөнхийд нь хэрэглэж болох боловч, олон нийтийн эрх ашигт хамаатай асуудал бол уг мэдээллийг хувь хүмүүст тэр ч бүү хэл мэдээллийн хэрэгсэлд гаргаж өгсөн тохиолдолд ч “мэдээлэгчийг” хамгаалах ёстой.

Энд “олон нийтийн эрх ашиг” гэж мэдээллийг задлах нь хор хохирлоосоо илүү ашиг авчрах, амин чухал ашиг сонирхлыг хамгаалахын тулд мэдээллийг өөр маягаар тараах шаардлагатай нөхцлүүдийг хамруулж ойлгоно. Тухайн буруутай үйлдлийг зохих журмаар илрүүлэн, шийдвэрлэх боломжгүй, маш онцгой шалтгаантай, цаашилбал нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учруулж байгаа эсвэл тухайн мэдээг дэлгэн тавихгүй бол гэм буруутай үйлдлийн баталгаа арилах аюултай зэргийг багтааж дээрх нөхцөлд мэдээлэл тараасан хүмүүсийг хууль ёсны хамгаалалтанд авна гэж зааж өгнө.

Орчуулсан Ж.Туул

§ Мэдээллийн эрх чөлөө ба Европын холбоо

Хууль ба мэдэх эрх

Олон улсын гэрээнд тулгуурласан Европын холбооны хууль тогтоомж нь олон нийтэд мэдээлэл олж авах эрх чөлөөг олгодог боловч ил тод байдлыг хайж байдаг сэтгүүлчдийн хувьд зарим талдаа хязгаарлагдмал байдаг. Европын холбооны шүүгчид энэ байдлыг харгалзан өөрсдийнхөө хэр хэмжээний хүрээнд ил тод байдлыг хэрэгжүүлдэг. Хүний Эрхийн тухай Европын Конвенц нь Европын холбооны хууль тогтоомжид шууд хамааралгүй боловч Европын холбооны шүүгчид энэ талаар маш тодорхой авч үздэг ба Конвенц нь Европын холбооны гишүүн орнуудын хууль, эрх зүйн тогтолцооны тодорхой хэсгийг бүрдүүлдэг байна. Уг конвенц нь үг хэлэх эрхийг хамгаалдаг хэдий ч албан бичиг баримтийг ашиглах тал дээр хангалтгүй юм. Энэ талаар Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах санал гарч байсан бөгөөд мэдээллийн эрх чөлөөний зорилго нь шүүх, хууль эрх зүйн гэхээсээ улс төрийн хандлагад чиглэгдсэн байдаг.

Хүмүүнлэгийн тухай хууль ба Европын холбооны хуулийн тогтолцоо

Холбооны үндсэн тогтолцоо нь худалдаа арилжааны асуудлыг чухалчилдаг. Нийгмийн хууль хүний эрхийн хуультай зохицон үндсэн гол чиглэл нь болж өгдөг байна. Худалдаа арилжааны асуудал хүний эрхийг илүү өргөн хүрээнд авчирч тавьдаг учир дээрх хуулиар бүтээгдэхүүн болон үйлчилгээг чөлөөтэй нэвтрүүлэх талаар ихээхэн анхаардаг.

Люксембург дэх Европын Шүүх Танхимыг (цаашид “ЕШТ” гэх) Страсбургт орших Европын Хүний Эрхийн Шүүхээс ялгаж ойлгох хэрэгтэй. ЕШТ нь нийгмийн хуулийг ард түмэнд хүргэж хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг. 1989 оноос хойш Европын Анхан Шатны Шүүх байгууллага нийгмийн хуулийн зарим нэгэн хэсэгт ЕШТ-ийн үндсэн үйл ажиллагаа гүйцэтгэх болсон. Уг холбооны гишүүн орнуудад ЕШТ-ийн шийдвэр дотоодын шийдвэрээс илүү хүчинтэй. Сайдын Зөвлөл, Парламент, Хороо гэсэн холбооны улс төрийн гурван байгууллага 1977 оны хамтын хэлэлцээрээр үндсэн эрх үүргээ баталсан бөгөөд мөн Европын Акт (1987) эдгээр байгууллагууд “үндсэн эрх ялангуяа эрх чөлөө, эрх тэгш байдал, нийгмийн эрх ашгийг эрхэмлэн ардчиллыг хөгжүүлэх үйлсэд хамтран ажиллана” гэдгээ тодорхойлсон юм.

Маастричд (Maastricht) энэ мэдэгдлийг шинэчлэн гаргасан. Энэ мэдэгдлийг хэрэгжүүлэхдээ, ЕШТ гишүүн орнуудын хуулийн уламжлалт нийтлэг шинж болон тэдний гарын үсэг зурсан гэрээ хэлэлцээрт тулгуурладаг. Үүний дундаас Хүний эрхийн тухай Европын Конвенци хамгийн чухал нь юм. Уг хэлэх эрх чөлөөг баталгаажуулсан Конвенцийн 10-р зүйл нь ЕШТ-ийн хууль, эрх зүйн эх сурвалжид хэдийнээ багтжээ. Хүний эрхийн хуулийн энэ гол хэсэг нь үндсэн эрхийг зөрчсөн асуудлуудын талаар Зөвлөлийнхөө эсрэг тэмцэлдсээр ирсэн. Үүнийг Зөвлөлийн хуулийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, Зөвлөлийн багц хуулийг тогтоох үндэсний арга хэмжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ. Хэрэв нийгмийн хуулийн хэрэгжилт нь зөрчилтэй, эсвэл аливаа үндэстэн уг зүйлд үл нийцэх арга хэмжээ явуулсан тохиолдолд ЕХШ 10-р зүйлийг баримтална. Гэвч гишүүн орны дотоодын хууль нь Зөвлөлийн хуулийн цар хүрээнд хамрагдаагүй тохиолдолд ЕШТ хөндлөнгөөс оролцдоггүй.

Хүний эрхийн тухай Европын Конвенц

Хүний Эрхийн тухай Европын Конвенцийн 10-р зүйлд “хүн бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй” гэжээ. Үүнд хил хязгаарын ялгаа болон нийгмийн удирдлагыг үл харгалзан мэдээлэл хүлээн авах ба түгээх эрх багтана. Гэвч энэ эрх чөлөөг дагалдах “үүрэг хариуцлага, хязгаарлалт”-ыг 10 дугаар зүйлд зааж өгсөн байдаг. Тухайлбал, ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай улс үндэстний аюулгүй байдал, газар нутгийн нэгдэл, нийгмийн аюулгүй байдал болон эмх замбараагүй байдал, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс хуулиар эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарладаг байна.

Эрх чөлөөг хязгаарлах өөр нэгэн шалтгаан нь эрүүл мэнд ба ёс суртахуун, хувь хүний нэр хүнд ба эрх чөлөө, хувийн нууцыг хадгалах болон “шүүхийн удирдах эрх ба шударга ёсыг” тогтоох явдал юм.

Европын Хүний Эрхийн Шүүх (цаашид “ЕХЭШ” гэх) нь олон нийт мэдээлэл түгээхийг хүсч буй хэн нэгний мэдээллийг сонсох эрхтэй гэж үздэг. 1979 онд “Sunday Times” сонин “Thailidomide” эмийн (энэ эмийг жирэмсэн эхчүүд хэрэглэдэг байсан боловч хожим энэ нь хүүхдийн бойжилтыг сааруулж тахир дутуу болгодгийг тогтоосон.) сөрөг үр дагаврыг олон нийтэд мэдээлснээр хуулиар уг сонины үйл ажиллагааг зогсоосон. Гэвч ЕХЭШ үүнд Британы шүүхийг буруутгасан бөгөөд “Sunday Times”-ийн зорилго бол ард түмэнд мэдээлэл хүргэх явдал байсан юм.

Засгийн газар, яам, агентлаг гэх мэт төрийн байгууллага мэдээлэл задруулахыг зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд шүүх үүнд болгоомжтой хандах нь зүйтэй юм. 1987 онд Швейцарын шүүх сэтгүүлчдэд газрын бүртгэлийн тухай мэдээлэл өгөхөөс татгалзсан нь тухайн нөхцөлд зөв шийдвэр байсан. Тэдний хуулиар асуудлыг сонирхох тодорхой шалтгаан бүрдсэн тохиолдолд мэдээллээр хангана хэмээн заасан бөгөөд сэтгүүлчдийн зорилго үүнтэй үл нийцнэ гэж үзсэн. Үүнийг ЕХЭШ хүлээн зөвшөөрсөн юм. Гэвч ЕХЭШ нь 10 дугаар зүйлд албан мэдээлэл ашиглах эрхийг бүрмөсөн хязгаарлаагүй гэж үздэг.

Ерөнхий дүгнэлт

Онөөдөр Европын Конвенц болон Европын Холбооны хуулиудад засгийн газар болон төрийн байгууллагаас мэдээлэл олж авах хууль эрх зүйн хангалттай үндсийг бүрдүүлж өгч чадахгүй байгаа юм.

Европын Холбооны хүрээнд мэдээлэл олж авах эрх

Зарим гишүүн орнууд Брюсселийн албан ёсны нууцын тухай шийдвэрийг эсэргүүцэж, өөрчлөхийг хүсдэг. Эдгээр эсэргүүцлийн зарим нь тухайлбал, 1996 оныг албаны нууцыг хадгалах журмыг дахин шалгах жил болгосон гэх мэт эерэг үр дүнд хүрсэн. Энэ нь бусад хүмүүс хатуу байр суурь баримталсан шийдвэр гаргахаас өмнө өөрсдийн нэн тэргүүний чухал зарчмуудыг илэрхийлэх боломж бидэнд олгож байна.

Нууцын тухай хууль тогтоомж

Сайдын зөвлөл хууль тогтоогчийн хувьд дүрэм, заавар, шийдвэрээрээ гишүүн орнуудыг хуулийн дагуу удирдан зааварладаг. Хорооноос ирүүлсэн саналын дагуу Зөвлөл энэ үүргийг гүйцэтгэдэг.

1992 онд Сайдын Зөвлөл хорооны бичиг баримттай танилцах тухай Бермингэм, Эдинбургэд хэлэлцсэн бөгөөд 1993 онд Данийн засгийн газар хэвлэлийг нээлттэй байлгахыг уриалсан юм.

Эцэст нь тус Зөвлөл 1993 оны 12 сард нээлттэй байдлыг ихээхэн хязгаарласан журмыг баталсан билээ.

Оноо үед Сайдын Зөвлөл доторх зарим үл сөргөлдөх маргааныг нийтэд нээлттэйгээр зохион байгуулдаг бөгөөд үйл ажиллагааныхаа журмын дагуу жилд доод тал нь 2 удаа нийтийн маргаан явуулахыг зөвшөөрсөн бөгөөд хэрэв явуулахаар бол сайдууд зөвшилд хүрэх ёстой байдаг.

Шийдвэрийн протоколыг журамд тэдгээрийг нууц байлгах ёстой гэсэн заалт байдаг. Хуулийн дагуу Зөвлөлийн шийдвэр гаргахад ашигласан хэлэлцүүлгийн баримтуудыг нууцалдаг бөгөөд олон нийт Зөвлөл эсвэл Хорооны бичиг баримтын ерөнхий бүртгэлтэй танилцах боломжгүй юм. Гэвч Европын Холбооны бусад бичиг баримттай танилцах өргөдөл нь товч тодорхой байх ёстой. Нийтийн байгууллагуудад баримтаа олонд мэдээлэх эсэхээ шийдэх сарын хугацаа олгодог. Татгалзсан хариу авсан тохиолдолд өргөдөл гаргагч шийдвэрийг дахин хянаж үзэх хүсэлтээ сарын хугацаанд өргөн барьж болно. Өргөдөл гаргагч ахин татгалзсан хариу авсныг ЕХ-ны байгууллагад мэдэгдэх хүртэл бас нэг сар болдог. Энэ тохиолдолд шалтгааныг тодорхойлвол зохино.

Шүүхийн үйл ажиллагааг хамруулан цаашид давж заалдах, шүүхийн түшмэлд санал хүсэлтээ илэрхийлж болно. Татгалзах болсны шалтгаан нь олон янз байх бөгөөд энэ нь тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны тэмдэглэл, баримтын нууцыг хадгалах сонирхлоос хамаардаг.

Дотроос тавьсан шүүмжлэл

Данийн засгийн газар нээлттэй байх явдлыг удаашруулж байгааг ил тод шүүмжлэн Эдинбургэд тохиролцсон амлалт талаар болсныг онцлон тэмдэглэсэн байдаг. “Зөвлөл зарим салбарт Холбооны иргэдэд шууд хамааралтай хууль батлах эрхтэй юм. Иймээс шүүх ажиллагаан дээр Зөвлөлд оруулсан Хорооны санал нь анхны нээлттэй хэлэлцүүлэгт заавал ордоггүй нь ноцтой асуудал мөн”.

Шууд сонгогддог Европын Парламент нээлттэй байдлыг дэмждэг бөгөөд 1992 онд Фэйот Шпитцэлийн тайлан АНУ-ын Мэдээллийн Эрх Чөлөөний тухай акттай төстэй удирдамж боловсруулахыг Хорооноос шаардсан. Парламентын дэмжлэгтэй энэ тайлан Нийгэм, үндэсний байгууллагуудын тухай мэдээ мэдээллийг баталгаатай авахыг санал болгосон. Энэ тайлан мөн сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалж болон “мэдээлэгч (шүгэл үлээгч) нар”-ыг хамгаалах үзлийг дэмжив.

1996 онд Парламент ЕХ-нд ил тод чиг бодлогыг хэрэгжүүлэх, ЕХ-ны баримт бичгийг хэрэглэх дүрэм журам бий болгох, Сайдын Зөвлөлийн хуралдааныг нээлттэй байлгах талаар санал хураасан аж.

Финни, Шведийн засгийн газрын аль аль нь илүү нээлттэй ил тод байдлыг уриалсан юм. 1995 оны 2-р сарын тайланд багтсан Финнийн санал Скандинавын хөршүүдийнхээсээ илүү боловсронгуй, гүнзгий бөгөөд олон улсын хэлэлцээрүүдэд эргэлт гаргаж ч болзошгүй юм.

Финнийн санал нь албан бичиг баримтын нууцын тухай асуудлаар гараагаа эхэлсэн бөгөөд Финни “ЕХ-ны бичиг баримтыг ашиглах ерөнхий дүрэм, журам нь үндсэн хуультай нийцэж байх шаардлагатай” гэсэн санал дэвшүүлсэн байна.

Европын нийгмийн гэрээнд шинэ 214а дугаар зүйлийг боловсруулан үүнийг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Скандинавын болон Нидерландын хуулиас жишээ авч албаны нууц бичиг баримтыг тодорхойлох журмыг тогтоох явдал Финнийн саналын гол зорилго нь байсан юм. Бичиг баримт тодорхой ангилагдаагүй тохиолдолд Зөвлөлийн хэлэлцээр ил тод, нээлттэй явагдах хэрэгтэй. Мөн Финлянд “Үйл ажиллагааны нууц болон хэсэг бүлэг нөхдийн сонирхлыг авч үзэхийн оронд олон нийтэд хамааралгүй бичиг баримтыг ангилан цэгцэлж, шаардлагатай үед тэдгээртэй танилцахыг татгалзаж, мөн зөвшөөрөх талаар шийдвэр гаргаж байх хэрэгтэй” гэсэн санал дэвшүүлсэн.

Мөн зөвлөлд “үйл ажиллагааг нээлттэй ил тод болгож, гишүүн орнууд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох” саналыг тавьсан байна. Зөвлөлийн хэлэлцээр, түүнээс гарсан тунхаглалын протоколыг олонд нээлттэй байлгах хэрэгтэй. Бичиг баримт болон хувилбарын үндсийг бүрдүүлж олон нийтэд дэлгэн тавих нь зүйтэй гэж Финлянд улс зөвлөсөн байна.

Мөн Финлянд улс сүүлийн үед бүртгэгдсэн хуулийн төслийн төлөвлөгөөний жагсаалт, Зөвлөлд ажиллах бүрэлдэхүүнийг мэдээлж байхыг шаардсан юм. Гадны бичиг баримт (засгийн газар болон тусгай сонирхогч хэсгийн тавьсан санал г.м) нууцлагдмал хадгалагддаг заншлыг төгсгөл болгох нь зүйтэй гэж үзжээ.

ЕХ-ны бүрэлдэхүүн, ажиллах хэсэг, Кореперийн зорилго, хөтөлбөр, ЕХ-ны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг ил тод мэдээлвэл зохих бөгөөд түүнчлэн ЕХ-ны албан бичиг баримтын тухай Шведийн саналыг хэрэгжүүлж болох хэдий ч энэ нь Зөвлөлийн ил тод байдлын хувьд Финляндынх шиг гүнзгий боловсронгуй биш юм. Дээрх арга хэмжээ нь ЕХ-ны бүрэлдэхүүн мэдээлэл хүлээн авах болон боловсруулах үйл ажиллагааг тодорхойлсон байдаг.

Хуулийн тэмцэл

Засгийн газрын нөлөөний нэгэн адил ЕХ-ны хуулийн арга хэрэгсэл мэдээлэл түгээх цар хүрээг тэлэхэд тодорхой хувь нэмэр оруулж чадна. 1995 онд Британийн сонин “Guardian”-ийн хэргийн үеэр анхан шатны шүүх (цаашид “ЕАШШ” гэх) Сайдын зөвлөлийн хэт их нууцлагдмал байдал нийгмийн хуульд сөргөөр нөлөөлж болзошгүйг анхааруулсан байдаг. Брюсселийн сонины сурвалжлагч Джонн Карвел 1994 онд Сайдын Зөвлөлөөс зарим нэгэн бичиг баримттай танилцах хүсэлт тавьсан боловч Хөдөө аж ахуйн Сайдын Зөвлөл татгалзсан байна. Энэ нь “Зөвлөлийн үйл ажиллагааны дотоод дүрмийн дагуу боломжгүй” гэсэн хариулт өгсөн юм.

Гэвч үйл ажиллагааны дотоод дүрмийн зүйл ангид “эсэргүүцэх боломжтой” гэсэн хэллэг хэрэглэсэн байдаг. Дани, Нидерландын Засгийн газар, Европын Парламентаас дэмжлэг авсан Карвел албан бичгийн нууц болон ил тодыг харьцуулж үзэлгүйгээр Зөвлөл шууд эсэргүүцсэн хэмээн гомдол гаргасан юм. ЕХАШШ “Guardian”-ийг дэмжиж “бичиг баримттай танилцах хүсэлт тавьсан тохиолдолд сонирхолыг харгалзан үзэж” ил тод байдал болон нууцыг дэнслэн тооцоолох хэрэгтэй гэж үзсэн. Гэвч уг заавар засгийн газарт мэдээлэл ашиглах хүсэлтийг няцаах өргөн боломж олгосон байдаг. Хэрэв тухайн асуудал нь хавсралт хуулийн шинжтэй эсвэл лавлагаа хийгдэх шатанд байгаа тохиолдолд нууцыг хадгалах мөн олон улсын худалдаа, үйлдвэрлэлийн нууц мэдээллийг задруулахгүй байх үүднээс нууцыг хадгалж болно.

Олон нийтэд зарлахыг эсэргүүцэх шийдвэр гаргах “хуулийн болон засаг захиргааны нөхцлүүд” байдаг. Гэвч зааварт ийм нөхцлүүдийг нарийн тодорхой зааж өгч чаддаггүй.

Заавар гаргагчид олон нийтэд зарлах боломжгүй байх үндэслэлүүдийг тогтоож болох байсан хэдий ч үүнийг тусгаагүй ажээ.

Харин цөмийн зэвсгийн нууцыг зөвхөн Холбооны хүрээнд хадгалах, ангилах тодорхой үндсийг заасан Евроатом гэрээнд Евроатомын төрөлд хамрагдах мэдээллийг ангилжээ. Нарийн чанд дэглэм өсөх дарааллаар дөрвөн зангилаа болгон Евро-хориглол, Евро-албаны нууц, Евро-нууц, Евро-маш нууц гэж хуваасан. Засаг захиргааны зөвшөөрөлгүйгээр олон нийтэд батлан хамгаалахын мэдээлэл тараах эрх байхгүй.

Улс орнуудаар харьцуулсан судалгааг дэлгэрэнгүйгээр “Глоб Интернэшнл” ТББ-аас эрхлэн гаргасан “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө” товхимолоос үзнэ үү.

Орчуулсан Түмэндэмбэрэл

§ Мэдээлэл олж авах тухай хуулийн төсөл боловсруулах нь -Төв болон Зүүн Европ, ТУХН-ын орнуудын чиг хандлага

Орчин үед мэдээллийн эрх чөлөө, ялангуяа төрийн албан хаагчдаас мэдээлэл олж авах эрхийн тухай асуудал олон нийтийн анхаарлыг ихээхэн татаж байна. Сүүлийн таван жилд дээрх эрхийг баталгаажуулах хууль тогтоомж баталж, хэрэгжүүлэх талаар дэлхий даяар дорвитой алхам хийжээ. Үүнд: Фижи, Энэтхэг, Япон, Омнөд Африк, Тринидад болон Англи зэрэг Европын хэд хэдэн орон хамрагдаж байна. Ингэснээр эдгээр улс хэдэн жилийн өмнөөс ийм хуультай болсон Швед, Америк, Финлянд, Нидерланд, Австрали, Канад зэрэг орны эгнээнд нэгдсэн юм. Мөн засгийн газар хоорондын байгууллагууд энэ асуудалд түлхүү анхаарал тавих болсон бөгөөд НҮБ, Европын Холбоо, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс илүү үр дүнд хүрсэн байна.

ТУХН-ын орнууд, Төв болон Зүүн Европын хэд хэдэн орон мэдээллийн эрх чөлөөний тухай хууль гаргажээ. Унгар улс 1992, Латви 1998, Чех 1998, Албани, Гүрж улс 1999 онд ийм хуультай болсон байна. 1992 онд Украйн улс албан ёсны мэдээлэл олж авах талаар “Мэдээллийн тухай” хуульдаа тусгасан хэдий ч энэ нь амьдрал дээр туйлын хязгаарлагдмал байдлаар хэрэгжиж байна. Оросын Холбооны улс “Мэдээлэл, мэдээлэлжүүлэлт, мэдээллийг хамгаалах тухай” хуульд албан ёсны мэдээлэл хүртэх боломжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд олгосон байна.

Мөн Болгар, Эстон, Литва, Молдав, Словак зэрэг улс энэ хүрээний хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, шинэ хуультай болох талаар янз бүрийн шатанд ярилцаж хэлэлцэж байна. Орос улс мэдээлэл олж авах ерөнхий эрхийн тухай авч үзэж байна.

“XIX зүйл” байгууллагаас Болгар, Молдав, Литва зэрэг орны энэ чиглэлийн хуулийн төслүүдэд судалгаа хийж, хуулийн төслийн заалтуудыг сайжруулах зорилго бүхий өргөн хүрээтэй компанит ажил явуулж байна.

Хуулийн харьцуулсан судалгааны үр дүнд “XIX зүйл” байгууллагаас 1999 онд “Олон нийтийн мэдэх эрх” нэртэй “Мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн зарчмууд” хэмээх олон улсын стандарт боловсруулсан юм.

Энэ баримт бичиг нь хууль боловсруулагч болон ийм төрлийн ажил эрхлэгчдэд мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл боловсруулах явцад тохиолддог гол бэрхшээл, асуудлыг тодруулан тайлбарлаж, ажлын удирдамж болгох зорилготой юм.

Энэхүү зорилго нь төсөлд тэр бүр байдаг жижиг өө сөв болгонд анхаарлаа хандуулахын тулд бус харин тохиолддог бэрхшээл, нийтлэг зүйлүүдийг тодотгоход оршиж байгаа юм. Энэ зөвлөмж ийм хууль хэлэлцэх, батлах үе шатандаа явж байгаа олон улс оронд тус болно гэдэгт бид найдаж байна.

Хуулиараа албан ёсны мэдээлэл олж авах эрхийг дээд зэргээр хамгаалсан байх нь туйлын чухал юм. Зарим хүн муу хууль гаргах нь огт хуульгүй байснаас илүү муу үр нөлөөтэй бөгөөд элдэв зөрчил маргаан үүсгэдэг гэж үздэг.

Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нийгэм нээлттэй, ил тод байх аугаа соёл, өндөр хэм хэмжээ агуулсан байх нь шударга ёсонд нийцнэ. Олон нийтэд үйлчилдэг байгууллага нь нээлттэй байх уламжлалгүй, эсвэл ёс төдий байдаг улс оронд хэдий муу хуультай ч Засгийн газрыг нээлттэй болгох анхны алхам болж болох юм.

Төв ба Зүүн Европын зарим орон ардчилсан зарчмын дэвшил бүхий улсуудын хувьд тааруу хууль гаргах нь зохимжгүй бөгөөд энэ нь хөгжлийн зөв зам өөд хөтлөхгүй.

“XIX зүйл” байгууллагын судалгаанд хамрагдсан хуулийн төслүүдийн ихэнх нь засгийн газар, олон нийтэд үйлчилдэг байгууллагуудыг илүү ил тод байлгахад чиглэгдсэн сайн заалтууд агуулсан байна.

Хэдий тийм боловч бидний судалж үзсэн хуулийн бүх төсөлд мэдээллийн эрх чөлөөний эрхийг үгүйдээ доод түвшинд ч болов хамгаалахад шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийх нь зүйтэй байна.

Ихэнх төсөлд зарим тодорхой чиг хандлага дутагдаж байна. Энэ нь тэдгээрийн зарим нь ийм хуулийн төсөл боловсруулах мэдлэг дутмаг, туршлага хомс, нөгөө хэсэг нь мэдээллийг өргөн хүрээнд нууц хэвээр хадгалах гэсэн хүсэл зэргээс урган гарчээ. Гэхдээ энэ нь хожим хуулийн төслийг илүү сайжруулахад нэмэр болдог.

Хуулийн төслүүдээс урган гардаг гол асуудлыг дор дурьдав.

1. Хуулийн бүтэц, зохион байгуулалт

Хуулийн үндсэн бүтэц ядмаг, ойлгомжтой логик дараалал үгүй байгаа нь нийтлэг дутагдал болжээ. Энэ нь тэдгээрийн хязгаар хүрээг ойлгоход хүндрэл учруулж, тайлбар хийхэд түвэгтэй, зөрчил нээлтэй болгоход хүргэж байна. Жишээ нь: хуульд нууцаас чөлөөлөгдөх мэдээллийг энд тэнд тарааж оруулсан нь чухамхүү алийг нь задруулахыг хориглосон болохыг олж мэдэхэд хүндрэл учруулж байна. “XIX зүйл” байгууллагын судалгаанд хамрагдсан нэг төсөлд хязгаарлалтыг ангилсан жагсаалтыг арван өөр хэсэгт оруулсан байна. Үүнтэй нэгэн адилаар мэдээлэл олж авах, эсвэл татгалзсаны учир санал гомдол гаргах журмын талаар хуулийн өөр өөр хэсэгт бүрхэг тусгасан байна. Хуулийг аль болох ойлгомжтой болгохын тулд хоорондоо холбоо бүхий заалтуудыг нэг дор тусгасан нь дээр байдаг. Хуулийн зорилго, үндсэн нэр томъёоны тодорхойлолт, чөлөөлөгдөх мэдээлэл, мэдээлэл олж авах журам, санал гомдол гаргах журам, бусад зүйл зэрэг нь нэгийг нь нөгөөгөөс нь ялгаж тодорхой болговол зохих чухал хэсгүүд юм.

2. Тодорхой бус зүйлс, давтагдсан хэллэг

Хуулийн заалтуудын томъёолол ойлгоход бэрх, ач холбогдол муутай болжээ. Шаардлагагүй, түвэгтэй томъёолол энгийн ойлголтыг ч ойлгомж муутай бүрхэг болгосон байна. Мөн зарим заалт энд тэнд давтагдаж, бусадтайгаа зөрчилдсөн нь харагдаж байна.

Жишээ нь, нэг хуулийн нэг хэсэгт нь мэдээлэл олж авахад аливаа төлбөр төлөхгүй гэж заасан хэрнээ өөр нэг газар төлбөрийн журмыг тусгасан байна. Хэд хэдэн дараалсан заалт нь үнэн чанартаа нэг зүйлийн тухай хэлж байгаа мөртөө тодорхой биш, томъёоллын хувьд төвөгтэй байх зэрэг нийтлэг дутагдал нэлээд байгаа бөгөөд тэдгээрийг ойлгомжтой томъёолж, нэг заалт болгон нэгтгэж болохоор байна.

Төслийн бүтэц, томъёоллын хувьд гэвэл, хэл зүйн үүднээс үгийг өнгөц, чамирхаж хэрэглэсэн байдал харагдаж байна. Энэ нь улсын байгууллагын үйлчилгээний ажилтан, хуульч, олон нийтийн төлөөлөгч зэрэг хүмүүсийн хуулийг ойлгож хэрэглэх чадварт нөлөөлнө. Хэрэв хуульд засгийн газрыг нээлтэй болгох асуудал ойлгомж муутай, түвэгтэй байдлаар туссан бол энэ нь албан ёсны мэдээллийн урсгалыг чөлөөтэй болгох, олон нийтэд үйлчилдэг байгууллага нээлттэй байх соёл уламжлал нэвтрүүлэхэд нөлөөлж чадахгүй.

3. Хуулийн зорилго

Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль эхнээсээ л олон нийтийн мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулах тодорхой зорилготой байх ёстой. Энэ нь олон нийтэд үйлчилдэг байгууллагуудын талаархи мэдээллийг аль болох өргөн хүрээнд нээлттэй болгох, туйлын хязгаарлагдмал нөхцөл байдалд л хаалт тавьж болох зарчимд тулгуурласан байвал зохино.

Олон нийтэд үйлчилдэг байгууллагууд мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд хүн бүр мэдээлэл хүлээн авах зохих ёсны эрхтэй. Тухайн улс орны аль ч дэвсгэр нутагт амьдарч байгаа хүн бүр ийм эрхээр хангагдана. Энэ эрхээ эдлэхдээ түүнээс тухайн мэдээллийг олж авах аливаа хүсэл сонирхлоо тайлбарлахыг шаардах ёсгүй. Албан ажилтан мэдээлэл өгөхөөс татгалзаж байгаа шалтгаанаа аль ч шатанд тайлбарлах, түүнийгээ нотлох үүргийг хүлээнэ. Өөрөөр хэлбэл, албан ажилтан нь тухайн мэдээлэл нууцын ангилалд багтаж буйг нотлох ёстой.

Хуулийн зарим төсөлд хуулийн зорилгыг ойлгомжтой, яв цав тодорхойлоогүй байна. Албани улсын хуулиас жишээ авахад, мэдээллийн эрхийг хамгаалах заалтыг энгийнээр тодорхойлохын оронд битүү хатуу, хоёрдмол утгатай илэрхийлсэн нь хэрэг дээрээ мэдээллийн эрх чөлөөний хамгаалалтыг бууруулсан ажээ.

Ийм жишээнүүдийг доор дурьдая.

- “Энэ хуулиар олон нийтийн мэдээлэл олж авахтай холбогдсон нийгмийн харилцааг зохицуулна” гээд
- Энэ хууль доорх зүйлийг зохицуулна.
 - а/ Олон нийтийн албан тушаалтан, байгууллага, иргэдийн хоорондын мэдээлэл олж авах эрхээ эдлэх явц дахь харилцаа,
 - б/ Өргөн олон нийтэд зориулагдсан мэдээлэл цуглуулах, боловсруулах, хэвлэн нийтлэх, тараах үйл ажиллагаа.

Суурьшинжтэй, нухацтай иймэрхүү төрөгдөл бас хэд хэдэн хуулийн төсөлд ажиглагдсан бөгөөд энэ талаар семинар, хэлэлцүүлгийн үед ч ярилцаж байсныг тэмдэглүүштэй. Дээр дурьдсан зүйл бол хэвлэл мэдээллийн хэрэгслийн ардчилсан нийгэмд дэх үүрэг, мөн төрийн ба төрийн бус гэж заагласан нь тухайн байгууллагын үүргийг бүрхэгдүүлж байгаа хэрэг юм. Нэгэн төсөлд олон түмний хэвлэл мэдээллийн хэрэгсэл түүнчлэн хувийн хэвлэл мэдээллийг хамруулсан бололтой (тэдгээрийг тусгайлан заагаагүй байсан), мэдээллийн эрх чөлөөний журмын дагуу л мэдээллийг задруулах шаардлага тавьсан байна. (Олон нийтэд үйлчилдэг байгууллагын тодорхойлолтыг харна уу)

Оөр нэг төслийг авч үзэхэд, хуулийг 2 хэсэгт хуваасан байна. Эхний хэсэг нь мэдээллийн эрх чөлөөний талаар, заалтуудыг агуулсан, хоёрдахь нь үнэндээ хэвлэл мэдээллийн тухай хууль байв. Хуулийн зорилгыг тодорхойлсон 1 дүгээр зүйлийн “в” хэсэгт “сэтгүүлч, мэдээлэл үйлдвэрлэгч тэдний эздийн эрх, үүргийг зохицуулах” хэмээн заажээ.

Хэдийгээр энэ жишээ туйлширсан боловч мэдээллийн эрх чөлөөний асуудалд хэвлэл мэдээллийн эрх, хариуцлагын тухай асуудлыг ойлгомжтой илэрхийлсэн байна. Суурь агуулгын хувьд ингэж ялгаж салгаж үзэх нь чухал бөгөөд энд дурьдсан нь сайн хэрэг юм.

Албан ёсны мэдээлэл олж авах эрхийг хөнгөвчлөх журам нь хэвлэл мэдээллийн талаарх төрийн ерөнхий зохицуулалтаас үндсээрээ өөр юм. Мэдээлэл хүлээн авах зохих ёсны эрх бүхий хүмүүст эрх хэмжээний хүрээнд мэдээлэл түгээх нь төр засгийн шууд үүрэг болохыг

тогтоож өгсөн байна. Энэ утгаар бол хэвлэл мэдээлэл нь үүргээсээ илүү эрхтэй гэсэн үг юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь төрийн байгууллага бус учир иргэдийн албан ёсны мэдээлэл олж авах эрхийг хэрэгжүүлэх, хангах шууд үүрэг байхгүй бөгөөд үүний хувьд төр засагтай ижил тэнцүү байх ёсгүй.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг мэдээллийн эрх чөлөөний хуультай холбож зохицуулсан заалт оруулах нь зохимжгүй бөгөөд тэдгээрийн суурь ялгааг бүрхэгдүүлэх аюултай. Хэвлэл мэдээлэлд үүрэг ногдуулсанаар түүний мэдээлэл, санаа бодлын эрх чөлөөг хязгаарлах практик нөлөөтэй. Хэвлэл мэдээлэлд хяналт тавих нь олон улсын эрх зүйтэй зөрчилдөнө. Хэвлэл мэдээллийг хянах тухай үзэл баримтлалыг мэдээлэл олж авах хуульд шингээхээс аюултай юм үгүй. Харин ингэснээрээ хэвлэл мэдээллийг төр засагтай эвсэж хамтран ажиллах соёл уламжлал тогтоно. Энэ нь сэтгүүлчийн засгийн газрын “хоточ нохой” байж хараат бусаар ажиллах бус харин мэдээллээ түгээхэд нь төр засагт туслах аюул төрүүлнэ.

4. Үндсэн нэр томъёоны тодорхойлолтын дутагдалтай байдал

Хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолтууд нь зохих шаардлага хангаагүй, бүрэн төгс тусгагдаагүй нийтлэг дутагдал байна. Энэ нь мөн л хуулийг ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг. Үүнд дараахь нэр томъёо орно:

Хуульд тусгасан мэдээ баримт, мэдээллийн талаар:

“Мэдээлэл”-д тэдгээрийн хадгалагдаж буй хэлбэр /баримт бичиг, соронзон бичлэг, электрон тайлан мэдээ гэх мэт/-ээс үл хамааран олон нийтэд үйлчлэх байгууллагын (бусад байгууллага ч ялгаагүй) бэлтгэсэн тайлан мэдээ баримт, тэдгээрийн эх сурвалж, түүнчлэн боловсруулсан цаг хугацааг хамруулбал зохино. Мөн хуульд адил шалгуураар нэрийн жагсаалтад оруулсан болон бусад ангилсан бүх мэдээ баримт бичгийг хамруулсан байх шаардлагатай.

Төсөлд ерөнхийдөө хуульд тусгах мэдээллийн цар хүрээ, мэдээллийн зааг хязгаарыг зохих түвшинд тодорхойлоогүй байна. Тодорхойлолт эргэлзээтэй, гол төлөв хэт явцуу байна. Тодорхойлолт өгсөн хэсгүүдэд олон нийтэд үйлчилдэг байгууллагуудын мэдээллийг энгийнээр томъёолон ялгааг нь гаргаж, янз бүрийн нэр томъёо хэрэглэж тодотгож өгсөнгүй. Жишээ нь: нэг төсөлд “албан ёсны мэдээлэл”, “төр засгийн байгууллагын мэдээлэл”, “олон нийтийн бусад мэдээлэл” гэсэн нэр томъёог нэг нь нөгөөгөөсөө ямар ялгаатайг нь тайлбарлалгүй оруулжээ.

Бас нэг төсөлд олон нийтийн үзэл бодлыг бүрэлдүүлэхэд тус болох мэдээллийг “олон нийтийн мэдээлэл” гэнэ хэмээн тодорхойлоод, үүнд гагцхүү олон нийтэд үйлчилдэг байгууллага төдийгүй аж ахуйн бусад бүх байгууллагын мэдээллийг хамруулан ойлгож болохоор тусгасан байна.

Мөн гагцхүү олон нийтэд үйлчилдэг байгууллагын бус харин мэдээллийн шинж чанар бүхий бүх баримт бичиг нийтэд хүртээмжтэй байх тухай тодорхой тусгаагүй байна. Нэг төсөлд “төр засгийн болон орон нутгийн захиргааны байгууллагын албан ёсны тайлан мэдээнд агуулагдаж буй олон нийтийн болон хувийн мэдээлэл”-ийг ил тод болгох талаар дурьдахдаа “мэдээлэл бүртгэгдэх шаардлагагүй, харин санаандгүй гарч явсны улмаас хуулбарлагдсан байж болно” гэсэн санаа агуулсан байх юм. Бас нэг төслийн мэдээлэл өгөх журмын хэсэгт ил тод болсон мэдээлэл “үнэн зөв, яв цав, бүрэн төгс” байх ёстой гэжээ. Үүний зэрэгцээ “албан ёсны баримт бичиг бүхий мэдээлэлд” нэвтрэх боломжтой бөгөөд мэдээлэл олж авахыг хүсэгч “албан ёсны баримт бичгийн хуулбарыг” хүлээн

авах тухай заажээ. Эдгээр нь нааштай хэдий ч, хэрэв мэдээ баримтыг бүхэлд нь олж авах боломж олдвол мэдээллийг нэг бүрчлэн тоочих шаардлагагүй юм. Цаашилбал, зарим төсөлд мэдээллийг аливаа шалгуургүйгээр хэсэгчлэн хүртэж болох нөхцөл боломжийг урьдчилан хамруулжээ. Хэрэв мэдээллийн тодорхой хэлбэрт нэвтрэх боломж өгөгдсөн бол түүний шалгуур, ангиллын журмыг тодорхой нарийвчлан заасан байх ёстой. Энэ нь аливаа шалгуургүйгээр мэдээлэл өгөхөөс татгалзсан албан тушаалтанд зохих үндэслэл болно.

Хоорондын ялгааг нь тайлбарлалгүйгээр ангилсан мэдээллийн тухай янз бүрийн нэр томъёог нэг хуульд хэрэглэх нь тохиолдож байна. Жишээ нь: нэг төсөлд “төрийн нууц”, “албаны нууц” гэсэн хоёр нэр томъёог хооронд нь ялгаж ангилалгүй, аль нэгийг нь иш татаж хэрэглэлгүйгээр өөр өөр хэсэгт оруулсан байна.

Олон хуульд бусад хуулиар нууцын ангилалд орсон мэдээлэл өгөхөөс татгалзахыг зөвшөөрсөн байна. Энэ нь Мэдээллийн Эрх Чөлөөний Хууль тогтоомжийг бусад хуулиар боомлихыг зөвшөөрч, зорилгыг нь бүрхэгдүүлдэг учир маргаантай асуудал юм (доор дурьдсан хувийн нууцын мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг үзнэ үү).

Хуульд олон нийтэд үйлчилдэг байгууллагын талаар:

Мэдээллийг ил тод болгох зорилгоор олон нийтэд үйлчилдэг байгууллагын тодорхойлолтыг томъёолохдоо ёс төдий хэлбэрдэлгүйгээр албан ёсны чиг үүргээс нь илүү үйлчилгээнийх нь төрөл хэлбэрт анхаарах нь зүйтэй. Олон нийтэд үйлчилдэг байгууллагад орон нутгийн захиргааны байгууллагыг оруулан Засгийн газрын бүтцийн бүх түвшин, салбарын байгууллага, сонгуульт байгууллага, хуулиар эрхийг нь тогтоосон байгууллага, үндэсний үйлдвэрлэл, олон нийтийн корпораци, бие даасан байгууллага (засгийн газраас байгуулагдсан боловч хууль, эрх зүйн хувьд бие даасан), хуулийн байгууллага, олон нийтэд үйлчлэх үүрэг бүхий (зам засах, төмөр зам г.м) хувийн байгууллагууд хамаарна. Байгаль орчин, эрүүл мэнд зэрэг олон нийтийн амин чухал ашиг сонирхолд хохирол учруулах эрсдлийг багасгахуйц мэдээлэлтэй хувийн байгууллагууд мөн өөрсдийгөө үүнд хамруулбал зохино. Засгийн газар хоорондын байгууллагууд ч мэдээллийн эрх чөлөөний дэглэмд хамаатай юм.

“19-р зүйл” байгууллагын судалгаанд хамрагдсан хуулийн төслүүдэд олон нийтэд үйлчлэх байгууллагын тодорхойлолт нь түүнд хамаарах байгууллагуудыг зохих ёсоор хамруулж чадаагүй байна. Зарим нэр томъёог “Нийгэм-улс төрийн байгууллагууд” гэх мэтээр огт тодорхойлолт тодорхой бус оруулсан ч харагдаж байна. Хуульд хамруулсан байгууллагуудад “олон нийтийн хэвлэл мэдээллийн ил тод байдлыг хангах, олон нийтийн мэдээллийг ил тод болгох” гэх мэтээр зүй бус шаардлага тавьсан нь бас нэг бэрхшээл байна. Энэ нь ардчилсан нийгэм дэх мэдээллийн хэрэгслийн үүрэг ролийг илт гажуудуулж байгааг онцгойлж тэмдэглэмээр байна /дээрх “Хуулийн зорилт”-ыг үз/. Ийм заалтыг төрөөс санхүүждэг мэдээллийн хэрэгсэлд хүлээн зөвшөөрч болох хэдий ч хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд бол хууль бус юм. Цаашилбал төрөөс санхүүждэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ийм үүрэг хариуцлагыг ногдуулж буй бол энэ нь нэргүй мэдээллийн эх сурвалжийг хамгаалах хэвлэл мэдээллийн эрхийн талаарх тодорхой заалттай хосолсон байх ёстой.

Бас нэг төсөлд тухайн хуулийн дагуу төрийн бус байгууллагуудыг мэдээллээ ил тод болгохыг хүчилсэн байна. Үүнд зарим талаар олон нийтэд үйлчлэх чиг үүрэг хүлээсэн Засгийн газартай холбоотой ТББ-ын төдийгүй хараат бус ТББ-ыг хамруулсан байна. Энэ нь өргөн түгсэн хэтрүүлэг бөгөөд нийгэмд туйлын сөрөг нөлөөтэй юм.

Хэн мэдээлэл олж авах эрхтэй вэ?

Хуулийн дагуу албан ёсны мэдээлэл нь тухайн улсын байнгын оршин суугчид буюу иргэд төдийгүй харьяалал нь асуудалтай байгаа этгээдэд ч нээлттэй байвал зохино. Зөвхөн иргэд, эсвэл байнгын оршин суугчдаар мэдээлэл хүртэх эрх хязгаарлагдвал олон тооны хүн ард нь үлдэх бөгөөд энэ нь харьяалалын асуудлаа шийдвэрлээгүй байгаа улс орнуудын иргэдийн хувьд онцгой хүндрэл учруулах болно.

Ерөнхийдөө “19-р зүйл” байгууллагын судалгаанд хамрагдсан хуулийн төслүүдэд эрх хэмжээнийхээ хүрээнд албан ёсны мэдээлэл олж авах тодорхой эрхийг тогтоож өгөөгүй байна. Зарим хууль зөвхөн иргэдийн, зарим нь иргэн, харьяалалгүй хүн, гадаадын байнга оршин суугчдийн эрхийг баталгаажуулсан байна. Нэг хуульд “аливаа этгээд” албан ёсны мэдээлэл олж авах эрхтэй гэсэн журам дэгийг тодорхойлсон хэсэгт зөвхөн “иргэд” гэсэн байх юм. Энэ нь хайнга хандсантай холбоотой байж болох хэдий ч үг үсэг бүхэн нь тайлбар шаарддаг хуулийн баримт бичгийн хувьд зохисгүй алдаа болжээ.

5. Мэдээллийг ил болгохоос татгалзах

Мэдээллийн эрх чөлөөний тухай аливаа хуульд хамгийн төвөгтэй, маргаантай нэг зүйл бол мэдээллийг ил тод болгохоос татгалзах дэгийн тухай асуудал юм. Олон нийтийн мэдэх эрх болон хууль ёсны бусад ашиг сонирхлын хоорондын тэнцвэрийн дэг боловсруулахдаа ихэд хянамгай авч үзэх нь чухал. Учир нь энэ асуудал бидний судалсан бүх хуулийн төсөлд хамгийн тулгамдсан зүйлийн нэг болж байсантай холбоотой байж болох юм. Үүний учир шалтгааны талаар дээр дурьдсан билээ. Жишээ нь: Нууц мэдээллийн жагсаалтыг бүлэг болгож, нэг хэсэгт оруулалгүй, хэд хэдэн газар оруулснаас түүнд тайлбар хийхэд хүндрэл учирдаг.

Мөн томъёололын хувьд бүрхэг тодорхой бус байгаа нь мэдээллийн тусгай ангилалд бус, харин өргөн утгатай ойлголтод хамруулж болохоор болжээ. Энэ нь заалтуудыг илүү өргөн хүрээнд ойлгож тайлбарлахад хүргэж буй тул албан тушаалтнуудад тэдгээрийг хэтрүүлэн ашиглах боломж бий болгодог. Мэдээллийг нууцлах, хүлээн зөвшөөрч үл болох үндэслэлийг дор дурьдав.

- “ёс зүйн хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээтэй” зөрчилдөж байвал;
- “иргэний “хувийн шударга ёс”-д харшилж байвал;
- “бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол”-д харшилж байвал;
- хүрээлэн буй орчинд нөлөөлөхөөр бол;
- “нотариатын мэдээлэл, баримт бичиг” болох нь тогтоогдвол.

Нэг хуульд мэдээллийг хязгаарласан аливаа ангилалгүйгээр зүгээр л бусад хуулиар хязгаарлагдсан албан ёсны аливаа мэдээллийг нууцална гэж заасан байна. Энэ нь мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн анхдагч /доорхи “Мэдээллийн эрх чөлөөний хуулийн анхдагч зүйлийг харна уу/ зарчмыг гажуудуулж, бусад хууль сайн ч бай, муу ч бай мэдээллийн эрх чөлөөний дэгээс дээгүүр үзэхэд хүргэдэг юм.

Үүнээс ч илүү дутагдлууд бас байна. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хүчтэй үндсэн шаардлага болох “Олон нийтийн ашиг сонирхол, бодит “хор уршиг”-ийн шалгуурууд дутагдаж байгаа нь төслүүдийн гол цоорхой, сул тал болж байна. “19-р зүйл” байгууллагын мэдээллийн эрх чөлөөний зарчмуудын дагуу олон нийтэд үйлчилдэг байгууллага өөрөө

хүссэн хүсээгүй бүх мэдээлэл нь нууцаас чөлөөлөгдвөл зохино. Мэдээллийг нууцаас чөлөөлөхөд доорх гурван талт шалгуурыг хангасан байвал зохино.

1. Задруулж үл болохоор хуульд нэг бүрчлэн заасан мэдээлэлд багтсан байх;
2. Тухайн мэдээллийг задруулвал хуулиар нууцыг нь хамгаалсан ашиг сонирхолд бодит хор уршиг учруулж болох;
3. Тэрхүү ашиг сонирхолд учруулах хор уршиг нь мэдээлэл хүртэгч олон нийтийн ашиг сонирхлоос дээгүүр байж болно. Энэ нь мэдээллийг задруулбал нь хууль ёсны зорилгод хор уршиг учруулахуйц байсан хэдий ч ил тод болгосны үр ашиг нь түүнээс илүү бол мэдээллийг ил тод болгож болно гэсэн үг юм.

Хуулийн төсөл нь олон нийтийн ашиг сонирхлын шалгуурыг хангасан ч олон нийтийн ашиг сонирхол бүхий мэдээллийг зохих шаардлагатай түвшинд хамгаалж чадаагүй бол сулхан болдог. Жишээ нь: нэг төсөлд хязгаарлах мэдээллийн жагсаалтын төгсгөлд "Гэсэн хэдий ч үүнийг олон нийтийн мэдээлэх хүртэх ашиг сонирхолтой нягт тэнцвэржүүлсэн байх ёстой" гэсэн өгүүлбэр нэмжээ. Ийнхүү хүч нэмэгдүүлсэн, эсвэл утга санаа агуулсан ухагдахууны хувьд гэвэл эрх хэмжээний талаарх тусгай заалтыг томъёолж оруулах ёстой бөгөөд үүнийгээ дээр дурьдсан 3 талт шалгуурын үндсэн дээр тодорхой ойлгомжтой болговол зохино.

Олон нийтийн ашиг сонирхлыг хангасан хэдий ч тэр нь хүчгүй, бүх мэдээллийг хүртэх боломжгүй байгаа жишээ ч байна. Төрийн, албаны, арилжааны, эсвэл банкны нууц зэрэг мэдээллийн зарим ангилал олон нийтийн ашиг сонирхлын шалгуурд үл нийцэх давхар хориг болж байна. Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, гадаад бодлого, газар нутгийн бүрэн бүтэн байдал, нийгмийн хэв журам, мөнгөний бодлогын зэрэг бусад хэлбэрийн мэдээлэл нь олон нийтийн ашиг сонирхлын шалгуурын дагуу харьцангуй байдалд нууцлагддаг.

6. Мэдээллийн эрх чөлөөний хуулийн анхдагч зарчим

Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь эрх зүйн энэ салбарт гол эх сурвалж болдгийн хувьд бусад хууль тогтоомжид энэ хуульд зааснаас өөр хэлбэрийн, олон тооны хязгаарлалтын журмыг тусгах боломж олгохгүй байвал зохино. Зарим тохиолдолд хуулийн төслүүдэд мэдээлэл үл задруулах янз бүрийн дэг журмыг бусад хуулиар зохицуулах боломж олгосон байгаа бөгөөд тэдгээр нь мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиас давуу үйлчлэхээр байгаа нь харагдаж байна. Энэ нь хуулийн зорилгыг ноцтой бууруулж, бүхэлдээ мэдээллийн эрх чөлөөний дэгийн утгыг алдагдуулахад хүргэж байна. Нууцаас чөлөөлөгдөх мэдээллийн дэгийг хуулийн төсөлд албан ёсны бүх нууц мэдээллийн бүхий л ангиллыг хамруулж, бусад хууль тогтоомжид тэдгээрийг үл задруулах, мэдээллийг хязгаарлах заалт оруулахыг үл зөвшөөрвөл зохино.

Мөн мэдээллийн эрх чөлөөний хуулийг төгс хэрэгжүүлэхийн тулд нууцын хууль зэрэг бусад хууль тогтоомжтой нарийн уялдуулах нь зүйтэй. Энэ явцад мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн зарчмуудад тулгуурлах нь зүйтэй. Энэ шаардлага хуулийн төслүүдэд цоорхой үлдсэнийг тэмдэглүүштэй.

7. Мэдээлэл олж авах дэг журам

Олон нийтийн зүгээс мэдээлэл хүсэх үндсэн дэг журам хуульд зохих ёсоор тусгагдсан байх хэрэгтэй. Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон Үндсэн хуульд заасан

эрхийн хамгаалалт хоёрын үндсэн ялгаа гэвэл хожим эрхээ эдлэх механизмыг хангаж буйд оршино. Хүсэлт тавих журмын заалтууд дутуу байх нь олон нийтэд үйлчилдэг байгууллагуудад хүссэнээ чөлөөтэй хийх боломж олгож, хуулийг бүхэлд нь ноцтой сулруулахад хүргэнэ.

Хуулийн төслүүдэд тусгасан мэдээлэл авах хугацаа нь ерөнхийдөө харьцангуй богино, ихэвчлэн 4-15 хоногийн дотор /нэг хуульд хугацааг 30 хүртэл хоног гэж заасан бөгөөд хэд хэдэн шалтгаанаар сунгаж болно/ гэсэн байна. Шинэ Зеланд, АНУ, Канад, Австралийн мэдээллийн эрх чөлөөний хууль, Их Британийн мэдээллийн эрх чөлөөний хуулийн төсөл¹-д заасан хугацаа тохиромжтой юм.

Хэдийгээр шинэлэг бус ч гэлээ хуулиудад² олон нийтэд үйлчилдэг байгууллагын гуравдагч талаас мэдээлэл хайх, тухайлбал мэдээллээс иш татах, мэдээлэл олж авах зөвшөөрлийн талаар тусгасан байна. Энэ нь албаны мэдээлэл олж авах эрхийг зүй бусаар хязгаарлаж, хуулийн зорилгыг сулруулж буй хэрэг юм. Мэдээллийг нууцлах талаар хангалттай шалтгаантай бол энэ нь зөвшөөрөгдсөн жагсаалтад багтах тул хөндлөнгийн этгээдтэй зөвлөлдөх шаардлагагүй юм.

Мэдээлэл авах төлбөрийн талаар ерөнхийдөө нарийвчлан заадаггүй. Тухайн хүсэлт шаардлагад нийцээгүй өндөр төлбөр тогтоохгүйн үүднээс хуульд зөвхөн төлбөрийн доод, боломжийн хэмжээг тусгасан заалт байх нь ашигтай байдаг.

8. Давж заалдах журам

Төслүүдэд мэдээллийг ил болгохоос татгалзсаны эсрэг давж заалдах журам “19-р зүйл” байгууллагын мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийн зарчмыг хангаж чадаагүй, ерөнхийдөө сулавтар байна.

Давж заалдах журмыг 3 хэлбэрээр тогтоож болно. Энэ нь дотооддоо давж заалдах буюу тухайн олон нийтэд үйлчилдэг байгууллагын дээд шатны эрх мэдэл бүхий хүнд гомдол гаргах, Омбудсмен, Хүний Эрхийн Комисс зэрэг хараат бус захиргааны байгууллагад хандаж давж заалдах хувь хүний эрх, хувь хүн, олон нийтэд үйлчилдэг байгууллага хоёр захиргааны шийдвэрийн эсрэг шүүхээс өмнө давж заалдах журам юм.

2 дахь хэлбэр болох хараат бус байгууллагын талаар хуульд ерөнхийдөө тусгаагүй байна. Энэ байгууллага нь мэдээллийн эрх чөлөөний хуулийн нэг чухал элемент юм. Иймэрхүү журам нь иргэдэд шүүхэд давж заалдахтай холбогдсон зардал, цаг алдалтыг тойрох, хууль эрх зүйн ээдрээтэй маргаангүйгээр олон нийтэд үйлчилдэг байгууллагын шийдвэрийг өөрчлөх боломж олддог.

1 Шинэ Зеланд, АНУ болон сүүлийн үеийн хувилбар болох Английн хуулийн төсөл, хүсэлтэд хариу өгөх хугацаа нь 20 хоног. Канад болон Австрали улсад 30 хоног.

2 Хуульд заасан гуравдагч талд хувь хүн, хувийн байгууллага, мэдээлэл нь ил болоход эрх ашиг сонирхолд нь нөлөөлөх талууд орно. Хувийн мэдээллийн хамгаалалтын тухай хуулиудад тусгаснаар энэ нь мэдээллийн эрх чөлөөний хуулиас хасагдана.

9. Нийтлэг хийдэл-Хамгаалалт

Энэ нь албан ёсны мэдээллийн эрх чөлөөний хуулийн хэрэгжилтийг сайжруулахтай холбогдсон олон асуудал, журам, механизм байдаг. Эдгээр нь нийтдээ төслүүдэд тусгагдаагүй байна. Тэдгээр нь:

а/Тодорхой төрлийн мэдээллийг зайлиггүй хэвлэн нийтлэх үүрэг

Мэдээллийн эрх чөлөө нь гагцхүү олон нийтэд үйлчилдэг байгууллагаас мэдээлэл хүссэн хүсэлтийг хангах бус, мөн олон нийтийн ашиг сонирхол бүхий чухал ач холбогдолтой баримт бичгийг хэвлэн нийтлэх, түгээх, тараахтай холбоотой юм. Энд зөвхөн эх сурвалжид тулгуурласан, учир шалтгаантай хязгаарлалт, хүчин чадлын тухай л яриа байж болно. Зарим үед Засгийн газар олон нийтийн санал хүсэлт, мэдээлэл олж авахтай холбоотой төгс систем бий болгох, үйл ажиллагаа явуулах нь үнэ өндөртэй, хөрөнгийн эх үүсвэр хангалтгүй хэмээн эсэргүүцдэг. Олон нийтэд зориулсан өргөн цар хүрээ бүхий материаллаг бааз бий болбол энэ нь Засгийн газрын ачааллыг хөнгөлж, олон нийт аяндаа мэдээллээр хангагдан яваандаа эх үүсвэртэй холбоотой бэрхшээл ч арилна.

б/ Мэдээллийг үл устгах, түүнийг зохих ёсоор хадгалах үүрэг

Мэдээ баримт, материалын жинхэнэ төрх бүрэн бүтэн байдлыг хамгаалахын тулд хуулиар мэдээлэл олж авахад хориг саад тавих, мэдээ баримтыг санаатайгаар устгахыг гэмт хэрэг гэж үзэх, олон нийтэд үйлчилдэг байгууллагад зориулан тэдгээрийн хадгалах, хамгаалахтай холбоотой доод түвшний стандарт тогтоох нь зүйтэй.

в/ Дэмжлэг үзүүлэх, боловсрол олгох үйл ажиллагаа

Мэдээллийн эрх чөлөөний хуультай улс орнуудын туршлагаас харахад нэг нууцаас нэг ил тод байдалд хүрэх иргэний нийгмийн үйлчилгээний соёлын шинэчлэл нь 10, түүнээс илүү олон жилийн хугацаанд өрнөх удаан үйл явц байдаг ажээ. Ийм учраас хуульд Засгийн газар доторх нууцын уламжлал соёлыг халах олон механизмыг хангаж өгвөл зохино. Энэ нь ялангуяа олон жилийн турш коммунист дэглэмд байсан Засгийн газрын нууцын уламжлалтай улс оронд нэн чухал асуудал юм. Иймд хууль:

- Мэдээлэл хүртэх эрхийн талаарх мэдээлэл түгээх эрх, олон нийтэд боловсрол олгох идэвхтэй кампанит ажил зохион байгуулах тухай заалт оруулах нь зүйтэй.
- Мэдээллийн эрх чөлөөний хууль тогтоомжийн хүрээ хязгаар, ач холбогдол, мэдээллийг ил болгох журам, мэдээ баримтыг арчлан тордох, тэдгээрт нэвтрэх талаар албан хаагчдад сургалт явуулах гэх мэтээр Засгийн газрын нууцын уламжлал соёлыг шинэчлэх механизмуудыг тусгавал зохино.

г/ Мэдээлэгчийг хамгаалах

Хувь хүмүүс нь гэмт хэрэг, халдлага, хуулийн хариуцлага хүлээлгэх явдал хэрэгжихгүй байгаа, авилга, ёс суртахуунгүй байдал, шүүх, олон нийтэд үйлчилдэг байгууллагын удирдлагын буруутай үйл ажиллагааны тухай зэрэг хууль эрх зүй, захиргаа, ажил эрхлэлттэй холбогдолтой үйлдлийг мэдээлж, ил гаргахдаа хуулийн хамгаалалтад байх ёстой. Үүнд мөн хувь хүний {санаатай, санамсаргүй} буруутай үйлдлийн улмаас хүмүүсийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд ноцтой аюул учуулсан тухай мэдээлэл багтана.

Мэдээлэгч аливаа буруутай үйл ажиллагааны талаар үнэн зөв, нотолгоотой мэдээлэл өгч, чин шударга, үндэслэлтэй итгэлтэй хандсан бол хуулиар удаан хугацаанд хамгаалуулах нь зүйтэй.

Зарим орон мэдээллийг тодорхой хувь хүн, хяналтын байгууллагад илчлэх шаардлага тавьж, ийм нөхцөлтэйгөөр мэдээлэгчийг хамгаалалтад авдаг байна. Үүнийг ерөнхийд нь хүлээн зөвшөөрөхийн сацуу олон нийтийн ашиг сонирхлын шаардлага хангахуйц мэдээллийг бусад хүмүүс, хэвлэл мэдээлэлд өгсөн үед хамгаалалт хийх нь зүйтэй.

д/ Нээлттэй хуралдаан

Мэдээллийн эрх чөлөөнд Засгийн газар ард олны нэрийн өмнөөс юу хийж буйг олж мэдэх эрх, шийдвэр гаргах явцад оролцох эрх багтана. Үүнд үндэсний, орон нутгийн засаг захиргааны байгууллага, төлөвлөлтийн хороод, боловсролын салбарын эрх мэдэлтэн, олон нийтийн үйлдвэрлэл хөгжлийн агентлаг, олон нийтэд үйлчилдэг бусад адил төстэй байгууллагын албан ёсны хурал хуралдаан орно. Хуралдаан нь зөвхөн тогтоосон журмын дагуу хаалттай явагдах бөгөөд энэ нь зохих үндэслэл, шалтгаантай байвал зохино. Хуралдааныг хаалттай явуулах шийдвэр нь өөрөө олон нийтэд нээлттэй байх ёстой. Хуульд олон нийтэд үйлчилдэг байгууллагын хуралдаан нээлттэй байх, хуралдаанд байлцахыг зөвшөөрсөн зохих мэдэгдлийг урьдчилан олгох, хуралдааныг бүрэн, эсвэл хэсэгчлэн хаалттай явуулах зэргийг заасан байвал зохино.

10. Дүгнэлт

Ардчиллыг бэхжүүлэхэд мэдээллийн эрх чөлөө хамгийн чухал үүрэг гүйцэтгэнэ. Олон нийтэд үйлчилдэг байгууллагын мэдээлэл бол улс төрч, албан тушаалтнуудын тусын тулд бус харин олон нийтийн ашиг сонирхолд зориулагдсан юм. Мэдээллийг нууцлах чухал шаардлага үндэслэл байсан ч түүнийг хүн бүр олж авах, хүртэх боломжтой байх нь зүйтэй. Хамгийн чухал нь, мэдээллийн эрх чөлөө бол хариуцлага хүлээх чадвартай, ил тод Засгийн газрын нэг гол бүрэлдэхүүн хэсэг юм.

Энэ нь иргэдэд Засгийн газрын явуулж байгаа үйл ажиллагаа, авилгыг илрүүлэх, удирдлагын алдаатай ажлыг харах боломж олгоход голлох үүрэг гүйцэтгэнэ. Засгийн газар нээлттэй байх нь сонгогчид сонгуульд албан тушаалтныхаа үйл ажиллагааг үнэлж дүгнэхэд зайлшгүй шаардлагатай. Мөн шинэ бодлогын эсрэг тухай бүр эсэргүүцлээ илэрхийлэх жишээгээр ард иргэдэд өөрийн ардчилсан эрхийг үр өгөөжтэй эдлэхэд ч чухал билээ.

Улс орнуудад хууль тогтоомжоор дамжуулан мэдээллийн эрх чөлөөний эрхийг хангах талаар бодитой алхам хийх үүрэг хариуцлагыг төр өөрөө хүлээх нь нэмэгдэж байна. Үндсэн хуулийн заалтаар мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулж байгаа нь ард нийт өөрийн хүсэлтээр эрх мэдэлтнүүдийг сонгодог, ардчилсан үйл явцын хэвийн бөгөөд зохих хэм хэмжээ гэж үзэх улс төрийн соёлыг эрхэмлэх эрмэлзлэл юм.

Мэдээлэл хүртэх хууль тогтоомж Үндсэн хуулийн заалтыг илүү баталгаажуулдаг. Ийм хууль үгүй бол чухамхүү яагаад мэдээллээ нууцалж буй үндэслэлээ Засгийн газар тодруулах шаардлагатай болно. Энэ нь эргээд өөрөө хариуцлага ноогдуулж буй хэргэ юм. Төв болон Зүүн Европ, ТУХН-ийн орнууд мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн зохицуулалттай болох талаар ач холбогдол бүхий алхам хийж байна Иймд үүнийг бүх талаар талархан дэмжүүштэй юм. Мэдээлэл хүртэх суут эрхийг хамгаалах сайн хуулийн төсөл боловсруулах нь туйлын чухал бөгөөд үүний тулд төрийн бус байгууллагууд, хууль боловсруулагч, хууль тогтоогчтой хамтран ажиллах нь тулгамдсан үйлс юм.

Орчуулсан Түмэндэмбэрэл

III. ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

§ Чөлөөт хэвлэлийн харти

Чөлөөт хэвлэлийн хартиг 1987 оны 1-р сарын 16-18 ны өдрүүдэд Лондон хотноо болсон "Дэлхийн эрх чөлөөний дуу хоолой" цагдан хяналтын (цензур) эсрэг бага хурлын төлөөлөгч, 34 орны сэтгүүлчид баталжээ. Энэхүү бага хурлыг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний хороо WPFC олон улсын хэвлэн нийтлэгчдийн холбоо (FIEJ) Олон улсын хэвлэлийн хүрээлэн (IPI), Америк Дундын хэвлэлийн эвлэл (IAPA), Хойд Америкийн өргөн нэвтрүүлэгчдийн эвлэл (NANBA) Олон улсын тоймол хэвлэлийн холбоо (IFPP) хамтран зохион байгуулсан юм. Хэвлэлийн эрх чөлөөний Хартын заалтууд нь чөлөөт хараат бус хэвлэл мэдээллийг дэмжихэд зайлшгүй зарчмуудыг өргөн хүрээтэй агуулсан бөгөөд хамгийн өргөн хүрээтэй хүсэлтийг зөвшөөрсөн баримт бичиг юм. Эдгээр зарчмыг 1989 онд, 1991 Лондонд, 1991 онд Москва хотноо Хэвлэл мэдээллийн асуудлаар болсон чуулга уулзалт, дугуй ширээний ярилцлага, 1891 онд Осло хотод болсон Ардчилсан байгууллагуудын шинжээчдийн зөвлөгөөнөөр хүлээн зөвшөөрчээ. Чөлөөт хэвлэл гэж чөлөөт ард иргэдийг хэлнэ. Улс үндэстэн дотор болон хилийн чанадад мэдээлэл, мэдээг саадгүй түгээх, ардчилсан байгуулалтыг хамгаалах, хөгжүүлэх үүрэг хүлээсэн бүхнийг дэмжихэд дараахь зарчим үндэс суурь болно.

1. Шууд болон шууд бус цагдан хяналтыг үл зөвшөөрнө. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийг чөлөөтэй цуглуулах, түгээх эрхийг хязгаарласан аливаа хууль, практик үйл ажиллагааг хориглох ёстой. Засгийн газрын, үндэсний болон орон нутгийн эрх мэдэлтнүүд үндэсний болон хэвлэмэл болон өргөн нэвтрүүлгийн мэдээллийн хэрэгслийн агуулгад хөндлөнгөөс оролцох, эсвэл мэдээллийн эх сурвалжид нэвтрэх боломжийг хязгаарлах ёсгүй.
2. Бүх улс оронд хэвлэмэл болон өргөн нэвтрүүлгийн хараат бус мэдээллийн хэрэгсэл байгуулах, үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулахыг зөвшөөрөх ёстой.
3. Засгийн газар нь улсынхаа мэдээллийн хэрэгслийн хандлага, эдийн засгийн байдал, эсхүл бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхах ёсгүй. Засгийн газрын мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй улс орнуудад хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгслийн адил хэвлэн нийтлэх, өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэхээр зайлшгүй хэрэгцээт материаллаг болон боломж нөхцөлтэй байх ёстой.
4. Улс орнууд сонины цаас, хэвлэх үйлдвэрийн боломжийг түшиглэн сонин, мэдээллийн ажиглалт явуулсан, өргөн нэвтрүүлгийн долгион, боломж нөхцлийг хязгаарлах ёсгүй.
5. Мэдээлэл түгээлтэд шахалт үзүүлэх, мэдээллийн урсгалыг хязгаарладаг харилцаа холбооны эрх зүй, техник, үнэ тарифын практикийг халбал зохино.
6. Засгийн газрын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд редакцийн хараат бус байдлыг эрхэмлэх, янз бүрийн үзэл бодлоо илэрхийлэхэд нээлттэй байх ёстой. Үүнийг эрх зүй, практикийн хүрээнд баталгаажуулбал зохино.
7. Хэвлэмэл болон өргөн нэвтрүүлгийн мэдээллийн хэрэгслийг дотооддоо болон гадаадад мэдээ, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх боломжид хязгаарлалт тавих ёсгүй. Олон нийт гадаадын хэвлэл, гадаадын өргөн нэвтрүүлгийг хөндлөнгийн оролцоогүй хүлээн авах

шинэ эрх чөлөө эдэлбэл зохино.

8. Улс орны хил хязгаар гадаадын сэтгүүлчдэд нээлттэй байх ёстой.

а) Ердийн гарам тэдэнд үйлчлэх ёсгүй.

б) Тэдний ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай, Виз хүссэн өргөдөл, мэргэжлийн итгэмжлэх, бусад баримт бичгийг саадгүй олговол зохино.

Гадаадын сэтгүүлчдэд улс орон дотороо чөлөөтэй зорчих, албаны болон албан бус мэдээллийн эх сурвалжид нэвтрэхийг зөвшөөрвөл зохино.

9. Зөвшөөрөл, үнэмлэх бусад журмаар дамжуулан сэтгүүл зүйн салбар, эсхүл түүний практик үйл ажиллагаатай холбоотойгоор улс оронд чөлөөтэй орохыг хязгаарлах явдлыг устгавал зохино.

10. Бусад иргэдийн адил сэтгүүлчдийн хувийн аюулгүй байдлыг хуулиар хамгаалах ёстой. Дайны бүсэд ажиллаж буй сэтгүүлчдийг эрхээ эдэлж энгийн хүмүүсийн адил суллаж чөлөөлөгдөх боломж бүхнийг энгийн иргэд хэмээн хүлээн зөвшөөрвөл зохино.

Орчуулсан Д.Дашдондов

§ Сэтгүүлчдийн эрх чөлөө, хүний эрх

Европын өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн бодлогын асуудлаар сайд нарын хэмжээнд болсон 4 дүгээр бага хуралд оролцогсод нь:

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, түүний дотор хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь ардчилсан нийгмийн үндсэн нөхцөл мөн гэж тэмдэглээд,

Үүнтэй холбогдуулан сэтгүүл зүйн салбарын нийт ажиллагсад, тухайлбал, сэтгүүлч, редактор, хэвлэлийн газрын ажилтан, электрон болон хэвлэх хэрэгсэл бүхий байгууллагын захирал, эздийн гүйцэтгэж буй үүрэг нь ихээхэн ач холбогдолтой бөгөөд тэдгээрийн эрх чөлөөг баталгаажуулах нь зайлшгүй шаардлагатай гэж үзэн,

Сэтгүүлчийн үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Европын Конвенцийн 10 дугаар зүйлийн хүрээнд Европын зөвлөлийн гишүүдийн талархан хүлээн авсан үүрэг, мөн түүнчлэн “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдээллийн эрх чөлөө нь ардчилсан, олон ургальч үзлийг баримталсан нийгмийн үндсэн элемент мөн” хэмээн зөвшөөрсөн 1982 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдээллийн эрх чөлөөний тухай тунхаглалд” заасан үүргүүд хэвээр хадгалагдаж буйг дахин батлан илэрхийлж,

Гишүүн орнууд нь тус тусынхаа хуулиар баталгаажсан өөр өөр соёл, уламжлалтайг харгалзан үзэж, сэтгүүл зүйн салбарт ажиллаж байгаа хүмүүсийн бусад эрх болон эрх чөлөөг хангахын чухлыг онцлоод,

Сэтгүүл зүйн салбарт ажиллагсад мэргэжлийн харьцангуй өндөр түвшинд байгаа бөгөөд үүрэг хариуцлагаа бүрнээ ухамсарлаж буй гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлээд, доорх зарчмыг хэлэлцэн тохиролцов.

Нэгдүгээр зарчим

Жинхэнэ ардчилал нь чөлөөтэй, бие даасан, олон ургальч үзэлд тулгуурласан, хариуцлага бүхий сэтгүүл зүй оршин тогтнох, хүч чадлыг нь бэхжүүлэх нөхцөл шаардана.

Үүнээс үүдээд сэтгүүл зүй нь:

- олон нийтийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагааны тухай хүмүүст мэдээлж, ингэснээр нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бололцоо олгоно.
- хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүст үзэл бодлоо илэрхийлэх бололцоо олгох, олон нийтийн болон нийгмийн санаа бодлыг тодорхойлон, түүний тухай мэдээлнэ.

Хоёрдугаар зарчим

Электрон болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажиллаж буй сэтгүүлчдийн үйл ажиллагаа нь Хүний эрхийн Европын конвенцийн 10 дугаар зүйлээр баталгаажиж, Конвенцийн байгууллагуудын хууль дүрэмд заасан үндсэн эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх дээр үндэслэгдэнэ.

Гуравдугаар зарчим

Сэтгүүл зүй нь доорхи нөхцөл бүрдсэн тохиолдолд жинхэнэ ардчиллыг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмрээ оруулна. Үүнд:

- а/ Сэтгүүлчийн мэргэжил эзэмшихэд ямарваа хязгаарлалт тогтоохгүй.
- б/ Улс төрийн хүчин болон хэсэг бүлэг хүмүүс, засаг захиргааны төлөөлөгчдийн өмнө хэвлэн нийтлэгчдийн хувьд бүрэн бие даасан байдалтай байх.

-
- в/ Засаг захиргааныханд байгаа мэдээллийг авч, үнэн шударгаар хэнд ч ая тал засахгүйгээр дамжуулах.
 - г/ Мэдээллийн эх сурвалжийг нууцлан хамгаалах.

Дөрөвдүгээр зарчим

Сэтгүүлчийн эрх чөлөө нь жинхэнэ ардчиллын нөхцөлд л үндсэн үүргээ биелүүлж чадна гэдгийг санах ёстой. Төр, захиргааны байгууллагынхнаас сэтгүүлчдийн ажилд оролцох тохиолдолд:

- а/ Хүний эрхийн Конвенцийн 10 дугаар зүйлийн хоёрдугаарт заасан хязгаарлалтаас хэтрэхгүй байх.
- б/ Ардчилсан нийгмийн зайлшгүй шаардлага, нийгмийн тулгамдсан хэрэгцээнд бүрэн нийцэж байх үүднээс асуудалд хандах
- в/ Тодорхой, цэгцтэй томъёолсон хуулийн хүрээнд хандах
- г/ Тодорхой тайлбарт хүлцэлтэй хандах
- д/ Чиглэсэн зорилгод нийцүүлж байх ёстой.

Тавдугаар зарчим

Төр, захиргааныхан болон сэтгүүл зүйн салбарын удирдах ажилтны зүгээс сэтгүүлчдэд дэмжлэг үзүүлж байх ёстой. Үүний тулд:

- а/ сэтгүүлчдийн мэргэжлийн сургалт системтэй, чанартай байх
- б/ сэтгүүлч, редактор, хэвлэн нийтлэгч, электрон болон хэвлэмэл мэдээллийн хэрэгслийн захирал, эзэд болон өргөн нэвтрүүлгийн бодлогыг хариуцсан эрх бүхий хүмүүсийн хооронд засгийн газрын түвшинд санал солилцох уулзалт ярилцлага зохиож байх
- в/ осолтой нөхцөлд ажиллаж байгаа болон осолтой байдалд татагдан орсон /тухайн орны болон гадаадын/ сэтгүүлчдийг хамгаалан дэмжиж, үүнийг хоёр талын болон олон талын гэрээ хэлэлцээрээр зохицуулах
- г/ олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн янз бүрийн хэлбэрийг тодорхой болгох
- д/ өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн салбарт ажиллагсдын бие даасан байдалд нөлөө бүхий гурав дахь этгээдтэй харьцаж байгаа харилцааг ил тод байлгах

Зургадугаар зарчим

Жинхэнэ ардчиллын нөхцөлд сэтгүүл зүйн үндсэн үүрэг нь тухайн салбарт ажиллагсад хариуцлагаа ухамсарлан, мэргэжлийн ёс зүйг сахин өөрийн бие даасан байдал, шүүмжлэлт байр сууриа алдахгүй байхад оршино.

Сэтгүүл зүй нь мэдээлэл авах, дамжуулах эрхийг агуулсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн тусын тулд үйлчилж, Хүний эрхийн Европын конвенциэр хамгаалуулсан бусад эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хүндэтгэнэ.

Долдугаар зарчим

Жинхэнэ ардчилсан нийгмийн сэтгүүл зүйн практикт мэргэжлийн сэтгүүлчийн ёс зүй гэж бий. Энэ нь:

- а/ болсон явдал, үйл явдлын тухай үнэн зөв мэдээлэл авах олон нийтийн эрхийг хүндэтгэх

-
- б/ мэдээллийг зөв шударга замаар олж авах
 - в/ үнэн шударга мэдээлэл, тайлбар, шүүмжлэлийг өгөх бөгөөд хүний хувийн амьдралын тухай худал зүйл мэдээлэх, гүтэх, үндэслэлгүйгээр буруутгахаас зайлсхийх
 - г/ мэргэжлийн болон мэдээллийн эх сурвалжийг нууцлах
 - д/ хүчирхийлэл, үзэн ядах, үл тэвчих үзэл болон арьсны өнгө, хүйс, бэлгийн харилцааны хандлага, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл, үндэс язгуур, нутгийн болон нийгмийн гарлаар ялгаварлан гадуурхах явдлаас зайлсхийх.

Наймдугаар зарчим

Олон нийтийн мэдээллийн төрөл бүрийн хэрэгслийн нөхцөл өөрчлөгдөж буйг бодолцон эрх баригчдаас долдугаар зарчимд заасан зүйлийг харгалзан, сэтгүүл зүйн салбарт ажиллаж буй хүмүүс өөрийгөө зөв эзэмдэх хэм хэмжээ, тухайлбал биеэ авч явах ёс журмыг нарийвчлан боловсруулах эрхийг дэмжвэл зохино.

Өөрийгөө зөв эзэмдэх эдгээр хэм хэмжээ нь сэтгүүл зүйн салбарт ажиллагсдын эрх болон эрх чөлөө нь харшилдаж, зөрчилдөж болзошгүй бусад эрх, эрх чөлөө, ашиг сонирхолтой хэрхэн нийцэхийг зааж, хариуцлагыг нь тодорхойлно.

Орчуулсан Д.Дашдондов

§ Ардчилсан хэвлэл мэдээллийн соёлын төлөө тунхаг

Олон улсын Сэтгүүлчдийн холбоо ирээдүйг өөдрөгөөр төсөөлөн харж байна. Ардчилсан хэвлэл мэдээллийн соёлыг төлөвшүүлэн бүрдүүлж дэмжих үйлсэд чөлөөт бие даасан мэргэжлийн холбоодод эвлэлдэн нэгдэж, зохион байгуулагдсан мэргэжлийн сэтгүүлчид онцгой үүрэгтэй.

Хаа сайгүй нийгмийн шударга ёс тогтож, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө газар авч, өргөжин тэлэхээс ардчилал хамааралтай байх юм гэж ОУСХ итгэж байна.

Ардчилсан нийгэмд мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг онцгой өвөрмөц агаад тухайлсан үүргийг ухаарч сэхээрсэн тэр цагт ардчилал бүрнээ үнэ хүндтэй болох учиртайг ОУСХ нотолж байна.

Ардчилсан нийгэм дэх мэдээллийн үүрэг гэдэг нь уг чанартаа хэвлэлийн эрх чөлөөний жаяг зарчмыг ёсчлон баримтлах явдал бөгөөд чухам үүн дээр л үзэл санаа бодлоо илэрхийлэх эрх чөлөө тулгуурлана.

ОУСХ-ын үзэж байгаагаар мэдээ мэдээлэл нь нийтэд зориулагдсан зүйл болохын хувьд сэтгүүлчдээс уншигч, үзэгч, сонсогч түмнээ болж, тэдэнд хэрэгтэй юмыг нь хүргэж дуулгах үүргээ биелүүлэхэд нь хөндлөнгийн оролцоо, хориг саад байх учиргүй.

ОУСХ нь хэвлэлийн эрх чөлөө гэдгийг: “хөндлөнгийн нөлөөлөл, оролцооноос чөлөөтэй байх явдал мөн. Энэ сэтгүүлч, сонины эрхлэгч, хэвлэн нийтлэгчдээс баримт сэлт хийгээд үзэл бодлыг нийтлэн нэвтрүүлж, дамжуулж түгээхдээ гагцхүү олны эрэлт шаардлага, эрх ашгийг хамгаас урьтал болгоход зайлшгүй чухал зүйл юм. Үүнгүйгээр ардчилсан сонголт нь хариуцлагатай шийдэл болж чадахгүй” хэмээн томъёолж тодорхойлох байна.

Тэгэхдээ хэвлэлийн эрх чөлөө хэдийд хэрэгжиж биелэх вэ гэвэл:

Нэгд: Янз бүрийн санаа, үзэл бодлыг тусгасан чөлөөт, бие даасан, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол ардчилсан нийгмийг цогцлуулан байгуулахад зайлшгүй хэрэгтэй утгвар нөхцөл мөнийг,

Хоёрт: Мэдээллийн урсгал нь газар зүйн байршил, гарал үүсэл, хөрөнгө баялаг, хэл яриа ямар байхаас шалтгаалахгүйгээр нийт хүн зоны нийтлэгүүдэд хэрэг болох амин чухал болохыг,

Гуравт: Ард иргэдээс эдлэх мэдээллийн эрх чөлөө, тэдэнд өөрт нь хэрэгтэй зүйлийг олж мэдэх эрх хаана баталгаажсан байна, зөвхөн тэнд л үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө байдгийг,

Дөрөвт: Дэлхийд хаа сайгүй ардчилсан, олон урьгалч хэвлэлийг дэлгэрүүлэхийн тулд мэргэжлийн халдашгүй бүрэн цогц байдал, сэтгүүл зүйн бие даасан шинж чанарыг үнэлэн дээдлэх ёстойг тус тус хүлээн зөвшөөрсөн үед л сая биелэлээ олно.

Мэдээллийг бичгээр буюу дуу авиа, дүрсийн алинаар нь ч дамжуулдаг бай, энэ салбарт ажилладаг мэргэжлийн хүмүүс, сэтгүүлч, эрхлэгч хэвлэн нийтлэгчид өөр хоорондоо тэрчлэн Засгийн газар, тэр ч байтугай Засгийн газар дундын зохих эрх бүхий байгууллага, хүнтэй мэдээллийн хэрэгслийн бодлогын чанартай асуудлаар ярилцах байх гэж ОУСХ найдаж байна.

Харилцан ярьж зөвшилдөх зорилготой иймэрхүү маягийн бүтэц нь энгийн ажиллагсад, эрх бүхий удирдлага, цаашилбал хэрэглэгчдийг төлөөлсөн хүмүүсийг оролцуулж, асуудал хэлэлцэхэд зохимжтой. Хэлэлцэх зүйл нь чухам юу байх вэ гэвэл:

-
- а/ Мэдээллийн хэрэгслийн эдийн засаг, нийгмийн талын асуудал, бүр тодруулбаас бүх түвшинд ардчиллыг бодитойгоор хэрэгжүүлэхэд гарцаагүй хэрэг болох мэдээллийн эх сурвалж олон төрөл янзаар байх ёстойг хумигдуулж мэдэх монопольчлолыг хязгаарлах,
- б/ Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эзэмшил ч юм уу, өөр бусад учир шалтгаанаас үүдэлтэй ажилгүйдэл, ажлын баталгаат бус байдал,
- в/ Чөлөөт, олон урьгалч мэдээллийн хэрэгслийг хөгжүүлэхэд тус дэм үзүүлэхүйц хууль, чиг бодлого, хэм хэмжээг ажил, амьдрал болгон мөрдөх,
- г/ Хэвлэл, мэдээллийн хүрээн дэх мэргэжил, эдийн засаг, нийгмийн нөхцөл, тухайлбал:
1. Нийт мэдээллийн хэрэгслийн хүрээн дэх ажил, үйлдвэрлэл эрхлэх бизнес, нийгмийн шинжтэй үйл ажиллагаанд ил тод ойлгомжтой байх зарчмыг нэвтрүүлэх,
 2. Улст төр, арилжаа, ашиг хонжоо бодсон албадлага, тусгалтаас ангид бие даасан, өндөр зэрэглэлийн сэтгүүл зүйн эрэлт шаардлагыг тусгасан мэргэжлийн хүлээн зөвшөөрөхүйц хараат бус тогтолцоог дэмжих
 3. Мэдээллийн эрх чөлөө хийгээд бие даасан хараат бус сэтгүүл зүйг хамгаалах механизмыг редакцийн эдлэх эрх, статус маягаар хуульчлан хүлээн зөвшөөрөх
 4. Орон тоогоор бус, хэлцлийн дагуу ажиллах, түүнчлэн үүрэг хавсран гүйцэтгэх үед сэтгүүлчийн хөдөлмөрийг завшуулахгүй байх, улмаар ажиллагсад адил тэгш нөхцөл бүрдүүлэхэд чиглэгдсэн баталгаат орчин бий болгох.

Хяналт, хориг цензур, улс төр, эдийн засгийн дарамт, шахалтыг эсэргүүцэн тэмцэхдээ ОУСХ-ны зарчим, чиг зорилгын дор нягтарч эвлэлдэн нэгдэхийг даян дэлхийн сэтгүүлчдэд ОУСХ уриалж байна.

Орчуулсан Д.Дашдондов

§ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛИЙН АРВАН НОМЛОЛ

Орнедийн сэтгүүлчид юмыг чин шударгаар, олон талаас нь нэгтгэн тусгадаг уламжлалтай.

Англо-Саксоны хэвлэлийн уламжлал нь арван номлолд багтана. Тэр нь чухам юу вэ гэвэл:

- 1. Хэвлэл чөлөөтэй байх ёстой бөгөөд энэхүү эрх чөлөө нь үндсэн хууль, хэвлэлийн хуулиар хүлээн зөвшөөрөгдөх учиртай.** Үүнийг цензур байхгүй, хэвлэл бие даасан, шүүмжлэмтгий дөрөв дэх засаглал гэж ойлгож болно.
- 2. Энгийн сэтгүүлч, редактор бүр үнэнч шударга байх, тодорхой шаардлагыг хангах.** Хэрвээ сонин нь бие даасан, хараат бус юм бол түүнийг эрхлэн гаргаж байгаа хүн ямар ч улс төрийн нам, байгууллагатай холбоо сүлбээгүй байна.Тэрээр хэн нэгэн хүний төлбөртэй захиалгаар түүний таалалд нийцсэн зүйл бичихийг татгалзах.
- 3. Хэвлэл эдийн засаг ба нийтлэлийн сонирхлыг хооронд нь хатуу зааглах.** Сонинд сурталчилгаа худалдан авснаар сайн нэртэй болохгүй. Хөрөнгө оруулагч ч гэсэн шүүмжлүүлж болох бөгөөд түүний таалалд тохирсон нийтлэлийн чиглэлийг баримталж болохгүй.
- 4. Хэвлэл найдвартай байх ёстой.** Нийтлэл бичихээс өмнө нарийвчлан судалгаа хийж алдааг засаж, тоо баримтын үнэн зөвийг магадлах.
- 5. Хэвлэл шударга байх.** Шүүмжилсэн хувь хүн юм уу, байгууллагад дайралт хийхээс өмнө хариу өгөх боломжийг олгох хэрэгтэй. Зарим нэгэн хүмүүсийн нэр төрийг үндэслэлгүй хөндөж байгаа мэдээллийг ямар ч зураг болон тодорхой нэртэй гаргаж болохгүй.
- 6. Хэвлэл нээлттэй байвал зохино.** Сонины газар, сэтгүүлч дээр бэлтгэгдээгүй бусад материал, үзэл бодлоо ч нийтлэхэд адилхан эрхтэй байх ёстой. Хэвлэл ноцтой алдаа хийсэн бол түүнийгээ хүлээх үүрэгтэй. Уншигчдаас ирсэн захидалд цензур байж таарахгүй.
- 7. Хэвлэл үйл явдлыг мэдээлэхдээ бодитойгоор хандана.** Үнэнийг өгүүлэхийг чухалчлах, мэдээлэлд тэгш хандаж тэнцвэр сахих, элдэв илүү тайлбар хийхээс зайлсхийх. Тайлбар, дүн шинжилгээ, редакцийн өгүүлэл зэрэг нь мэдээнээс ялгаатай төрөл зүйл юм.
- 8. Хэвлэл хэрэглэгчдийг хүндэлнэ.** Хамгийн чухал мэдээллийг нийтлэлийн эхэнд байрлуулж, сонины ерөнхий эвлүүлэг нь зохистой, зөв байрлалтай, ямар ч хүнд ойлгогдохуйц хэлээр бичсэн байна.
- 9. Хэвлэл алсыг харсан зөв чиг баримжаатай байх ёстой.** Зөвхөн эрх мэдэл бүхий шийдвэр гаргадаг хүмүүсийн хэлсэн үгийг иш татах биш энгийн хүмүүсийн саналыг тусгаж, болж өнгөрсөн үйл явдлуудын, жишээлбэл улс төрийн нэгэн шийдвэрийн учир холбогдлыг нээн дэлгэж харуулах хэрэгтэй.
- 10. Хэвлэл зарим талаар зугаатай байвал зүгээр.** Зугаацуулах нь сонины гол зорилго биш, гэхдээ тохиромжтой үед хэрэглэсэн бол энэ нь сонины өрсөлдөх чадварыг дээшлүүлж гүйлгээг нэмэгдүүлдэг.

Энэ бүхнийг ганцхан үгээр илэрхийлэх юм бол “тохирох бүхнийг нийтэл” гэж хэлж болно.

Орчуулсан Д.Дашдондов

§ Сэтгүүлчдийн баримтлах зарчим

1. Үнэнийг эрхэмлэж, үнэнийг мэдэх гэсэн олон түмний эрхийг хүндэтгэх нь сэтгүүлч хүний нэн тэргүүний үүрэг мөн.
2. Энэ үүргээ биелүүлэхдээ сэтгүүлч мэдээ сэлтийг зүй зохисынх нь дагуу цуглуулж, хэвлэн нийтлэх эрх чөлөө, шударгаар хэлж шүүмжлэх эрхийн зарчмуудыг цаг ямагт хамгаалах.
3. Сэтгүүлч цаад эх сурвалжаар нь мэдэх зөвхөн тийм л баримтуудад тулгуурлан бичиж мэдээлж байх. Сэтгүүлч чухал мэдээг нуун дарах юм уу баримт сэлтийг мушгин гуйвуулж болохгүй.
4. Шинэ сэргэг мэдээ, гэрэл зураг, баримт мэтийг олж авахдаа сэтгүүлч гагцхүү шударга аргыг хэрэглэх учиртай.
5. Аль нэг хэвлэгдсэн зүйл хор уршиг тарихуйц хуудуутай болох нь нотлогдвол түүнийг засч залруулахын тулд сэтгүүлч бололцоотой бүхнийг хийнэ.
6. Итгэл хүлээж олж авсан мэдээллийн уг сурвалжтай холбогдох мэргэжлийн нууцыг сэтгүүлч хадгалж байх.
7. Мэдээллийн хэрэгслээр дэвэргэсэн ялгаварлан гадуурхалт ямар аюултайг сэтгүүлч хүн ухамсарлаж, улмаар арьсны өнгө, хүйсний ялгаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн юм уу өөр үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарлаар болон бас бус шалтгаанаар ялгаж гадуурхахаас сэрэмжлэхийн төлөө чадах бүхнийг хийх.
8. Дараах зүйлийг сэтгүүлч мэргэжлийн ноцтой алдаанд тооцно. Үүнд:
 - бусдын бүтээлийг хулгайлах
 - юмыг санаатайгаар мушгин гуйвуулах
 - бусдыг гүтгэх, нэр төрийг нь гутаах, элдвийн нэр хоч өгч доромжлох хүнийг ул үндэсгүй буруутгах
 - юмыг нийтэд мэдээлэх эсэхийг шийдэхдээ ямарваа нэг хэлбэрээр хээл хахууль авах
9. Сэтгүүлчид эрхэм нэр төрдөө эзэн болж, дээрх зарчмуудыг ёсчлон биелүүлэхийг өөрсдийн үүрэг гэж үзвэл зохино.

Тухайн улс орны хуулийн хүрээнд сэтгүүлчид үзэг нэгт нөхдийнхөө асуудлыг зөвхөн мэргэжлийн үүднээс шүүн хэлэлцэхийг хүлээн зөвшөөрнө.

Засгийн газар болон бусад эрх мэдэлтэн хөндлөнгөөс оролцох явдал байж болшгүй.

*Брюссельд төвтэй Олон Улсын сэтгүүлчдийн холбооны 1954 оны Их хурлаас баталж,
1986 оны Их хурлаас шинэчлэн засварлав.*

§ Мэргэжлийн Сэтгүүлчдийн Нийгэмлэг: Ёс зүйн код

Оршил

Олон нийтийг гэгээрүүлэх нь шударга ёсны үндсэн шинж, ардчиллын эх үндэс мөнгөдэгт Мэргэжлийн Сэтгүүлчдийн Нийгэмлэгийн гишүүд итгэдэг. Үндэслэлтэй чин шударгаар үнэнийг хайж, аливаа үйл явдал, асуудлын тухай үнэн зөв, олон талын мэдээллийг түгээх нь сэтгүүлчдийн хамгийн гол үүрэг юм. Чин сэтгэлт сэтгүүлч мэргэжилтнүүд олон нийтэд үйлчлэхдээ буурь суурьтай, нэр төртэй байхыг эрмэлздэг. Мэргэжлийн шаргуу байдал нь сэтгүүлчдийн бусад итгэл төрүүлэх гол үндэс нь юм. Нийгэмлэгийн гишүүд нь ёс зүйн биеэ авч явах төлөвшлөө өөр хоорондоо хуваалцдаг болохоор Нийгэмлэгийн ажил хэргийн зарчим, стандартыг тогтоосон энэхүү дагаж мөрдөх ёс зүйг тунхаглаж байна.

Үнэнийг хайж, түүнийгээ сурвалжил

Сэтгүүлч нь мэдээлэл цуглуулах, илтгэх, тайлбарлахдаа үнэнч, шударга, эрэлхэг зоригтой байвал зохино.

Сэтгүүлчид:

- Бүхий л эх сурвалжаас авсан мэдээллээ нягт нямбай шалгаж, санамсаргүй алдаанаас зайлсхийхийн тулд анхааралтай бай. Санаатай мушгин гуйвуулахыг хэзээ ч үл зөвшөөрнө.
- Буруу үйлдлийг нотлох боломжтой байхын тулд мэдээ сурвалжлагадаа оролцох хүмүүсээ олохдоо хянамгай бай.
- Хэдийд ч хэрэг болохуйц эх сурвалжийг таньж ол. Олон нийт эх сурвалж нь найдвартай мэдээлэл хүртэх эрхтэй.
- Нэрийг нь дурьдахгүй гэж амлахаасаа өмнө эх сурвалжийг нууцлах шалтгааныг нь байнга тодруул. Мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд амлалтаа уялдуулан нөхцлүүдээ тодруул. Амлалтаа биелүүл.
- Гарчиг, сгөөдсөн мэдээ, дэмжлэг үзүүлэх материал, фото зураг, дуу, дүрс бичлэг, график, дуу чимээ, ишлэлүүдийг буруу ойлгогдохоос сэрэмжлэн тодорхой болго. Эдгээр нь агуулгыг хэт хялбарчлах, эсхүл хэт онцлох алдаанд хүргэж үл болно.
- Фото зурган болон дүрстэй мэдээний агуулгыг хэзээ ч бүү мушгин гуйвуул. Техник технологийн зорилгоор баяжуулахыг зөвшөөрнө. Эвлүүлэг, фото зургийн дүрсжүүлэлт байж болно.
- Мэдээний үйл явдлын дахин давтуулах, тоглуулахаас зайлсхий. Мэдээ сурвалжлагын өгүүлэмжид зайлшгүй чухал бол эвлүүлэг хийж болно.
- Уламжлалт нээлттэй арга барил тохирохгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд олон нийтэд туйлын хэрэгцээтэй мэдээллийг нь өгөхөд мэдээлэл цуглуулах тагнуулын буюу бусад нууц арга хэрэглэхээс зайлсхий. Ийм арга барилыг ашигласан тухай мэдээ сурвалжлагынхаа нэг хэсэг болгон тайлбарла.
- Бусдын бүтээлийг хэзээ ч бүү хулгайл.
- Амьд, олон талт байдлыг мэдээ сурвалжлагадаа тусга. Харин түгээмэл бус ч гэсэн хүний хувийн туршлагыг тодорхой, ач холбогдол өгч өгүүл.
- Хүмүүсийн хувийн соёлын үнэт зүйлсэд хүндэтгэлтэй хандаж, тэдгээрийг бусад тулган хүлээлгэхээс зайлсхий.

-
- Арьсны өнгө, хүйс, нас, шашин шүтлэг, үндэс угсаа, газар зүйн байрлал, бэлгийн харилцааны хандлага, бие эрхтний согог, биеийн гадаад төрх байдал болон нийгмийн байдлын талаарх хэвшмэл үзэл бодлоос зайлсхий.
 - Үзэл бодол нь тэвчишгүй байлаа ч үзэл бодлоо нээлттэй солилцоход нь дэмжлэг үзүүл.
 - Дуу хоолойгоо хүргэж чадахгүй байгаа хүмүүст боломж олго. Мэдээллийн албан болоод албан бус эх сурвалжийн аль аль нь адилхан хүчин төгөлдөр байж болно.
 - Өмгөөлөл болон мэдээ сурвалжлагыг ялгаж сур. Дүн шинжилгээ, тайлбар нийцтэй байвал зохих бөгөөд баримт сэлт, далд санааг орхигдуулж үл болно.
 - Мэдээг зар сурталчилгаанаас ялгаж сур. Энэ хоёрын шугамыг бүдгэрүүлж буй зүйлээс хол бай.
 - Олон нийт нь нээлттэй байдлыг эрхэмлэдэг бөгөөд засаг захиргааны тайланг хянаж шалгах нөхцөлийг хангах нь онцгой үүрэг болохыг ухамсарла

Гэм хорыг багасга

Ёс зүйтэй сэтгүүлчид нь эх сурвалж, судлагдахуун болон мэргэжил нэгт нөхдөө хүндэтгэвэл зохино.

Сэтгүүлчид:

- Сурвалжлагад сөрөг байдлаар хөндөгдөж болзошгүй хүмүүст нигүүлсэнгүй ханд. Хүүхдүүд, туршлагагүй эх сурвалж болон хүмүүсийн тухай бичихдээ онцгой мэдрэмжтэй бай.
- Эмгэнэл, уй гашууд автагдсан хүмүүсийг эрж хайх, ярилцлага хийх, фото зургийг нь ашиглахдаа мэдрэмжтэй бай.
- Мэдээлэл цуглуулах, сурвалжлах нь хэн нэгэнд гэм хор, зовлон бэрхшээл учруулж болзошгүйг ухамсарлан ойлго. Мэдээлэл хайж сураглах нь бие тоох тусгай зөвшөөрөл бус юм.
- Энгийн иргэд нь эрх мэдэл, нэр нөлөө, анхаарал хараа бүхий албан тушаалтнуудаас хавьгүй илүүтэйгээр өөрсдийнх нь тухай мэдээллийг хянах эрхтэй болохыг хүлээн зөвшөөр. Гагцхүү олон нийтийн хэрэгцээ л хэн нэгний хувийн нууцад халдах үндэслэл болно.
- Сайн мэдрэмжтэйгээ үзүүл. Хэт сониучирхлыг өөгшүүлэхээс зайлсхий.
- Хүчингийн гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй этгээдийг сэжигтэн, эсхүл хохирогчоор тогтоосон тухай асуудалд хашир хянамгай ханд.
- Гэм буруутайг шүүхээр тогтоохоос нь өмнө эрүүгийн хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийн нэрийг дурьдахаас болгоомжил.
- Эрүүгийн хэргийн сэжигтний шударгаар шүүлгэх эрхийг олон нийтийн мэдээлэлтэй байх эрхтэй тэнцвэржүүлж үз.

Хараат бусаар ажилла

Сэтгүүлчид нь олон нийтийн мэдэх эрхээс бусад аливаа ашиг сонирхлын төлөө үүрэг хүлээхгүй.

Сэтгүүлчид:

- Сонирхлын зөрчлөөс зайлсхийж, бодитой, ухамсартайгаар асуудалд ханд.

-
- Шударга ёс, итгэл хүлээхэд нь хор хохирол учруулахуйц үйл ажиллагаа, нэгдэл хөдөлгөөнөөс ангид бай.
 - Бэлэг дурсгал, дэмжлэг тусламж, шагнал урамшуулал, үнэгүй аялал, тусгай эрх хангамжаас татгалз. Сэтгүүлчийн шударга ёсонд харшлахуйц бол давхар ажил эрхлэх, улс төрийн амьдралд оролцох, төрийн албанд ажиллах, олон нийтийн байгууллагад үйлчлэхээс зайлхий.
 - Зайлшгүй зөрчилдөөнийг илчил.
 - Эрх мэдэл бүхий хариуцлага хүлээдэг хүмүүстэй сонор сэрэмжтэй харилцаж, зоригтой бай.
 - Зар сурталчилгаагаар хангагч болон тусгай ашиг сонирхол бүхий этгээдийн дэмжлэг тусламжаас татгалзаж, тэдний зүгээс мэдээ сурвалжлагад нөлөөлөхүйц дарамт, шахалтын эсрэг бай.
 - Мөнгө, бусад хангамж санал болгож буй мэдээллийн эх сурвалжид хянуур болгоомжтой бай. Мэдээлэлд үнэ хаялцахаас зайлсхий.

Хариуцлагатай бай

Сэтгүүлчид нь уншигч, сонсогч, үзэгчид болон бие биенийхээ өмнө хариуцлага хүлээнэ.

Сэтгүүлчид:

- Мэдээ, сурвалжлагаа тайлбарлаж ойлгомжтой болго. Мөн сэтгүүлчдийн баримтлах зарчмын талаар олон нийтийг урьж хэлэлцүүлэг явуулж бай.
- Хэвлэл мэдээллийн эсрэг гомдол эсэргүүцлээ илэрхийлэхэд нь олон нийтэд боломж олго.
- Алдаагаа хүлээн зөвшөөрч, нэн даруй залруул.
- Хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн ёс зүйгүй аливаа үйл ажиллагааг илчил.
- Бусдыг ч ёс зүйн ийм өндөр зарчмыг адилхан дагаж мөрдөхийг уриал.

Мэргэжлийн Сэтгүүлчдийн Нийгэмлэгийн ёс зүйн кодыг мянга мянган зохиогч, редактор, хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд сайн дураараа хүлээн зөвшөөрч дагаж мөрддөг юм. Ёс зүйн кодын энэ хувилбарыг 1996 онд Мэргэжлийн Сэтгүүлчдийн Нийгэмлэгийн Үндэсний Конвенци баталсан бөгөөд энэ нь хэд хэдэн сарын турш Нийгэмлэгийн гишүүдийн дунд өрнүүлсэн хэлэлцүүлэг, судалгааны үр дүн юм.

Сигма Дельта Чи нь анх Америкийн Сонины Редакторуудын Нийгэмлэгээс ёс зүйн кодыг нь авч хэрэглэж байсан юм.

Сигма Дельта Чи нь Ёс зүйн кодын өөрийн хувилбарыг 1973 онд боловсруулсныг 1984, 1987, 1996 онд дахин шинэчлэн засварласан болно.

Орчуулсан Д.Мөнхбүрэн

§ Америкийн сонины редакторуудын нийгэмлэгийн үйл ажиллагааны зарчим

Оршил

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдлыг аливаа хуулиар хязгаарлахаас хамгаалсан нэгдүгээр нэмэлт өөрчлөлт нь ард түмэн хэвлэлээр дамжуулан дээрх эрхийг эдлэх явдлыг үндсэн хуулиар баталгаажуулдаг бөгөөд үүнээс үүдэн сэтгүүлчдэд онцгой хариуцлага оногддог юм.

Тийм сэтгүүлзүйн салбарт ажиллагсаас мэдлэг, чадвараас гадна сэтгүүлчийн үүрэгт зохицсон хэм хэмжээ нь өндөр түвшинд байхыг шаарддаг. Ийм ч учраас америкийн сонины редакторуудын нийгэмлэг дараах байдлаар зарчмуудаа тунхаглаж мэргэжлийн болон ёс зүйн эрхэм дээд хэм хэмжээг дэмжиж буйгаа илэрхийлж байна.

Нэгдүгээр зүйл. Хариуцлага

Мэдээлэл, бодол санааг цуглуулан түгээх гол зорилго нь мэдээллээр дамжуулан нийгмийн сайн сайханд үйлчилж, хүмүүст өдөр тутмын үйл явдал, асуудлын талаар өөрсдийн үзэл бодолтой байхад нь туслах явдал мөн.

Мэргэжлийнхээ дагуу өөрт нь олгогдсон эрх мэдлийг хувийн ашиг хонжоо буюу бусад зүй бус зүйлд ашиглах нь нийгмээс түүнд хүлээлгэсэн итгэл найдварыг хөсөрдүүлж байгаа хэрэг. Америкийн хэвлэл эрх чөлөөтэй болохдоо зөвхөн мэдээлэх буюу үзэл бодлыг өрсөлдүүлэх индэр болоод зогсоогүй нийгмийн дээд өндөрлөгүүдийг, тэр дотроо бүх түвшний албан ёсны удирдагчдын үйл ажиллагааг гадны нөлөөгүй, бие даан хянах зорилго агуулсанд оршино.

Хоёрдугаар зүйл. Хэвлэлийн эрх чөлөө

Хэвлэлийн эрх чөлөөг хүн ард эдэлнэ. Түүнийг нийгэм болон хувь хүний аливаа халдлага, дайралтаас хамгаалах ёстой. Нийгмийн үйл амьдрал ямагт олон нийтийн хараа хяналт дор ил тод явагдаж буйг сэтгүүлчид байнга соргог ажиглах хэрэгтэй. Хэвлэлийг хувийн ашиг завшаанд ашиглах гэсэн хэний боловч оролдлоготой сэтгүүлчид тэмцэх ёстой.

Гуравдугаар зүйл. Тусгаар байдал

Сэтгүүлч /үл нийцэх зүйл/ гаргах, аливаа ашиг сонирхол мөргөлдөхөөс зайлсхийх хэрэгтэй.

Дөрөвдүгээр зүйл. Үнэн зөв, мадаггүй байх

Чанартай сайн сэтгүүлзүйн үндэс нь уншигчдын итгэл хүлээх явдал мөн. Мэдээлэл мадаггүй, агуулгын аливаа гажуудалгүй хийгээд бүх талуудыг адил тэгш гаргасан байхын төлөө сэтгүүлчид бүхий л хүч бололцоогоо дайчлах хэрэгтэй.

Тэргүүн өгүүлэл /редакторын өгүүлэл/, задлан шинжилсэн өгүүлэл болон тайлбар өгүүлэл /тойм/ зэрэг нь мэдээний нэгэн адил баримт сэлтэд хянуур хандсан хэм хэмжээний өндөр түвшинд байх шаардлагатай.

Баримтын алдаа гаргасан буюу баримтыг орхигдуулсан тохиолдолд нэн даруй тод томруунаар залруулах ёстой.

Тавдугаар зүйл. Нэг талыг үл баримтлах

Аль нэг талыг үл баримтлах гэдэг нь сэтгүүлч эргэлзсэн асуулт тавихгүй буюу сониныхоо байр суурийг илэрхийлэхээс татгалзана гэсэн үг биш. Практикаас үзэхэд объектив мэдээлэл болон санаа бодлыг уншигчдад ялгаж алгаж өгч байх шаардлага байдаг.

Санаа бодол буюу хувийн тайлбар /интерпретация/ бүхий өгүүллийг маш тодорхой ялгаж үзүүлсэн байх ёстой.

Зургадугаар зүйл. Булхайгүй тоглох

Мэдээлэлд нэр нь гарч байгаа хүмүүсийн эрхийг хүндэтгэж, нийтээр хүлээн зөвшөөрсөн нэр төрийн хэм хэмжээг сахиж, олон нийтийн өмнө мэдээллийнхээ үнэн зөв, мадаггүй байх хариуцлага хүлээнэ.

Ил тод буруушаагдсан хүнд хамгийн богино хугацаанд хариу мэдэгдэл хийх бололцоо олгох ёстой. Мэдээллийн эх сурвалжийг нууцлах хүсэлтийг бүрэн биелүүлж амар хялбар задлахгүй байхыг эрмэлзэх хэрэгтэй. Эх сурвалжийг нууцлах шаардлага нь тодорхой бөгөөд зайлшгүй тохиолдлоос бусад үед эх сурвалжийг нэрлэх хэрэгтэй.

Манай улсыг үндэслэгчдээс ард түмэн, сэтгүүлч нарт аль алинд нь хишиг болгон өгсөн эрх чөлөөг эрхэмлэхэд хоёулангий нь хоорондын итгэлцэл, хүндэтгэлийг хадгалан хамгаалж, бэхжүүлэхэд дээр зарчмууд үйлчилнэ.

Энэхүү тунхаглал нь Америкийн сонины редакторуудын нийгэмлэгийн захирлуудын зөвлөлөөр 1975 оны 10 сард батлагдсан бөгөөд 1922 онд гарсан. "Сэтгүүл зүйн үндэслэлүүд"-ийг баяжуулсан хувилбар болно.

Орчуулсан С.Баяраа

§ Сэтгүүлчдийн эрх, үүргийн тунхаглал

(“Мюнхений дүрэм”)

Энэхүү тунхаглал нь 1971 оны 11 дүгээр сарын 24, 25-нд Мюнхен хотноо хэлэлцэгдэж батлагдсан. Хожим Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо, Европын сэтгүүлчдийн бусад холбоод хүлээн зөвшөөрсөн билээ.

Өмнөх үг

Мэдээлэлтэй байх эрх, үзэл бодлоо илэрхийлэх, шүүмжлэх эрх чөлөө нь хүний суурь эрхүүдийн нэг. Үйл явдал, үзэл бодлуудын талаар мэдээлэлтэй байх олон нийтийн эрхээс сэтгүүлчийн бүх эрх, үүргүүд урган гардаг билээ. Олон нийтийн өмнө хүлээх сэтгүүлчдийн үүрэг хариуцлага нь бусад ямар ч хариуцлагаас тухайлбал ажил олгогчид, төрийн эрх баригчдын өмнө хүлээх хариуцлагаас дээгүүр тавигдана. Мэдээллийн үүрэг нь сэтгүүлчид өөрсдөө дагахаас аргагүй хязгаарлалтуудыг зайлшгүй агуулдаг. Энэ бол доор өгүүлэх үүргийн тунхаглалын гол зорилго юм. Гэхдээ сэтгүүлчид зөвхөн хараат бус байдалд мэргэжлийн дагуу ажиллаж, мэргэжлийн хувьд хүндлэгдэх нийгмийн нөхцөл бүрдсэн үед л эдгээр үүргийг сахин биелүүлж чадна.

Үүргийн тунхаглал

Мэдээллийг олж авах, хянаж засварлах, тайлбарлахдаа сэтгүүлчдийн зайлшгүй дагаж мөрдөх үүрэг хариуцлагууд нь:

1. Гагцхүү үнэнийг эрхэмлэж, өөрт учрах аливаа үр дагаврыг эс тооцон үнэнийг мэдэх олон нийтийн эрхийг хүндэтгэх.
2. Мэдээллийн эрх чөлөөг хамгаалах, дүгнэх, шүүмжлэх
3. Зөвхөн жинхэнэ эх сурвалжаар нь мэдэж буй баримтуудад тулгуурлан мэдээлэх, чухал мэдээллийг нуун дарагдуулахгүй байх, баримт, эх бичвэрийг гуйвуулахгүй байх
4. Мэдээ, гэрэл зураг, баримтыг олж авахдаа шударга бус арга хэрэглэхгүй байх
5. Бусдын хувийн амьдралыг хүндэтгэж, тодорхой хязгаартай хандах
6. Аливаа хэвлэгдсэн зүйлс хуудуутай болох нь нотлогдвол засаж, залруулах
7. Мэргэжлийн нууцыг хадгалж, итгэл хүлээж олж авсан мэдээллийн эх сурвалжаа илчлэхгүй байх
8. Бусдын бүтээл, санааг хулгайлах, гүтгэх, цуурхал дэгдээх, нэр төрийг нь гутаах, ул үндэсгүйгээр буруутгах, мэдээллийг хэвлэн нийтлэх эсвэл нуун дарагдуулах гэж ямарваа нэг хэлбэрээр хахууль авах зэрэг мэргэжлийн ноцтой алдаа гаргахаас зайлсхийх
9. Сэтгүүлчийн мэргэжлийг зар сурталчилгааны борлуулагч ба ухуулагчийн ажилтай хэзээ ч хольж хутгалгүй сурталчилгааны шууд ба шууд биш аливаа саналуудаас татгалзах
10. Аливаа дарамт шахалтыг эсэргүүцэх. Зөвхөн редакцийн зөвлөл дэх зохих хариуцлагатай ажилтны зүгээс өгсөн редакцийн заавруудыг хүлээн авах

Сэтгүүлч бүр дээр дурдсан зарчмуудыг дагаж, үүргээ итгэмжтэйгээр гүйцэтгэж, сэтгүүлчийн нэр төрийг өндөрт авч явах нь зүйтэй. Сэтгүүлч мэргэжлийн асуудлаа тухайн улс орны нийтлэг хуулийн хүрээнд, засгийн газар болон бусад аливаа хөндлөнгийн оролцоогүйгээр зөвхөн мэргэжил нэгт нөхдийнхөө хүрээнд авч үзэх ёстой.

Эрхийн тунхаглал

1. Сэтгүүлчид мэдээллийн бүх эх сурвалжуудыг чөлөөтэй олж авах, олон нийтийн амьдралд нөлөөлж буй бүх үйл явдлын тухайд чөлөөтэй эрж хайх эрхтэй.
Зөвхөн тодорхой дурдагдсан шалтгаантай онцгой тохиолдлуудад төрийн ба хувийн нууцад хамаарах хэргүүд сэтгүүлчдэд хаалттай байж болно.
2. Сэтгүүлч өөрийн хамтран ажиллах тухайгаа бичгээр үйлдсэн болон ажиллахаар гэрээгээр нэгдсэн мэдээллийн байгууллагынхаа ерөнхий бодлогод харш бөгөөд түүнд тодорхой тусгагдаагүй аливаа зүйлд захирагдахаас татгалзах эрхтэй.
3. Сэтгүүлч өөрийн итгэл үнэмшил, ухамсрын эсрэг үзэл бодлыг илэрхийлэх, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах дарамтанд байх ёсгүй.
4. Редакцийн зөвлөл нь өөрийн байгууллагын ажил, амьдралд нөлөөлөх бүх чухал шийдвэрүүдийн талаар заавал мэдэж байх ёстой. Сэтгүүлчийг ажилд авах, ажлаас чөлөөлөх, шилжүүлэх, урамшуулах зэрэг редакцийн зөвлөлийн ажил үүрэгт хамаарах бүхнийг ядаж холбогдох эцсийн шийдвэр гарахаас өмнө нь зөвлөлдсөн байх ёстой.
5. Сэтгүүлч үүрэг, хариуцлага хүлээхийн зэрэгцээ хамтын хэлэлцээрээс үүдэх давуу талыг эдлээд зогсохгүй өөрийн ажил үүргийн материаллаг ба ёс суртахууны хамгааллыг баталгаажуулсан хөдөлмөрийн гэрээтэй байх, нийгмийн байдалд нь дүйсэн эдийн засгийн хараат бус байдлын баталгаат цалин хөлс авах эрхтэй.

Монголын Эмнести Интернэшнл ТББ-аас эрхлэн гаргасан “Хил хязгааргүй сурвалжлагчид” сэтгүүлчдэд туслах зөвлөмжөөс хэсэгчлэн авав

§ Францын өдөр тутмын хэвлэлүүдэд хүчин төгөлдөр мөрдөгддөг дүрэм болон мөрдлөгүүдээс

Үзэл бодол, санаагаа чөлөөтэй илэрхийлэх нь хүний хамгийн нандин эрхүүдийн нэг мөн. Иймээс хүн бүр өөрийн хүссэнээ ярих, бичих, хэвлэн нийтлэх эрхтэй бөгөөд энэхүү эрх чөлөөг буруугаар ашигласан бол уг хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ. (1789 оны 8 дугаар сарын 26-нд батлагдсан Хүний болон Иргэний Эрхийн Тунхаглалын 11-р Зүйл).

Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Үүнд өөрийн үзэл бодлоо баримтлах, аливаа мэдээ, санаануудыг эрх баригчдын хориг цээргүйгээр улсын хилийн заагаар үл хязгаарлан хүлээн авах, илэрхийлэх эрх багтана. (Хүний Эрх, Суурь Эрх Чөлөөг Хамгаалах тухай Европын Конвенцийн 10-р зүйл).

Мэргэжлийн дүрэм болон мөрдлөгүүд

Сонин нь уншигчидтайгаа ойр дотно байж, тэдний өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарладаг байна. Иймд үйл явдлыг сурвалжлах мэдээлэхдээ “баримт”, “үзэл бодол”-ыг хооронд нь заагтай байлгана.

1. Мэдээллийг нарийвчлан нягталж, анхаарал, болгоомжтой хандах.

Зөвхөн батлагдсан, мадаггүй өгүүлүүд нийтлэгдэх ёстой. Мэдээ материалынх нь баталгаатай, мадаггүй байдлаас сонины нэр хүнд хамаардаг. Иймд нягталж шалгагдсан мэдээллийг нийтлэх нь хэрсүү, нягт нямбай, итгэмжтэй сайн сонины шинж юм. Хоосон яриа, цуурхалыг хөгжөөдөггүй байх ёстой. Хэвлэл мэдээллийн бусад хэрэгсэл цуурхал, хоосон яриаг дэврээж байлаа ч тухайн сонин түүнийг хориглох талаар чадах бүхнээ хийнэ.

4. Хувь хүнийг хүндэтгэх. Сонин нь ялгаварлан гадуурхалт, арьс өнгөний

үзэл, хүчирхийллийг өдөөн хатгалгүйгээр мэдээлэх ёстой. Ингэхдээ бие хүн ба хүмүүсийн эсрэг тэдний төрөлх байдал, аливаа онцгой угсаа гарал, яс үндэс, арьс өнгө, шашны бүлгээр нь ялгаварлан гадуурхах, үзэн ядах ба хүчирхийлэхийг хориглосон хуулиудыг чанд сахиж мөрдөнө. Ялгаварлан гадуурхалт бол уншигчдын сэтгэхүй дэх хардалт, сэрдэлт, дайсагнал, зэвүүцлээс үүдэлтэй салан тусгаарлах үзлийг өдөөгч юм. Үзэн ядалт бол хэн нэгэн рүү чиглэсэн угсаа гарал, яс үндэс, гишүүнчлэлийн ялгаанаас үүдэлтэй өсөрхөл нь хорлон сүйтгэх хүсэл болж хувирахыг хэлнэ. Хүчирхийлэл нь бие махбодын болон сэтгэл зүйнгэж хоёр ангилагдана. Сонины бүх материал иймэрхүү өдөөн хатгалтууд болон ийм сэтгэгдэл төрүүлэх эрсдэл бүхий нэр, хаяг, үг хэллэгүүдээс ангид байна.

7. Гүтгэлгээс зайлсхийх

Сонин нь хүний нэр төр, алдар хүндийг дээдэлнэ. Үүнийг дараах дөрвөн зарчмын дагуу хэрэгжүүлнэ.

- Зорилго зөв байх. Нийтлэгдэж буй баримтууд нь мэдээллээр хангагдах олон нийтийн эрхэн дээр ямагт тулгуурлаж, жирийн уншигчдад зориулагдсан байна гэдгийг сонин батална. Оролцогч хүмүүсээс нь илүүтэйгээр тухайн үйл явдалд ач холбогдол өгнө.
- Хувийн өс хонзон агуулахгүй байх. Хоорондын зөрчилтэй хувь хүмүүсийн тухай сөрөг нийтлэлүүдийг зориудаар нийтлэхээс сонин зайлсхийх ёстой.
- Үг хэллэг хэтрүүлэггүй байх. Нийтлэлүүд нь хүмүүсийг цочроох, түгшүүлэх үг хэллэгийг агуулаагүй байна.

- Эрэн сурвалжлага найдвартай байх. Тухайн үйл явдлын оролцогч бүх талыг сонсох нь аливаа шударга эрэн сурвалжлагын гол цөм бөгөөд үүн дээр тулгуурлан мэдээллийг эрж хайна.

8. Бүх үзэл бодолд нээлттэй байх. Үйл явдлын гол талуудын үзэл бодол, тэдэнд байгаа мэдээллийг нь шударгаар олж авах ёстой. Аль нэг тал нь мэдээлэл өгөхөөс татгалзвал сонин уншигчиддаа мэдэгдэнэ.

9. Гэм буруутай нь тогтоогдоогүй хүнийг хүндэтгэх. 1789 оны 8 дугаар сарын 26-ны Хүний ба Иргэний эрхийн Тунхаглалын 9 дүгээр зүйлд: “Гэм буруутай нь шүүхээр тогтоогдох хүртэл хэнийг ч гэм буруугүй гэж үзнэ” гэж заасан.

Энэхүү заалтыг Францын Үндсэн хуулинд оруулсан байдаг. Хэрэв тухайн хүний талаар нийтлэгдсэн мэдээлэл олон нийтийн эрх ашгийн үүднээс зөвтгөгдвөл буруугүй хэмээх олны таамаглалыг хүндэтгэж, уншигчдад өгөх зүйлсийг сайтар бодож сонгох ба хүргэх аргаа онцгойлон анхаарна.

10. Мэдээний мадаггүй, няхуур, шударга байдлыг нягтлах. Хүний эрх ашиг хөндсөн өгүүлэлд юуны өмнө алдаа мадаггүй, няхуур, шударга, анхааралтай байх зарчмуудыг баримтална.

Монголын Эмнести Интернэшнл ТББ-аас эрхлэн гаргасан “Хил хязгааргүй сурвалжлагчид” сэтгүүлдэд туслах зөвлөмжөөс хэсэгчлэн авав

§ Хэвлэлийн ажилтны ёс зүй

Австри, Нидерланд, Норвег, Швед, Их Британийн нэгдсэн вант улс зэрэг долоон орны үндэсний хэвлэлийн зөвлөлүүд нь хэвлэлийн ажилтны ёс зүйг тодорхойлсон бөгөөд түүнийг үндэслэн шийдвэрээ гаргадаг байна. Хэвлэлийн ажилтны ёс зүйд доорх зүйлийг тусгажээ. Үүнд:

1. Зөв шударга байх. Зохисгүй зүйлийг хасах. Бодит зүйлийг мушгиж гуйвуулахгүй байх
2. Санал шүүмжлэлд хариу өгөх бололцоог нээх
3. Байдлыг бодитой харуулах. Зарим ёс зүйн журамд хэвлэлийн ажилтнууд бэлэг авч болохгүй гэсэн заалт байдаг.
4. Хувийн нууцыг хүндэтгэх
5. Баримт санал бодол хоёрыг хооронд нь ялгаж салгах
6. Арьсны өнгө, үндэс язгуур, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлан гадуурхахгүй байх
7. Шударга бус замаар мэдээлэл авахгүй байх
8. Хүмүүсийг аюул осолд нэрвэгдүүлэхгүй байх
9. Ёс журам, таашаалын хүрээнээс халихгүй байх
10. Итгэж нууцлан дамжуулсан зүйлийг задраахгүй байх
11. Хүнийг урьдаас буруушаан ялласан зүйл нийтлэхгүй байх зэрэг үүргийг заажээ.

Орчуулсан Д.Дашдондов

IV. СОНГУУЛЬ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

§ Ардчилал ба сэтгүүлчдийн гүйцэтгэх үүрэг

Дэлхийн 120 гаруй орны олон зуун мянган сэтгүүлчийг эгнээндээ нэгтгэсэн Олон улсын сэтгүүлчдийн холбоо чөлөөт сэтгүүл зүйн үйл ажиллагааг ардчиллын гол үндсэн бүрэлдэхүүн хэсэг хэмээн үздэг. Сонгогчдод үнэн зөв мэдээлэл, үзэл бодлыг цаг тухайд нь өгөх асуудал нь тус байгууллагад нэгдсэн сэтгүүлчдийн эвлэлүүдийн нийтлэг шаардлага юм.

ОУСХ хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг тодорхойлохдоо: “Сэтгүүлч, редакторууд баримт, үзэл бодлыг хэвлэн нийтлэх, нэвтрүүлэх, түгээх замаар олон нийтийн сонирхлыг өдөөхгүй аваас ардчилсан нийгэмд сонгогч хариуцлагатай үнэлэлт хийж чадахгүй” хэмээн үзнэ.

ОУСХ-д нэгдсэн эвлэлүүд хэвлэл мэдээллийг залуурдах зорилго бүхий албан ёсны цензур болон сэтгүүлчид юу бичих, юу нэвтрүүлэхийг нь зааварчилсан аливаа арга хэрэгслийг зөвшөөрөхгүй. Залуурдах оролдлого нь мэдээллийн яам, тамгын газрын хүнд дарамтаас авахуулаад зар сурталчилгаа, арилжааныхны шахалт шаардлага хүртэл олон хэлбэрээр илэрдэг.

Гэвч ихэнхдээ хэвлэлийн эрх чөлөөнд хамгийн аюултай нь шууд хяналтын хэлбэрүүд бус сэтгүүлч, редакторууд өөрөө өөртөө цензуртэй болоход хүргэдэг тийм уур амьсгалыг бий болгох явдал юм.

Сэтгүүлчдийн хэвлэлийн эрх чөлөөний төлөө тэмцэлд нь хүч, зориг нэмэх хэрэгтэй гэж ОУСХ үздэг. Тиймээс ч бид 1991 оны Виндхукийн Тунхаглалд заасан хараат бус, олон ургальч хэвлэлийн тухай тодорхойлолтыг бүрэн дэмждэг.

“Хараат бус хэвлэл гэдэг нь Засгийн газар, улс төрийн болон эдийн засгийн хяналтаас хараат бус, сонин хэвлэлийг гаргахад шаардлагатай үндсэн эд материалын болон эд бүтцийн эрхшээлээс хараат бус байх явдал гэж бид үзнэ”.

“Аливаа дангаар ноёрхлыг арилгаж нийгэм дэх олон үзэл бодлыг аль болох өргөн тусгасан сонин хэвлэл бололцооны хэрээр олон гарч байхыг бид олон ургальч хэвлэл гэж үзнэ”.

Сэтгүүлчид үр ашигтай үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн байгууллагыг бий болгож өөрийн эрх ашгийн төлөө бат зогсохыг ОУСХ хөхиүлэн дэмжинэ. Ардчиллын үйл хэрэгт сэтгүүлчид гол үүрэгтэй. Гэвч сүрдүүлгээс айдаггүй, гадны нөлөөллөөс чөлөөтэй байх хэрэгцээг нь нийгмийн болон мэргэжлийн хүрээнд нөхцөлдүүлсэн тохиолдолд л сэтгүүлчид дээрх үүргээ биелүүлж чадна.

Сонгуулийг чөлөөтэй, шударга зарчмын үүднээс сурвалжлах шаардлагыг бид тодорхойлохдоо, сэтгүүл зүйн мэргэжлийн ур чадвар нь ёс зүйн болон ёс суртахууны хүндтэй үүрэг хариуцлагатай холбоотойг онцлон тэмдэглээд, энэ зарчим нь зөвхөн сонгуулийн үеэр бус, сэтгүүлчдийн ажлын бүхий л хүрээнд үйлчлэх ёстой гэж үздэг.

Сэтгүүлчид ардчиллыг өнгөн талаас нь гоёж чимэхээсээ илүү мэргэжлийн байр сууринаас ардчилалд хандах шаардлага байгаа учраас ОУСХ сэтгүүлчдийн дунд эв нэгдлийг бий болгохын төлөө байдаг.

НЭГ ТАЛЫГ БАРИХ БЭРХШЭЭЛТЭЙ ТЭМЦЭХ НЬ

Мэдээллийн чанартай хэвлэлүүд нэг талыг баримталсан гэх гомдол ямагт гарч байдаг боловч сонгуулийн үеэр энэ нь хамгийн тод томруун илэрдэг.

Сонин хэвлэлийн хуудаснаа буюу радио телевизийн нэвтрүүлэгт мэдээлбэл зохих зүйл, үйл явдлыг орхигдуулсан, эсвэл мэдээ нийтлэлийн өнгө аяс, сонины нүүрэнд байрлуулсан байдал нь нэг талыг барьж хийсэн хэмээн улс төрчид, сонирхлын бүлэглэлийн зүгээс сэтгүүлчдийг буруутгадаг билээ.

Сэтгүүлчид сонголтоо хийхдээ ихэнхдээ мэргэжлийн үүднээс ханддаг. Гэвч цаг хугацааны болон бусад шахалт дарамтын улмаас тэд алдах тохиолдол цөөнгүй гардаг. Гэвч бусдыг буруутгах эрх сэтгүүлчдэд байхгүй.

Сонины нэгэн ахмад редактор бичихдээ:

“Бид улс төрч, хэт туйлшрагч, мэдлэг хомстнууд биш. Бид бол сэтгүүлчид. Бид аль нэг намд тал засаж мэдээллийг гуйвуулахгүй, учир нь ингэснээрээ бид уншигчдаа хуураад, сэтгүүл зүйн мэргэжлийн гэдгээ харуулаад зогсохгүй, энэ нь ердөө л шударга бус юм.

Сэтгүүл зүй гэдэг нь цэвэр утгаараа олон түмний эрх ашгийн төлөө үнэнийг хэлэх явдал. Бид улс төрчид юмуу намуудад зориулжхүн зориулж бичдэггүй. Бид хүн олонд зориулж бичдэг”.

Гэвч улс төрийн дарамт байдгийг бид бүгдээрээ мэднэ. Ихэнхдээ энэ нь тухайн хэвлэлийн уншигчдын үзэл бодлыг дэмжих уламжлалтай холбоотой. Либерал буюу консерватив чиглэлийн сонинууд сайн тайлбар өгүүлэл, үзэл бодлын булантай байж болох боловч мэдээнийхээ хэсэгт аль нэг талыг илүү үзэж болохгүй.

Нэг сэтгүүлч хэлэхдээ:

“Хэвлэл нэг талыг баримталдаг гэдэг нь мэдээжийн зүйл. Мэдээ цуглуулах, редакторлах, хэвлэх ажлыг хийж байгаа хувь хүмүүс хүссэн хүсээгүй бичиж байгаа зүйлдээ өөрийн мэдлэг, туршлага, үнэлэмж, дүгнэлтээрээ мэдээллийн сонголт хийх, онцлох, өнгө аяс оруулах замаар нөлөөлдөг.

Сонинд Ерөнхийлөгч юмуу Ерөнхий сайдын тухай илүү олон мэдээлээд, сөрөг намын удирдагчийн талаар цөөхөн бичигдэж байвал зөвхөн энэ утгаараа сонин нэг талыг барьсан гэж шууд дүгнэж болохгүй. Учир нь ажил үүргийнхээ дагуу хоёр нь илүү олон дуугарч байгаа ч юмуу, эсвэл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хоёрын хэлсэн зүйл нь олон нийтийн сонирхол татаж байхад сөргөлдөгч нь үнэмшил муутай байгаа, эсвэл төр, засгийн тэргүүн нь цаг алдалгүй түрүүлж санал бодлоо илэрхийлсэн байдагтай холбоотой байж болох юм.

Сүүлийн үед зарим нэр дэвшигчид сэтгүүлчдийн шүүлтүүрээр оролгүй сонгогчидтойгоо шууд харьцах арга зам сүвэгчлэх боллоо. Тухайлбал 1992 онд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч тэрбумтан Рос Перо чөлөөт хэвлэлээр ярихааас зайлсхийж телевизийн цагийг шууд худалдаж авч байв. Тэрээр эфирийн цагийг хүссэн хэмжээгээрээ худалдаж авч байжээ. Тэр үед Рос Перо нэвтрүүлгийнхээ үеэр сэтгүүлчдийг дайрч давшлах бүрийд түүний албан контор руу олон сонгогч утасдаж түүнийг дэмжихээ илэрхийлж байсан нь бидний мэргэжлийн хувьд харамсалтай баримт болсон билээ .

Зарим нэр дэвшигчид шууд нэвтрүүлгээр сэтгүүлчдийн оролцоогүй үзэгч, сонсогчдын асуултуудыг хариулдаг. Ийм үед сэтгүүлчид олон түмнээс тавьж байгаа асуултыг анхааралтай сонсож тэдний санаа сэтгэлийг зовоож байгаа сэдвүүдийг зөв ойлгож нийтлэл нэвтрүүлэгтээ тусгаж байхад тустай байдаг .

Та үйл явдал, уншигч хоёрыг холбох шижим болохоос шүүлтүүр биш гэдгийг ямагт санагтун.

Америкийн Сонины Редакторуудын Нийгэмлэгийн Семур Топпинг хэлэхдээ: “Хүмүүсийн улс төрийн үйл явцад оролцох хүсэл улам бүр нэмэгдсээр байна. Тэд өөрсдийн үзэл бодлыг сонин хэвлэлд ойр ойрхон, илүү дэлгэрэнгүй нийтлүүлэхийг хүсэж байна. Үүнийг захидлын тойм, уншигчдаас авсан ярилцлага зэрэг олон хэлбэрээр хийж болох бөгөөд олон түмний хэрэгцээ, шаардлагыг тэднээс асуух нь улс төрч, шилдэг бизнес эрхлэгч, бусад мэргэжлийн тэргүүлэх хүмүүстэй ярихаас давамгайлж эхлэв” гэжээ.

Сонгуулийн кампанийн дотоод зүй тогтолтой хэт хутгалдсанаас болж өдөр тутмын үйл явдлаас хөндийрснөөс нэг талыг баримтлахад хүрдэг аюул бий. Сонирхолтой мэдээллийн хойноос хөөцөлдөж байгаад улс үндэстнийхээ тулгамдсан асуудлуудыг орхигдуулж болохгүй. Америкт 1988 онд явуулсан нэг судалгаанаас үзвэл сонгогчид хамгийн сайн мэдээллийг нэр дэвшигчдийн халз маргаанаас олж авсан дүн гарчээ.

Сэтгүүлчдээс биш шүү.

Сонгуулийн үеэр аль нэг талыг илүү товойлгохгүйн тулд зарим редакциуд дотоодын зохицуулалт, зарчмуудыг боловсруулан ажилладаг. Ер нь өөрийн зохицуулалт, дотоод хяналттай байх нь хэвлэлийн маргаан зохицуулах зөвлөлийн “бүхнийг мэдэгч” төлөөлөгчөөр шүүлгэхээс ямагт дээр байдгийг битгий мартаарай .

РЕДАКЦИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

Хэвлэл мэдээлэл гэдэг бизнес боловч дан ганц бизнес биш юм. Сэтгүүлч редакторууд бүхэл нийгмийн өмнө хариуцлага хүлээдэг. Энэ юуг хэлж байгаа юм бэ гэвэл сэтгүүлчид зах зээл, ардчилал хоёрын торгон зааг дээр ажилладагт оршино.

Италийн сэтгүүлчдийн Федерасион Националь Делла Стампа байгууллагын үзэж байгаагаар:

“Хэвлэлийн үүрэг нь эдийн засаг, улс төрийн аль нэг эрхтэн дархтаныг дэмжихэд бус, харин уншигчдынхаа тусын тулд нийгэм, түүн доторхи эрх мэдэл бүхий хүмүүсийн талаар өдөр тутам иж бүрэн дүр зургийг нээн харуулахад оршино. Сонин, сэтгүүл болоод сэтгүүлчид нь анх бий болохдоо нийтлэг эрх ашгийг илэрхийлэх хэрэгсэл байсан, байсаар ч байх ёстой. Хэн нэгэн хүний юмуу аль нэг явцуу сонирхлын дуу хоолой байх ёсгүй.

Зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийгөө бүх төрлийн шахалт, дарамтаас чөлөөтэй байх байдлаа баталгаажуулах зорилгоор редакцийн хараат бус байдлын статусыг бий болгосон байна. Тухайлбал, Австралид, тус улсын сэтгүүлчдийн эвлэл болон Мельбурн хотноо хэвлэгддэг “Зэ Эйж” хэмээх өдөр тутмын сонины хэвлэн нийтлэгчдийн хооронд байгуулсан гэрээнд дараах зүйлүүдийг тохиролцжээ:

1. Захирлуудын зөвлөл болон түүнээс томилогдсон сонины удирдлага нь редакцийн хараат бус байдлыг хүндэтгэн хүлээн зөвшөөрнө.
2. Захирлуудын зөвлөл, сонины удирдлага, редакторууд болон бүх ажилтнууд Австралийн Сэтгүүлчдийн Эвлэлийн ёс зүйн зарчмууд, Австралийн Хэвлэлийн Зөвлөлөөс тунхагласан зарчмуудыг дагаж мөрдөнө.
3. Сэтгүүлч, зураач, гэрэл зурагчид хот, улс үндэстний амьдралыг үнэн зөв шударга тусгаж, аль нэг бизнес, хувь хүн, улс төр, түүний дотор сонины хувьцаа эзэмшигч, захирал, менежер, эрхлэгч, сурвалжлагчийн ашиг сонирхолыг үл харгалзана.

-
4. Сонины эрхлэгчийг ажилд томилох, халах эрхийг Захирлуудын зөвлөл болон түүнээс томилогдсон сонины удирдлага эдэлнэ. Сонины эрхлэгч удирдлагатайгаа зөвшилцсөн төсвийг зарцуулах, сониныг нийтлэлийн хувьд хянах эрхийг эдэлнэ. Эрхлэгч дангаараа нийтлэлийн бодлого, агуулгыг тодорхойлох бөгөөд сонины ажилтнуудыг томилох, халах эрхтэй.
 5. Сонины эрхлэгч сонины удирдлагын өмнө шууд хариуцлага хүлээж, ажил үүргээ биелүүлэхдээ энэхүү гэрээний дагуу сониныхоо бие даасан байдал, нэр төрийг ямагт хамгаална.

Германд “Штерн” сэтгүүлийн ажилтнууд редакцийн чөлөөт байдлыг нарийн тохиролцсон гэрээгээр баталгаажуулсан байдаг. Үүний дагуу “Штерн” сэтгүүл нь нийгэм, улс төрийн сэтгүүл боловч Герман улсын аливаа улс төрийн нам, бизнесийн бүлэглэл буюу аль нэг ашиг сонирхлын бүлгээс хараат бус байх статустай юм.

Уг баримт бичигт “Штерн” сэтгүүл уншигчдаа мэдээллээр хангах, тэднийг зугаацуулахыг зорино гээд редакцийн хамт олон чөлөөт, ардчилсан тогтолцоог шүтэж, ажилдаа дэвшилт либерал зарчмуудыг мөрдлөг болгоно гэжээ.

“Штерн” сэтгүүлийн ажилтнуудад тэдний итгэл үнэмшлийн эсрэг чиглэсэн аливаа зүйл бичих, ямар нэг хариуцлага хүлээхийг тулган шаардахыг хориглоно. Дээрх явдлыг эсэргүүцсэнийхээ төлөө тэд ямар нэг байдлаар хохирох ёсгүй.

“Штерн” сэтгүүлийн редакцийн ажилтнуудын эрх ашгийг хамгаалах зорилгоор зөвлөх хэсгийг 7 хүний бүрэлдхүүнтэйгээр жил бүр нууц санал хураалтаар сонгодог. Редакцийн 30 ажилтны шаардлагаар зөвлөх хэсгийг шинээр сонгоно.

“Штерн” сэтгүүлийн ерөнхий эрхлэгчийг хэвлэн нийтлэгч томилоно. Ерөнхий эрхлэгч нь редакцийг бүрэн төлөөлөх тул түүнийг томилохдоо зөвлөх хэсэгтэй зөвшилцөнө. Зөвлөх хэсгийн гишүүдийн 2/3 ерөнхий эрхлэгчийг шинээр томилох буюу халахыг эсэргүүцэх эрхтэй.

СОНГУУЛИЙГ СУРВАЛЖЛАХ РЕДАКЦИЙН ЗАГВАР

Сонгуулийг дорвитой сурвалжлахад төлөвлөлт гол үүрэгтэй. Дор санал болгож буй загвар нь нарт болон сонгуулийн сурвалжлагын хэсгийн ажилд тус дөхөм болох болов уу. Гэвч энэ загварыг өөрийн нөхцөлд ашиглахдаа болгоомжтой хандаарай. Нөгөө талаар мөнгө санхүү муутай хэвлэл энэхүү зарчмуудыг дагаж мөрдөх бололцоогүй гэж хэн нэг нь хэлбэл бүү итгэ. Бага мөнгөөр сайн хэвлэл гаргаж болдог юм шүү.

- *Сонгуулийн хорооноос сонгуультай холбоотой бүх зүйлийг асууж лавла.* Үүнд: нэр дэвшигчдийг бүртгэх хугацаа, сонгуулийн кампани эхлэх, дуусах хугацаа, санал хураалтын бүх дэг журам г.м.
- *Сонгуулийн дүрэм, журмыг судал.* Үүнд: санал хураах зарчим, сонгуулийн хууль, сонгуулийг ажиглах журам, гадаадын ажиглагчдын үйл ажиллагаа зохицуулсан байдал, олон нийтийн санал асуулгын дүнг хэрэглэх журам, сонгуулийн сурталчилгааны зохицуулалт, төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл сонгуулийн сурталчилгааг явуулах журам г.м.
- Бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн байгууллага, хэвлэн нийтлэгчдийн холбоо зэрэгтэй хамтарч сонгуулийн үеэр сэтгүүлчдийн баримтлах зарчмуудыг боловсруулж улс төрийн бүх намуудад танилцууснаар тэдний зүгээс сэтгүүлчдийг хүндэтгэх, дэмжигчид нь хэвлэл мэдээллийнхнийг дайрч давшлахгүй байх боломж

нээгдэнэ.

- **Уншигчиддаа сонгуулийн кампанийг хэрхэн сурвалжлах, ямар зарчим баримтлахаа тайлбарла.**
- **Сонгуулийг сурвалжлах зардлаа тооцоол.** Сонгуулийн кампани нь хэвлэл мэдээллийн хувьд ашигтай бизнес байдаг боловч ихээхэн зардал шаарддаг. Танд нэмэлт телефон утас, факс, унаа, цаг хугацаа шаардагдана. Зардлаа зөв төлөвлөж, хөрөнгөө ухаантай зарцуул. Мөнгө дутвал хүндрэл гарна.
- **Ажлын хэсгээ бүрдүүл.** Сонин хэвлэлийн улс төрийн албаныхны хувьд сонгууль нь хамгийн сонирхолтой ажил байдаг. Хэдий тийм боловч тэд сонгуулийг сурвалжлах эрхийг дангаараа эдлэх ёсгүй. Сонины бүх албадыг онцлогийн нь дагуу энэ ажилд оролцуулах хэрэгтэй. Мэргэшсэн хүмүүсээр өөр өөрийн чиглэлээр нь /эдийн засаг, эрүүлийг хамгаалах, гадаад харилцаа, боловсрол г.м./ намуудын мөрийн хөтөлбөрт задлан шинжилгээ хийж, нэр дэвшигчдийн хэлсэн үгийг шүүн тунгааж, бодитой зүйл хоосон амлалтыг нь ялган салгасан нийтлэлүүд бичүүлж болно. Сонгуулийн кампани чухал боловч өдөр тутмын мэдээгээ мартаж болохгүйг сануулья.
- **Редакцийн зөвлөл байгуул.** Энд ерөнхий эрхлэгч, хэлтэс, албадын дарга нар болон цөөн тооны чадварлаг тоймч, сурвалжлагчийг оролцуулан сонгуулийн явцад гарах хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэнэ.
- **Техник ажлаа төлөвлө.** Зар сурталчилгааны алба сонгуулийн үеэр рекламны талбайгаа улс төрийн сурталчилгаанд чөлөөлж өгөх хэрэгтэй, хэвлэлт хариуцсан менежер сонгуулийн өдөр сонин оройтож хэвлэгдэхтэй холбогдсон зохицуулалт хийнэ, сонины тараалт хариуцсан менежер мөн ажлаа урьдчилан зохицуулсан байх шаардлагатай.
- **Нэмэгдэл хүн хүч дайчил.** Сонгуулийн өдөр их хэмжээний мэдээлэл цуглуулах шаардлагатай тул залуу сэтгүүлчид, утас факс дээр ажиллах хүн, жолооч, нарийн бичгийн дарга г.м. хүмүүсийг авч ажиллуулах хэрэгтэй.
- **Сонгуулийн экспертүүдтэй холбоотой бай.** Сонгуулийн кампанийн явцад болон сонгуулийн дүн гармагц улс төр судлаачид, олон нийтийн санал бодлыг судалдаг мэргэжилтнүүд зэрэг экспертүүдээр задлан шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах хэрэгтэй. Урьдчилан тохирч улс төрийн намуудын удирдагчидтай сонгуулийн өдөр дуусахад уулзаж санал бодлыг нь сонсоход ашигтай. Гэвч жирийн иргэдийн бодлыг сонсохоо бас мартуузай.
- **Гэрэл зургийн цуглуулгаа шалга.** Сонины гэрэл зургийн тасагт сонгуульд нэр дэвшигчдийн аль болох олон зураг байх хэрэгтэй.
- **Гэнэтийн тохиолдолд бэлтгэлтэй бай.** Танай талаас-компьютер гацах, орон нутагт байгаа сурвалжлагчтайгаа холбоо барьж чадахгүй болох, сурвалжлагч тань баривчлагдах юмуу гэмтэх, Засгийн газрын талаас-сонгуулийн дүн гарах хугацаа хойшлох, сонгуулийн журам өөрчлөгдөх г.м. гэнэтийн тохиодол гарахад юу хийхээ урьдчилан төлөвлөсөн байвал зохино.
- **Иргэдийн санаачлагын байгууллагатай хамтарч ажилла.** АНУ-ын Ухаалаг сонголт” төслийн зөвлөгөөг үзье:
 1. Манай нийгмийн эзэн нь иргэд. Албан тушаалтнууд бол түр хугацаагаар сонгогдсон хөлсний хүмүүс гэдгийг бүү март.
 2. Сонгуулийн кампани бол улс төрчдөөс батлуулах гэсэн өргөдөл гэж үзэцгээ.

3. Бид нэр дэвшигчдийг сонгосноороо тэднийг ажилд авч байгаа хэрэг.

Тиймээс тэдний хэн нь хамгийн сайн ажилтан бэ гэдгийг шийдэхэд шаардлагатай мэдээллээр нэр дэвшигчид биднийг хангаж байгаа эсэхийг эргэцүүлэн бод.

- **Иргэний сургалт.** Сонгуулийн зарчим, саналаа өгөх арга техник, сонгууль явагдсанаар ямар үр дагавар гарах /шинэ парламент, засаглалын хуваарилалт г.м./ талаар хэвлэл мэдээллийнхэн уншигч, сонсогч, үзэгчдэд уйгагүй, ахин, дахин тайлбарлан таниулах ёстой. Сонгуультай холбогдсон уншигчдын асуулгад хариулах тусгай булан нээх хэрэгтэй.
- **Олон нийтийн санал асуулга.** Мэргэжлийн түвшин дорой хийгдсэн санал асуулгыг бүү ашигла. Ашигласан ч зохих тайлбар хийж, дутагдал сул талыг нь тайлбарлах хэрэгтэй. Олон нийтийн санал асуулга нь уламжлалт, шалгарсан улс төрийн сурвалжлагыг хэзээ ч гүйцдэггүй гэдгийг бүү март.
- **Сонгуулийн өдрийн бэлтгэлээ сайн ханга.** Гол гол нэр дэвшигчдийн намтар, мөрийн хөтөлбөр, сонгуулийн тойрог дахь хүн амын судалгаа, аль нам давамгайлж байгаа, ямар тулгамдсан асуудал байгааг г.м.
- **Сонгуульд дэвшүүлж байгаа сэдвүүдийг зөв тусга.** Сэдвүүдийг намуудын байр сууринаас хараат бусаар тусгаж, тэдний орхигдуулсан, үгүйсгэсэн сэдвийг чухал байвал дэвшүүл. Нэр дэвшигчид юу хэлсэн, урьд нь /зөвхөн сонгуулийн кампанийн үеэр биш, хэдэн жилийн турш/ юу ярьж, юу хийж байв гэдгийг гаргаж тавь.
- **Утга зохиолын ажилтнуудынхаа ажлыг сайжруул.** Нийтлэлүүдээ уншигчдад ойлгомжтой энгийн хэлбэрт оруул. Улс төр, эдийн засгийн түвэгтэй, ойлгомжгүй хэллэгээс зайлсхийж, сунжирсан, урт өгүүлүүд битгий нийтэл.
- **Нэр дэвшигчийн нөлөөнд бүү ор.** Санал асуулгын дүнгээр дээгүүр явж байгаа нэр дэвшигчийг хэвлэлийнхэн даган хошуурч, нэг талыг барих явдал гардгийг санагтун.
- **Нам болон нэр дэвшигчдийн ард хэн байгааг мэдэж тэдэнтэй холбоо барь.** Нэр дэвшигчийн амлалт, хөтөлбөрийг судалж, тэрээр сонгогдвол хэнд ямар байдлаар тусахыг олж хар. Мөнгө хаанаас гарч байгааг мэд. Сонгуулийн кампанийг хэн санхүүжүүлж байна, тэр хүмүүс юу хүсэж байгааг /шинэ хууль, эрх мэдэл г.м./ мэдэж ав.
- **Сэтгүүл зүйн бичлэгийн бүх хэлбэрийг ашигла:** Урт сурвалжлага, дүн шинжилгээ бүхий нийтлэл, зураглал болон шог зураг эрэн сурвалжлах сэтгүүл зүй /тухайн нэр дэвшигчийн ард хэн байна вэ тухайлсан ашиг сонирхлын үүрэг роль гэх мэт/ фото сурвалжлага, хувийн хэрэг, ярилцлага, маргаан.
- **Нээлттэй зай:** Улс төрийн өөр өөр намуудын улс төрчдөд шударга бөгөөд дарааллын зарчмын үндсэн дээр сониндоо өгүүлэл бичих бололцоог олговол зохино . Харин аливаа нэр дэвшигчид зохисгүй арга замаар давуу байдал олгохгүй байх, уншигчдаа намын ухуулгаар дарахгүй байх үүднээс үүнийг санал хураах өдрөөс хоёр долоо хоногийн өмнө зогсоох учиртай.
- **Сонгуулийн кампанийн хуйвалдаан, заль мэхийн тухай мэдэж авбал зохино.** Зөвхөн шуугиантай материал гаргахын тулд зохиосон болон зохиомол үйл явдлаас сэрэмжлэгтүн.
- **Пресс-релиз:** Улс төрийн намуудын пресслезийг тэр хэвээр нь хэвлэж болохгүй. Тэдгээрийг нягтлан шалгаж, илүү тэнцвэртэй өгүүлэл бичих эх үүсвэр болгон ашиглах

хэрэгтэй. Фото зургийн боломжийн хойноос хөөцөлдөх хэрэггүй. Зөрчилдөөнийг хэтрүүлэх хэрэггүй. Зохиомол хов жив сонгогчдын жинхэнэ ашиг сонирхлоос өөрийг чинь холдуулж болзошгүй.

- **Итгэл үнэмшилтэй байгтун:** Та удаан хугацааны туршид итгэл үнэмшилтэй байх чадвараа бооцоо болгон тавьж байгаагаа бүү мартагтун. Нэр дэвшигч бүрийн сурталчилгааны кампанийг ойроос сайтар ажигла. Зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэл сонгуулийн кампаний амлалт болон сурталчилгааны арга барилыг нягтлан шинжилж байдаг тусгай булантай. Худал хуурмаг зүйл, хэтрүүлгийг тааралдсан газар бүрт илчилж бай. Бие даасан хэвлэл мэдээллээс бусад эх сурвалжаас авсан аливаа мэдээ сэлтийг нягталж, учир холбогдлыг нь тодруулан тогтоож байвал зохино.
- **Сонгуулийн дараа:** Ажлын хэсгийнхээ сонгуулийн кампаний сурвалжилсан байдал, арга замыг эргэн хар. Үйл ажиллагаагаа өрсөлдөгчийнхтэйгээ харьцуулан үз.
- **Олон намын суудалтай парламент буюу эвслийн засгийн газрын талаарх мэдээлэл сурвалжлагад ажилтнуудаа сургавал зохино.** Нэр дэвшигчдийн сонгуулийн кампанийн явцад амласан зүйлүүдийг нягтлан үз. Тэдний хийсэн бүтээснийг үүрэг амлалттай нь харьцуулан шалга. Алба, амины сонирхлын зөрчилдөөн байгаа эсэхийг ямагт анхаар. Парламентын аль нэг гишүүн ямар хууль тогтоомж боловсруулахад идэвхийлж буйгаас түүнийг санхүүгийн хувьд хэн дэмжиж байна вэ гэдгийг олж тогтоох сэжүүр гарч болзошгүй.

Орчуулсан С.Баяраа

§ Сонгууль сурвалжлах зарчмууд

1. ТАНИЛЦУУЛГА

Ардчилалд шилжиж байгаа орны төдийгүй тухайн орны янз бүрийн бүс нутгийн нөхцөл байдал сонгуулийн явцад нөлөөтэй тул энэхүү зарчмуудыг үндэсний онцлогийг харгалзан хэрэглэх нь чухал гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Гэхдээ ямар ч зарчмын үндэс суурь нь сонгууль явуулах талаар хүлээсэн үүрэг болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн практик үйл ажиллагаа байдаг. Олон улсын шалгарсан туршлагаар сонгууль явуулахын тулд сонгуулийн өмнө хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд үл нийцэх хууль тогтоомжийг хүчингүй болгох арга хэмжээ авах шаардлагатай. Тийм учраас, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйлийн заалтад харшилж байгаа аливаа хуулийн заалтыг тодруулан тогтоож, сонгууль явагдахаас өмнө хүчингүй болгох арга хэмжээ авах хэрэгтэй.

Сонгуультай холбоотой аливаа мэдээлэл, ялангуяа нэр дэвшигч болон улс төрийн намуудын үзэл баримтлал, санаа бодол, хэлэлцүүлэг зэрэг материалыг олны хүртээл болгох давуу эрх бүхий олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хууль, эрх зүйн актыг анхааралдаа авах хэрэгтэй.

Эдгээр материал, илгээлтийг радио, телевизээр дамжуулах, эсвэл олон нийтээс санаачилсан цуглаан гэх мэт мэдээллийн бусад сувгаар дамжуулж болно. Тийм учраас аль нэг, эсвэл дээрх бүх олон төрөл хэлбэр нь олон ургальч үзэл, ил тод байх хэрэгцээ шаардлага бол сонгуулийн мэдээллийн стратегийг тодорхойлоход эхний бөгөөд онцгой чухал цэг юм.

Бүх төрлийн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, чухал шийдвэрүүдийг танилцуулах шаардлага бүхий мэдээллээр ард иргэдийг хангахад төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэргүүлэх үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр иргэдийнхээ эрхийг хүндэтгэж буйгаа Засгийн газрууд харуулж чадна гэдэгт Олон улсын сэтгүүлчдийн холбоо бат итгэдэг.

Бичиг үсэг үл мэдэх явдлын түвшин өндөр, үндэсний хэлийг /Англи, Франц, Португал хэлээр/ үгүйсгэх, сонины үнэ, тээвэрлэлт, орон нутагт тараахад тулгарах хүндрэл бэрхшээл болон сонин сэтгүүл хэвлэн гаргах боломжгүй байдлаас үүдэн олонхи улс оронд радио телевизийн тэнцвэрт байдлын шударга зарчмыг хадгалах явдал чухлаар шаардагдаж байна. Радио телевиз нь ихэнх газар нутгийн хэлээр мэдээлэл дамжуулах гол хэрэгсэл болсоор байна. Ийм ч учраас оршин суугчдыг аль болох их мэдээллээр хангах өндөр хариуцлага радио телевизийн байгууллагад ноогддог.

Эдгээр зарчмын дагуу Засгийн газрын хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээж, үнэнч шударгаар, ямар нэг ялгаварлалгүйгээр үүргээ гүйцэтгэх ёстой. Эдгээр зарчим нь хувийн радио, телевизийн нэвтрүүлгийн тэнцвэрт байдал, долгионыг тэгш эрхтэй ашиглах зарчмын үндсэн дээр ажиллахыг дэмжин сайшаадаг.

Хэвлэл мэдээлэлд цензур тогтоохын эсрэг 19 дүгээр зүйл хэмээх Олон улсын Төвөөс үндэслэн боловсруулсан энэхүү зарчмын үндсэн ба анхны хувилбарууд сонгууль сурвалжлах хүрээ хэмжээг тогтооход Засгийн газруудад туслана гэдэгт бид итгэж байна.

2. МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН АЖИГЛАХ ХЭСЭГ

Сэтгүүлчид сонгуулийн хугацаанд ихээхэн хяналт ажиглалтад өртдөг. Жишээлбэл, Омнөд Африкт гадаадын санхүүжилтээр сонгуулийн ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслийнхэн хэрхэн сурвалжилж байгаад ажиглалт хийх төслүүдийг хэрэгжүүлсэн байна.

Хэрэв улсын буюу хувийн монополиуд мэдээллийн талбарыг дагнан эзэмшсэн, сонгуулийн ажиллагааны дүр зургийг тэнцвэртэй, тэгш төлөөллийн зарчмаар ард түмэнд мэдээлээгүй, эсвэл сэтгүүлчид муу ажилласан бол сонгуулийг чөлөөтэй, шударга болсон гэж үнэлэх ёсгүй.

Сэтгүүлч, редактор, хэвлэн нийтлэгчид зарим үед энэ ажиглалтад эмзэглэдэг боловч хэвлэлийн шүүмжлэл нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн чансаа мэргэжлийн түвшинг дээшлүүлэхэд хэрэгтэй, ардчилсан үйл явцын бүрэлдэхүүн хэсэг юм.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл сонгуульд зонхилох үүрэг гүйцэтгэдэг учраас ажиглагчийн өөрийн хэсгийг сонгуулийн энгийн сурталчилгааны 1 хэсэг гэж үзэн зохион байгуулдаг.

АНУ-ын “Vote smart” төсөлд ажиглалт хийхдээ дараах асуудалд хариулт авч болох юм гэсэн санааг тусгажээ. Үүнд:

- Сөрөг хүчний нэр дэвшигчдэд адил тэгшээр хандаж байгаа эсэх?
- Нэр дэвшигчээс түүний холбоотон, өрсөлдөгч, эсвэл хөндлөнгийн хүн ярилцлага авсан уу?
- Мэдээллийн хэрэгсэл дуу бичлэг, фото зураг ашиглаж байна уу?
- Мэдээллийн хэрэгсэл нь танай нийгэмлэг болон улс оронд тулгамдсан асуудлын талаар хэрэгтэй мэдээлэл өгч чадаж байна уу? гэх мэт.

Омнөд Африкт мэдээллийн хэрэгслийг ажиглах төсөл нь бүх телевизийн станц, 13 радиостанц, өдөр тутмын 17 сонинг хяналтдаа авч байжээ.

Ажиглах хэсгийн тайланг мэдээллийн албад, улс төрийн намууд, ЭСЯ-д, үндэсний болон гадаадын ажиглагчид, сонгуулийн комисст хувь хүн буюу байгууллагаар нь ялган илгээж байсан байна.

Ажиглах хэсгийн төсөлд “Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд ажиглалт хийхдээ хоёр зүйлийг авч үзнэ.

- 1/ Улс төрийн намуудын үйл ажиллагааг адил тэгш сурвалжилж байгаа эсэх,
- 2/ Ер нь олон нийтийн мэдээллийн ямар хэрэгслүүд сонгуулийг хэрхэн сурвалжилж байна вэ?

Энд мэдээллийн хэрэгсэл нь сүрдүүлгийн жишээ баримт илрүүлсэн үү? Эсвэл сонгуулийн луйвар, зүйд үл нийцэх болон буруу ташаа мэдээ нийтлэсэн үү гэх мэт асуулт гарна” гэжээ. Ажиглах хэсгийн төслийг Омнөд Африкт хэрэгжүүлэх болсны үндэс нь улсынхаа анхны ардчилсан сонгуульд Омнөд Африкийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд чухал үүрэг гүйцэтгэсэн явдал байв.

Тэд сөрөг хүчнийг үл ялгаварлан, шударга зарчмыг эрхэмлэн, олон түмний санаа бодлыг бодитойгоор илэрхийлж ажилласнаараа олон нийтийн мэдээллийн хэрэгслийг

үнэлдэг олон улсын түвшинд хүрч авч чадсан байна. Олон улсын сэтгүүлчдийн холбооны дагаж мөрдөх хууль мөн энэ түвшингийн нэг болдог /50 дугаар хуудас/.

Европын шүүх иргэний эрхийг иш татан тунхаглахдаа:

Иргэд: Тухайн асуудлын бүх талыг хамарсан бүрэн мэдээлэл, аливаа асуудлаар илэрхий нэг талыг барьсан, эсвэл далдуур дэмжээгүй шударга мэдээлэл, улс төрийн аливаа эрх ашигт үйлчлэхгүй бие даасан мэдээлэл, олон нийтийн ашиг сонирхлыг үгүйсгэж гуйвуулаагүй үнэн зөв, тодорхой мэдээлэл авах ёстой гэжээ.

Ажиглах хэсгийн төслөөр дараах зүйлүүдэд хяналт хийсэн байна. Үүнд:

- 1/ Сонгуулийн кампаний холбогдолтой асуудлаар хэвлэлд гарсан бүх зүйлд,
- 2/ Сонгуульд оролцсон намуудын сурталчилгааны холбогдолтой бүх материалд,
- 3/ Улс төрийн намууд, засгийн газрын тухай бүх материал,
- 4/ Засгийн газар болон улс төрийн намуудын тухай дурдсан бусад мэдээ материал,
- 5/ Засгийн газрын аппарат /цагдаа, аюулаас хамгаалах, орон нутгийн засаг захиргаа/ болон сөрөг хүчинтэй холбоотой бүх мэдээ материалыг хамарсан байна.

Мэдээллийн хэрэгсэлд ажиглалт хийхдээ ерөнхийдөө дараах асуудлыг хамарна. Үүнд:

- а/ “Үнэн бодит хүчин зүйл” буюу тоон үзүүлэлтийг судлах өрсөлдөгч тал /эсвэл улс төрийн намуудад/ холбогдох байгууллагуудад хэдий хэмжээний цаг хугацаа, хэвлэл нийтлэлийн зай талбай зарцуулсан тухай,
- б/ Чанарын үзүүлэлтийн хувьд: мэдээ, түүхийн булан, үг хэллэгийн утга, цаг үеийн байдал, онцлог тооцоолсон цаг хугацаа, орон зай, агуулгын талаар,
- в/ Онцгой үйл явдлуудын судалгаа: /сонины эхний нүүрт харьцуулсан дүн шинжилгээ судалгаа, чимээгүй өнгөрсөн тохиолдлууд/, яагаад, хэн, уг мэдээллийг гаргаагүй талаар,
- г/ Мэдээг ач холбогдолоор нь зэрэглэн дугаарласан байдал: давтагдах байдал, эсвэл байр сууриар нь санаа бодол, биеэ авч явах явдлыг хэрхэн үнэлсэн зэргээр сонгуулийн асуудлаар аль нэг намд давуу байдал олгосон эсэх г.м.

ЗАСГИЙН ГАЗРЫН БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Зарчим 1. Засгийн газрын мэдээллийн хэрэгсэл бүх иргэнд мэдээлэл хүргэх ёстой

Сонгуулийн өмнөх үед засгийн газрын мэдээллийн хэрэгслүүд нь иргэдийг сонголтоо хийхэд нь тус болох холбогдох мэдээллээр хангах ёстой. Засгийн газар мэдээллийн хэрэгсэл олон түмэнд:

- сонгуульд өрсөлдөх улс төрийн намууд, нэр дэвшигчдийн тухай,
- намуудын мөрийн хөтөлбөрийн холбогдолтой материал зэрэг сонгуулийн гол зүйлүүдийн тухай,
- санал хураах явц болон иргэд сонгуульд оролцохтой холбоотой бусад бүх мэдээллийг өгөх ёстой.

» *Тайлбар:*

- 1/ Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25–р зүйлд: “Иргэн бүр жинхэнэ сонгуульд ялгаваргүйгээр санал өгөх эрх, боломж нөхцөлөөр хангагдсан байх эрх эдэлнэ” гэсэн заалтыг Засгийн газрууд хангах үүрэгтэйг заасан.

-
- 2/ Ард түмний олонхи нь олон намын сонгуулийн туршлагагүй улс орнуудын Засгийн газар сонгуулийн холбогдолтой мэдээллийг өргөн хүрээтэй тараах онцгой үүрэг хүлээнэ.
 - 3/ Энэхүү эрх нь бичиг үсэг мэдэхгүй хүмүүсийг санал өгөхөд онцгой ач холбогдолтой. Тэдний бүх мэдээллийг олж авах, саналаа өгөх аргачлалыг Засгийн газар баталгаажуулах ёстой.
 - 4/ Засгийн газрууд нь радио, телевизийн мэдээллийн хэрэгсэл, эсвэл бусад мэдээллийн хэрэгслүүдийн тухайн оронд оршин амьдарч байгаа бүх санал өгөгчдийг сонгуулийн мэдээлэл, үйлчилгээнд нэвтрэх боломжоор хангах ёстой.

Зарчим 2. Засгийн газрын мэдээллийн хэрэгсэл шударга байх ёстой

Засгийн газрын мэдээллийн хэрэгсэл нь сонгуулийн холбогдолтой мэдээ, мэдээллийг дамжуулж мэдээлэхдээ тэнцвэртэй байдлыг хадгалж, шударга зарчим баримтлах ёстой. Ялангуяа Засгийн газрын мэдээллийн хэрэгсэл нь программууд болон мэдээллийн үйлчилгээг аль нэг нэр дэвшигч, эсвэл аль нэг намыг дэмжихийг зорилго болгохгүйг баталгаажуулахын зэрэгцээ сонгуульд өрсөлдөгч бүх нэр дэвшигчид болон намуудыг мэдээллийн хэрэгсэлд адил тэгш нэвтрэх нөхцөлийг хангана.

» *Тайлбар:*

- 1/ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйлд: “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Үүнд: үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах, аливаа үзэл санаа мэдээллийг Улсын хил заагаар үл хязгаарлан, боломжтой бүх арга замаар эрж сурвалжлах, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана” гэж заасан.
- 2/ Иргэдийн энэхүү эрхийн баталгааг хангахын тулд сонгуулийн хугацаанд бүх нам болон нэр дэвшигчид өөрсдийн үзэл бодлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр илэрхийлэх, түүнд нэвтрэх боломжийг засгийн газар болон төрөөс баталгаажуулах ёстой. Сэтгүүлчид Засгийн газар болон төрийн эрх баригчдын удирдамж, чиглэлд баригдахгүй сонгуулийн хүрээнд мэргэжлийн үүднээс чөлөөтэй ажиллах ёстой.
- 3/ Төрийн мэдлийн мэдээллийн хэрэгсэл нь Засгийн газрын төлөөлөгчийн албан үүрэг болон сонгуулийн кампаний үйл ажиллагаанд өөрсдийн нам, түүнээс сонгуульд нэр дэвшигчдийн нэрийн өмнөөс авч, болох үүргийг редакцийн хүрээнд ялгавартайгаар гүйцэтгэнэ.

Зарчим 3. Засгийн газар олон нийтийн мэдээллийн хэрэгслийг хамгаалах ёстой

Засгийн газар нь олон нийтийн мэдээллийн байгууллага болон мэдээллийн хэрэгслийн ажилтнуудын эсрэг бүх төрлийн сүрдүүлэг хүчирхийлэл үйлдэх, эсвэл сэтгэлзүйн дарамт үзүүлэхээс хамгаалах үүрэг хүлээнэ.

Засгийн газар нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөнд халдах, эсвэл сэтгүүлчдийн чөлөөтэй ажиллах явдлыг хязгаарлахыг эрмэлзсэн хууль бус үйлдлийг шалгаж тогтоох, мөрдөх, шийтгэх асуудлыг хариуцна.

» *Тайлбар:*

- 1/ Онөөдөр НҮБ, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, сэтгүүлчдийн аюулгүй байдал болон бусад асуудлын талаар авч хэлэлцэх зорилгоор Авид Нассеймыг тусгай илтгэгчээр томилсон. Энэ томилолт болон олон улсын хамтын нийгэмлэг, ялангуяа ЮНЕСКО

болон НҮБ-ын Хүний эрхийн Комиссын бусад тунхаглал нь сэтгүүлчдийн амь насыг хамгаалах асуудалд өндөр ач холбогдол өгч байгааг харуулж байна.

- 2/ Олон нийтийн мэдээллийн байгууллагын бие бүрэлдэхүүн, тоног төхөөрөмж, орон байрыг найдвартай хамгаалах нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ард түмний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар мэдээлэл хийх үүргээ гүйцэтгэхэд нь чухал ач холбогдолтой. Энэ нь сонгуулийн үед бүр ч чухал байдаг.

Зарчим 4. Засгийн газар хэвлэл мэдээллийг хянах ёсгүй

Засгийн газар нь сонгуулийн хөтөлбөрүүдийг хянах ёсгүй бөгөөд сонгуулийн өмнөх үеэс эхлэн сэтгүүлчид мэргэжлийн үйл ажиллагаагаа бүрэн бие дааж явуулах нөхцөлийг баталгаажуулах ёстой.

Засгийн газрууд сонгуулийн явцад хяналт болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийн сурвалжлага, нийтлэлийг хариуцсан бие даасан комиссыг ажиллуулж болно.

» *Тайлбар:*

- 1/ Засгийн газар олон нийтийн мэдээллийн бүх хэрэгсэл сонгуультай холбогдолтой мэдээ, мэдээллийг чөлөөтэй хэвлэн нийтлэх, нэвтрүүлэх боломжоор хангагдсан тухай болон мэдээллийн байгууллагууд нь засгийн газар болон эрх баригч намын бодлого үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандсан радио телевизийн нэвтрүүлэг, сонины нийтлэл гаргаж болох тухай тодорхой мэдэгдэл гаргах болно.
- 2/ Засгийн газар нь радио телевизээр нэвтрүүлэх буюу хэвлэн нийтлэх сонгуулийн хөтөлбөрийг хянах ёсгүй.

Зарчим 5. Засгийн газар агаарын долгионыг нээлттэй байлгах ёстой

Засгийн газрын мэдээллийн хэрэгсэл нь албан ёсны улс төрийн намууд болон тэдгээрийн нэр дэвшигчдэд үзэл бодлоо чөлөөтэй, ямар нэг тайлбар, нэмэлт өөрчлөлтгүй, сэтгэлзүйн засваргүйгээр тараах, цацах, дамжуулах эрхийг баталгаажуулах ёстой.

Сонгуульд нэр дэвшигчдийн оролцоо доорхи байдлаар баталгаажсан байх болно.

- а/ Нэвтрүүлгийн программд бүх нам, нэр дэвшигчид шууд, аливаа ялгаваралгүй адил нөхцөлөөр хамрагдах,
- б/ бүх нам, нэр дэвшигчид нь зүй бусаар гүтгэгдсэн, эсвэл буруутгагдсан гэж үзвэл шууд бусаар хариулт өгөх, залруулга хийхдээ сэтгүүлзүйн мэргэжлийн туслалцаа авах.

» *Тайлбар:*

1. Шилжилтийн үеийн анхны сонгуульд улсын болон хувийн мэдээллийн хэрэгслүүд шударга зарчим баримтлан бүгд тэгш оролцох нөхцөлийг хангасан байх ёстой. Зарим сонгуулийн үед ийм боломжгүй эсвэл саад бэрхшээлтэй тулгарах нь бий. /1989 онд Намибид улс төрийн 14 нам эфирийн цагийг хувааж авсан байхад Европын нэлээд оронд анхны сонгуулийн үед улс төрийн арав гаруй нам эфирийн цагийн асуудлаар маргаантай байжээ/.

Нэг онцлог асуудал бол санал бодлоо илэрхийлэгч тухайн хүн болон сонгогчийн ашиг сонирхолд нийцсэн үзэл бодол нь богино хугацаанд давамгайлан, бусдын анхаарлыг татаж, өөр бусад үзэл дарагдах явдал гардаг. Ийм учраас бүх намд байр сууриа илэрхийлэхэд нь зориулж адил тэнцүү цаг хугацаа олгох зарчмыг баримтлах нь сонголт хийх хэлбэр агуулгыг сонгогч өөрөө шийдэх, сонгуулийн үйл ажиллагааг итгэл үнэмшилтэй болгоход туслана.

-
2. Шууд мэдээлэл хүргэх аргаа тодорхойлж, баталгаажуулахдаа хоорондоо зөвшилцөх нь зүйтэй.
 3. Сонгуулийн сурталчилгааг худалдан авахдаа хөрөнгө чинээтэй намуудын давуу талыг хязгаарлан адил тэгш байх асуудлыг баталгаажуулан зохицуулах нь зүйтэй.

Зарчим 6. Засгийн газрын мэдээллийн хэрэгсэл нь сонгогчдод шаардлагатай мэдлэг олгох ёстой

Засгийн газар нь улс орны бүх бүс нутагт оршин суудаг, сонгуульд санал өгөх чадвартай хүмүүст сонголтоо хийхэд нь шаардлагатай бүхий л мэдээллийг хүлээн авах нөхцөлийг хангах ёстой.

» *Тайлбар:*

- 1/ Сонгогчдын үндсэн эрхийн дагуу адил тэгш, шударга байх зарчмыг хангах Засгийн газрын үүрэгт сонгогчдоос үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэхийн зэрэгцээ сонгуулийн үйл явцын тухай мэдээлэл хүлээн авах боломж бүрдүүлэх асуудал мөн хамрагдана.
- 2/ Парламентын уламжлалт засаглалтай, олон намын ардчилал тогтсон улс оронд сонгуулийн үйл явцын үед элдэв бэрхшээл хүндрэл гарах явдал тохиолддог ба холбоо харилцаа хязгаарлагдмал, олонхи хүн ам нь боловсрол мэдлэг муутай улс оронд бүр ч ихээр гардаг.
- 3/ Сонгуулийн тусгай мэдээллийн кампанит ажил нь нарийн тодорхой, шударга байх ёстой. Нутгийн хэлээр гардаг радио, телевизийн нэвтрүүлэг, сонин хэвлэл, олон нийтийн пуглаан зэргээр дамжин олон нийтэд хүрдэг бөгөөд сонгогчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг болдог.
- 4/ Сонгуулийн тухай мэдлэг олгох кампанит ажлын хүрээнд эмэгтэйчүүд, шашныхан, үндэсний цөөнх зэрэг улс төрийн үйл явдлаас хоцорч болох хүмүүст онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.
- 5/ Засгийн газар нь санал өгөгчдөд мэдлэг боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагуудаас зохион явуулдагтай адил тусгай судалгаа хийх нь зүйтэй.

Зарчим 7. Засгийн газрын мэдээллийн хэрэгсэл нь мэргэжлийн байх ёстой

Засгийн газрын мэдээллийн хэрэгсэл нь сэтгүүл зүйн өндөр шаардлагын түвшинд үйл ажиллагаагаа явуулж, үйл явдлыг сурвалжлах, мэдээ, мэдээлэл дамжуулахдаа тэнцвэртэй байдлыг хадгалж үнэн бодит, нягт нямбай, шударга зарчим баримтлах ёстой. Засгийн газар нь сонгууль сурвалжлах явцыг ажиглах, хянах тогтолцоог бүрдүүлсэн байх ёстой.

» *Тайлбар:*

- 1/ Мэдээллийн чанартай нийтлэл сурвалжлага сонгуулийн кампанид хамгийн их нөлөөтэй байдаг учраас сонгууль бол сэтгүүлзүйн мэргэжлийн түвшингийн дээд зэргийн шалгуур болдог. Төрийн мэдээллийн байгууллага нь сэтгүүлчдэд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх ёстой.
- 2/ Олон оронд янз бүрийн тодорхой асуудал, сэдвээр нэвтрүүлэг явуулах, мэдээллийн хөтөлбөрт цагийг хуваарилан өгч, ашиглалтыг хянах систем тогтоодог бөгөөд мэдээллийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор өөрчлөлт зохицуулалт хийхэд анхаардаг.

-
- 3/ Сайд нар болон Засгийн газрын ажилтнуудын албан үүргийн тухай болон сонгуульд нэр дэвшигчийнх нь хувьд үйл ажиллагааг нь сурвалжлахад ялгавартай хандахыг сэтгүүлчдэд зөвшөөрөх нь чухал юм.
 - 4 / Сэтгүүлчид бусдын дарамт шахалт, хээль хахуульд /нэр дэвшигчдийн болон намуудын унаа, тээвэр, харилцаа холбооны хэрэгслийг нь ашиглах гэх мэтээр/ орооцолдох ёсгүй.
 - 5/ Засгийн газар нь сонгуулийн холбогдолтой мэдээ, мэдээлэл цуглардаг, сэтгүүлчид нэвтэрч болохуйц танхим, сонгуулийн холбоо харилцааны төв байгуулах нь зүйтэй.

Орчуулсан С.Баяраа

§ Их Британий "БИ-Би-Си" Радио, Телевизийн корпорацийн мэдээллийн программын зарчмуудаас

Бүх нийтийн сонгуулийн үеэр “Би-Би-Си” нэвтрүүлэгтэй тэнцвэртэй байдлыг хадгалахыг зорино.

- “Би-Би-Си” сонгуулийн кампанийн бүхий л хугацаанд тэнцвэртэй байдлыг хадгалах үүргээ хүлээн зөвшөөрнө.
- Дээрх зарчим нь нэвтрүүлгийн бүх хэлбэрт хамаарна.
- Гол гол намуудын сонгуулийн сурталчилгааны тэнцвэртэй байдлыг тэдгээрийн Парламентад эзэлж буй суудлын харьцаагаар тодорхойлно. /1987 оны сонгуулийн байдлаар Консерватив намд-5, Хөдөлмөрийн намд-5, Эвсэлд-5 нэвтрүүлэг оногдож байжээ./

Олон нийтийн санал асуулга

- Сонгуулийн кампанийг сурвалжлахад олон нийтийн санал асуулга /ОНСА/ чухал хүчин зүйл болдог. “Би-Би-Си” ОНСА-гийн дүнг ашиглахдаа аль нэг намд давуу байдал олгохгүйг зорино.
- ОНСА-гийн дүнг мэдээлэхдээ зохих тайлбар өгөх шаардлагатай.
- ОНСА-гийн дүнд гагцхүү тухайн үед сонгогчид ямар санаа бодолтой буйг тусгасан байдгийг санавал зохино.

Улс төрчдийг нэвтрүүлэгт оролцуулах нь

- Тухайн нэвтрүүлэгт бүх намын төлөөлөгчдийг заавал урьж оролцуулах ёстой гэсэн хөдлөшгүй зарчим байх ёсгүй.
- Нэвтрүүлгийг бэлтгэгчид нь эн тэргүүнд шударга ёсны зарчмыг баримтална.
- Нэвтрүүлгийн бүтэц, хэлбэр, зорилгоос хамааран оролцуулах хүмүүсээ сонгоно. Гэхдээ редакторуудаас сонгуулийн кампанийн явцад намуудын тэнцвэрийг хадгалахыг шаардана.
- Парламентын гишүүдийн сонгуулийн сурталчилгааг явуулахдаа түрүүчийн сонгуулиар бий болсон хүчний харьцааг баримтална. Парламентын гишүүн нэвтрүүлэгт оролцохоос татгалзсан эсвэл хүндэтгэх шалтгаанаар оролцож чадаагүй бол тухай бүрд нь нийтэд мэдээлнэ.
- Аль нэг нам нэвтрүүлэгт оролцохоос татгалзсан буюу оролцож чадаагүй бол энэ нь нөгөө намыг нэвтрүүлэгт оролцуулахгүй байх шалтгаан болох ёсгүй. Гэхдээ дээрх шаардлагыг биелүүлээгүй байх тодорхой нөхцөл байдал бий болохыг үгүйсгэхгүй.
- Улс орныг хамарсан асуудлаар мэдээллийн нэвтрүүлэгт оролцсон Парламентын гишүүдэд идэвхтний шагнал олгохгүй.

Орчуулсан С.Баяраа

§ Хэвлэл мэдээллийн байгууллагуудын баримтлах зарчим

Энэхүү зарчмыг нь Австралийн радио, телевизийн /корпорацид ажилладаг сэтгүүлчид баримталдаг бөгөөд Их Британий радио, телевизийн Би-Би-Си болон бусад олон орны баримталдаг зарчимтай адил төсөөтэй болно. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлэгт олон ургальч үзэл чухал болохыг эндээс харж болно.

БАРИМТЛАХ ЗАРЧИМ

1. Мэдээний болон цаг үеийн үйл явдлын программууд нь сонгуулийн мэдээллийг олон нийтэд хүргэнэ.
2. Намыг төлөөлөн хөтлөгч сонгуулийн кампанийн асуудлаар тайлбар, тойм бэлтгэх нь зохимжтой.
3. Улс төрийн намын удирдагчдыг сурвалжлахдаа үндсэн асуудлыг хохироох ёсгүй.
4. Мэдээллийн нэвтрүүлгээр явсан зарим зүйл сонгуулийн кампаний өмнөх үеийнхээс өөрчлөгдөж болно. Гэхдээ үүнийг сонгуулийн кампаний тухай мэдээллийн хөтөлбөрийн хүрээнд оруулахаар өөрсдийн сонгож авсан жагсаалтаас хасна гэсэн үг биш юм.
5. Ерөнхий журмын дагуу том намуудад адил хэмжээний цаг олгодог нь тэнвэрт байдлыг хэрхэн хадгалж байгааг хянах бас нэг арга юм. Гэхдээ мэдээллийн үнэ цэнээс шалтгаалан зарим тохиолдолд цаг хугацааны адил тэнцүү байдал алдагдаж болохыг мэдэж байх нь зүйтэй. Жижиг намуудыг сурвалжлахдаа тэдний сонгуульд гүйцэтгэх үүрэг ролийг алдагдуулах ёсгүй. Тухайн намын бодлого нь сонгуулийн кампаниас өмнөх тавьж байсан зарим асуудалтай жишиж үзэхэд нийцэхгүй байж болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Нам бүрт олгосон цагийн нийт хэмжээг тогтоож, мөрдөхийн зэрэгцээ энэ тухай 7 хоног бүр корпорацийн гүйцэтгэх захирлуудад мэдэгдэнэ.
6. Редакцийн харти нь 1984 оны 7-р сарын 7-нд удирдлагын зөвлөлөөр дараах байдлаар батлагдсан.

Редакцийн харти

1. Австралийн радио телевизийн корпораци программ төлөвлөлтдөө редакцийн байр суурийг удирдлага болгохгүй.
2. Редакцийн бүрэлдэхүүн өөрсдийн үүргийг биелүүлэхэд саад болохуйц аливаа зөрчлөөс зайлсхийнэ.
3. Мэдээ, мэдээллийн программын агуулгыг өөрийнх нь тодорхой онцлогуудад тохирсон байлгах талаар бүхий л хүчин чармайлт тавих ёстой.
Тодорхой алдааг нөхцөл байдалд хамгийн тохиромжтой хэлбэрээр аль болохоор хурдан засаж залруулах ёстой.
4. Чухал асуудлыг аль болохоор зарчмын үзэл бодлыг нээн харуулах үүднээс тэнцвэрт байдлыг хангах.
Энэхүү шаардлагыг тухайн нэг нэвтрүүлэг, эсвэл мэдээллийн хөтөлбөрийн хүрээнд биелүүлэх боломж үргэлж гарахгүй байж болзошгүй. Гэлээ ч гэсэн шаардлагатай хугацаанд биелүүлэхийг хичээнэ.
5. Шударга зарчим нь редакцийн бүрэлдэхүүнтэй зөвшилцөхгүйгээр шийдвэр гаргах, эсвэл тухайн асуудлын бүх талыг харуулахад зориулан корпорациас нийтэд нь олгохыг шаардана гэсэн үг биш. Шийдвэр гаргах болон шаардлагын түвшинд

-
- хүрсэн эсэхээс нь хамааран мэдээллийн үнэ цэнэ, ач холбогдлыг давуу байдлаар оруулж болно.
6. Редакц нь олон түмний эрх ашигт үйлчлэхдээ нийгэм, хувь хүнд түгээсэн мэдээ тэдэнд нөлөөлдөг гэдгийг мэдэрч, зорилгодоо хүрэхийн тулд зоригтой ажиллана.
 7. Редакц нь нэвтрүүлэгт оролцох хүмүүсийнхээ хувийн нууцаа хадгалах хуулийн эрхийг нь хүндэтгэнэ.
 8. Редакцийн удирдлага бүрэлдэхүүндээ шийдвэр, чиглэл өгөх эрхтэй.
 9. Редакцийн бүрэлдэхүүн нь мэдээллийн үйл ажиллагаандаа Австралийн хамтын нийгэмлэгийн олон талт, үл ялгаварлах зарчмыг хангана.

Орчуулсан С.Баяраа

V.ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ

§ Агаарын долгионыг хүртээмжтэй болгох: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон өргөн нэвтрүүлгийг зохицуулах зарчмууд

Зохиогчийн эрхийг Лондон хот дахь “19 дүгээр зүйл байгууллага” эзэмшинэ.

ISBU 1 90259846 6

2002 оны 3 сар

ТАЛАРХАЛ

Эдгээр зарчмуудыг “19 дүгээр зүйл” байгууллагын хуулийн хөтөлбөрийн захирал Тоби Мендель боловсруулав. Эдгээр нь “19 дүгээр зүйл” байгууллагаас удаан хугацаанд явуулсан судалгаа, дүн шинжилгээ, зөвлөгөө болон түүний дэлхийн олон оронд байдаг түнш байгууллагуудтай хамтран ажилласан өргөн туршлагын үр дүн юм.

“19 дүгээр зүйл” байгууллага нь эдгээр зарчмуудыг боловсруулах, хэвлүүлэхэд санхүүгийн туслалцаа үзүүлсэн Их Британы Гадаадын болон Хамтын Нөхөрлөлийн асуудал эрхэлсэн Албанд талархсанаа илэрхийлэхийг хүсч байна. Энэ баримт бичгийн үзэл санаа нь Гадаадын болон Хамтын Нөхөрлөлийн асуудал эрхэлсэн Албаны үзэл баримтлалыг шууд тусгаагүй болно.

АГУУЛГА

ОМНОХ ҮГ

I ХЭСЭГ. Ерөнхий Зарчмууд

II ХЭСЭГ. Өргөн нэвтрүүлгийн орчин

III ХЭСЭГ. Долгион

IV ХЭСЭГ. Зохицуулах ба Гомдол Хүлээн Авч Шийдвэрлэх Байгууллага

V ХЭСЭГ. Тусгай эрх (лиценз) олгох

VI ХЭСЭГ. Агуулгатай холбогдолтой асуудлууд

VII ХЭСЭГ. Хариуцлага

VIII ХЭСЭГ. Төрийн мэдээллийн эх сурвалжийг хүртээмжтэй болгох

IX ХЭСЭГ. Сонгуулийг нэвтрүүлэн үзүүлэх нь

X ХЭСЭГ. Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллага

ӨМНӨХ ҮГ

Өргөн нэвтрүүлэг нь дэлхийн ихэнх улс оронд хүмүүсийн хамгаас чухал мэдээллийн төдийгүй зугаацан цэнгэх эх сурвалж нь болж байдаг. Бичиг үсэг үл мэдэх байдал их байгаагийн хажуугаар сонин түгээх явдал хүндрэлтэй зэргээс дүгнэвэл өргөн нэвтрүүлэг нь олон хүмүүс хүртэж чадах ганц мэдээллийн эх сурвалж мөн. Ядуу дорой хүмүүст сонин нь хэт өндөр үнэтэйгээс гадна зарим хүмүүс мэдээг үзэж харж, сонсож суух нь түүнийг

уншсанаас илүү хялбар бөгөөд тааламжтай гэж үздэг байна. Өргөн нэвтрүүлэг нь зугаацан цэнгэх хямд төсөр, хүргээмжтэй хэлбэр болж чаддаг нь түүний бас нэг чухал үүрэгт оршино.

Мэдээлэл болон мэдээний нэгдсэн эх сурвалж болж, түүнээс олох ашиг орлого нь өссөөр байгаагаас улбаалан өргөн нэвтрүүлгийг хянах эрмэлзлэл засгийн газар болон арилжааны хүчирхэг бүлэглэлүүдээс гардаг болохыг түүх гэрчилдэг. Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага нь олон нийтэд үйлчлэхээсээ илүү ихэндээ засгийн газрын дуу хоолой болж үйл ажиллагаа явуулж байдаг. Саяхныг хүртэл ихэнх улс оронд өргөн нэвтрүүлэг төрийн монопольд байсан бөгөөд ийм байдал зарим улс оронд хадгалагдсан хэвээр байна. Бусад улс оронд хувийн өргөн нэвтрүүлгийн гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд түүнийг олон янзын арга замаар хяналтандаа оруулах оролдлого хийгдсээр байна. Засгийн газар зөвшөөрөл олгох шат дамжлагаараа түүнийг хянахыг оролдохын зэрэгцээ, өргөн нэвтрүүлгийн салбарт ноёрхохыг тэмүүлэгч арилжааны ашиг сонирхол нь чанар муутай боловч өндөр ашигтай хөтөлбөр рүү чиглэж байна.

Дээрх зарчмууд нь хараат бус өргөн нэвтрүүлгийг хөхиүлэн дэмжиж, нүдлэн хамгаалах хэм хэмжээний цогцыг агуулахын зэрэгцээ тэр нь олон нийтэд үйлчилдэг байх явдлыг баталгаажуулахад чиглэдэг.

Эдгээр нь хараат бус өргөн нэвтрүүлгийг олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн зохицуулах мөртлөө уг зохицуулалт нь төрийн хяналтыг тогтоох хэрэглүүр болохоос урьдчилан сэргийлэх гэсэн нарийн төвөгтэй асуудлыг зохицуулдаг байна. Мөн нөгөөтэйгүүр өсөн нэмэгдэж буй арилжааны ашиг сонирхлын хэт ноёрголоос өргөн нэвтрүүлгийг хамгаалах, түүнийг олон нийтэд бүхэлд нь үйлчлэх баталгааг хангах гэсэн зохицуулагчдад шаардлагатай байгаа асуудлыг хөнддөг.

Энэ зарчмууд нь “19 дүгээр зүйл” байгууллагаас боловсруулсан Олон Улсын Хэм Хэмжээний Цувралын хэсэг ба үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний утга санааг олон төрлийн сэдвийн хүрээнд илүү тодорхой болгож боловсруулах гэсэн оролдлого чармайлтын үргэлжлэл мөн. Эдгээр нь кампанит хөдөлгөөн зохион байгуулагчид, үйл ажиллагаа явуулагчид, өргөн нэвтрүүлэг эрхлэгчид, хуульчид, шүүгчид, сонгууль бие төлөөлөгчид болон төрийн албан хаагчдын мэдрэмжтэй, хараат бус өргөн нэвтрүүлгийн салбарыг бүх бүс нутаг, нийгмийн бүлгүүдэд үйлчлэх үйлс болгохын төлөө хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан.

ТАНИЛЦУУЛГА

Эдгээр зарчмууд нь өргөн нэвтрүүлгийн эрх чөлөөний хэм хэмжээг тогтоосон байдаг. Энэ нь өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын тусгай журам руу хандаж байгаа ч ерөнхийдөө үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хуулийн ерөнхий хүрээ, төр болон мөн энэ салбар дахь хувийн үйл ажиллагаанд илүү чиглэж байна. Эдгээр нь засгийн газар болон арилжааны ашиг сонирхлын хөндлөнгийн оролцооноос гадуур хараат бус өргөн нэвтрүүлгийн шаардлага болон өргөн нэвтрүүлгийг мэдрэмжтэй, олон талт байлгах үүднээс зарим нэг байдлаар тодорхой алхмууд хийх шаардлагын аль алийг хүлээн зөвшөөрч байна.

Эдгээр зарчмууд нь олон улсын болон бүс нутгийн хууль тогтоомж, стандартууд, улс орнуудын хуулийн практик, /үндэсний хууль тогтоомж, шүүхийн шийдвэрт тусгалаа олсон байдаг/ мөн олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн ерөнхий зарчмууд дээр суурилсан болно. Уг зарчмууд нь “19 дүгээр зүйл” байгууллагын

удаан хугацаанд явуулсан судалгаа, дүн шинжилгээ, зөвөлгөө болон дэлхийн олон оронд байдаг түнш байгууллагуудтай хамтран ажилласан өргөн туршлагын үр дүн юм.

I ХЭСЭГ. ЕРӨНХИЙ ЗАРЧМУУД

Зарчим 1: Мэдээллийн чөлөөт байдал ба үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх

1. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд үүнд нь төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаар үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр, эсхүл уран сайхны, өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон өөрийн сонгосон бусад хэвлэл мэдээллээр чөлөөтэй эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.
2. Энэ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд өргөн нэвтрүүлэг эрхлэгч нь төр, улс төр, арилжааны ашиг сонирхлын нөлөөлөөс гадуур байх болон өргөн нэвтрүүлгээр төрөл бүрийн мэдээлэл, үзэл санааг дээд зэргээр хүлээн авах олон нийтийн эрхийн аль алийг багтаана.
3. Засгийн газар, зохицуулах байгууллагын аль аль нь өргөн нэвтрүүлгийн агуулгад хэзээ ч урьдчилсан хяналт тавих ёсгүй. Агуулгатай холбоотой зохицуулалтын дүрмыг зөрчсөний төлөө хүлээх аливаа хариуцлагыг зөвхөн эргэлзээтэй материал нэвтрүүлэгдсэний дараа тооцох ёстой.

Зарчим 2. Редакцийн хараат бус байдал

1. Өргөн нэвтрүүлэг эрхлэгчдийн программын талаарх шийдвэрийг мэргэжлийн шалгуур, олон нийтийн мэдэх эрхэд тулгуурлан гаргагч редакцын бие даасан байдал нь хуулиар баталгаажсан бөгөөд амьдралд бодитойгоор хэрэгждэг байх ёстой. 6 (Агуулгатай холбогдой асуудлууд) болон 9 (Сонгуулийг нэвтрүүлэн үзүүлэх нь)-р хэсэгт зааснаас бусад тохиолдолд юуг нэвтрүүлэх нь зөвхөн өргөн нэвтрүүлэг эрхлэгчдийн өөрийн шийдэх асуудал ба энэ нь засгийн газар, зохицуулах байгууллага, арилжааны байгууллагын шийдвэрлэх асуудал биш юм.
2. Энэ зарчим нь редакцийн ерөнхий болон тусгай бодлогын аль алиныг хамгаална (жишээ нь, өргөн нэвтрүүлэг эрхлэгчдийг дайныг хэрхэн тайлбарлах болон тодорхой эдийн засгийн бүтэц загварыг дэмжих зэргээр шаардах нь хууль бус юм).
3. Зарчим 31-д (Улс төрийн шууд нэвтрүүлэг) заасанчлан засгийн газар нь өргөн нэвтрүүлэг эрхлэгчдээс тусгай нэвтрүүлэг явуулах, нэвтрүүлэх цаг хувиарлахыг шаардах ёсгүй.

Зарчим 3. Олон талт байхыг хөхиүлэн дэмжих

1. Өргөн нэвтрүүлгийн байгууллага олон талт байх гэдэг нь тэдний өмчлөлийн байдал, нэвтрүүлгийн программын хүрээн дэх дуу хоолой, аливааг үзэх үзэл бодол, хэл зэргийн хувьд олон талтай байх гэсэн утга санааг агуулсан байдаг. Ялангуяа, олон төрлийн гэдэг нь нийгмийг бүхэлд нь төлөөлж, тусгаж байгаа төрөл бүрийн хараат бус өргөн нэвтрүүлэг эрхлэгчид болон хөтөлбөрүүд өргөн хүрээнд оршин тогтнож байхыг хэлдэг.
2. Төр нь өргөн нэвтрүүлгийн өсөлт, хөгжлийг дэмжих зохистой арга хэмжээнүүдийг авах үүрэгтэй бөгөөд энэ нь олон төрлийг дээд зэргээр баталгаажуулж чадсан байх ёстой. Мөн төр нь энэ салбарын ерөнхий өсөлт, хөгжилд саад болохуйц тавьсан онцын шаардлагагүй хязгаарлалтуудаас татгалзах үүрэгтэй.

-
3. Өргөн нэвтрүүлгийн салбарт болон өргөн нэвтрүүлэг ба бусад хэвлэл мэдээллийн салбар хоорондын зэрэг өмчлөлийн олон төрлийг дэмжих, шаардлагагүй төвлөрөл үүсэхээс урьдчилан явдлаас сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ тухай бүр авч байх ёстой. Ийм арга хэмжээ авахдаа өргөн нэвтрүүлгийн салбарыг бүхэлд нь хөгжүүлэх хэрэгцээ шаардлага болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнүүд нь эдийн засгийн хувьд үр ашигтай байх зэргийг тооцож үзэх ёстой.

Зарчим 4. Онц байдлын арга хэмжээнүүд

Онц байдлын үед өргөн нэвтрүүлэг эрхлэгчид, өөрөөр хэлбэл түүний тоног төхөөрөмж эсвэл нэвтрүүлэгт аль алинд төрөөс хяналт тавих явдлыг өргөн нэвтрүүлгийн хуулийн хүрээнд зөвшөөрөх ёсгүй. Хэрэв ийм арга хэмжээг авах шаардлагатай, лавтай онц байдал тохиолдсон үед олон улсын эрх зүйн хүрээнд зайлшгүй нөхцөл байдалд нарийн тохируулан тухай үед нь тусгай хууль гаргаж болно.

Зарчим 5. Бусдын мэдэгдлийн төлөө хүлээх хариуцлага

Өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь бусдын мэдэгдлийн төлөө хүлээх хариуцлагаас дараахь нөхцөл байдалд мултрах ёстой:

- Шууд нэвтрүүлгийн үед өөрөөр хэлбэл өргөн нэвтрүүлэг эрхлэгчээс мэдэгдлийг дамжуулахаас сэргийлэхийг шаардах бодит үндэслэл байхгүй бол;
- Уг мэдэгдлийг дамжуулах нь олон нийтийн ашиг сонирхолд нийцэж байвал жишээ нь, нийгэмд тодорхой үзэл бодол байгааг харуулах зорилгоор нэвтрүүлсэн бөгөөд өргөн нэвтрүүлэг эрхлэгч нь уг мэдэгдлийг батламжлаагүй бол;
- Улс төрийн шууд нэвтрүүлгийн агуулгын хувьд (Зарчим 31-ийг хар)

II ХЭСЭГ. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ОРЧИН

Зарчим 6. Бүх нийтээр хүртэх

1. Төр нь тухайн үйлчилгээг олон нийтийн болон хувийн салбараас явуулж байгаа эсэхээс үл хамааран телефон утас, интернет, цахилгаан зэрэг холбоо харилцааны хэрэгсэлээр өргөн нэвтрүүлгийг хүргэх болон түүнийг бүх нийтээрээ хямд төсрөөр хүлээн авч хүртэх боломжыг дэмжих ёстой. Үүнтэй холбоотой нэг санаа бол олон нийтэд хүртээмжтэй номын сан болон бусад газруудад мэдээлэл дэмжуулах төвүүдийг байгуулах явдал юм.
2. Төр нь дамжуулалтын сүлжээг хөгжүүлэх зэрэг арга замаар өргөн нэвтрүүлгийг нутаг дэвсгэрийн өнцөг булан бүрт дээд хэмжээнд хүргэх арга хэмжээг авах ёстой. Нийтийн өмчийн дамжуулалтын сүлжээг бүх өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд бололцооны үнэ ханшаар, аливаа ялгаваргүйгээр хүртээх ёстой. Энэ нь боломжоор хязгаарлах гэсэн бүлэг асуудалд хамааралтай байдаг.

Зарчим 7. Дэд бүтэц

1. Төр нь өргөн нэвтрүүлгийн хэрэгцээг хангахуйц байнгын цахилгаан эрчим хүч, харилцаа холбооны шаардлагатай дэд бүтцийг өргөжүүлэх ёстой.
2. Өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд интернет, хиймэл дагуул, тоон дамжуулалт зэрэг өргөн нэвтрүүлэгт нэвтэрсэн орчин үеийн техник, технологийг ашиглах бололцоог хангах зорилгоор тодорхой чармайлт гаргах ёстой.

Зарчим 8. Эдийн засгийн орчин

Төр нь өргөн нэвтрүүлэг хөгжих эдийн засгийн орчинг дэмжих ёстой. Тусгай арга хэмжээ авах шаардлагатай эсэх нь байдлаас хамаарах боловч аливаа арга хэмжээг шударга, ил тод, аливаа ялгаваргүй авах ёстой. Эдгээр арга хэмжээнд:

- өргөн нэвтрүүлэг эрхлэгчид хүлээн авах тоног төхөөрөмж (радио, телевизийн зэрэг) худалдан авах тохиолдолд хөнгөлттэй татвар, худалдааны тарифын журам тогтоох,
- өргөн нэвтрүүлэг эрхлэгчдээс авах шууд татаасыг багасгах, жишээ нь, үнэ багатай зөвшөөрлийн журам болон үндэсний дамжуулалтын сүлжээг хөнгөлттэй хүртээх
- бололцоотой сургалт явуулах

III ХЭСЭГ. ДАВТАМЖ

Зарчим 9. Давтамж төлөвлөлт

1. Олон улсын болон үндэсний хэмжээний бүх шатанд долгионы давтамжийн зурвасыг хувиарлах шийдвэр гаргах процессд өргөн нэвтрүүлгийн зохицуулах байгууллагыг оролцуулан бүх долгионы давтамж хэрэглэгчдийн оролцоог нээлттэй байлгах замаар өргөн нэвтрүүлгийн хэрэглээнд давтамжийн зурвасыг шударга хувиарлах ёстой.
2. Процесс нь өргөн нэвтрүүлгийн олон төрлийг хангасан тэдний хамгийн тохиромжтой хэрэглээг дэмжихийн тулд өргөн нэвтрүүлэгт хувиарлагдсан долгионы давтамжийн ашиглалтын төлөвлөгөөг гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой. Уг үйл ажиллагаа нь улс төрийн болон арилжааны ашиг сонирхол бүхий бүлэглэлийн хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах байгууллагын хяналтан дор нээлттэй, оролцоог хангасан байдлаар хийгдэх ёстой. Батлагдсан долгионы давтамжийн ашиглалтын төлөвлөгөөг хэвлэж өргөн хүрээнд тараах ёстой.
3. Долгионы давтамжийн төлөвлөгөө нь өргөн нэвтрүүлгийн олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, шударга зарчмын үндсэн дээр 3 шатны (олон нийтийн, арилжааны, нийтийн) мөн 2 хэлбэрийн (радио, телевиз) болон газар зүйн янз бүрийн хүрээнд (үндэсний, бүс нутгийн, орон нутгийн) тэнцүү хувиарлах ёстой.
4. Долгионы давтамжийн төлөвлөгөө нь нэмэлт долгионы давтамжийг тэнцвэртэй хүртэх, олон төрлийг баталгаажуулах зорилгоор цаашид тодорхой долгионы давтамжийг тусгай бүлэглэлд орох өргөн нэвтрүүлэг эзэмшигчдэд зориулж хадгалж үлдээж болно.

IV ХЭСЭГ. ЗОХИЦУУЛАХ БА ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ БАЙГУУЛЛАГА

Зарчим 10. Хараат бус байдал

Олон нийтээс гомдол хүлээн авахыг оруулан өргөн нэвтрүүлэг болон харилцаа холбооны салбарт зохицуулах эрх үүрэг бүхий нийтэд үйлчилдэг байгууллага нь хөндлөнгийн ялангуяа улс төр, арилжааны шинжтэй нөлөөлөөс хамгаалагдсан байх ёстой. Эдгээр байгууллагын эрх зүйн байдал хууль тогтоомжид тодорхой тусгагдсан байх ёстой. Тэдгээр байгууллагын бие даасан ба хараат бус байх нөхцлийг хууль тогтоомжид дараах байдлаар хамгаалж, баталгаажуулсан байх ёстой.

- Уг байгууллагыг үүсгэн байгуулах заалтыг хуульд тусгайлан, нарийвчлан тодорхойлох болж өгвөл мөн үндсэн хуульдаа тусгах
- Зохицуулалтын байгууллагын эрх үүрэг, хариуцлага болон өргөн нэвтрүүлгийн ерөнхий бодлогыг эрх зүйн баримт бичигт тодорхой заах

-
- Холбогдох дүрмээр гишүүн элсүүлэх
 - Олон намын байгууллагаар дамжуулан олон нийтэд хариуцлага хүлээдэг байх
 - Санхүүжилтийг зохицуулах замаар

Зарчим 11. Хараат бус байдлын баталгааг нарийвчлан тусгах

Зохицуулалтын байгууллага болон тэдгээрийн үйл ажиллагаа, гишүүдийн хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглож, хуульд тусгайлан нарийвчлан зааж өгөх, болж өгвөл мөн үндсэн хуульдаа тусгах. Энэ зорилгод тусгай хэллэгийн хэлбэр байхгүй бол дараах зүйл нь хараат бус байдлыг баталгаажуулах нэг арга зам байж болно.

Аливаа хүн болон хуулийн этгээдээс түүн дотроо Засгийн газар болон түүний агентлагуудаас тус (байгууллагын нэр нь) үйл ажиллагаа болон захиргааны хувьд бие даасан байдлыг эдлэх ёстой. Энэхүү бие даасан байдал нь байнга хүлээн зөвшөөрөгдөж байх ёстой бөгөөд хуульд тусгайлан заагаагүй бол аливаа хуулийн этгээд түүний гишүүд, ажилтан нарт нөлөөлөх, тэднийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх зэргээр үйл ажиллагаанд хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хөндлөнгөөс оролцох ёсгүй.

Зарчим 12. Өргөн нэвтрүүлгийн бодлого

Зохицуулалтын байгууллагын тухай хууль тогтоомжид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, олон талт, нягт нямбай, тэнцвэртэй, мэдээлэл болон үзэл санааны чөлөөт урсгалыг хүндэлж дэмжсэн байдлаар өргөн нэвтрүүлгийн зохицуулалтыг сайжруулах бодлогыг тодорхой тусгасан байх ёстой. Зохицуулалтын байгууллага нь бүх үйл ажиллагаандаа энэ бодлогыг баримтлан олон нийтийн ашиг сонирхлыг үргэлж тооцож үзсэн байх шаардлагатай.

Зарчим 13. Гишүүнчлэл

1. Өргөн нэвтрүүлэг болон харилцаа холбооны салбарт эрх үүргээ хэрэгжүүлж буй олон нийтийн байгууллагын Удирдах байгууллагын (Удирдах зөвлөл) гишүүдийг томилох журам нь улс төр, арилжааны ашиг сонирхол хөндлөнгөөс нөлөөлөх эрсдэлийг багасгасан чиглэлд хийгдсэн байх ёстой. Гишүүдийг томилох энэ процесс нь хуульд тодорхой заагдсан байх ёстой. Гишүүд нь өөрийн бие хувь хүний хувьд ажил үүргээ эрхлэх бөгөөд түүнийгээ хэрэгжүүлэхдээ байнга олон нийтийн ашиг сонирхолд үйлчлэхийн төлөө хэрэгжүүлэх ёстой.
2. Гишүүдийг томилох процесс нь олон нийтийн оролцоо, санал бодлыг авдаг, нээлттэй, ардчилсан, аливаа улс төр, арилжааны ашиг сонирхолын дарамт шахалтаас ангид байх ёстой. Зөвхөн холбогдох мэдлэг, дадлага туршлагатай хувь хүмүүс томилогдох ёстой. Гишүүнчлэлийг бүхэлд нь нийгмийг төлөөлж чадахуйц байдлаар сонгох ёстой.
3. Огцруулах, халах болон шаардлагад нийцэхгүй байх журам дараах байдалтай байна. Доорхи хүмүүс томилогдож болохгүй:
 - Төрийн алба эсвэл Засгийн газрын бусад аль нэг салбарт ажилладаг бол,
 - Улс төрийн намд тодорхой алба хашдаг, түүнд гэрээгээр ажилладаг эсвэл засгийн газарт сонгуульт эсвэл томилгооны ажил эрхэлдэг бол,
 - Харилцаа холбоо өргөн нэвтрүүлгийн салбараас төлбөр авдаг буюу авсан, мөн түүнтэй нилээд хэмжээний санхүүгийн ашиг сонирхолтой ажлыг шууд болон шууд бус замаар эрхэлдэг бол,
 - Залилан болоод хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэний төлөө олон улсын эрх зүйн хэм

хэмжээнд зөвшөөрөгдсөн процессын дүнд ял эдэлсэн бөгөөд ялын хугацаа дууссанаас хойш 5 жил өнгөрөөгүй бол

4. Гишүүд нь тодорхой тогтмол хугацаатай томилогдох ба хугацаанаасаа өмнө халагдахаас хамгаалагдсан байх ёстой. Зөвхөн томилсон байгууллага гишүүнийг халах эрхтэй ба энэхүү шийдвэр нь шүүхээр хянагдах бололцоотой байх ёстой. Гишүүдийг дор дурьдсанаас бусад тохиолдолд халж болохгүй.
 - Дээр заасан “шаардлагад нийцэхгүй” журмын шаардлагыг хангахаа больсон
 - Хуульд заасан үүрэг хариуцлагаа ноцтойгоор зөрчсөн, түүн дотроо үүрэг хариуцлагаа бүрэн дүүрэн гүйцэтгээгүй
 - Оөрийн ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэх чадваргүй нь илт болсон
5. Гишүүнчлэлийн нөхцөл байдал, гишүүдийн хариуцлагыг хуульд тодорхой зааж өгөх ёстой. Хуульд зааснаас өөр нөхцөл, үүрэг хариуцлага үйлчлэх ёсгүй. Ялангуяа, гишүүдэд ямар нэгэн нөхцөл, шалгуур, үүрэг хариуцлагыг ямар ч сайд, засгийн газрын төлөөлөгчд тавих эрхгүй байх ёстой. Оөрийг нь томилсон байгууллагаас бусад ямарч байгууллагаас гишүүн болон байгууллага нь зааварчилгаа авах ёсгүй.
6. Гишүүдийн төлбөр, урамшуулалтай холбоотой журмыг ямар нэг байдлаар хувь хүн өөрөө дур мэдэн тогтоох боломжгүй байдлаар хуульд тодорхой тусгаж өгсөн байх хэрэгтэй. Гишүүд нь хуульд зааснаас бусад өөрсдийн ажил үүрэгтэй холбоотой ямар нэгэн төлбөр, мөнгө авах ёсгүй.
7. Хурал, ээлжит бус хурлын дотоод журмыг батлах зэрэг эрх нь хуульд эсвэл зохицуулах байгууллагын эрх мэдэлд байхаар заагдах ёстой.

Зарчим 14. Эрх мэдлийн хүрээ

1. Зохицуулах байгууллагын эрх, үүргийг тусгай эрх (лиценз) олгох буюу гомдол хүлээн авах зэргээр хуульд тодорхой зааж өгсөн байх ёстой ба эдгээр эрх, үүргийг холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар л зөвхөн өөрчилж болно. Зохицуулах байгууллага нь өргөн нэвтрүүлгийн салбарыг чиг үүргээ шударгаар гүйцэтгэх, олон ургальч, уян хатан хэлбэртэй байх, дүрэм, түүгээр тогтоох хэм хэмжээг эрх мэдлийнхээ хүрээнд гаргадаг байх зэргийг хангахуйц байдлаар дээрх эрх үүргийн нарийн төвөгтэй бөгөөд урьдчилан харах бололцоогүй байдлыг харгалзан байдлаар дээрх эрх, үүрэг хэрэгжих ёстой.
2. Одоо байгаа болон цаашид шинээр гарч ирэх өргөн нэвтрүүлэг эрхлэгч бүрт хамааралтай байдаг зохицуулах байгууллага эрх үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой процессыг нарийн ойлгомжтой, ил тод, шударга байхаар хангаж өгөх хэрэгтэй. Бүх шийдвэрүүд захиргааны шүүхээр хянагдаж болох ёстой бөгөөд аливаа шийдвэрийг гаргах болсон учир шалтгааныг бичгээр тайлбарлан гарсан байх ёстой.

Зарчим 15. Хариуцлага тооцох

1. Зохицуулах байгууллага нь яамны сайд болон намын харьяалалтай хувь хүн болон байгууллагаас илүүтэй олон намын байгууллага болох хууль тогтоогч болон хороогоор дамжуулан олон нийтэд албан ёсоор хариуцлага хүлээх ёстой. Зохицуулах байгууллага нь үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлангаа аудитын дүгнэлтийн хамт гаргаж байх ёстой. Уг жилийн тайлангаа хэвлэж, өргөнөөр тараах ёстой.

2. Зохицуулах байгууллага бүх хяналт шалгалтаа аль хэдийнээ явуулчихсан үйл ажиллагаанд холбогдуулж хийх ба хувь шийдвэрт нөлөөлөх зорилготой оролдлогыг хэзээ ч агуулж болохгүй.

Зарчим 16. Шүүхээр хянагдах

Хувь хүн бүрт хамааралтай байдаг зохицуулах байгууллагын бүх шийдвэр шүүхээр хянагдах бололцоотой байх ёстой.

Зарчим 17. Санхүүжилт

1. Зохицуулах байгууллага нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх зохих санхүүжилттэй байх ба сайн дурын хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалагдсан байх ёстой. Санхүүжилтийн бүтэц, санхүүжүүлтийн тухай шийдвэрүүд хуульд тодорхой тусгагдсан байх ёстой бөгөөд түүнийг ганц нэг тохиолдолд тохируулах биш харин тодорхой хийгдсэн төлөвлөгөөний дагуу гаргах ёстой. Санхүүжилтийн тухай шийдвэр нь ил тодоор, зөвхөн холбогдолтой байгууллагатай зөвшилдсөний үндсэн дээр гарах ёстой.
2. Зохицуулах байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд санхүүжилтын процесс хэзээ ч нөлөөлөх ёсгүй.

V ХЭСЭГ. ТУСГАЙ ЭРХ (ЛИЦЕНЗ) ОЛГОХ

Зарчим 18. Тусгай эрх (лиценз) олгох шаардлага

Өргөн нэвтрүүлэг эрхлэгчид үйл ажиллагаа явуулах тусгай эрх (лиценз) авахдаа энэ Хэсэгт заасан зарчмыг мөрдлөг болгох шаардлагатай. Энэхүү зорилгоор өргөн нэвтрүүлэг эрхлэгчид газрын дамжуулалтын, хиймэл дагуулын, кабелин хэмээн ажилж болох бөгөөд харин интернэтээр дамжуулах гэж ангилахгүй.

Зарчим 19. Тусгай эрх (лиценз) олгох үүрэг хариуцлага

1. Бүх зөвшөөрөл олгох процесс болон шийдвэр нь Хэсэг 4-д заасан хараат бус нөхцөл байдалд нийцсэн бие даасан зохицуулах байгууллагаар хянагдсан байна.
2. Хариуцлага бүхий зохицуулах байгууллага нь олон төрлийн өргөн нэвтрүүлгийг дэмжсэн, долгионы давтамжийн төлөвлөгөөний дагуу зөвшөөрөл олгох шаардлагыг хангах ёстой.

Зарчим 20. Шаардлага ханган тэнцэх нөхцөл

1. Хориглолтыг ямарваа нэг үндэслэлгүйгээр өргөдөл гаргагчийн бүтэц, гарлаас шалтгаалан гаргаж болохгүй боловч улс төрийн намтай холбоотойгоор ийнхүү гаргах нь хууль ёсны байж болно. Ялангуяа, өргөдөл гаргагчид корпораци байх гэх мэт хуулийн хэлбэртэй байхыг шаардах ёсгүй. Шашны байгууллага гэх мэт тодорхой төрлийн өргөдөл гаргагчдад болоод өөр хэн ч бай тодорхой үндэслэлгүйгээр тусгай эрх олгохоос татгалзахыг хориглоно. Түүний оронд зохицуулах байгууллага нь тухайн байдал бүрийг нарийвчлан үзсэний үндэслэн дээр шийдвэр гаргах эрх мэдэлтэй байх ёстой.
2. Хязгаарлалтыг гадаадын өмчлөл эсвэл ба өргөн нэвтрүүлэгч эрхлэгчдэд хяналт тавих зорилгоор ногдуулж болох ба гэхдээ эдгээр
3. Хязгаарлалт нь өргөн нэвтрүүлгийн салбарыг бүхэлд нь хөгжүүлэхэд шаардлагатай, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ нь эдийн засгийн хувьд үр ашигтай байх талаар анхаарч үзсэн байх ёстой.

Зарчим 21. Тусгай эрх (лиценз) олгох процесс

1. Тусгай эрх (лиценз) авах процесс нь хуульд ойлгомжтой, нарийн тусгагдсан байх ёстой. Процесс нь шийдвэр гарах цаг хугацааг нь тодорхой заах, олон нийтийн үр нөлөөтэй санаа бодлыг тусгах, өргөдөл гаргагчдад сонгох боломжтой байх зэргээр шударга, ил тод байна. Харин хязгаарлалтай давтамжийн төлөө өрсөлдөж байгаа үед тендэрт оролцогчдыг дуудах эсвэл нөхцөл байдлаас хамаарч өргөдөлд зөвшөөрөл олгогч байгууллагаас шаардлагатай баримт гаргуулан авах зэргийг тендэрийн процессд ашиглах хэрэгтэй.
2. Зөвшөөрөл хүсэх өргөдөл нь тодорхой шалгуурын дагуу хууль зүйн хэлбэртэй (хууль буюу зохицуулалт) байна. Шалгуурын мөн чанар нь бодитой, хүн амын төрөл бүрийн санаа бодлыг өргөн хүрээнд тусгасан, өмчлөлийн байдалд хэт анхаарал тавих явдлаас хамгаалсан, мөн санхүүгийн болон техникийн чадавхийг дүгнэж үзсэн байх ёстой.
3. Аливаа тусгай эрх (лиценз)-ийг олгох зөвшөөрөл өгөхөөс татгалзсан хариуг шалтгааны хамт бичгээр өгөх ба тэр нь шүүхээр хянагдах ёстой.
4. Тусгай эрх (лиценз)-ийн эзэмшигч өргөн нэвтрүүлгийн давтамж авах шаардлагатай бол давтамж авах тусдаа шийдвэр гарах процессийг дамжих ёсгүй бөгөөд зөвшөөрөл авсан өргөдөл хүсэгчид өөрсдийн өргөн нэвтрүүлгийн зөвшөөрлийн шаардлага хангасан давтамжаар хангагдах ёстой.
5. Тусгай эрх (лиценз) авсан өргөдөл хүсэгчид өөрсдөө дамжуулах, эсвэл дамжуулах үйлчилгээтэй гэрээ байгуулах сонголттой байна.

Зарчим 22. Зөвшөөрлийн нөхцөл

1. Тусгай эрх нь тодорхой хугацаа, нөхцөлтэй байна. Хугацаа, нөхцөл нь хууль зүйн хэлбэрт (хууль, зохицуулалт) заасан ерөнхий эсвэл өргөн нэвтрүүлэг эрхлэгчид зориулсан тусгай байж болно. Өргөн нэвтрүүлгийн өргөдөлд заасан мэдээлэл нь зөвшөөрлийн хугацаа, нөхцөлөөс бүрдсэн хэсэгтэй байх нь зүгээр. Хугацаа, нөхцөлийг дараахь тохиолдолд заахгүй:
 - өргөн нэвтрүүлэгт холбогдолгүй
 - хуульд заасан өргөн нэвтрүүлгийн бодлогын зорилгод хамаарахгүйЦаашилбал, аливаа тусгай хугацаа, нөхцөл нь учир шалтгаантай, зөвшөөрөл олгоход бодитой байна.
2. Тусгай эрх (лиценз) эзэмшигч түүний хугацаа, нөхцөлийг өөрчлүүлэхээр хүсэлт гаргах эрхтэй. Яливаа өөрчлөлт хийх эрх зөвшөөрөл олгогч байгууллагад ногдох ба захиргааны ёс зүйн зарчим, Зарчим 21-ийн нөхцөлд нийцсэн байна.
3. Аливаа өргөн нэвтрүүлгийг тусгай эрхийн хугацаа хууль тогтоомжид харийн тусгагдсан байх ёстой. Эдгээр хугацааны хязгаарлалт нь өргөдөл гаргагчдад санхүүгийн болон хүний асуудлаар хөрөнгө оруулалтаа сайжруулах бодитой боломж олгосон үр дүнтэй байх ёстой. Тусгай эрх (лиценз)-ийн хугацааны хязгаарлалт нь өргөн нэвтрүүлгийн хэлбэр, янзаас хамаарч янз бүр байж болно.
4. Тусгай эрх (лиценз) эзэмшигч нь зөвшөөрлийн хураамж төлж болох боловч энэ нь салбарыг хөгжүүлэх, зөвшөөрөл авах өрсөлдөөн болон ерөнхийд нь арилжааны чадавхид анхаарч авч үзсэн байж болохгүй. Янз бүрийн хэлбэрийн тусгай эрх (лиценз)-ийн хураамж нь хувиарын дагуу гарсан байх ёстой.

-
5. Тусгай эрх (лиценз) эзэмшигч нь уг эрхээ шинэчлэн сэргээлгэх эрхийг эдлэх боловч олон нийтийн ашиг сонирхол давуу байсан эсхүл тусгай эрх (лиценз) эзэмшигч зөвшөөрлийн хугацаа нөхцөлийг тогтмол биелүүлээгүй байсан шалтгаанаар түүнийг сэргээхгүй байж болно. Тусгай эрх (лиценз)-ийг сэргээхэд түүний нөхцлийг эргэн харах бололцоогоор хүсэгч, зохицуулагч хоёр хоёулаа хангагдсан байх хэрэгтэй. Зөвшөөрлийг сэргээхгүй гэсэн аливаа татгалзсан хариундаа түүний учир шалтгааныг бичгээр гаргаж өгөх ёстой.

VI ХЭСЭГ. АГУУЛГАТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД

Зарчим 23. Захиргааны дүрэм

1. Өргөн нэвтрүүлгийн хууль нь өргөн нэвтрүүлэг эрхлэгчид эсвэл бүх төрлийн хуулбарлалтад иргэний болон эрүүгийн шинжтэй агуулгын хязгаарлалтыг тавих ёсгүй.
2. Нэвтрүүлгийн агуулгыг зохицуулах захиргааны журам тогтоох нь энэ Хэсэгт заасан зарчмын дагуу бол хууль ёсны байж болно. Нэвтрүүлгийн агуулгад хандсан өөрийн үр ашигтай зохицуулалтын системтэй үед захиргааны систем байх албагүй.
3. Аливаа дүрмийн агуулга нь өргөн нэвтрүүлэг эрхлэгчидтэй болон бусад сонирхогч талуудтай ойр хамтран зөвлөлдөж хийгдэх ёстой ба зөвхөн олон нийтээр хэлэцүүлсний дараа эцэслэн гарна. Зөвшөөрсөн журам нь тодорхой, нэг бүрчилсэн байдлаар хийгдсэн, мөн хэвлэгдсэн байна. Журамд өргөн нэвтрүүлгийн 3 янз, 2 хэлбэрүүдийн өөр өөр нөхцөл байдлыг анхаарч үзсэн байх ёстой.
4. Аливаа агуулгын журмыг хянах үүрэг нь зохицуулах байгууллагад ногдох ба энэ Хэсэг 4-д заасан хараат бус байдлын нөхцөлд нийцсэн байна. Бүх өргөн нэвтрүүлэгийн агуулгын журам нь ганц байгууллагаар хянагддаг байх нь илүү зохимжтой.

Зарчим 24. Эерэг үүргийн агуулга

1. Олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь Зарчим 37 (Олон нийтийн үйлчилгээ) дагуу олон янзын дуу хоолой болон нэвтрүүлгийн ирээдүй, нэвтрүүлгийн өргөн хүрээний материалаараа олон нийтийн мэдэх эрхийг дэмжих тэргүүн зэргийн үүрэгтэй байна.
2. Энэ Хэсэгт заасанчлан, арилжааны болон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд эерэг үүргийг зөвхөн өргөн хүрээний материалыг нэмэгдүүлснээр олон нийтэд хүргэх боломжтой олон төрлийн нэвтрүүлгийг дэмжих зорилго, үр нөлөөтэй үед ногдуулж болно. Иймэрхүү үүрэг нь өргөн нэвтрүүлгийн хөгжлийг боогдуулсан жишээ нь тэдгээр нь бодитой бус эсвэл хэт дарамт учруулхаар байвал хууль бус байж болно. Цаашилбал, улс төрийн хувьд дундыг барих, явуулж байгаа материалын хэв маяг нь тодорхой байх (иймээс эдгээр хоёрдмол утга санаагүй), хэт бүрхэг, ерөнхий байхгүй байх зэрэг үүргийн мөн чанар нь хүрэлцэхүйц хэмжээнд ерөнхий байх ёстой. Иймэрхий үүргийг жишээ нь, орон нутгийн чанартай нэвтрүүлгийн агуулга, хэл, цөөнхийн хэсэг, хүүхдийн хөтөлбөр, мэдээнд ногдуулж болно.

Зарчим 25. Зар сурталчилгаа

1. Зар сурталчилгааны хэмжээ нь ерөнхий хязгаарлалтад байж болох ба харин эдгээр нь өргөн нэвтрүүлгийн салбарын өсөлт, хөгжилтөд хэт хатуурхсан шинжтэй байж болохгүй. Европын Хил Дамнасан Телевизийн тухай Конвенцид зарим бүс нутагт зар

-
- сурталчилгааны хязгаарлалт тогтоосон гэрээ байдаг. (Энэ нөхцөлд 20% байдаг)
- Олон нийтийн өргөн нэвтрүүлэг нь аливаа зар сурталчилгаатай холбоотой үйл ажиллагааг шударга өрсөлдөөний дүрмээр явуулах ёстой. Ялангуяа олон нийтийн санхүүжилтийн боломжийг ашиглаж зах зээлийн үнэ ханшаас доогуур санал болгох ёсгүй.
 - Зар сурталчилгааны агуулгыг зохицуулах тусдаа захиргааны журам энэ хэсэгт заасан зарчмын дагуу байх ба түүнийг улам сайжруулж болно.

VII ХЭСЭГ. Шийтгэл

Зарчим 26. Шийтгэл оногдуулах үе шат

Өргөн нэвтрүүлэг эрхлэгчдийн төлөөлөх боломж нь хангалттай баталгаажсан шударга, нээлттэй үйл явцын дараа хуулийн шаардлага болон зөвшөөрлийн нөхцөл байдлыг илт зөрчсөнөөс бусад тохиолдолд өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд шийтгэл хэзээ ч ногдуулах ёсгүй. Шийтгэлийг Хэсэг 4 заасан хараат бус нөхцөлтэй нийцсэн байгууллагаас ногдуулах ёстой. Шийтгэл ногдуулсан тухай шийдвэр нь хэвлэгдэж өргөнөөр тараагдсан байна.

Зарчим 27. Тэнцвэртэй байх

- Зохицуулах байгууллагад шийтгэлийн хэд хэдэн хэлбэрүүд олгогдсон байх ёстой. Шийтгэл нь учруулсан хохиролтой тэнцвэртэй байх ёстой. Зохицуулах байгууллага нь аливаа хэлбэрийн шийтгэлийг ногдуулахдаа “өргөн нэвтрүүлгийн “цагдаа” гэхээсээ илүү өргөн нэвтрүүлгийн байгууллагад үйл ажиллагаагаа аятай явуулчих боломжийг нь хангасан, нэвтрүүлгийнх нь олон төрөл, чанарыг дэмжсэн, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоо эн тэргүүнд тавьж анхаарсан байх ёстой.
- Шийтгэл нь ихэнх тохиолдолд ялангуяа, агууллагатай холбоотой журмыг зөрчсөн тохиолдолд бага багаар ахиулах хэлбэртэй байх ёстой. Эхний зөрчилд ногдуулах шийтгэл нь түүнийг дахин давтуулахгүй байх тал дээр анхааруулсан байх нь хэвийн зүйл юм. Агуулгатай холбоотой дүрмийг зөрчсөн тохиолдолд торгууль ногдуулах, зөвшөөрлийг түтгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг илүү хатуу шийтгэл ногдуулах нөхцөлүүдийг оруулсан байх ёстой. Иймэрхүү тохиолдолд торгох шийтгэлийг асуудлыг сайжруулах арга хэмжээ авагдаад амжилтгүй болсны дараа ногдуулах ба өргөн нэвтрүүлэг эрхлэгчид зөрчлийг дахин давтсан нь тодорхой болсон, бусад шийтгэлүүд нь асуудлыг сайжруулахад хангалтгүй болох нь тогтоогдсон бол тусгай эрх (лиценз) өгөхийг түтгэлзүүлэх, түүнийг хүчингүй болгох шийтгэл ногдуулж болно.
- Өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь түүнд ногдуулсан аливаа хатуу шийтгэлийг хянуулахаар шүүхэд давж заалдах эрхтэй.

VIII ХЭСЭГ. Төрийн мэдээллийг хүртэх

Зарчим 28. Ялгаварлалгүй байх

- Төрийн зар сурталчилгааны байршуулалтыг багтаасан төрийн мэдээллийг хүртэхдээ Зарчим 36-д (олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн санхүүжилт) заасанчлан байнгын шударга, аливаа ялгаваргүй байх байдлаар хангагдах ёстой.
- Хэвлэл мэдээллээрх албаны хүний мэдээллийн талаарх заалт нь олон нийтийн, арилжааны, нийтийн өргөн нэвтрүүлэгт аливаа ялгаваргүй хандсан байх ёстой.

-
3. Аливаа арилжааны ба нийтийн өргөн нэвтрүүлэгт зориулсан олон нийтийн санхүүжилт нь өргөн нэвтрүүлгийн олон төрлийг дэмжсэн зорилготой байх ёстой. Санхүүжилтыг хувиарлалт нь дэвшилттэй хийгдсэн тодорхой шалгуур дээр үндэслэж Хэсэг 4 заасан хараат бус байдлын нөхцөл байдалтай нийцсэн зохицуулах байгууллагаар хийгдэх ёстой.

IX ХЭСЭГ. Сонгуулийн нэвтрүүлэг

Зарчим 29. Олон нийтийн хэрэгцээ шаардлага хангасан мэдээлэл

1. Сонгуулийн үеэр хэрхэн саналаа өгөх, улс төрийн намууд болон нэр дэвшигчидийн байр суурь, сонгуультай холбоотой кампанит ажил болон бусад асуудлаар өргөн нэвтрүүлгийг оролцуулан олон нийт бүрэн дүүрэн мэдээлэл хүлээн авч байх байдлыг хангах үүргийг төр хүлээнэ. Иймэрхүү мэдээлэл нь мэдээ, цаг үеийн үйл явдлын хөтөлбөр, сонгуульд зориулсан тусгай хөтөлбөр, улс төрийн зөвшөөрөгдсөн шууд нэвтрүүлэг, улс төрийн арилжааны сурталчилгаар явагдах ёстой.
2. Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь үүнд гол үүрэгтэй ба харин гэхдээ энэ үүргүүд нь Хэсэгт заасны дагуу арилжааны болон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд хэт дарамт учруулхааргүй байх ёстой.
3. Өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь сонгуулийн нэвтрүүлгийг шударга, тэнцвэртэй, аливаа ялгаваргүй байдлаар явуулах шаардлагыг хангах ёстой.
4. Сонгуулийн нэвтрүүлэгтэй холбоотой аливаа үүрэг нь Хэсэг 4 заасан хараат бус нөхцөл байдалд нийцсэн зохицуулах байгууллагаар хянагдах ёстой.

Зарчим 30. Сонгогчдын боловсрол

Сонгогчдод яаж, хэзээ, хаана бүртгүүлэх, саналаа өгөх, нэр дэвшигчдын төлөө чөлөөтэй болон нууцаар саналын өгөх, сонгуульд саналаа өгөхийн ач холбогдол зэрэг сонгогчид саналаа өгөх техник ажиллагааг ойлгуулах явдлыг төрөөс хангах шаардлагатай. Энэ нь үйл ажиллагаа хийгдээгүй бол олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлэг эрхлэгч нь сонгогчдын боловсролын хөтөлбөрийг явуулах шаардлагатай. Арилжааны болон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгч нь сонгогчдын боловсролын хөтөлбөр явуулах шаардлагатай байж болно.

Зарчим 31. Улс төрийн шууд нэвтрүүлэг

1. Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь улс төрийн нэвтрүүлэгт шударга, тэнцвэртэй ба аливаа ялгаваргүй байх үндсэн дээр улс төрийн намууд болон нэр дэвшигчдэд шууд нэвтрүүлэг явуулах баталгаат цаг олгож байх шаардлагатай. Арилжааны болон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь нь улс төрийн нэвтрүүлэгт улс төрийн намууд болон нэр дэвшигчдэд шууд нэвтрүүлэг явуулах баталгаат цаг олгох шаардлагатай байж болно. Шударга, тэнцвэртэй, аливаа ялгаваргүй байх асуудал нь баталгаажсан цагийн нийт хэмжээ, нэвтрүүлэх хуваарь болон аливаа нэмэлт төлбөргүй байхад хамаарна. Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь намуудад болон нэр дэвшигчдэд шууд нэвтрүүлэг бэлтгэхэд зориулж техникийн туслалцаа үзүүлэх ёстой ба арилжааны болон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь ийм үүргийн мөн хүлээж болно.
2. Хэрэв улс төрийн шууд нэвтрүүлгүүд нь хууль ёсны үүргийг илт, сүрхий зөрчөөгүй байвал өргөн нэвтрүүлэг эрхлэгчид энэ үүргээс татгалзах ёсгүй. Үүний зэрэгцээ өргөн

нэвтрүүлэг эрхлэгчид нь Зарчим 5-д заасны дагуу улс төрийн шууд нэвтрүүлэг явуулах хуулийн үүрэг хариуцлагаас хамгаалагдах ёстой.

Зарчим 32. Улс төрийн арилжааны сурталчилгаа

Намууд болон нэр дэвшигчид улс төрийн арилжааны сурталчилгаа явуулах нэвтрүүлгийн цаг худалдан авах зөвшөөрөл авсан бол өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь бүх намууд нэр дэвшигчдэд энэ цагийг тэнцвэртэй, аливаа ялгаваргүй байх үндсэн дээр гаргаж өгөх ёстой.

Зарчим 33. Шуурхай залруулга

Сонгуулийн нэвтрүүлгийг хянах хариуцлага бүхий байгууллага нь намууд болон нэр дэвшигчидийн гомдолд хариу өгөх зэрэг сонгуультай холбоотой зөрчлийг шуурхай залруулах боломжийг хангах үүрэгтэй. Хянах байгууллага нь энэ асуудлаар хариуцагч өргөн нэвтрүүлэг эрхлэгчид залруулга хийх, татгалзах эсвэл хариу өгөхийг шаардах бүрэн эрхтэй. Тус байгууллагын энэ шийдвэр нь шүүхээр хянагдах ёстой.

**Х ХЭСЭГ. ОЛОН НИЙТЭД ҮЙЛЧИЛДЭГ ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН
БАЙГУУЛЛАГА**

Зарчим 34. Төр, засгийн газрын өргөн нэвтрүүлгийн байгууллагыг өөрчлөн байгуулах

Энэ хэсэгт заасны дагуу төрийн болон засгийн газрын өргөн нэвтрүүлгийн байгууллага нь олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллага болж өөрчлөгдөх ёстой.

Зарчим 35. Хараат бус байдал

1. Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллага нь Удирдах Зөвлөл гэх мэт хараат бус байгууллагын хяналтад байх ёстой. Энэ байгууллагын бие даасан байдал нь Хэсэг 4-д заасан зохицуулах байгууллагуудад зориулсан арга замаар баталгаажих ёстой. Ялангуяа, хараат бус байдал нь дараах байдлаар хуульд баталгаажиж хамгаалагдсан байх ёстой.
 - Байгууллагыг байгуулах заалтыг хууль тогтоомждоо тусгайлан нарийвчлан заах, боломжтой бол мөн үндсэн хуульд тусгагсанаар
 - Зорилго, эрх, үүрэг, хариуцлагыг хуульд тодорхой зааснаар
 - Гишүүдийг томилох холбогдох дүрмээр
 - Олон намын байгууллагаар дамжуулан олон нийтийн хяналтад байхаар
 - Редакцийн хараат бус байдалд хүндэтгэл үзүүлснээр
 - Санхүүжилт нь гэрээгээр
2. Удирдах байгууллага нь олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллагын удирдлагыг томилох хариуцлагыг хүлээх ба удирдлага нь зөвхөн тус байгууллагын өмнө хариуцлага хүлээх мөн сонгогдсон олон намын байгууллагад дараа ээлжинд хариуцлага хариуцлага хүлээх ёстой. Удирдлагыг томилох процесс нь нээлттэй, шударга байх, хувь хүмүүс нь чадвар, туршлагатай, шаардлагыг хангасан байх ба Зарчим 13.3-д заасан шаардлагад нийцэхгүй байх журмууд нь удирдлагад мөн хамаарах ёстой. Гишүүн хувь хүн бүр үүрэгт ажлаас нь чөлөөлсөн зэрэг тэдний эсрэг зүй бус үйлдлийн учир шалтгааныг бичгээр гаргуулж авах ба шүүхээр хянуулах ёстой.

3. Удирдах зөвлөлийн үүрэг ролийг хууль тодорхой зааж өгөх ёстой. Удирдах зөвлөлийн үүрэг рольд олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллага нь олон нийтийн төлөөлөх эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлдэг мөн өргөн нэвтрүүлгийн байгууллагыг хөндлөнгийн нөлөөлнөөс хамгаалдаг зэргийг багтааж оруулах ёстой. Хараат бус удирдах зөвлөл нь ялангуяа нэвтрүүлгийн агуулгатай холбоотой өдөр тутмын шийдвэрт оролцохгүй бөгөөд редакцийн хараат бус байдлыг хүндэтгэх ба хэзээ ч урьдчилсан хяналт тавих ёсгүй. Удирдлага нь хөтөлбөрийн асуудал болон өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах хариуцлага хүлээнэ.

Зарчим 36. Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн санхүүжилт

Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллага нь түүний эрх үүргийн хүрээг тооцон үзсэний үндсэн дээр Зарчим 37-ын дагуу түүний төсөвт хөндлөнгөөс дур мэдэн нөлөөлөх бололцоогүйгээр хангалттай санхүүжилттэй байх ёстой.

Зарчим 37. Олон нийтийн үйлчилгээ тусгай үүрэг

Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллага нь олон нийтийн санхүүжилттэйгээ ойр холбогдсон, хуульд ойлгомжтой тодорхойлогдсон байх ёстой. Олон нийтэд үйлчилдэг өргөн нэвтрүүлгийн байгууллага нь олон нийтийн нийт ашиг сонирхлыг хангасан өргөн хүрээний мэдээлэлтэй, боловсрол, соёл, зугаа цэнгээний олон төрлийн нэвтрүүлэг явуулах ёстой. Тэдгээрийн тусгай үүрэг дараах болон бусад үйлчилгээ болох:

- Санаа бодлын олон эшт үзэл бодолд хувь нэмэр оруулах, чанартай, хараат бус мэдээллээр олон нийтийг хангах,
- Ойлгомжтой олон талт мэдээтэй байх ба нягт нямбай, тэнцвэртэй цаг үеийн үйл явдлын хөтөлбөртэй байх,
- Хөтөлбөр хоорондын тэнцвэрийг хангасан өргөн хүрээний мэдээлэлтэй байх, мөн өөр өөр үзэгч сонсогчдод зориулсан тусгай хөтөлбөртэй байх,
- Цөөнхийн хэсэг, бүх хүмүүс, улс орны бүс нутагт зориулсан бүгдэд хүртээмжтэй байх,
- Боловсролын болон хүүхэд зориулсан нэвтрүүлэгтэй байх,
- Жинхэнэ бүтээл болон чөлөөт уран бүтээлчдийн бэлтгэсэн нэвтрүүлэг болон орон нутгийн бэлтгэж буй нэвтрүүлгийг зохих хэмжээнд дэмжих

Орчуулсан С.Баяраа